МОНГОЛЫН ГААЛЬ
MONGOLIAN CUSTOMS

TRAM
Trade Related Assistance for Mongolia
This project is funded by the European Union

Монголын Худалдаат Дэмжих Төсөл

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ НЭР ТОМЬЁОНЫ АНГЛИ-МОНГОЛ ТАЙЛБАР ТОЛЬ БИЧИГ

ENGLISH-MONGOLIAN GLOSSARY OF TRADE FACILITATION TERMS

Улаанбаатар хот
2020 он

Монголын Худалдааг Дэмжих Төсөл

Энэхүү хэвлэлийн агуулгыг Зөвлөх Компани бүрэн хариуцах ба
Европын Холбооны үзэл санааг ямар нэгэн байдлаар тусгаагүй болно.

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ НЭР ТОМЬЁОНЫ АНГЛИ-МОНГОЛ ТАЙЛБАР ТОЛЬ БИЧИГ

ENGLISH-MONGOLIAN GLOSSARY OF TRADE FACILITATION TERMS

This project is funded by the European Union.

FOREWORD

Since 2017 when the WTO Trade Facilitation Agreement (TFA) came into force Mongolia is paying great attention to implementing trade facilitation measures that are considered of high priority for a landlocked country. In order to facilitate and ensure smooth implementation process of TFA in Mongolia, the project "Trade Related Assistance for Mongolia" (TRAM) which is funded by the European Union has provided significant support to the Mongolian National Trade Facilitation Committee and especially, to the Mongolian Customs Administration. TRAM aims to increase the capacity of the Government to better facilitate trade through a range of measures that reduce trade costs and ease the rapid movement of legitimate import and export of goods and services.

Today, as a result of our cooperation, we are pleased to present you this publication "Glossary of Trade Facilitation Terms" for nationwide utilisation. The Glossary is considered indispensable not only for public sector responsible for adopting regulations that facilitate international trade but also for companies running foreign trade business and for Universities and their students.

We would like to express our sincere appreciation and thanks to our translators Ms. E Chinbat, TRAM Non-Key Expert and Mr. D. Bayarsaikhan, State Customs Inspector of the Customs General Administration and to Ms. D. Tsendsuren, State Customs Senior Inspector of the Customs General Administration for her dedication on collecting and compiling the Glossary.

EU TRAM Project

ӨМНӨХ ҮГ

ДХБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр 2013 онд байгуулагдаж, 2017 онд хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан Худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ далайд гарцгүй Монгол Улсын хувьд тэргүүлэх чиглэл болоод байна. Монгол Улсад Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Монголын Худалдааг Дэмжих-TRAM” төсөл Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороо түүнчлэн Гаалийн Ерөнхий Газарт дорвитой дэмжлэг туслалцааг үзүүлсээр ирсэн билээ. TRAM төслийн гол зорилго нь Монгол Улсын Засгийн газарт худалдааг хөнгөвчлөхөд чиглэсэн чадавхийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлснээр худалдаа эрхлэх зардлыг бууруулж хууль ёсны бараа, үйлчилгээний экспорт, импортын барааны урсгал хөдөлгөөнийг хялбаршуулж хурдасгахад чиглэж байгаа болно.

Өнөөдөр бидний хамтын ажиллагааны хүрээнд үндэсний хэмжээнд энэхүү “Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны глоссари”-ийг гарган Та бүхний хүртээл болгож байна. Энэ ном нь гадаад худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага төдийгүй гадаад худалдаанд хяналт тавин ажилладаг төрийн байгууллагын ажилтнууд, оюутан сурагчдад хүртээл болох нь дамжиггүй.

Энэ номыг гаргахад хувь нэмэр оруулж эмхэтгэсэн материалыг орчуулсан УИХ-ын Гишүүний зөвлөх Э.Чинбат, Гаалийн ерөнхий газрын гаалийн улсын байцаагч Д.Баярсайхан, холбогдох эх сурвалжаас мэдээллийг цуглуулан эмхэтгэсэн Гаалийн ерөнхий газрын гаалийн улсын ахлах байцаагч Д.Цэндсүрэн нарт талархснаа илэрхийлье.

ЕХ-ны TRAM төсөл

A

24-HOUR ADVANCE MANIFEST RULE (24 AMR)

A rule on 24-hour advance cargo manifest declaration. In US the system is called Advanced Manifest System (AMS), in China China Customs Advance Manifest (CCAMS), and in the EU it is related to the Entry Summary Declaration (ENS) which should be lodged at least 24 hours before commencement of loading in each foreign port (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

МАНИФЕСТЫГ 24 ЦАГИЙН ӨМНӨ УРЬДЧИЛАН ИЛГЭЭХ ДҮРЭМ

Ачааны манифестыг 24 цагийн өмнө урьдчилан илгээх дүрэм. Үүнийг АНУ-д Манифест урьдчилан илгээх систем, Хятадад Хятадын гаалийн урьдчилсан манифест гэж нэрлэдэг. Европын Холбоонд энэ нь Импортын товч мэдүүлэгтэй холбогдсон байдаг. Эдгээр системийн дагуу гадаадын аль ч боомтод барааг ачуулж эхлэхээс дор хаяж 24 цагийн өмнө манифест урьдчилан илгээгдсэн байна.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ACCEPTANCE CREDIT

A letter of credit that provides for payment by means of a time draft. Acceptance and payment of the draft are guaranteed by the bank issuing the credit only if the documents presented under the credit conform to the L/C. Acceptance credits are advantageous because the beneficiary (the seller) can receive immediate payment by having the draft discounted, while the applicant's (buyer's) obligation to pay is deferred until the maturity of the draft.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АКЦЕПТТАЙ АККРЕДИТИВ

Хугацаат чек (вексель, тратта) ашиглан төлбөр хийх боломжтой аккредитив. Аккредив нээсэн банк хэрэв тухайн аккредитивын дагуу гаргаж өгсөн бичиг баримтууд уг аккредитивтай тохирч байвал чек (вексель, тратта)-ийг хүлээн зөвшөөрч, төлбөр үйлдэх баталгаа өгнө. Акцепттай аккредитив нь дараах давуу талтай байдаг: Төлбөр хүлээн авагч буюу нэхэмжлэгч (худалдагч) хөнгөлөлттэй чек (вексель, тратта)-ээр нэн даруй төлбөрөө авах боломжтой байдаг бол өргөдөл гаргагч (худалдан авагч)-ийн төлбөр төлөх үүрэг уг чек (вексель, тратта)-ээр төлбөр төлөгдөх хүртэл хугацаагаар хойшлогдоно.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ACCESSIBILITY

The published information should be easily accessible for all interested parties. Article 1 of the TFA requires Members to publish information 'in a non-discriminatory and easily accessible manner'. There are potentially various ways to increase accessibility to the information. Generally, publication through the Internet has been recognized as one of the best ways to ensure high accessibility.

ХҮРТЭЭЛТЭЙ БАЙХ

Олон нийтэд зориулан хэвлэсэн мэдээлэл нь түүнийг сонирхогч талууд хялбархан олж авах буюу үзэх боломжтой байх ёстой. Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 1 дүгээр зүйлээр мэдээллийг "үл ялгаварласан бөгөөд хялбар хүртээлтэй байх арга хэлбэрээр" хэвлэн нийтлэхийг гишүүн орнуудаас шаардаж байгаа. Мэдээлэлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх янз бүрийн арга бий. Үндсэндээ интернетээр дамжуулан олон нийтэд хүргэх нь мэдээлэлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх шилдэг арга юм.

ACCESSION

Becoming a member of the WTO, signing on to its agreements. New members have to negotiate terms: — bilaterally with individual WTO members — multilaterally, (1) to convert the results of the bilateral negotiations so that they apply to all WTO members, and (2) on required legislation and institutional reforms that are need to meet WTO obligations.

НЭГДЭН ОРОХ

ДХБ-ын хэлэлцээрүүдэд гарын үсэг зурах замаар ДХБ-ын гишүүн болох. Шинэ гишүүд дараах замаар хэлэлцээ хийж, болзол нөхцөлөө тохиролцоно: – хоёр талын хүрээнд, ДХБ-ын гишүүдтэй нэг бүрчлэн хэлэлцээ хийх – олон талын хүрээнд, (1) хоёр талын хэлэлцээний үр дүнг ДХБ-ын бүх гишүүдэд хамаарахаар хувиргах мөн (2) ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлийн талаар хэлэлцэх.

ACKNOWLEDGMENT OF ORDER

Document or message acknowledging an undertaking to fulfil an order and confirming conditions or acceptance of conditions.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЗАХИАЛГА БАТАЛГААЖУУЛАХ

Болзол нөхцөлийг баталгаажуулах, эсхүл хүлээн зөвшөөрөх замаар захиалга биелүүлэх амлалтаа баталгаажуулсан бичиг баримт буюу мессеж (зурвас). (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ACP GROUP

African, Caribbean and Pacific countries. Composed of 79 countries with preferential trading relations with the EU under the former Lomй Conventions now replaced by the Cotonou Agreement

АСР БҮЛЭГ

Африк тив, Карибын тэнгис, Номхон далайн орнууд. Энэ Бүлэг нь тухайн үеийн Ломегийн конвенцууд буюу одоогийн Котонугийн хэлэлцээрийн хүрээнд Европын Холбоотой хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдаа хийдэг 79 улсыг эгнээндээ багтааж байгаа.

ADDRESSEE OF AN ELECTRONIC COMMUNICATION

A party who is intended by the originator to receive the electronic communication, but does not include a party acting as an intermediary with respect to that electronic communication.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАГЧ (ХАЯГЛАГЧ)

Цахим мэдээлэл илгээгчийн хаягласан, түүнийг хүлээн авах ёстой тал. Уг цахим мэдээллийг зуучилсан тал үүнд хамаарахгүй.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ADMINISTRATIVE SETTLEMENT OF A CUSTOMS OFFENCE

The procedure laid down by national legislation under which the Customs are empowered to settle a Customs offence either by ruling thereon or by means of a compromise settlement.

Note:
Administrative settlement of a Customs offence is dealt with in Annex H.2 to the Kyoto Convention of 1974 and Specific Annex H, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ГААЛИЙН ЗӨРЧЛИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ

Гаалийн байгууллага гаалийн зөрчлийг тогтоол шийдвэр гаргах замаар, эсхүл харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх эрхтэй байхаар үндэсний хууль тогтоомжид заасан ажиллагаа.

Жич:
Гаалийн зөрчлийг захиргааны журмаар шийдвэрлэх талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт H.2 болон шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт H-ийн 1-р бүлэгт тус тус заасан байдаг.

AD-VALOREM DUTIES AND TAXES

Duties and taxes which are calculated on the basis of value.

АДВАЛОРЕМ (ҮНИЙН ДҮНГЭЭС ХУВИАР ТОГТООСОН) ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР

Үнийн дүнг үндэслэн тооцдог гаалийн болон бусад татвар.

AD VALOREM EQUIVALENT (AVE)

A tariff (e.g., dollars per ton) that is not ad valorem can be estimated as a percentage of the price of the imported item

АДВАЛОРЕМД ШИЛЖҮҮЛСЭН ТЭНЦҮҮ УТГА (ЭКВИВАЛЕНТ)

Адвалорем биш (үнийн дүнгээс хувиар тогтоогоогүй) (жишээлбэл, тонн тутамд ... ам. доллар гэж тогтоосон) тарифыг тухайн импортын барааны үнийн дүнгийн тодорхой хувьд шилжүүлэн тооцож болно.

AD VALOREM TARIFF

A tariff rate charged as percentage of the price. See “specific tariff”

АДВАЛОРЕМ (ҮНИЙН ДҮНГЭЭС ХУВИАР ТОГТООСОН) ТАРИФ

Үнийн дүнгээс хувиар тооцож ногдуулдаг тарифын хувь хэмжээ.
“Биет хэмжигдэхүүнээр тогтоосон тариф”-г үз

ADVANCE AGAINST DOCUMENT

Loan made on the security of the documents covering the shipment (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БИЧИГ БАРИМТ БАРЬЦААЛЖ УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР АВАХ

Ачилтын бичиг баримтыг барьцаалж олгох зээл. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ADVANCE CARGO INFORMATION SYSTEM (ACIS)

ACIS electronic system gives information on cargo, in advance of its arrival, across different modes and interfaces. By making appropriate information available, it allows the effective logistics management of a transport chain.
(UNCTAD)

АЧААНЫ МЭДЭЭЛЛИЙГ УРЬДЧИЛАН ДАМЖУУЛАХ СИСТЕМ (ACIS СИСТЕМ)

Цахим ACIS систем нь ачааны мэдээллийг уг ачаа ирэхээс өмнө янз бүрийн арга хэлбэр, интерфэйсээр дамжуулан хүргэдэг. Энэ систем нь хэрэгтэй мэдээлэл хүргэж, ачаа тээврийн сүлжээний ложистикийн менежментийг үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлдэг.
(НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал - ЮНКТАД)

ADVANCE PASSENGER INFORMATION (API)

The Advance Passenger Information system (API) provides data about travellers in advance of their arrival into the country. This can include information about passengers, crew and transit travellers. The information can then be checked against warning lists and used for immigration processing, security and customs purposes. The main objectives of API systems are to provide advance warning of persons of interest travelling to the country and to facilitate the clearance of legitimate travellers.

ЗОРЧИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ УРЬДЧИЛАН ДАМЖУУЛАХ (API) СИСТЕМ

Зорчигчийн мэдээллийг урьдчилан дамжуулах (API) систем нь зорчигчдын мэдээллийг тэд тухайн улсад ирэхээс өмнө дамжуулдаг. Үүнд зорчигчид, багийн гишүүд болон дамжин өнгөрөх зорчигчийн мэдээллийг багтааж болно. Уг мэдээллийг сэрэмжлүүлэг өгсөн жагсаалттай тулган шалгаж, цагаачлал, аюулгүй байдал, гаалийн хяналтын зорилгоор ашиглаж болно. API системийн гол зорилтууд нь тухайн улсад зорчиж буй бөгөөд анхаарал татсан хүмүүсийн талаар урьдчилан сэрэмжлүүлэг өгөх, мөн хууль ёсны дагуу зорчиж буй зорчигчдын бүрдүүлэлтийг хөнгөвчлөх явдал юм.

ADVANCE RULING

Advance rulings are binding decisions by Customs at the request of the person concerned on specific particulars in relation to the intended importation or exportation of goods. Advance rulings can be requested with regard to either the classification, the origin or the Customs value of the goods in preparation for importation or exportation. Advance rulings facilitate the declaration and consequently the release and clearance process, as critical assessments in relation with the goods have already been made in the advance ruling. Advance rulings are binding throughout the Customs territory

УРЬДЧИЛСАН ШИЙДВЭР

Урьдчилсан шийдвэр гэдэг нь бараа оруулах, эсхүл гаргахаас өмнө холбогдох этгээдийн хүсэлтээр гаалийн байгууллагаас тодорхой асуудлаар гаргасан бөгөөд заавал дагаж мөрдвөл зохих шийдвэр юм. Урьдчилсан шийдвэр гаргаж өгөх хүсэлтийг бараа импортлох, эсхүл экспортлох бэлтгэл ажлыг хангах явцад холбогдох барааны ангилал, гарал үүсэл, эсхүл гаалийн үнийг (урьдчилан) тодорхойлох явдалтай холбогдуулан тавьж болно. Урьдчилсан шийдвэр нь бараа мэдүүлэх, улмаар бараа олгох болон бүрдүүлэлт хийх ажиллагааг хөнгөвчилдөг.

at all Customs offices and valid for a specific period of time, e.g. 3 months or 1 year.
According to Standard 9.8 of the Revised Kyoto Convention (RKC) and the WCO Recommendation on binding pre-entry classification information requests for advance rulings need to be made in writing. Also Customs is required to issue the advance ruling in writing, including providing a right of appeal. According to Standard 9.9 of the Revised Kyoto Convention (RKC), binding rulings are obligatory for contracting parties.

Учир нь тухайн бараатай холбоотой нарийн тооцоог холбогдох урьдчилсан шийдвэрт урьдчилан тооцож гаргасан байдаг. Урьдчилсан шийдвэрийг гаалийн холбогдох нийт нутаг дэвсгэрийн хүрээнд гаалийн бүх байгуулага (бүх газар, хороод) тодорхой хугацаанд, жишээлбэл, 3 сарын хугацаанд, эсхүл бүтэн жилийн хугацаанд заавал дагаж мөрдөнө. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Стандарт 9.8 болон Ангиллын талаар заавал дагаж мөрдвөл зохих урьдчилсан мэдээлэл (шийдвэр) гаргаж өгөх тухай ДГБ-ын зөвлөмжид урьдчилсан шийдвэр гаргаж өгөх хүсэлтийг бичгээр гаргахыг шаарддаг. Түүнчлэн гаалийн байгууллага урьдчилсан шийдвэрийг бичгээр үйлдэх бөгөөд уг шийдвэрт түүнийг давж заалдах эрхтэй болохыг бас дурдсан байна. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Стандарт 9.9-д зааснаар хэлэлцэн тохиролцогч бүх тал урьдчилсан шийдвэр гаргаж өгөх үүрэгтэй.

Notes: 1. Advance rulings are dealt with in Article 3 of the WTO Agreement on Trade Facilitation. 2. Advance rulings are provided for under the revised Kyoto Convention standard on “binding rulings” (General Annex, Standard 9.9) as well as in the WTO Agreement on Rules of Origin (“assessments on origin”). Some Customs administrations may refer to advance rulings as “preliminary decisions”; “binding tariff information” or “binding origin information”.

Жич: 1. Урьдчилсан шийдвэрийн талаар Худалдааг хөнгөвчлөх тухай ДХБ-ын Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан байдаг. 2. Урьдчилсан шийдвэрийн талаар Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн “заавал дагаж мөрдөх урьдчилсан шийдвэр”-ийн тухай стандарт (Ерөнхий хавсралтын Стандарт 9.9)-д, мөн ДХБ-ын Гарал үүслийн тухай хэлэлцээр (“гарал үүслийг тодорхойлох” хэсэг)-т заасан байгаа. Зарим гаалийн байгууллага урьдчилсан шийдвэр гэдгийг “урьдчилсан шийдвэр”, “тарифын заавал дагаж мөрдөх мэдээлэл (шийдвэр)”, эсхүл “гарал үүслийн заавал дагаж мөрдөх мэдээлэл (шийдвэр)” гэдэг байж болно.

ADVICE OF DISTRIBUTION OF DOCUMENTS

Document in which the party responsible for the issue of a set of trade documents specifies the various recipients of originals and copies of these documents, with an indication of the number of copies distributed to each of them.

Note: Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary , 2019

БИЧИГ БАРИМТ ХҮРГҮҮЛСЭН МЭДЭГДЭЛ

Худалдааны иж бүрэн бичиг баримт үйлдэгч тал тэдгээр бичиг баримтын жинхэнэ болон хуулбар хувийг хүлээн авах янз бүрийн талуудын нэрсийг дурдаж, тэдэнд очих хувиудын тоог тус бүрд нь заасан бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AFFREIGHTMENT/FREIGHTMENT

An agreement by a shipping line to provide cargo space on a vessel at a specified time and for a specified price to accommodate an exporter or importer, who then becomes liable for payment even though he is later unable to make the shipment (or alternatively: a contract for the carriage of goods by sea for payment expressed in charter party or Bill of Lading).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАЛАЙН ТЭЭВРИЙН ГЭРЭЭ

Усан онгоцны компани ачааг тодорхой хугацаанд усан онгоцонд ачих зай талбай гаргаж өгөх гэрээ. Түүгээр экспортлогч буюу импортлогч бараагаа ачуулаагүй байсан ч гэсэн түүнд заасан үнийн дүнг төлөх үүрэг хүлээдэг. (Эсхүл, тээврийн гэрээ буюу тээврийн баримтад заасан төлбөр төлж, бараагаа далайгаар тээвэрлэх гэрээ). (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AFRICAN GROUP

African members of the WTO

АФРИКИЙН БҮЛЭГ

ДХБ-ын Африкийн гишүүн орнууд

AGENDA 21

The Agenda for the 21st Century — a declaration from the 1992 Earth Summit (UN Conference on the Environment and Development) held in Rio de Janeiro

ХӨТӨЛБӨР 21

21 дүгээр зууны хөтөлбөр – Рио де Жанейро-д 1992 онд болсон Дэлхийн дээд хэмжээний уулзалт (Байгаль орчин болон Хөгжлийн асуудлаарх НҮБ-ын Бага хурал)-аас гаргасан тунхаглал

AGGREGATE MEASUREMENT OF SUPPORT (AMS)

Trade-distorting AMS has two components – non-product specific and product-specific support: the product-specific AMS is calculated for each basic agricultural product and typically covers support measures such as market price support and non-exempt direct payments. Non-product specific support is support provided in favour of agricultural producers in general. Only members with an AMS commitment in their schedules of commitments can provide AMS support beyond their de minimis level and up to this commitment.

ДЭМЖЛЭГ (ТАТААС) ҮЗҮҮЛЭХ ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭ

Худалдааны хазайлт үүсгэх уршигтай Дэмжлэг (татаас) үзүүлэх цогц арга хэмжээ нь – тодорхой бүтээгдэхүүнд чиглэгүй болон тодорхой бүтээгдэхүүнд чиглэсэн – хоёр бүрдэл хэсэгтэй: тодорхой бүтээгдэхүүнд чиглэсэн Дэмжлэг (татаас) үзүүлэх цогц арга хэмжээг хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн тус бүрээр тооцож гаргадаг бөгөөд үүнд ерөнхийдөө зах зээлийн үнийн дэмжлэг үзүүлэх болон татвараас чөлөөлөгдөөгүй шууд төлбөр үйлдэх зэрэг дэмжлэгийн арга хэмжээ багтана. Тодорхой бүтээгдэхүүнд чиглээгүй дэмжлэг (татаас) гэдэг нь ерөнхийдөө хөдөө аж ахуйн аливаа бүтээгдэхүүнийг дэмжсэн дэмжлэг болно. Зөвхөн үүрэг амлалтын жагсаалтдаа Дэмжлэг (татаас) үзүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан гишүүд өөрсдийн de minimis түвшин (үл тооцох хувь)-нөөс хальж, тэрхүү үүрэг амлалтынхаа хүрээнд Дэмжлэг (татаас) үзүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.

AGRICULTURAL PRODUCT

Defined for the coverage of the WTO's Agriculture Agreement, by the agreement's Annex 1. This excludes, for example, fish and forestry products. It also includes various degrees of processing for different commodities

ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН

ДХБ-ын Хөдөө аж ахуйн хэлэлцээрт хамаарах, түүний 1 дүгээр хавсралтад заасан бүтээгдэхүүн. Үүнд, жишээлбэл, загасны болон ойн аж ахуйн бүтээгдэхүүн хамаарахгүй. Үүнд бас зарим барааны боловсруулалтын түвшин хамаарахгүй.

AGREEMENT ON INTERNATIONAL GOODS TRAFFIC

Agreement on International Goods Traffic, 1951

ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН АЧААНЫ ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Олон улсын төмөр замын ачааны харилцааны тухай 1951 оны хэлэлцээр

AGREEMENT ON TECHNICAL BARRIERS TO TRADE (TBT)

The Agreement on Technical Barriers to Trade consists of 15 articles and three annexes. The Agreement uses two terms: "Technical Regulation", which includes requirements that are mandatory, and the term "standard", the observance of which is voluntary. It applies to all industrial and agricultural goods. However, sanitary and phytosanitary measures are the subject of another agreement. The agreement also extends to the production processes in cases when they change the qualitative characteristics of goods.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААН ДАХЬ ТЕХНИКИЙН СААД ТОТГОРЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР (TBT)

Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр нь 15 зүйл, 3 хавсралттай. Энэ хэлэлцээрт дараах хоёр нэр томьёо хэрэглэгдсэн байдаг: "техникийн дүрэм журам" – заавал хангасан байх ёстой шаардлагууд, "стандарт" – сайн дурааараа мөрдвөл зохих заалтууд. Энэ хэлэлцээр нь аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн бүх барааND хамаарна. Гэвч амьтан, ургамлын хорио цээрийэ арга хэмжээг өөр хэлэлцээрээр зохицуулсан байдаг. Хэрэв үйлдвэрлэлийн процессын явцад барааны чанарын үзүүлэлтүүд өөрчлөгдсөн бол энэ хэлэлцээр бас тийм үйлдвэрлэлийн процесст хамаарна.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AIR FREIGHT FORWARDER

A type of freight forwarder who specializes in air cargo. An air freight forwarder usually consolidates the air shipments of various exporters, charging them for actual weight and deriving profit by paying the airline the lower consolidated rate. Air freight forwarders issue their own air waybills to the exporters.

АГААРЫН ТЭЭВЭР ЗУУЧ

Агаарын ачаагаар дагнаж мэргэшсэн тээвэр зууч. Агаарын тээвэр зууч нь гол төлөв янз бүрийн экспортлогч нараас агаарын ачаа түүвэрлэн цуглуулж, бодит жингээс хураамж авч, агаарын тээврийн компанид бага хэмжээний нэгдсэн төлбөр төлж, зөрүүнээс нь ашиг олдог. Агаарын тээвэр зууч нь экспортлогч нарт өөрийн гэсэн тээврийн баримт олгодог.

AIRCRAFT GENERAL DECLARATION

Declaration conforming to the provisions of Annex 9 to the Convention on International Civil Aviation, Chicago 1944. The general declaration is the basic document on arrival and departure providing information concerning the aircraft itself and summary information relating to the itinerary, crew, passengers and health.

НИСЭХ ОНГОЦНЫ ЕРӨНХИЙ МЭДҮҮЛЭГ

1944 онд Чикаго хотноо байгуулагдсан Олон улсын иргэний агаарын тээврийн тухай Конвенцийн 9 дүгээр хавсралтын заалтад нийцсэн мэдүүлэг. Уг ерөнхий мэдүүлэг нь ирэх, явах нислэгийн тухай үндсэн бичиг баримт бөгөөд түүнд нисэх онгоцны өөрийнх нь тухай мэдээллээс гадна нислэгийн маршрут, нислэгийн баг, зорчигчид болон тэдний эрүүл мэндэд хамааралтай товч мэдээллүүд агуулагдана.

AIR WAYBILL (AWB)

A contract between the shipper and airline that states the terms and conditions of transportation (IATA). An air waybill (AWB) or air consignment note is a document issued by an airline for goods and an evidence of the contract of carriage, but it is not a document of title to the goods. Hence, the air waybill is non-negotiable.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АГААРЫН ТЭЭВРИЙН БАРИМТ

Ачаа бэлтгэгч (ачигч компани) болон авиакомпани хооронд байгуулсан, тээвэрлэлтийн хугацаа, нөхцөлийг заасан гэрээ (Агаарын тээврийн олон улсын агентлаг (Олон улсын агаарын тээврийн нийгэмлэг)). Агаарын тээврийн баримт буюу агаарын ачааны дагалдах хуудас нь тухайн барааны хувьд авиакомпаниас олгосон бичиг баримт бөгөөд тээврийн гэрээ болохыг илтгэнэ. Гэвч энэ нь бараа эзэмших буюу өмчлөх эрхийн бичиг биш юм. Тэгэхээр агаарын тээврийн баримт нь төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) биш юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AIRPORT

Any location with permanent facilities at which aircraft can load or discharge cargo moving in air traffic.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ

Нисэх онгоц агаарын тээврийн ачаа ачих, буулгах боломжтой байнгын байгууламж бүхий аливаа газар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AIRPORT OF DEPARTURE

Airport from which a means of transport is scheduled to depart or has departed.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НИСЭХ ОНГОЦ ХӨӨРӨХ БУУДАЛ

Агаарын тээврийн хэрэгсэл хөөрөх зориулалттай буюу хөөрдөг нисэх онгоцны буудал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ALTERNATIVE DISPUTE RESOLUTION

Dispute resolution processes such as negotiation, mediation and arbitration, which occur out of court.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ШҮҮХИЙН БУС АРГААР МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭЛБЭРҮҮД

Хэлэлцээ, эвлэрүүлэн зуучлал, арбитр зэрэг шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх процесс.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AMBER BOX

Domestic support for agriculture that is considered to distort trade and therefore subject to reduction commitments. Technically calculated as “Aggregate Measurement of Support” (AMS)

ХУВ ШАР (ШАР, ШАРГАЛ) ХАЙРЦАГ

Худалдааны хазайлт (гажилт) үүсгэдэг гэж үздэг бөгөөд тиймээс бууруулах үүрэг амлалт авбал зохих хөдөө аж ахуйн дотоодын дэмжлэг (татаас). Түүнийг Дэмжлэг (татаас) үзүүлэх цогц арга хэмжээг тооцдог аргачлалаар тооцож боддог.

ANDEAN COMMUNITY

Bolivia, Colombia, Ecuador, Peru and Venezuela

АНДЫН НУРУУНЫ ХАМТЫН НИЙГЭМЛЭГ

Болив, Коломби, Эквадор, Перу, Венесуэль

ANTI-DUMPING DUTIES

Measures taken to compensate for or correct the injury caused to producers in the importing country by imports deemed to be dumped. If it is demonstrated that the dumping is detrimental, Article VI of the GATT allows anti-dumping duties to be imposed.

ДЕМПИНГИЙН ЭСРЭГ ТАТВАР

Демпингийн улмаас импортлогч улсын үйлдвэрлэгч нарт учирсан хохирлыг барагдуулах, эсхүл засч залруулах зорилгоор авсан арга хэмжээ. Хэрэв уг демпинг хохиролтой болох нь нотлогдвол ТХЕХ-ийн VI зүйл нь демпингийн эсрэг татвар ногдуулахыг зөвшөөрдөг.

APEC

Asia Pacific Economic Cooperation forum

АПЕК

Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны форум

APPEAL

The act by which a person who is directly affected by a decision or omission of the Customs and who considers himself to be aggrieved thereby seeks redress before a competent authority.

Note:
Appeal in Customs matters is dealt with in Annex H.1. to the Kyoto Convention of 1974 and the General Annex, Chapter 10 of the revised Kyoto Convention.

ДАВЖ ЗААЛДАХ

Гаалийн байгууллагын шийдвэр, эсхүл эс үйлдлийн нөлөөгөөр ашиг сонирхол нь шууд хөндөгдсөн бөгөөд үүний улмаас өөрийгөө хохирсонд тооцож буй аливаа этгээд хохирлоо нөхөн төлүүлэх үүднээс эрх бүхий байгууллагад хандах үйл ажиллагаа.

Жич:
Гаалийн асуудлаар давж заалдах талаар 1974 оны Киотогийн Конвенцийн хавсралт Н.1-д, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 10 дугаар бүлэгт заасан байдаг.

APPELLATE BODY

An independent seven-person body that considers appeals in WTO disputes. When one or more parties to the dispute appeals, the Appellate Body reviews the findings in panel reports

ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

ДХБ-ын давж заалдсан маргааныг шүүн хэлэлцэх, бие даасан 7 хүний бүрэлдэхүүнтэй шүүх. Аливаа нэг маргаантай асуудлын нэг буюу хэд хэдэн тал давж заалдсан бол Давж заалдах шатны энэ шүүх өмнөх шүүх бүрэлдэхүүний тайлан (шийдвэр)-д тусгагдсан дүгнэлтийг хянан үзнэ.

APPLICATION FOR EXCHANGE ALLOCATION

Document whereby an importer/ buyer requests the competent body to allocate an amount of foreign exchange to be transferred to an exporter/seller in payment for goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ВАЛЮТЫН ГҮЙЛГЭЭ ХИЙХ ӨРГӨДӨЛ

Импортлогч (худалдан авагч) барааны төлбөр болгон экспортлогчид (худалдагчид) тодорхой хэмжээний гадаад валют шилжүүлэхийг эрх бүхий байгууллагаас хүссэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

APPLICATION FOR EXPORT PERMIT

Document or request submitted to a competent body in order to request permission for exportation.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ӨРГӨДӨЛ

Бараа экспортлох зөвшөөрөл авах зорилгоор эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн бичиг баримт буюу хүсэлт
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

APPLICATION FOR GOODS CONTROL CERTIFICATE

Document or request submitted to a competent body by party requesting a goods control certificate to be issued in accordance with national or international standards, or conforming to legislation in the importing country, or as specified in the contract.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААНЫ ХЯНАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ АВАХ ӨРГӨДӨЛ

Үндэсний, эсхүл олон улсын стандартын дагуу, импортлогч улсын хууль тогтоомжид нийцүүлэн, эсхүл гэрээнд заасны дагуу барааны хяналтын гэрчилгээ авахыг хүссэн талаас эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн бичиг баримт буюу хүсэлт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

APPLICATION FOR INSPECTION CERTIFICATE

Document or request submitted to a competent body by a party requesting an inspection certificate to be issued in accordance with national or international standards, or conforming to legislation in the country in which it is required, or as specified in the contract.

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙСЭН ГЭРЧИЛГЭЭ АВАХ ХҮСЭЛТ

Үндэсний, эсхүл олон улсын стандартын дагуу, тийм гэрчилгээ авахыг шаарддаг улсын хууль тогтоомжид нийцүүлэн, эсхүл гэрээнд заасны дагуу үзлэг шалгалт хийсэн гэрчилгээ авахыг хүссэн талаас эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн бичиг баримт буюу хүсэлт.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

APPLICATION FOR PHYTOSANITARY CERTIFICATE

Document or request submitted to a competent body by party requesting a phytosanitary certificate to be issued.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ГЭРЧИЛГЭЭ АВАХ ХҮСЭЛТ

Ургамлын хорио цээрийн гэрчилгээ авахыг хүссэн талаас эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн бичиг баримт буюу хүсэлт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

APPLIED RATES

See Applied tariff

ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ХУВЬ ХЭМЖЭЭ

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тарифыг үз.

APPLIED TARIFF (APPLIED RATES)

Duties that are actually charged on imports. They can be below the bound rates of the Schedules of concessions of the Members of the WTO.

ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ТАРИФ (ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ХУВЬ ХЭМЖЭЭ)

Импортын барааанд бодитоор ногдуулж буй гаалийн татвар. Энэ нь ДХБ-ын гишүүн орнуудын Үүрэг амлалтын жагсаалтад заасан заавал мөрдөх хувь хэмжээнээс доогуур байж болно.

ARRIVAL NOTICE (OF GOODS)

Notification from the carrier to the consignee in writing, by telephone or by any other means (express letter, message, telegram, etc.) informing him that a consignment addressed to him is being or will shortly be held at his disposal at a specified point in the place of destination (GIT).

(БАРАА) ИРСЭН (ИРЭХ ГЭЖ БАЙГАА) ТУХАЙ МЭДЭГДЭХ

Тээвэрлэгч аливаа ачаа хүрэх газрын (хүлээн авагч улсын) заасан газарт ирж, бараа хүлээн авагчийн мэдэлд шилжиж байгаа, эсхүл удахгүй шилжинэ гэдгийг бараа хүлээн авагчид бичгээр, утсаар, эсхүл өөр бусад арга (буухиа захидал илгээх, мессеж, телеграм илгээх гэх мэт)-аар мэдэгдэх.

ARTICLE XII MEMBERS

The Group of Article XII Members (previously recently acceded members) is composed of members that joined the WTO after 1995. The Group seeks to close the gap between the commitments of the original WTO members and the greater level of commitments undertaken by their members during their accession to the WTO. Excludes least-developed countries and EU members that joined post-1995.

XII ЗҮЙЛИЙН ГИШҮҮД

ДХБ-д 1995 оноос хойш нэгдсэн орсон гишүүдээс бүрдсэн XII зүйлийн гишүүд (өмнө нь сайхан нэгдэн орсон гишүүд)-ийн бүлэг. Энэ Бүлэг нь ДХБ-ын анхны гишүүдийн авсан үүрэг амлалт болон түүний гишүүд ДХБ-д нэгдэн орох явцад авсан ихэнх үүрэг амлалт хоорондын зөрүү арилгах зорилготой. Энэ Бүлэгт буурай хөгжилтэй орнууд болон ДХБ-д 1995 оноос хойш нэгдэн орсон Европын Холбооны гишүүд хамаарахгүй.

ARTICLE XX

(i.e. 20) A GATT article listing allowed "exceptions" to the trade rules

XX ЗҮЙЛ

(өөрөөр хэлбэл, 20) ТХЕХ-ийн худалдааны дүрэм журамд үл хамаарах тохиолдлыг жагсаасан зүйл

ARTIFICIAL INTELLIGENCE

The theory and development of computer systems / algorithms able to perform tasks and take decisions normally requiring human intelligence, such as visual perception, speech recognition, decision-making, operating huge data bases, and translation between languages. Articles 7 and 10 of the TFA contain provisions, the implementation of which can be supported by making use of data analysis and Artificial Intelligence (AI). Specific measures where AI could be applied are risk management, separation of release from clearance, audits, facilitation measures for authorized operators, and the analysis of release times beyond the simple "average" that needs to be published.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХИЙМЭЛ ОЮУН УХААН

Ерөнхийдөө хүний оюун ухаан шаардсан ажил үүрэг гүйцэтгэх болон хүний оюун ухаан шаардсан шийдвэр гаргах, тухайлбал, дүрс ялган таних, хэл яриа ялган таних, шийдвэр гаргах, маш том хэмжээний өгөгдлийн бааз ажиллуулах, олон хэлний орчуулга хийх боломжтой компьютерийн систем буюу алгоритмын онол болон хөгжүүлэлт. Худалдааг, хөнгөвчлөх тухай хэлэлцээрийн 7, 10 дугаар зүйлд мэдээллийн (өгөгдлийн) дүн шинжилгээ болон хиймэл оюун ухаан ашиглах замаар хэрэгжүүлж болох заалтууд байгаа. Хиймэл оюун ухаан ашиглаж болох тодорхой арга хэмжээг дурдвал: эрсдэлийн менежмент, бараа олгох процессыг бүрдүүлэлтээс салгах, аудит, итгэмжлэгдсэн операторт хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ, бараа олгох ердийн "дундаж" хугацаа (түүнийг нийтлэх ёстой байдаг)-аас дээш цаг хугацаанд дүн шинжилгээ хийх, г.м. байж болно.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ASEAN

Association of Southeast Asian Nations. Eight ASEAN members are members of the WTO — Brunei, Cambodia, Indonesia, Malaysia, Myanmar, the Philippines, Singapore and Thailand. The other ASEAN members — Laos and Vietnam — are negotiating WTO membership

АСЕАН

Зүүн Өмнөд Азийн орнуудын нийгэмлэг (Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг). АСЕАН-ы 8 улс – Бруней, Камбоди, Индонези, Малайз, Мянмар, Филиппин, Сингапур, Тайланд – ДХБ-ын гишүүн. АСЕАН-ы бусад гишүүд – Лаос, Вьетнам – ДХБ-ын гишүүн болохоор хэлэлцээ хийж байна.

ASSESSMENT OF DUTIES AND TAXES

Determination of the amount of duties and taxes payable.

ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР ТООЦОХ

Төлбөл зохих гаалийн болон бусад татварын хэмжээг тодорхойлох.

Note:
Assessment of duties and taxes is dealt with in the General Annex,
Chapter 4 of the revised Kyoto Convention.

Жич:
Гаалийн болон бусад татварыг ногдуулах талаар шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 4 дүгээр бүлэгт заасан байдаг.

ASSIST

Something of value that the buyer of goods provides directly or indirectly, free or at a reduced cost, to the manufacturer or seller of the goods for use in the production of the goods. The value of the assist (or a percentage thereof) should be added to the transaction value when calculating value for customs purposes. Tools dies and moulds used to produce goods may be considered assists.

ДЭМЖЛЭГ

Холбогдох барааг үйлдвэрлэхтэй холбогдуулан ашиглуулахаар худалдан авагчаас үйлдвэрлэгчид, эсхүл худалдагчид шууд, эсхүл шууд бус хэлбэрээр үнэ төлбөргүй, эсхүл хямдруулсан үнээр нийлүүлсэн (нийлүүлж буй) үнэ бүхий ямар нэгэн зүйл (бараа, ажил, үйлчилгээ). Гаалийн зорилгоор үнийг тооцохдоо дэмжлэгийн үнийг (эсхүл түүний тодорхой хувийг) хэлцлийн үнэд нэмж тооцно. Бараа үйлдвэрлэхэд ашигласан цутгуур болон хэвийг дэмжлэг гэж үзэж болно.

ATA CARNET

An international Customs document which, issued under the terms of the ATA Convention and the Istanbul Convention, incorporates an internationally valid guarantee and may be used, in lieu of national Customs documents and as security for import duties and taxes, to cover the temporary admission of goods and, where appropriate, the transit of goods. It may be accepted for controlling the temporary exportation and re-importation of goods but, in this case, the international guarantee does not apply.

АТА КАРНЕЙ

АТА карнейн тухай конвенц болон Түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенцид заасан болзол нөхцөлийн дагуу олгосон, олон улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчлэх баталгааг агуулах бөгөөд үндэсний гаалийн бичиг баримтуудыг орлуулан, мөн импортын гаалийн болон бусад татвар төлөх баталгаа болгон барааг түр хугацаагаар оруулах, мөн боломжтой бол, барааг дамжуулан өнгөрүүлэх горимд ашиглаж болох олон улсын гаалийн бичиг баримтыг хэлнэ. Түүнийг барааг түр хугацаагаар гаргах болон буцаан оруулах горимд хяналт тавих зорилгоор хүлээн зөвшөөрч болно. Гэвч энэ тохиолдолд олон улсын баталгаа гэдэг утгаараа хэрэглэгдэхгүй.

Notes:
1. The ATA carnet may not, in principle, be used for the temporary admission of means of transport (See Commentary 2 to Article 1, Annex A of the Istanbul Convention).
2. Instead of “import duties and taxes” the ATA Convention uses the term “import duties”, giving it the same scope as the Glossary gives to the former expression.

Жич:
1. АТА карнейг зарчмын хувьд тээврийн хэрэгслийг гаалийн нутагт түр хугацаагаар оруулахад хэрэглэхгүй байж болно (Стамбулын конвенцын Хавсралт А-гийн 1 дүгээр зүйлийн Тайлбарын 2-ыг үз).
2. АТА карнейн тухай конвенцид “импортын гаалийн болон бусад татвар” гэсэн нэр томьёоны оронд “импортын татвар” гэсэн нэр томьёо хэрэглэсэн бөгөөд тэр нь энэ Нэр

томьёоны толинд орсон “импортын гаалийн болон бусад татвар” гэсэн нэр томьёотой адил утга агуулна.

ATA CONVENTION
(Convention ATA)

The expression commonly used to refer to the Customs Convention on the ATA carnet for the temporary admission of goods (ATA Convention) adopted by the Customs Co-operation Council in Brussels in 1961.

АТА КАРНЕЙН ТУХАЙ КОНВЕНЦ

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 1961 онд Брюссель хотноо батлсан Барааг түр хугацаагаар оруулах зориулалттай АТА карнейн тухай гаалийн конвенцийн түгээмэл нэр.

ATC

The WTO Agreement on Textiles and Clothing which integrated trade in this sector back to GATT rules, expired on 1 January 2005

ATC

Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай хэлэлцээр. Энэ хэлэлцээр нь энэ салбарын худалдааг ТХЕХ-ийн дүрэмд буцаан хамааруулсан. Түүний хүчинтэй хугацаа 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дуусгавар болсон.

AUDIT-BASED CONTROL

Measures by which the Customs satisfy themselves as to the accuracy and authenticity of declarations through the examination of the relevant books, records, business systems and commercial data held by persons concerned.

Note:
Audit-based control is dealt with in the Ge neral Annex, Chapter 6 of the revised Kyoto Convention.

АУДИТАД СУУРИЛСАН ХЯНАЛТ

Гаалийн байгууллага холбогдох этгээдийн санхүүгийн баримт, бүртгэл, бизнесийн систем болон худалдааны мэдээллийг, шалгах замаар мэдүүлгийн үнэн зөвийг бататган тогтоох арга хэмжээ.

Жич:
Аудитад суурилсан хяналтын талаар шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэгт заасан байдаг.

AUTHENTICATION

The process of verifying the identity of a party to electronic transactions against its credentials

Note: United Nations Convention on the Use of Electronic Communications in International Contracts

БАТАЛГААЖУУЛАЛТ

Цахимаар хэлцэл хийсэн талыг түүний хувийн мэдээлэл (түүх)-тэй тулган таньж тогтоох процесс.

Жич: Цахим мэдээллийг (цахим харилцааг) олон улсын гэрээнд ашиглах тухай НҮБ-ын конвенц

AUTHORITY

In international trade and trade documents, the term (often in plural authorities) means a person or organization having political or administrative power and control. In general, the term means the power or right to give orders, make decisions, or act in a specified way,

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

Олон улсын худалдаа болон худалдааны бичиг баримтад ийм томьёо (англи хэл дээр ихэвчлэн олон тоон дээр хэрэглэдэг)-гоор улс төрийн буюу захиргааны эрх мэдэлтэй, төрийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд, эсхүл байгууллагыг илэрхийлдэг.

delegated by another body, or an official permission or sanction.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

Энэ нэр томьёо нь ерөнхийдөө тушаал буулгах, шийдвэр гарах, эсхүл өөр нэг байгууллага эрх мэдлээ шилжүүлсний дагуу тодорхой чиг үүрэгтэй ажиллах, эсхүл албан ёсны зөвшөөрөл буюу санкц олгох эрх мэдэл буюу эрх гэсэн утгатай болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AUTHORIZATION

The act of granting permission for someone or something to conduct an action.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЗӨВШӨӨРӨЛ (ЭРХ) ОЛГОХ

Хэн нэгэнд ямар нэгэн үйл ажиллагаа явуулах (эрхлэх) зөвшөөрөл олгох үйлдэл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

AUTHORIZED ECONOMIC OPERATOR (AEO)

AEO is a party involved in the international movement of goods in whatever function that has been approved by or on behalf of a national Customs administration as complying with WCO or equivalent supply chain security standards. AEOs may include manufacturers, importers, exporters, brokers, carriers, consolidators, intermediaries, ports, airports, terminal operators, integrated operators, warehouses, distributors and freight forwarders.

Note:
Authorized Economic Operator (AEO) is dealt with in the WCO SAFE Frameworks of Standards.

ИТГЭМЖЛЭГДСЭН АЖ АХУЙН НЭГЖ

ДГБ-аас батлан гаргасан, эсхүл түүнтэй адилтгах өөр бусад бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлын стандартыг мөрдлөг болгон ажилладаг болохыг үндэсний гаалийн байгууллагаас, эсхүл түүний томилсон өөр этгээдээс батлан илэрхийлсэн, барааны олон улсын хөдөлгөөнд ямар нэгэн үүрэг гүйцэтгэн оролцогч аль нэг тал
ИААН нь үйлдвэрлэгч, импортлогч, экспортлогч, зуучлагч, тээвэрлэгч, консолидатор (цуглуулбар (түүвэр) ачаа нэгтгэн бэлтгэгч), завсрын этгээд, боомт, нисэх онгоцны буудал, терминалын эрхлэгч, цогцолборын оператор, агуулах, дистрибьютор болон тээвэр зууч нар байж болно.

Жич:
Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг ДГБ-ын Аюулгүй байдлын багц стандартын хүрээнд авч үздэг.

AUTHORIZED CONSIGNEE

A person empowered by Customs to receive goods directly at his/her premises without having to present them at the office of destination (The WCO Transit Guidelines, 2017).

ИТГЭМЖЛЭГДСЭН ХҮЛЭЭН АВАГЧ

Барааг хүлээн авагч гаалийн албанд үзүүлэлгүйгээр шууд өөрийнхөө байр агуулахад хүлээн авахыг гаалийн байгууллагаас зөвшөөрсөн этгээд
(Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е1 – Дамжуулан өнгөрүүлэх гаалийн горим)

AUTHORIZED CONSIGNOR

A person empowered by Customs to send goods directly from his/her premises without having to present them at the office of departure (The WCO Transit Guidelines, 2017).

ИТГЭМЖЛЭГДСЭН ИЛГЭЭГЧ

Барааг хүлээн авагч гаалийн албанд үзүүлэлгүйгээр шууд өөрийнхөө байр агуулахаас илгээхийг гаалийн байгууллагаас зөвшөөрсөн этгээд
(Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е1 – Дамжуулан өнгөрүүлэх гаалийн горим)

AUTOMATED MESSAGE SYSTEM

A computer program or an electronic or other automated means used to initiate an action or respond to data messages or performances in whole or in part, without review or intervention by a natural person each time an action is initiated or a response is generated by the system.

Note: United Nations Convention on the Use of Electronic Communications in International Contracts

МЕССЕЖ ДАМЖУУЛАХ АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

Уг системээс ямар нэг үйлдэл санаачлан эхлүүлэх, эсхүл хариу өгөх бүр хувь хүний хяналт, оролцоогүйгээр мэдээлэл бүхий мессеж буюу гүйцэтгэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн эхлүүлэх, хариу өгөхөд ашигладаг компьютерийн програм буюу цахим, эсхүл бусад автоматжуулсан хэрэгслүүд.

Жич: Цахим мэдээллийг (цахим харилцааг) олон улсын гэрээнд ашиглах тухай НҮБ-ын конвенц

AUTOMATIC IMPORT LICENSING

According to the WTO Agreement on Import Licensing Procedures (art.2): “Automatic import licensing is defined as import licensing where approval of the application is granted in all cases, and which is in accordance with the requirements of paragraph 2(a):… automatic licensing procedures shall not be administered in such a manner as to have restricting effects on imports subject to automatic licensing.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)
See “Non-Automatic Licensing”.

ИМПОРТЫН ШУУД ЛИЦЕНЗ ОЛГОХ

ДХБ-ын Импортын лиценз олгох журмын тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн дагуу: Импортын шууд лиценз олгох гэдгийг холбогдох өргөдлийг бүх (ямар ч) тохиолдолд зөвшөөрөхийг хэлэх бөгөөд тэр нь 2(а)-д заасан шаардлагад нийцсэн байвал зохино: ... Импортын шууд лиценз олгох журмыг шууд лиценз олговол зохих импортын барааг хязгаарлах байдлаар хэрэгжүүлж болохгүй.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)
“Шууд бус лиценз олгох“ гэдгийг үз.

AUTOMATICITY

In disputes, the “automatic” chronological progression for settling trade disputes in regard to panel establishment, terms of reference, composition and adoption procedures

АВТОМАТ БИЧИГЛЭЛ

Маргаан шийдэх тохиолдолд шүүх байгуулах, ажлын удирдамж батлах, бүрэлдэхүүнийг сонгож, батлах журамтай холбогдуулан худалдааны маргааныг шийдвэрлэх зорилгоор ашигладаг он дараалсан “автомат” бичиглэл.

AVERAGE ADJUSTER

When used in relationship to marine insurance, the term means a person who investigates and apportions general average losses on behalf of ship owners.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОСЛООС ҮҮДЭЛТЭЙ ХОХИРЛЫГ ТОГТООГЧ (ДИСПАШЕР)

Далайн тээврийн даатгалтай холбогдуулан ашигладаг энэ нэр томьёогоор усан онгоцны эзний нэрийн өмнөөс ослыг шалгаж, ослоос үүдэлтэй ерөнхий хохирлыг хуваарилдаг этгээдийг илэрхийлдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

B

BAGGAGE

Personal property of passengers or crew carried on an aircraft

АЧАА ТЭЭШ (ТЭЭШ)

Нисэх онгоцоор тээвэрлэж буй зорчигчийн, эсхүл багийн гишүүдийн хувийн эд хөрөнгө.

BALANCE OF PAYMENTS BASIS

Trade data conforming with national income accounting methods (the value of trade in goods and services changing hands between residents and non-residents sometimes without crossing borders); the figures for goods trade are derived and adjusted from customs data (the value of goods trade crossing borders)

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН СУУРЬ

Үндэсний орлогын бүртгэлийн аргачлалд нийцсэн худалдааны мэдээлэл (оршин суугч болон оршин суугч бус хүмүүсийн хооронд заримдаа хил нэвтрэлгүйгээр гараар гарт шилжиж буй бараа болон үйлчилгээний үнэ); барааны худалдааны тоон үзүүлэлтийг гаалийн мэдээллээс гарган авч, залруулга хийдэг (хил дамнасан худалдааны барааны үнэ).

BANK DRAFT

An order issued by a seller against a purchaser; directs payment, usually through an intermediary bank. Typical bank drafts are negotiable instruments and are similar in many ways to cheques drawn on bank accounts.

БАНКНЫ ЧЕК

Худалдагчаас худалдан авагчийн нэр дээр бичсэн ордер; ерөнхийдөө зуучлагч банкаар дамжуулан хийдэг шууд төлбөр. Банкны ердийн чек нь төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) бөгөөд банкны дансны (тооцооны) чектэй олон талаараа төстэй байдаг.

BANK FOR FOREIGN TRADE

Special credit institution (commercial bank), which provides loans to import and export, to export credit insurance and to conduct mutual trade settlements.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГАДААД ХУДАЛДААГ ДЭМЖИГЧ БАНК

Импорт, экспортын үйл ажиллагаа эрхлэх, экспортын зээлийн даатгал хийлгэх, талуудын хоорондын худалдааны төлбөр тооцоог барагдуулахад зээл олгодог зээлийн тусгай байгууллага (арилжааны банк).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BANK GUARANTEE

Guarantee issued by a bank to a carrier to be used in lieu of lost or misplaced original negotiable bill of lading.

БАНКНЫ БАТАЛГАА

Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн баримтын эх хувь алдагдсан буюу гэзгдсэн тохиолдолд түүнийг орлуулан банкнаас тээвэрлэгчид олгосон баталгаа.

BARCODE; BAR CODE

A series of bars and spaces encoded to correspond to alphanumeric characters. Barcodes are designed to be read by scanners and converted into data.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЗУРААСАН КОД

Үсэг ба тоон тэмдэгтүүдэд тохируулан кодолсон эгнээ зураас ба зай. Зураасан кодыг сканнераар уншуулж, мэдээлэл болгон хувиргадаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BASEL CONVENTION

A multilateral environmental agreement dealing with hazardous waste. The Basel Convention on the Control of Transboundary Movements of Hazardous Wastes and Their Disposal.

БАЗЕЛИЙН КОНВЕНЦ

Аюултай хог хаягдалд хяналт тавих тухай, байгаль орчныг хамгаалах олон талт хэлэлцээр. Аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн Конвенц.

BERNE CONVENTION

A treaty, administered by WIPO, for the protection of the rights of authors in their literary and artistic works. The Berne Convention for the Protection of Literary and Artistic Works.

БЕРНИЙН КОНВЕНЦ

Утга зохиол болон уран сайхны бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалах зорилгоор Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас хяналт тавин хэрэгжүүлж буй гэрээ. Утга зохиол болон уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц.

BIG DATA

Sets of information to ensure that smarter decisions are taken. Some Customs administrations have already embarked on big data initiatives, leveraging the power of analytics, ensuring the quality of data (regarding cargos, shipments and conveyances), and widening the scope of data they could use for analytical purposes.
Note: WCO Research paper No. 39: Implications of Big Data for Customs How It Can Support Risk Management Capabilities , 2017

ИХ ӨГӨГДӨЛ

Илүү ухаалаг шийдвэр гаргах явдлыг хангах зорилготой мэдээллийн багц. Гаалийн зарим байгууллага, логик анализийн аргын хүчийг ашиглах, (ачаа, ачилт (тээвэрлэлт) болон тээврийн хэрэгсэлтэй холбогдсон) өгөгдлийн чанарыг хангах, дүн шинжилгээ хийхэд ашиглаж болох өгөгдлийн цар хүрээг өргөжүүлэх замаар их өгөгдлийн санаачлага гаргаж эхлээд байна.
Жич: ДХБ-ын судалгааны ажил № 39: Их өгөгдлийн гаалийн байгууллагад үзүүлэх нөлөө: Энэ нь эрсдэлийн менежментийн чадавхыг хэрхэн дэмжиж чадах вэ?, 2017 он

BILL OF EXCHANGE

An unconditional order in writing from one person (the drawer) to another (the drawee), directing the drawee to pay a specified amount to a named drawer at a fixed or determinable future date.

ВЕКСЕЛЬ (ТРАТТА)

Нэг этгээд (вексель бичигч)-ээс нөгөө этгээд (төлбөр хариуцагч)-д хандан тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд, эсхүл дараа нь тогтоож болох хугацаанд нэр заасан вексель эзэмшигч (вексель бичигч)-д төлөхийг төлбөр хариуцагчид даалгаж бичгээр үйлдсэн, ямар нэгэн болзол нөхцөлгүй ордер.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BILL OF LADING (B/L)

Abbreviation for Bill of Lading; a document issued by a carrier, or its agent, to the shipper as a contract of carriage of goods. It is also a receipt for cargo accepted for transportation, and must be presented for taking delivery at the destination.

ТЭЭВРИЙН БАРИМТ (B/L ГЭЖ ТОВЧИЛДОГ)

Тээврийн баримт (коносамент) гэдэг нь тээврийн бичиг баримт гэсэн англи үгийн товчлол юм; тээвэрлэгч буюу түүний төлөөлөгчөөс ачаа бэлтгэгч (ачигч компани)-д бараа тээвэрлэх гэрээ болгон олгосон бичиг баримт. Энэ нь бас ачааг тээвэрлэхээр хүлээн авсан баримт болох бөгөөд түүнийг ачаа хүргэсэн газарт ачаагаа авахад үзүүлэх ёстой.

BINDING, BOUND

See ‘Tariff binding’.

ҮҮРЭГ АМЛАЛТ АВСАН

“Тарифын үүрэг амлалт” гэдгийг үз.

BIOLOGICAL DIVERSITY

Variability among living organisms from all sources including, inter alia, terrestrial, marine and other aquatic ecosystems and the ecological complexes of which they are part: this includes diversity within species, between species and of ecosystems.

Convention on Biological Diversity (Biodiversity Convention)

БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ (ОЛОН ЯНЗ БАЙДАЛ)

Хуурай газар, далай тэнгисийн болон бусад усны экосистемүүд, экологийн цогцолборууд, өөр бусад бүхий л эх үүсвэрүүдийн амьд организмын төрлүүд юм. Энэ ойлголт нь зүйлийн хүрээнд дэх төрөл зүйлүүд ба экосистемийн хоорондын төрөл зүйлийг өөртөө агуулна.

Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

Biological resources

Genetic resources, organisms or parts thereof, populations, or any other biotic component of ecosystems with actual or potential use or value for humanity.

Convention on Biological Diversity (Biodiversity Convention)

БИОЛОГИЙН НӨӨЦ

Генетикийн нөөц, организм эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэг, бүлгэмдэл (популяцууд), хүн төрөлхтөнд бодит болон боломжит ашиг, үнэ цэнэ бүхий экосистемийн бусад бүх бүрэлдэхүүн хэсгийг багтаана.

Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

BIOTECHNOLOGY

Any technological application that uses biological systems, living organisms, or derivatives thereof, to make or modify products or processes for specific use.

Convention on Biological Diversity (Biodiversity Convention)

БИОТЕХНОЛОГИ

Тодорхой зориулалтаар ашиглах бүтээгдэхүүн гаргаж авах эсхүл сайжруулах, түүнийг гаргаж авах үйл явцыг өөрчлөхөд биологийн тогтолцоо, организм тэдгээрийн бүтээгдэхүүнийг ашиглахтай холбогдсон технологийн аливаа төрөл.

Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

BIT
bilateral investment treaties

BIT
Хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээнүүд

BLOCKCHAIN
Also known as Distributed Ledger Technology (DLT), blockchain is a technology that has the potential to deliver significant improvements and automation in trust that underlies almost every action and data exchange in international trade.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БЛОКЧЭЙН
Түүнийг бас тархмал дасны технологи гэдэг. Блокчейн нь нэн чухал дэвшилт өөрчлөлтүүд хийх боломжтой технологи, мөн олон улсын худалдаан дахь бараг бүх үйл хөдлөл болон мэдээлэл солилцооны үндэс болсон итгэл найдвартай автоамтжуулалт юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BLUE BOX
Amber Box type of support provided under government programmes that aim to limit production and reduce distortion. Currently, Blue Box support is not subject to any limitation other than adherence to the criteria set out in Art. 6.5 of the Agreement on Agriculture

ХӨХ ХАЙРЦАГ
Үйлдвэрлэлийг хязгаарлах болон (худалдааны) хазайлт (гажилт)-ыг багасгах зорилгоор төр засгаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд үзүүлж буй, хув шар (шар, шаргал) хайрцаг маягийн дэмжлэг (татаас). Одоогийн байдлаар хөх хайрцагт багтах дэмжлэг (татаас) нь хэрэв Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 5-д заасан шалгуурыг хангаж байвал түүнд ямар нэгэн хязгаарлалт тавихгүй байгаа.

BOARDING AND SEARCH OF MEANS OF TRANSPORT
The operations under which means of transport are visited by the
Customs for:
(a) collection of information from the person responsible for the means of transport and examination of commercial, transport or other documents concerning the means of transport, the cargo, stores, crew and passengers; and

(b) inspection, examination and search of the means of transport.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ОРОХ, НЭГЖЛЭГ ХИЙХ
Гаалийн байгууллага (гаалийн байцаагч) дараах зорилгоор тээврийн хэрэгсэлд орох ажиллагаа:
(a) тээврийн хэрэгслийг хариуцагч этгээдээс мэдээлэл авах, түүнчлэн тухайн тээврийн хэрэгсэл, түүний ачаа, тэнд байгаа олон улсын тээврийн үйлчилгээний бараа, багийн гишүүд болон зорчигчтой холбоотой худалдааны, тээврийн, эсхүл өөр бусад бичиг баримт шалгах; мөн
(b) тухайн тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт, нэгжлэг хийх.

BOGIE EXCHANGE STATION; TRANSFER STATION
Station for changing wheeled carriages of wagons (with a difference in the width of the same gauge).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ВАГОНЫ ДУГУЙ СОЛИХ ӨРТӨӨ (ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ӨРӨӨ)
(Царигийн өргөн зөрөөтэй байх тохиолдолд) вагоны дугуй солих өртөө
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BOND

- An undertaking in due legal form, by which a person binds himself to the Customs to do or not to do some specified act.

- A debt security. In Customs terms, a bond is the dept security put in place by a trader in order to utilize a specific Customs facilitation procedure that suspends the payment of duties and/or taxes, such as a transit procedure, a bonded warehouse, processing, etc. (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary , 2019)

БОНД (ӨРИЙН БИЧИГ, ОБЛИГАЦ, ӨР ТӨЛӨХ БАТАЛГАА)

- Аливаа нэг этгээд зарим тодорхой зүйл хийхээр, эсхүл эс үйлдэхээр хууль тогтоомжид заасан хэлбэрээр гаалийн байгууллагын өмнө амлалт авах үйлдэл.

- Өр төлөх баталгаа. Гаалийн утгаар, бонд гэдэг нь худалдаа эрхлэгч дамжин өнгөрөх горим, баталгаат агуулахын горим, боловсруулах горим, г.м. гаалийн болон/эсхүл бусад татвар төлөх үүргийг хойшлуулж өгдөг гаалийн хөнгөвчилсөн тусгай горим ашиглах зорилгоор гаргаж өгсөн өр төлөх баталгаа юм. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, 2019 он)

BONDED CARGO

Cargo for which duties and taxes have not yet been settled, and which can therefore not yet be freely sold within the economy; a bond will almost always have been put in place in order to guarantee the unpaid duties and taxes.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАТАЛГААТ АЧАА

Гаалийн болон бусад татварыг нь бүрэн төлөөгүй бөгөөд үүний улмаас тухайн улсад чөлөөтэй худалдаж болохгүй ачаа; Төлөгдөөгүй гаалийн болон бусад татварыг нь төлөх баталгаа болгож бараг бүх тохиолдолд бонд (өр төлөх баталгаа) гаргаж өгсөн байдаг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BONDED GOODS

Goods stored in a warehouse (operated or approved by Customs),
without the payment of duty until that duty is paid or the goods are exported or otherwise legally dealt with.

Goods, for which duties and taxes have not yet been settled, and which can therefore not yet be freely sold within the economy; a bond will almost always have been put in place in order to guarantee the unpaid duties and taxes.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАТАЛГААТ АГУУЛАХЫН БАРАА

(Гаалийн байгууллагын, эсхүл гаалийн байгууллагаас зөвшөөрөл олгосон) агуулахад, гаалийн татвар төлөгдөж дуустал, эсхүл барааг экспортоор гаргах хүртэл, эсхүл хууль дүрмийн шийдэгдэх хүртэл гаалийн татваргүй хадгалж байгаа бараа.

Гаалийн болон бусад татварыг нь бүрэн төлөөгүй бөгөөд үүний улмаас тухайн улсад чөлөөтэй худалдаж болохгүй бараа; Төлөгдөөгүй гаалийн болон бусад татварыг нь төлөх баталгаа болгож бараг бүх тохиолдолд бонд (өр төлөх баталгаа) гаргаж өгсөн байдаг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BONDED WAREHOUSE

A warehouse authorized by Customs authorities for storage of goods on which payment of duties is deferred until the goods are removed.

БАТАЛГААТ АГУУЛАХ

Холбогдох барааг агуулахаас гаргах хүртэл гаалийн татварын төлбөрийг нь хойшлуулсан бараа хадгалахыг гаалийн байгууллагаас зөвшөөрсөн агуулах.

BOOKING CONFIRMATION

Document issued by a carrier to confirm that space has been reserved for a consignment on a means of transport.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЗАХИАЛГА БАТАЛГААЖУУЛАХ

Ямар нэг тээврийн хэрэгсэлд ачаа ачих байр талбайг баталгаажуулж, тээвэрлэгчээс үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BOOKING REFERENCE

Reference number assigned by a carrier or its agent to identify a specific consignment number when cargo space is reserved prior to loading.

Note: Trade facilitaion implementation guide, 2012

ЗАХИАЛГЫН ДУГААР

Ачаа ачих байр талбайг ачаа ачихаас өмнө бэлдэж нөөцөлсөн бол тодорхой нэг ачааг ялган таних зорилгоор тээвэрлэгчээс, эсхүл түүний төлөөлөгчөөс олгосон дугаар.
Жич: Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх хөтөч, 2012 он

BOOKING REQUEST

Document issued by a supplier to a carrier requesting space to be reserved for a specified consignment, indicating desirable conveyance, dispatch time, etc.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЗАХИАЛГА ӨГӨХ ХҮСЭЛТ

Бараа нийлүүлэгчээс тээвэрлэгчид хандан, хүссэн тээврийн хэрэгсэл, илгээх цаг хугацаа, г.м.-ийг зааж, тодорхой ачаа ачих байр талбай бэлдэх өгөхийг хүсч үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BORDER AGENCY COOPERATION

Governmental agencies and executive bodies need to offer a public service that is effective, transparent and customer friendly. To achieve this, they have to cooperate to implement more efficient controls and offer simplified procedures. Border Agency Cooperation is one of the key commitments (Article 8) included in the WTO Agreement on Trade Facilitation. Border agencies can achieve cooperation through the coordination of their respective mandates, policies and procedures.

ХИЛИЙН (ХЯНАЛТЫН) БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрийн байгууллагууд болон гүйцэтгэх байгууллагууд үр дүнтэй, ил тод, үйлчлүүлэгчдэд ээлтэй төрийн үйлчилгээг хүргэх шаардлагатай байдаг. Энэ үүднээс тэд илүү үр ашигтай хяналтыг хэрэгжүүлэх, хялбарчилсан журмыг нэвтрүүлэх зорилгоор хамтран ажиллах ёстой. Хилийн (хяналтын) байгууллагууд хоорондоо хамтран ажиллах нь Худалдааг хөнгөвчлөх тухай ДХБ-ын хэлэлцээрт тусгагдсан үндсэн үүргүүд (8 дугаар зүйл)-ийн нэг юм. Хилийн (хяналтын) байгууллагууд өөрсдийн эрх, мэдэл, бодлого, журмаа уялдуулан зохицуулах замаар хамтран ажиллана.

BORDER CONTROL

International system for admission of goods to national territory. Border control includes: Customs, health, veterinary, phytosanitary controls, as well as compliance with technical standards and quality control.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХИЛИЙН ХЯНАЛТ

Барааг үндэсний нутаг дэвсгэрт оруулах олон улсын систем. Хилийн хяналт нь дараах зүйлийг багтаана: гаалийн, эрүүл мэндийн, мал эмнэлгийн, ургамлын хорио цээрийн хяналтууд, мөн түүнчлэн техникийн стандарт болон чанарын хяналт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BORDER PROTECTION

Encompasses any measure which acts to restrain imports at point of entry

ХИЛ ХАМГААЛАХ

Орох цэг дээр импортыг хязгаарлах аливаа арга хэмжээ багтана.

BORDER TRADE

A type of international trade carried out to meet local needs for goods and services, in goods produced within a limited distance from the State border. Cross-border trade is usually conducted on the basis of international agreements on benefits in trade and payments. GATT 1994 (Article XXIV, paragraph 3a) allows WTO member countries to establish a special preferential Customs regime for border trade affecting residents of areas near the border.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ХИЛИЙН ХУДАЛДАА

Улсын хилээс холгүй хязгаарлагдмал зайнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр орон нутгийн бараа, үйлчилгээний хэрэгцээг хангах зорилгоор эрхэлдэг олон улсын худалдааны нэг төрөл. Хил дамнасан худалдаа нь гол төлөв олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу, худалдаа, төлбөрийн ашгийн үндсэн дээр явагддаг. 1994 оны ТХЕХ (XXIV зүйлийн 3а заалт) нь ДХБ-ын гишүүн орнууд хил орчмын бүсийн оршин суугчдад нэмэртэй хилийн худалдаанд зориулсан хөнгөлөлттэй гаалийн тусгай дэглэм бий болгохыг зөвшөөрдөг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BORDEREAU

Document used in road transport, listing the cargo carried on a road vehicle, often referring to appended copies of the road consignment note.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БОРДЕРО

Авто замын тээвэрт ашигладаг бичиг баримт. Түүнд авто замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж яваа ачааг жагсаан бичсэн байдаг. Түүнийг гол төлөв авто замын ачааны дагалдах хуудсын хавсралт хуулбар гэдэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BTA

Border tax adjustment (a short name for a destination-based cash flow tax (DBCFT). It is a value-added tax on imported goods and is also referred to as a border-adjusted tax, destination tax or border tax adjustment). The border adjustment tax (BAT) levies a tax depending on where a good is consumed rather than where it is produced. For example, if a corporation ships tires to Mexico where they will be used to make cars, the profit the tire company makes on the tires it exports is not taxed. However, if a U.S. car company purchases tires from Mexico for use in cars made in the United States, the money the company makes on the cars (including the tires) sold in the United States is taxed. In addition, the company cannot deduct the cost of the imported tires as a business expense. The concept was first introduced by 1997 by economist Alan J. Auerbach, who believed that the tax system would be in line with business goals and the national interest.

BTA

Хилийн ашгийн (гүйлгээний) татвар (“Бараа хүлээн авагч газрын мөнгөний урсгалын татвар” гэдэг татварын товч нэр). Энэ нь импортын барааND ногдуулдаг нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ-ын нэг төрөл) бөгөөд түүнийг англиар “border-adjusted tax”, “destination tax” or “border tax adjustment” гэж янз бүрээр нэрлэдэг. Энэ татварыг аливаа нэг барааг хаана үйлдвэрлэсэн бэ гэдэг үүднээс биш, хаана хэрэглэх гэж байгаа вэ гэдэг үүднээс харж ногдуулдаг. Жишээлбэл, хэрэв ямар нэг компани (АНУ-аас) Мексик рүү дугуй гаргаж, тэнд машин үйлдвэрлэхэд ашигладаг бол уг компанийн дугуй зарсан ашгаас татвар авахгүй. Гэвч хэрэв АНУ-ын машин үйлдвэрлэгч компани Мексикээс дугуй худалдан авч, АНУ-д машин үйлдвэрлэхэд ашигладаг бол уг компанийн АНУ-д борлуулсан машин (дугуй)-ы ашгаас татвар авна. Түүнээс гадна уг компани импортын дугуйны зардлыг бизнесийн зардал гэж үзэж хасч болохгүй. Энэ санааг анх Alan J. Auerbach 1997 онд гаргасан байдаг. Түүний үзэж байгаагаар татварын систем нь бизнесийн зорилго болон үндэсний эрх ашигт нийцсэн байх ёстой.

BOTTOM UP

Drawing on members’ (evolving) positions.

(Top-down and bottom-up approaches are methods used for WTO negotiations, etc. These methods can be possible approaches for a wide range of endeavors such as goal setting, budgeting, and forecasting. The top-down approach goes from the general to the specific, and the bottom-up approach begins at the specific and moves to the general. Some RTAs use either a positive-list (‘bottom up’) or negative-list (‘top down’) scheduling approach. Others contain elements of both approaches.)

ЭЕРЭГ ЖАГСААЛТ ГАРГАХ

Гишүүдийн (хувьсан өөрчлөгдөж буй) байр суурийг харах.

(Эерэг болон сөрөг жагсаалт гаргах аргыг ДХБ-ын хэлэлцээний үеэр, г.м. олон тохиолдолд хэрэглэдэг. Эдгээр аргыг зорилго тавих, төсөв зохиох, прогноз гаргах г.м. санасандаа хүрэх янз бүрийн зорилгоор ашиглаж болно. Сөрөг жагсаалт (top down) гаргах нь ерөнхийгөөс тусгай руу, эерэг жагсаалт (bottom up) гаргах нь тусгайгаас эхэлж, ерөнхий рүү чиглэсэн байдаг. Бүс нутгийн худалдааны зарим хэлэлцээр байгуулахад эерэг (bottom up), эсхүл сөрөг (top down) жагсаалт ашигласан байдаг. Зарим хэлэлцээрт аль алиныг нь ашигласан байдаг.)

BOXES

Categories of domestic support.
Green box is a category of domestic support considered to have no, or at most minimal, trade and production distorting effect. Blue box is support provided with the aim of limiting production. Amber box is support considered to distort trade and is therefore subject to limits and reduction commitments.

ХАЙРЦГУУД

Дотоодын дэмжлэг (татаас)-ийн категори буюу түүнийг ангилсан хайрцгууд. Ногоон хайрцаг нь худалдаа болон үйлдвэрлэлийн хазайлт (гажилт) үүсгэх нөлөөгүй, эсхүл хамгийн бага хэмжээний нөлөөтэй гэж үздэг дотоодын дэмжлэг (татаас)-ийн нэг категори юм. Хөх хайрцаг нь үйлдвэрлэлийг хязгаарлах зорилгоор үзүүлдэг дэмжлэг (татаас) юм. Хув шар (шар, шаргал) хайрцаг гэдэг нь худалдааны хазайлт (гажилт) үүсгэдэг гэж үздэг бөгөөд тиймээс хязгаарлах, бууруулах үүрэг амлалт авбал зохих дэмжлэг (татаас) болдог.

BRACKETED

In official drafts, square brackets indicate text that has not been agreed and is still under discussion

ДӨРВӨЛЖИН ХААЛТАНД ХИЙСЭН

Албан ёсны баримт бичгийн төслийн хувьд, дөрвөлжин хаалт нь эцэслэн тохиролцоогүй бөгөөд хэлэлцэж дуусаагүй байгаа текстийг заана.

BREAKBULK CARGO

Packaged but non-containerized cargo. Loose cement, grains, ores, etc., are termed bulk cargo, whereas cargo shipped as a unit (bags, bales, barrels, boxes, cartons, drums, pallets, sacks, vehicles, etc.) is termed break bulk.

ЖИЖИГЛЭН САВЛАСАН ЗАДГАЙ АЧАА

Жижиглэн савласан хэдий ч чингэлэгт хийгээгүй ачаа. Задгай цемент, үр тариа, хүдэр гэх мэтийг задгай ачаа гэдэг. Харин нэг нэгж (уут, боодол (бухал), торх, модон болон картонон хайрцаг, цилиндр сав (бойшиг, бетон, хувин), тавиур, шуудай, тээврийн хэрэгсэл, гэх мэт) болгон савлаж тээвэрлэж буй ачааг жижиглэн савласан задгай ачаа гэж нэрлэдэг.

BSE

Bovine spongiform encephalopathy, or “mad cow disease”

BSE

Үхрийн сээр нурууны энцефалопати (эмгэг, тархины гажиг) буюу үхрийн галзуу өвчин (галзуу үхрийн өвчин)

BUDGETARY EFFICIENCY OF IMPORT

The ratio of the value of the imported goods sold to the domestic customer to its import value (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ИМПОРТЫН БАРААНЫ ТӨСВИЙН ҮР АШИГ

Дотоодын хэрэглэгч нарт борлуулсан импортын барааны өртгийг уг барааг импортлох өртөгтэй харьцуулсан харьцаа.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BULK CARGO

Loose, unpackaged, non-containerized cargo (such as cement, grains, coal, ores, etc.) carried in a ship's hold, and loaded and discharged through hatchways.

ЗАДГАЙ АЧАА

Усан онгоцны ачааны хонгилд тээвэрлэдэг бөгөөд түүний нүхээр ачиж, буулгадаг савлаагүй, чингэлэгт хийгээгүй ачаа (цемент, үр тариа, нүүрс, хүдэр гэх мэт).

BUSINESS DATA EXCHANGE

A collection of information used within a particular business process, structured in such a way that it covers the business data exchange needs. These structures can be a complete business document, such as an invoice or a mini document (snippet) as a result of a query e.g. on master data.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БИЗНЕСИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

Тодорхой нэг бизнес процессын хүрээнд ашигладаг мэдээлэл цуглуулах. Энэ мэдээлэл нь бизнесийн мэдээлэл солилцох хэрэгцээ шаардлагыг хангасан байдлаар бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй) байна. Энэ бүтэц нь үнийн нэхэмжлэх зэрэг бизнесийн бүрэн төгс бичиг баримт хэлбэртэй, эсхүл жишээлбэл, үндсэн өгөдлийн талаар лавласан ажлын үр дүн болох бичил бичиг баримт (фрагмент, өчүүхэн нэг хэсэг) хэлбэртэй байж болно.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BUSINESS PROCESS

Structured, measured set of activities designed to produce a specific output for a particular customer or market. It implies a strong emphasis on how work.

Note: Trade facilitaion implementation guide, 2012

БИЗНЕС ПРОЦЕСС

Тодорхой нэг үйлчлүүлэгч, эсхүл тодорхой нэг зах зээлд зориулж тодорхой нэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй), хэмжигдэхүйц цогц үйл ажиллагаа. Энэ нь цаанаа хэрхэн ажиллах вэ гэдэг дээр анхаардаг.

Жич: Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх хөтөч, 2012 он

BUY-SHIP-PAY MODEL

The Buy-Ship-Pay model, developed by UN/CEFACT, describes the main processes and parties in the international supply chain. The supply chain ensures that goods are ordered, shipped and paid for while complying with regulatory requirements. The Buy-Ship Pay model identifies the key commercial, logistical, regulatory and payment procedures involved in the international supply chain and provides an overview of the information exchanged between the parties throughout its various steps. The model was formally developed according to the UN/CEFACT Modelling Methodology (UMM) using Enterprise Architect software.

ХУДАЛДАН АВАХ-АЧУУЛАХ (ТЭЭВЭРЛЭХ)-ТӨЛӨХ ЗАГВАР

НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвөөс боловсруулсан "Худалдан авах-Ачуулах (Тээвэрлэх)-Төлөх загвар" нь олон улсын худалдааны үндсэн процессууд болон талуудыг дүрслэн харуулдаг. Бараа нийлүүлэх сүлжээ нь дүрэм журмын шаардлагын дагуу бараа захиалах, ачуулах (тээвэрлэх), төлбөр үйлдэх (гүйцэтгэх) нөхцөлийг бүрдүүлдэг. "Худалдан авах-Ачуулах (Тээвэрлэх)-Төлөх загвар" нь бараа нийлүүлэх олон улсын сүлжээнд хамаарах арилжааны, ложистикийн, хэм хэмжээ тогтоосон болон төлбөр үйлдэх үндсэн горим журмуудыг тодорхойлж, холбогдох талуудын хооронд

солилцох мэдээллийг алхам бүрээр тоймлон хүргэдэг. Энэ загварыг анх НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Загвар гаргах аргачлалын дагуу, Байгууллагын архитектурын (бүтцийн) програм хангамж ашиглан албан ёсоор боловсруулж байсан.

Note: Trade facilitaion implementation guide, 2012

Жич: Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх хөтөч, 2012 он

BUY-SHIP-PAY REFERENCE DATA MODELS (BSP RDM)

ХУДАЛДАН АВАХ-АЧУУЛАХ (ТЭЭВЭРЛЭХ)-ТӨЛӨХ ҮЛГЭРЧИЛСЭН ДАТА МОДЕЛЬ (ҮЛГЭРЧИЛСЭН ӨГӨГДЛИЙН ЗАГВАР)

RDMs, as outlined by the UN/ CEFACT White Paper on RDM from April 2017, are complete and focused subsets specific to the needs of a particular domain. The context messages are then subsets of the RDMs.

Үлгэрчилсэн дата модель (Үлгэрчилсэн өгөгдлийн загвар) нь Үлгэрчилсэн дата модель (Үлгэрчилсэн өгөгдлийн загвар)-ийн тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн 2017 оны 4 дүгээр сарын Цагаан хуудаст зааснаар, тодорхой нэг домэйн (худалдан авах, эсхүл ачуулах (тээвэрлэх), эсхүл төлбөр гүйцэтгэх процесс)-ийн хэрэгцээ шаардлагад тохирсон бүрэн гүйцэд бөгөөд овоо хараанд туссан дэд функууд юм. Хамрагдах мессежүүд нь тухайн үеийн Үлгэрчилсэн дата модель (Үлгэрчилсэн өгөгдлийн загвар)-ийн дэд функцүүд болно.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BUYER

ХУДАЛДАН АВАГЧ

A party who makes a purchase. An entity or a person stipulated as the party to which merchandise or services are sold

Note: The United Nations Trade Data Element Directory (*UNTDED*)

Бараа, үйлчилгээ худалдан авч буй этгээд. Бараа, үйлчилгээ борлогдсон тал гэж заасан аливаа аж ахуйн нэгж буюу этгээд.

Жич: НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах

BUYER'S CREDIT

ХУДАЛДАН АВАГЧИЙН КРЕДИТ

A financial arrangement in which a bank or financial institution, or an export credit agency in the exporting country, extends a loan directly to a foreign buyer or to a bank in the importing country to pay for the purchase of goods and services from the exporting country. Buyer's credit covers up to 80-85% of the contract price and is accompanied by a banking and insurance guarantee.

Экспортлогч улс дахь банк, санхүүгийн байгууллага буюу экспортын зээлийн агентлаг нь экспортлогч орноос бараа, үйлчилгээ худалдан авах төлбөрийг гүйцэтгэх зорилгоор гадаадын худалдан авагчид, эсхүл импортлогч улсад байгаа банкинд шууд зээл маягаар шилжүүлдэг санхүүгийн зохицуулалт. Худалдан авагчийн кредит нь гэрээний үнийн дүнгийн 80-85%-ийг хамардаг бөгөөд түүнийг банк, даатгалын байгууллагын баталгаа дагалддаг.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

BUYING AGENT

An agent who purchases goods in his or her own country on behalf of foreign importers such as government agencies and large private concerns.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДАН АВАГЧИЙН АГЕНТ

Төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн томоохон компаниуд зэрэг гадаадын импортлогчдын нэрийн өмнөөс өөрийн суугаа орондоо бараа бүтээгдэхүүн худалдаж авдаг төлөөлөгч.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

C

CABOTAGE (AIR)

Cargo carried on what is essentially a domestic flight and therefore not subject to international agreements that fix set rates.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

КАБОТАЖ (АГААРЫН)

Үндсэндээ дотоодын нислэгээр тээвэрлэдэг ачаа. Тэгэхээр энэ нь тарифын хувь хэмжээ тогтоодог олон улсын гэрээ хэлэлцээрт хамаарахгүй.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CAPACITY-BUILDING

Activities which strengthen the knowledge, abilities, skills and behavior of individuals and improve institutional structures and processes such that the beneficiary organization can efficiently meet its mission and goals in a sustainable way.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Хувь хүний мэдлэг, чадвар, ур чадвар, зан төлөвийг бэхжүүлэх, мөн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, түүнчлэн ашиг хүртэгч байгууллага нь эрхэм зорилго болон зорилтуудаа тогтвортой биелүүлэх боломжийг хангасан процес.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CAPACITY LOAD; MAXIMUM LOAD

Maximum load imposed for transport purposes under applicable regulations (The United Nations Trade Data Element Directory (*UNTDED*))

ДААЦ; ДААЦЫН ДЭЭД ХЭМЖЭЭ

Бараа тээвэрлэх зорилгоор холбогдох дүрэм журмын дагуу тогтоосон даацын дээд хэмжээ. (НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

CARGO

Merchandise/commodities/freight carried by means of transportation.

АЧАА

Тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй бараа/таваар/ачаа.

CARGO COMMUNITY SYSTEM

An information technology platform linked to the freight flows (import/export /transit) of any kind of cargo passing through an identified port, airport, or multimodal site(s) at a local or national level. A CCS is open to all parties involved in cargo freight and logistics including Customs administrations. It handles a database in which information is collected, processed, stored and exchanged, and aims to enhance freight optimization, trade safety and security, cargo tracking and tracing, and facilitate customs and administrative procedures.

АЧАА ТЭЭВРИЙН САЛБАРЫН СИСТЕМ

Орон нутгийн буюу үндэсний түвшинд, танигдсан боомт, нисэх онгоцны буудал, эсхүл тээврийн олон төрөл хосолсон өртөөгөөр дамжин нэвтрэх аливаа төрлийн ачааны ачаа тээврийн урсгал (импорт/экспорт/дамжин өнгөрөх)-д холбогдсон мэдээллийн технологийн платформ. Ачаа тээврийн салбарын систем нь ачаа тээвэр, ложистикийн үйл ажиллагаанд оролцогч бүх тал, түүний дотор гаалийн байгууллагад нээлттэй байдаг. Энэ нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, солилцох дата баазтай бөгөөд цаашлаад тээврийн

оновчтой зохицуулалт, худалдааны бүрэн бүтэн болоод аюулгүй байдал, ачааны хөдөлгөөний трэкинг болон трэйсинг системийг сайжруулах, улмаар гаалийн болон захиргааны байгууллагын горим журмыг хөнгөвчлөх зорилготой болно.

Note: UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms

(Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт)

CARGO DECLARATION

Information submitted prior to or on arrival or departure of a means of transport for commercial use that provides the particulars required by the Customs relating to cargo brought to or removed from the Customs territory.

АЧААНЫ МЭДҮҮЛЭГ

Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэл ирэх буюу явахаас өмнө, эсхүл ирэх буюу явах үед гаргаж өгсөн, гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах ачаанд холбогдох, гаалийн байгууллагад шаардлагатай зүйлийг агуулсан мэдээлэл.

Notes:

1. The nature and contents of Cargo declarations may vary from country to country ac cording to the commercial means of transport used. The particulars of the cargo (freight) may include kind, number, marks and numbers of packages, brief description of the goods, gross weight, etc. In some countries, these particulars may be submitted by electronic means.

2. Cargo declarations are often referred to as “manifests”; in some countries Aircraft cargo manifests, Ship’s manifests or Goods manifests are accepted in place of the Cargo declarations. Cargo declarations are also sometimes referred to as freight declarations.

3. The Annex to the Convention on Facilitation of International Maritime Traffic, London, 1965, provides for a Cargo declaration (Model Form IMO FAL Form 2). With regard to air transport, the corresponding declaration is called Cargo manifest (Model Form as on International Civil Aviation, Chicago, 1944)

Жич:

1. Ачааны мэдүүлгийн мөн чанар, агуулга нь худалдааны ямар тээврийн хэрэгсэл ашигласнаас хамаарч улс орнуудад өөр өөр байж болно. Ачаа (бараа)-ны тухай мэдээлэлд барааны нэр төрөл, тоо, баглаа боодлын тэмдэглэгээ, тоо ширхэг, тухайн барааны товч тодорхойлолт, бохир жин зэрэг мэдээлэл багтана. Зарим Улсад эдгээр мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлж болдог.

2. Ачааны мэдүүлгийг ихэвчлэн “манифест” гэдэг; зарим улсад ачааны мэдүүлгийн оронд нисэх онгоцны ачааны манифест, усан онгоцны манифест буюу барааны манифестыг хүлээн зөвшөөрдөг.

3. 1965 онд Лондон хотноо батлагдсан Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенцийн хавсралтад ачааны мэдүүлэг (Олон улсын далайн тээврийн байгууллагын Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц (IMCO FAL)-ийн загвар маягт 2)-ийн талаар заасан. Агаарын тээврийн хувьд дээрх мэдүүлгийг ачааны манифест хэмээн нэрлэдэг (1944 оны Олон улсын иргэний агаарын тээврийн тухай Чикагогийн конвенцийн 9 дүгээр хавсралтын 3 дахь зүүлтэд заасан Загвар маягт).

4. Goods declarations may subsequently be presented in respect of the individual consignments covered by the Cargo declarations.

4. Ачааны мэдүүлэгт заасан ачаа тус бүрээр дараа нь Барааны мэдүүлэг бичиж болно.

5. Cargo declaration is defined in Specific Annex A, Chapters 1 and 2 of the revised Kyoto Convention.

5. Ачааны мэдүүлгийг шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт А-гийн 1, 2 дугаар бүлэгт тодорхойлсон байдаг.

CARGO INSURANCE

An inland marine or ocean marine policy covering cargo in the care, custody, or control of the carrier.

АЧААНЫ ДААТГАЛ

Тээвэрлэгчийн мэдэл, хадгалалт, хяналтанд шилжүүлсэн ачааны хуурай газрын (дотоодын) ус болон далайн тээврийн даатгалын гэрээ

CARGO MANIFEST

A listing of the goods comprising the cargo (freight) carried in a means of transport or in a transport-unit. The Cargo manifest which gives the commercial particulars of the goods, such as transport document numbers, consignors, consignees, marks and numbers, number and kind of packages, descriptions and quantities of the goods, may be used in place of the Cargo declaration.
(see “Load manifest”)

Note:
Examples of Cargo manifests are Aircraft cargo manifests, Ship’s manifests, Goods manifests and “bordereaux” (road traffic).

АЧААНЫ МАНИФЕСТ

Аль нэг тээврийн хэрэгсэлд ачсан ачааны жагсаалт. Ачааны манифест нь тээврийн баримтын дугаар, илгээгч, хүлээн авагч, баглаа боодлын тэмдэглэгээ, тоо ширхэг, дугаар, төрөл, барааны тодорхойлолт (бичиглэл) ба тоо хэмжээ зэрэг барааны худалдааны мэдээллийг агуулна. Ачааны манифестыг ачааны мэдүүлгийн оронд хэрэглэж болно.
(“Ачааны манифест”-ыг үз)

Жич:
Нисэх онгоцны ачааны манифест, усан онгоцны манифест, барааны манифест болон авто тээврийн манифест (bordereaux) зэрэг нь ачааны манифестын жишээ юм.

CARGO RECEIPT

A receipt of cargo for shipment by a consolidator (used in ocean freight).

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА ХҮЛЭЭЖ АВСАН БАРИМТ (АЧААНЫ ТАСАЛБАР)

Консолидатор (цуглуулбар (түүвэр) ачаа нэгтгэн бэлтгэгч) ачааг ачуулахаар хүлээн авсан баримт (далайн тээвэрт хэрэглэдэг).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CARRIER

The person actually transporting goods or in charge of or responsible for the operation of the means of transport.

ТЭЭВЭРЛЭГЧ

Барааг бодитоор тээвэрлэж байгаа, эсхүл тухайн тээврийн хэрэгслийн ашиглалтыг хариуцсан, эсхүл түүний төлөө хариуцлага хүлээсэн этгээд.

Annex A.1.to the Kyoto Convention of 1974 and Specific Annex A, Chapter 1 and Specific Annex J, Chapter 4 of the revised Kyoto Convention.

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн Хавсралт А1, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт А-гийн 1 дүгээр бүлэг болон Тусгай хавсралт J-гийн 4 дүгээр бүлэг.

CARRIER (ROAD TRANSPORT)

Any natural or legal person, registered in one or several countries, and permitted to carry out the international road transport of goods or passengers in accordance with the national and international legislation in force.

ТЭЭВЭРЛЭГЧ (АВТО ЗАМЫН)

Нэг буюу хэд хэдэн оронд бүртгэлтэй, үндэсний болон олон улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу олон улсын хэмжээнд авто замаар бараа, эсхүл зорчигч тээвэрлэх зөвшөөрөлтэй хувь хүн буюу хуулийн этгээд.

CARRIER NAME

Name and address of party providing the transport of goods between named points (The United Nations Trade Data Element Directory).

ТЭЭВЭРЛЭГЧИЙН НЭР

Нэрлэсэн цэгүүдийн хооронд бараа тээвэрлэж буй этгээдийн нэр, хаяг.
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

CARRIER PERMIT

Authorization for transportations.

ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ

Тээвэр хийх зөвшөөрөл олгох.

CARRIERS REPAIR

Maintenance of vehicles (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

Автомашины засвар үйлчилгээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CARTAGE ORDER (LOCAL TRANSPORT)

Instructions from the consignor to the carrier regarding local transport from pick-up point to carrier's organization, from carrier's organization to delivery point, or between carriers' organizations at the same place (The United Nations Trade Data Element Directory)

ТЭЭВРИЙН ЗАХИАЛГА (ДОТООДЫН ТЭЭВЭР)

Бараа байгаа газраас тээвэрлэгч байгууллага хүртэл, тээвэрлэгч байгууллагаас бараа хүргэх цэг хүртэл, эсхүл нэг газарт байгаа тээвэрлэгчийн байгууллага хооронд явагдах дотоодын тээвэртэй холбоотой, бараа илгээгчээс тээвэрлэгч хүртэл тээвэрлэх заавар
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

CASH AGAINST DOCUMENT (CAD)

Payment for goods in which title documents are transferred to the buyer upon payment in cash.

БИЧИГ БАРИМТЫГ ҮНДЭСЛЭН ТӨЛБӨРИЙГ БЭЛНЭЭР ТӨЛӨХ

Төлбөрийг бэлнээр хийснээр эрх эзэмших бичиг баримтууд худалдан авагчид шилжих барааны төлбөр.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CASH IN ADVANCE (C.I.A.)

ТӨЛБӨРИЙГ УРЬДЧИЛАН БЭЛНЭЭР ТӨЛӨХ

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CASH ON DELIVERY (C.O.D.)

БАРАА ХҮРГЭХЭД ТӨЛБӨР БЭЛНЭЭР ТӨЛӨХ

A transaction in which goods are paid for in full in cash or by certified check immediately after they are received by the buyer.

Худалдан авагч бараагаа хүлээн авсаны дараа барааны төлбөрийг бүтнээр нь нэн даруй бэлнээр, эсхүл баталгаажсан чекээр төлөхөөр тохиролцсон хэлцэл.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CASH ON DELIVERY AMOUNT

БАРАА ХҮРГЭХЭД БЭЛНЭЭР ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Monetary amount to be paid at time of delivery in figures (The United Nations Trade Data Element Directory)

Бараа хүргэх үед төлөх төлбөрийн тоогоор илэрхийлэгдсэн мөнгөн дүн.
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

CASH WITH ORDER (CWO)

ТӨЛБӨРИЙГ ЗАХИАЛГА ӨГӨХ ҮЕД БЭЛНЭЭР ТӨЛӨХ

A method of payment for goods where cash is paid at the time of order and the transaction becomes binding on both buyer and seller

Төлбөрийг захиалга өгөх үед бэлнээр төлж, холбогдох хэлцэл худалдан авагч болон худалдагч хоёулаа заавал дагаж мөрдөх хүчинтэй болж байгаа барааны төлбөрийн арга.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CERTIFICATE OF ANALYSIS (COA)

ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ

A certificate required by some countries as proof of the quality and composition of goods such as pharmaceuticals. The required analysis may be made by a private or government health agency. The certificate may need to be legalized by a foreign consul of the country concerned, as is the case with similar certificates such as the phytosanitary certificate.

Эм зэрэг барааны чанар, найрлагын нотолгоо болгож зарим улсад шаарддаг гэрчилгээ. Шаардагдах дүн шинжилгээг хувийн, эсхүл төрийн эрүүл мэндийн агентлаг хийж болно. Уг гэрчилгээг ургамлын хорио цээрийн гэрчилгээ зэрэг түүнтэй адилтгах гэрчилгээний адил холбогдох улсад суугаа гадаадын консул хууль ёсны болгохыг шаардаж болно.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CERTIFICATE OF COMPLIANCE

In a number of CIS countries this document brings together several other certificates - phytosanitary, veterinary, technical standards, etc.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НИЙЦЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Тусгаар тогтносон улсуудын хамтын нийгэмлэгийн хэд хэдэн оронд энэ бичиг баримтыг өөр бусад хэд хэдэн гэрчилгээний хамт, тухайлбал, ургамлын хорио цээрийн, мал эмнэлгийн, техникийн стандартын, г.м. гэрчилгээний хамт шаарддаг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CERTIFICATE OF INSURANCE

Document issued to the insured certifying that the insurance is in effect and that a policy has been issued. Such a certificate for a particular cargo is primarily used when goods are insured under the terms of a floating or an open policy; at the request of the insured it can be exchanged for a policy.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДААТГАЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Даатгал хүчин төгөлдөр бөгөөд даатгалын гэрээ үйлдсэн болохыг гэрчилж даатгуулагчид олгосон баримт. Ийм гэрчилгээг тодорхой ачааны хувьд, барааг хөвөх (ерөнхий) буюу нээлттэй (валютжуулаагүй) даатгалын гэрээний нөхцөлийн дагуу даатгуулсан тохиолдолд голчлон ашигладаг; даатгуулагчийн хүсэлтээр үүнийг даатгалын гэрээгээр сольж болдог.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CERTIFICATE OF MANUFACTURE

A statement in which a producer specifies where his goods were manufactured, certifies that manufacturing has been completed, and confirms that the goods are at the buyer's disposal.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ

Үйлдвэрлэгч барааг хаана үйлдвэрлэснийг зааж, үйлдвэрлэл бүрэн гүйцэд явагдсаныг гэрчилж, мөн уг бараа худалдан авагчийн эзэмшилд очсоныг баталгаажуулсан мэдүүлэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CERTIFICATE OF ORIGIN

A specific form identifying the goods, in which the authority or body empowered to issue it certifies expressly that the goods to which the certificate relates originate in a specific country.

ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

- Тухайн барааг тодорхойлсон тусгай маягт. Түүнийг олгох эрх бүхий төрийн буюу төрийн бус байгууллага уг гэрчилгээнд хамаарах бараа тодорхой нэг улсын гарал үүсэлтэй болохыг түүгээр гэрчилж байгаагаа уг маягтад тод томруун илэрхийлсэн байна.

This certificate may also include a declaration by the manufacturer, producer, supplier, exporter or other competent person.

Document or request submitted to a competent body in order to evidence the origin of the goods according to the relevant criteria.

Notes:
1. In this definition the word “country” may include a group of countries, a region or a part of a country.
2. Specific forms for certificates of origin have been laid down in Annex D.2. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex K, Chapters 2 and 3 of the revised Kyoto Convention and in the framework of preferential arrangements such as the Generalized System of Preferences.

Энэ гэрчилгээ нь бас үйлдвэрлэгч, хийгч, нийлүүлэгч, экспортлогч, эсхүл эрх бүхий бусад этгээдийн үйлдсэн мэдүүлгийг өөртөө багтаасан байж болно.

- Барааны гарал үүслийг холбогдох шалгуурын дагуу нотлох зорилгоор эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн бичиг баримт буюу хүсэлт

Жич:
1. Энэ тодорхойлолтод дурдсан “улс” гэдэгт бүлэг улс, аль нэг бүс нутаг, эсхүл нэг улсын тодорхой хэсгийг хамааруулан ойлгож болно.
2. Барааны гарал үүслийн гэрчилгээний тусгай маягтыг 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.2-т, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт К-гийн 2, 3 дугаар бүлэгт, мөн Хөнгөлөлтийн ерөнхий систем зэрэг преференц үзүүлэх тухай хэлэлцээрүүдийн хүрээнд заасан байдаг.

CERTIFICATION

A procedure used, directly or indirectly, to establish whether there is compliance with requirements contained in legal acts, technical regulations and standards, in order to carry out foreign trade operations. Such procedures may include inspection, testing of samples and product, product certification after the test or inspection, registration and accreditation.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

Гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах үүднээс, эрх зүйн акт, техникийн дүрэм журам, стандартад заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор шууд буюу шууд бусаар ашигладаг горим журам. Ийм горим журамд барааны хяналт шалгалт, загвар болон бүтээгдэхүүний туршилт, туршилт буюу хяналт шалгалт хийсний дараа бүтээгдэхүүнд холбогдох гэрчилгээ олгох, бүтээгдэхүүнийг бүртгэх, магадлан итгэмжлэл олгох ажиллагаа багтаж болно.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CERTIFIED DECLARATION OF ORIGIN

A declaration of origin certified by an authority or body empowered to do so.

Note:
Annex D.2 to the Kyoto Convention of 1974 and Specific Annex K, Chapters 2 and 3 of the revised Kyoto Convention.

ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖУУЛСАН МЭДҮҮЛЭГ

Эрх бүхий төрийн буюу төрийн бус байгууллагаас гэрчлэн баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлэг.

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.2, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт К-гийн 2, 3 дугаар бүлэг.

CFR – (COST AND FREIGHT) [INSERT NAMED PORT OF DESTINATION]

Incoterms rule under which the seller delivers the goods on board the vessel or procures the goods already so delivered. The risk of loss of or damage to the goods passes when the goods are on board the vessel. The seller must contract for and pay the costs and freight necessary to bring the goods to the named port of destination and owes no obligation to the buyer to purchase insurance cover. When CPT, CIP, CFR or CIF are used, the seller fulfils its obligations to deliver when it hands the goods over to the carrier in the manner specified in the chosen rule and not when the goods reach the place of destination. This rule has two critical points, because risk passes and costs are transferred at different places. While the contract will always specify a destination port, it might not specify the port of shipment, which is where risk passes to the buyer. CFR requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out import Customs formalities. This rule is to be used only for sea or inland waterway transport. Where more than one mode of transport is to be used; the appropriate rule to use is CPT (Carriage Paid to).
[ICC/INCOTERMS 2020]

CFR – ӨРТӨГ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ ШИНГЭСЭН [НЭР ЗААСАН ХҮРЭХ БООМТЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч барааг усан онгоцны тавцан дээр гаргасан буюу ийнхүү нийлүүлсэн барааг худалдаж авсан гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм. Тийм бараа алдагдах, эсхүл гэмтэх эрсдэл нь барааг усан онгоцонд ачуулсан үед шилжинэ. Худалдагч тухайн барааг нэр заасан хүрэх боомтод хүргэхэд шаардагдах өртөг болон тээврийн зардлыг гэрээ байгуулж, төлөх ёстой. Худалдагч худалдан авагчийн өмнө даатгалын гэрээ байгуулах үүрэг хүлээхгүй. Хэрэв CPT, CIP, CFR, CIF нөхцлийг ашигласан бол бараа хүрэх газарт очсоноор бус, харин худалдагч барааг холбогдох дүрэмд (ИНКОТЕРМС-ийн холбогдох нөхцөлд) заасан хэлбэрээр тээвэрлэгчид шилжүүлэн өгсөнөөр худалдагч өөрийн үүргээ гүйцэтгэсэн гэж үзнэ. Энэ дүрэм нь хоёр чухал үеийг онцолдог. Эрсдэл болон өртөг нь хоёр өөр үед шилждэг. Гэрээнд ямагт бараа хүлээн авах газрыг заасан байдаг бол бараа ачуулах газрыг заалгүй орхидог. Гэтэл бараа ачуулах газар дээр эрсдэл худалдан авагчид шилждэг. CFR нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг. Энэ дүрмийг зөвхөн далайн буюу усан тээвэрт хэрэглэнэ. Тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах бол CPT (Тээврийн зардлыг ... хүртэл төлсөн) нөхцөлийг ашиглах нь тохиромжтой байдаг.
[ОУХТ/ИНКОТЕРМС]

CHARGEABLE WEIGHT

Gross weight (mass) on which a charge is to be based (The United Nations Trade Data Element Directory).

ТӨЛБӨР ХУРААМЖ НОГДУУЛАХ ЖИН

Төлбөр хураамж ногдуулахад суурь болгон авах бохир жин.
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

CHARGES

Cost of freight, insurance and/or any other costs and expenses (The United Nations Trade Data Element Directory)

ТӨЛБӨР

Тээврийн зардал, даатгалын хураамж болон/эсхүл өөр бусад өртөг болон зардал
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

CHARTER PARTY BILL OF LADING

A Bill of Lading issued under a charter party. It is not acceptable by banks under letters of credit unless expressly authorized in the credit. (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УСАН ОНГОЦ ХӨЛСЛӨХ ГЭРЭЭНИЙ ТЭЭВРИЙН БАРИМТ

Усан онгоц хөлслөх гэрээний дагуу үйлдсэн тээврийн баримт. Энэ талаар аккредитивт тодорхой заагаагүй бол тийм тээврийн баримтыг банкууд хүлээж авдаггүй.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CHECKING THE GOODS DECLARATION

The action taken by the Customs to satisfy themselves that the Goods declaration is correctly made out and that the supporting documents required fulfil the prescribed conditions

Note:
General Annex, Chapter 2, to the Revised Kyoto Convention).

БАРААНЫ МЭДҮҮЛГИЙГ ШАЛГАХ

Барааны мэдүүлгийг үнэн зөв бүрдүүлсэн, мөн шаардлагатай хавсралт бичиг баримтууд нь тавигдсан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг бататган тогтоох үүднээс гаалийн байгууллагаас хийж гүйцэтгэж байгаа үйлдэл.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралт, 2 дугаар бүлэг.

CIF (COST, INSURANCE AND FREIGHT) [INSERT NAMED PORT OF DESTINATION]

Incoterms rule under which the seller delivers the goods on board the vessel or procures the goods already so delivered. The risk of loss of or damage to the goods passes when the goods are on board the vessel. The seller must contract for and pay the costs and freight necessary to bring the goods to the named port of destination. The seller also contracts for insurance cover against the buyer's risk of loss of or damage to the goods from the port of shipment to at least the port of destination. When the destination country regulations require purchasing local insurance cover, ICC recommends considering selling and buying under CFR (Cost and Freight) rule. The buyer should note that under CIF the seller is required to obtain limited insurance cover complying with Institute Cargo Clause ©. However, the parties can agree on a higher level of protection. When CPT, CIP, CFR, or CIF are used, the seller fulfils its obligation to deliver when it hands the goods over to the carrier in the manner specified in the chosen rule and not when the goods reach the place of destination.

CIF – ӨРТӨГ, ДААТГАЛ, ТЭЭВРИЙН ЗАРДАЛ ШИНГЭСЭН [НЭР ЗААСАН ХҮРЭХ БООМТЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч барааг усан онгоцны тавцан дээр гаргасан буюу ийнхүү нийлүүлсэн барааг худалдаж авсан гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм. Тийм бараа алдагдах, эсхүл гэмтэх эрсдэл нь барааг усан онгоцонд ачуулсан үед шилжинэ. Худалдагч тухайн барааг нэр заасан хүрэх боомтод хүргэхэд шаардагдах өртөг болон тээврийн зардлыг гэрээ байгуулж, төлөх ёстой. Худалдагч мөн худалдан авагчийн бараа алдагдах, гэмтэх эрсдэлээс хамгаалж бараа ачуулсан боомтоос наандаж бараа хүрэх боомт хүртэл даатгалын гэрээ байгуулдаг. Хэрэв бараа хүрэх газрын улсын дүрэм журмаар дотоодын компанитай даатгалын гэрээ байгуулах ёстой бол бараа худалдах, худалдан авах явдлыг CFR (Өртөг ба тээврийн зардал шингэсэн) дүрмийн дагуу авч үзэхийг Олон улсын худалдааны танхимаас зөвлөдөг. Худалдан авагч нь CIF нөхцөлийн дагуу худалдагч даатгалын гэрээг Institute Cargo Clause ©-д нийцүүлэн хязгаарлагдмал хэмжээгээр төлнө гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэвч талууд илүү өндөр хэмжээгээр даатгуулах талаар хоорондоо тохиролцож болно.

This rule has two critical points, because risk passes and costs are transferred at different places. CIF requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out import Customs formalities. This rule is to be used only for sea or inland waterway transport. Where more than one mode of transport is to be used; the appropriate rule to use is CIP (Carriage and Insurance Paid to).
[ICC/INCOTERMS 2020]

Хэрэв CPT, CIP, CFR, CIF нөхцлийг ашигласан бол бараа хүрэх газарт очсоноор бус, харин худалдагч барааг холбогдох дүрэмд (ИНКОТЕРМС-ийн холбогдох нөхцөлд) заасан хэлбэрээр тээвэрлэгчид шилжүүлэн өгсөнөөр худалдагч өөрийн үүргээ гүйцэтгэсэн гэж үзнэ. Энэ дүрэм нь хоёр чухал үеийг онцолдог. Эрсдэл болон өртөг нь хоёр өөр үед шилждэг. Гэрээнд ямагт бараа хүлээн авах газрыг заасан байдаг бол бараа ачуулах газрыг заалгүй орхидог. Гэтэл бараа ачуулах газар дээр эрсдэл худалдан авагчид шилждэг. CFR нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг. Энэ дүрмийг зөвхөн далайн буюу усан тээвэрт хэрэглэнэ. Тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах бол CPT (Тээврийн зардлыг ... хүртэл төлсөн) нөхцөлийг ашиглах нь тохиромжтой байдаг.
[ОУХТ/ИНКОТЕРМС]

CIM CONSIGNMENT NOTE

Consignment note provided for in the Uniform Rules concerning the contract of international carriage of goods by rail (the CIM Uniform Rules - Appendix B to the Convention concerning international carriage by rail (COTIF)).

CIM-ИЙН АЧААНЫ ДАГАЛДАХ

Барааг улс хооронд төмөр замаар тээвэрлэх гэрээний нийтлэг дүрэм (CIM-ийн нийтлэг дүрэм – Олон улсын төмөр замын тээврийн тухай Конвенц (КОТИФ) (1980-05-09, Берн. 1985-05-01-нд хүчин төгөлдөр болсон)-ийн Хавсралт B)-д заасан ачааны дагалдах.

CIP (CARRIAGE AND INSURANCE PAID TO) [INSERT NAMED PLACE OF DESTINATION]

Incoterms rule under which the seller delivers the goods to the carrier contracted by the seller or procures the goods so delivered. The seller may do so by giving the carrier physical possession of the goods in the manner and at the place appropriate to the means of transport used. The seller must contract for and pay the costs of carriage necessary to bring the goods to the named place of destination. The seller also contracts for insurance cover against the buyer's risk of loss of or damage to the goods from the point of delivery to at least the point of destination.

CIP – ТЭЭВРИЙН ЗАРДАЛ БОЛОН ДААТГАЛЫГ ... ХҮРТЭЛ ТӨЛСӨН [НЭР ЗААСАН ХҮРЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч бараагөөрийн гэрээт тээвэрлэгчид хүргэсэн буюу ийнхүү нийлүүлсэн барааг худалдаж авсан гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм. Худалдагч барааг холбогдох тээврийн хэрэгсэлд тохиромжтой хэлбэрээр болон тохиромжтой газарт тээвэрлэгчийн эзэмшилд ийнхүү биетээр шилжүүлэн өгч болно. Худалдагч тухайн барааг нэр заасан хүрэх газарт хүргэхэд шаардагдах өртөг болон тээврийн зардлыг гэрээ байгуулж, төлөх ёстой.

When the destination country regulations require purchasing local insurance cover, ICC recommends considering selling and buying under CPT (Carriage Paid to) rule. The buyer should note that under CIP the seller is required to obtain extensive insurance cover complying with Institute Cargo Clause (A). However, the parties can agree on a lower level of protection. When CPT, CIP, CFR or CIF are used, the seller fulfils its obligation to deliver when it hands the goods over to the carrier and not when the goods reach the place of destination. CIP requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out import Customs formalities. This rule has two critical points, because risk passes and costs are transferred at different places. It may be used irrespective of the mode of transport selected and may also be used where more than one mode of transport is employed.
[ICC/INCOTERMS 2020]

Худалдагч мөн худалдан авагчийн бараа алдагдах, гэмтэх эрсдэлээс хамгаалж бараа ачуулсан боомтоос наандаж бараа хүрэх боомт хүртэл даатгалын гэрээ байгуулдаг. Хэрэв бараа хүрэх газрын улсын дүрэм журмаар дотоодын компанитай даатгалын гэрээ байгуулах ёстой бол бараа худалдах, худалдан авах явдлыг CPT – (Тээврийн зардлыг … хүртэл төлсөн) дүрмийн дагуу авч үзэхийг Олон улсын худалдааны танхимаас зөвлөдөг. Худалдан авагч нь CIP нөхцөлийн дагуу худалдагч даатгалын гэрээг Institute Cargo Clause ©-д нийцүүлэн хязгаарлагдмал хэмжээгээр төлнө гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэвч талууд илүү өндөр хэмжээгээр даатгуулах талаар хоорондоо тохиролцож болно. Хэрэв CPT, CIP, CFR, CIF нөхцлийг ашигласан бол бараа хүрэх газарт очсоноор бус, харин худалдагч барааг холбогдох дүрэмд (ИНКОТЕРМС-ийн холбогдох нөхцөлд) заасан хэлбэрээр тээвэрлэгчид шилжүүлэн өгсөнөөр худалдагч өөрийн үүргээ гүйцэтгэсэн гэж үзнэ. CIP нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг. Энэ дүрэм нь хоёр чухал үеийг онцолдог. Эрсдэл болон өртөг нь хоёр өөр үед шилждэг. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно.
[ОУХТ/ИНКОТЕРМС]

CITES CONVENTION

Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora, signed in Washington on 3 March 1973.

CITES-ИЙН КОНВЕНЦ

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц. 1973 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Вашингтон хотноо гарын зурсан.

CLAUSED BILL OF LADING

A Bill of Lading that contains a notation indicating that either the packaging or the merchandise is damaged.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТАЙЛБАР БҮХИЙ ТЭЭВРИЙН БАРИМТ

Сав боодол, эсхүл бараа гэмтсэн тухай тэмдэглэл хийсэн тээврийн баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CLEAN BILL OF LADING

A Bill of Lading which covers goods received in “apparent good order and condition” and without qualification.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ЦЭВЭР БАРИМТ

“Эвдрэл гэмтэлгүй, бүрэн бүтэн” ирсэн бөгөөд өө сэвгүй барааны тээврийн баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CLEAN DRAFT

Draft to which no documents have been attached.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАН ЧЕК (ВЕКСЕЛЬ, ТРАТТА)

Бичиг баримт хавсаргаагүй чек (вексель, тратта).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CLEARANCE

The accomplishment of the Customs formalities necessary to allow goods to enter home use, to be exported or to be placed under another Customs procedure.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

БҮРДҮҮЛЭЛТ

Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах, экспортлох, эсхүл гаалийн өөр горимд байршуулахын тулд шаардлагатай гаалийн ёс журмын ажиллагааны гүйцэтгэл.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

CLEARANCE FOR HOME USE

The Customs procedure which provides that imported goods enter into free circulation in the Customs territory upon the payment of any import duties and taxes chargeable and the accomplishment of all the necessary Customs formalities.

Note:
Special Annex B, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАН ОРУУЛАХ

Импортын барааг түүнд ногдуулсан импортын гаалийн болон бусад татвар төлөгдөж, гаалийн шаардлагатай бүх ёс журмын ажиллагаа дуусгавар болмогц гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд оруулах гаалийн горим.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт B-гийн 1 дүгээр бүлэг.

CLEARANCE OF GOODS

The accomplishment of the Customs formalities necessary to allow goods to enter home use, to be exported or to be replaced under another Customs procedure.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААНЫ БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ

Дотоодын хэрэглээнд зориулан оруулах, эсхүл гаргах, эсхүл гаалийн өөр горимд байршуулах барааг зөвшөөрч, шаардлагатай гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CMR CONSIGNMENT NOTE

Legal contractual document between a consignor, a road transport operator and a consignee, which standardizes the conditions governing the contract for international road transport, particularly with respect to documents to be used and the carrier's liability with the aim of facilitating international road transport and international trade. To use the CMR (Convention on the contract for the international carriage of goods by road) note, at least one of the countries involved in the international transport (of origin or of destination) should be a Contracting Party to the CMR Convention. A new standard for an electronic CMR consignment note was adopted in 2018.
(The *United Nations Economic Commission for Europe)*

CMR КОНВЕНЦИЙН АЧААНЫ ДАГАЛДАХ ХУУДАС

Бараа илгээгч, авто замын тээврийн компани, бараа хүлээн авагч гурвын хооронд байгуулсан эрх зүйн шинжтэй гэрээний бичиг баримт. Энэ нь ачааг олон улсын авто замын тээвэр болон олон улсын худалдааг хөнгөвчлөх зорилгоор олон улсын хэмжээнд авто замаар тээвэрлэх гэрээ, ялангуяа ачааг тийнхүү тээвэрлэхэд ашиглах бичиг баримтуудад хамаарах нөхцөлүүд, мөн тээвэрлэгчийн үүргийг стандартчилж өгдөг. CMR конвенц (Ачааг олон улсын хэмжээнд авто замаар тээвэрлэх гэрээний тухай НҮБ-ын Конвенц – Женев, 1956-5-19)-ийн ачааны дагалдах хуудсыг ашиглахын тулд тухайн олон улсын тээвэрт оролцох улсуудын ядаж нэг нь (гарал үүслийн улс, эсхүл хүлээн авагч улс) CMR конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал байх ёстой. CMR конвенцийн ачааны дагалдах цахим хуудсын шинэ стандарт 2018 онд батлагдсан.
(НҮБ-ын Европын эдийн засгийн комисс*)*

CN22/23

The special declaration forms for postal items as described in the Acts of the Universal Postal Union currently in force.

Note:
Specific Annex J, Chapter 2 of the revised Kyoto Convention.

CN22/23

Дэлхийн шуудангийн холбооны одоо мөрдөж буй актуудад заасан, шуудан илгээмж мэдүүлэх зориулалттай тусгай маягт.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 2 дугаар бүлэг.

CODE

Data transformation or data representation in different forms according to pre-established rules. In trade facilitation and electronic business:

(a) a character string used as an abbreviated means of recording or identifying information; or
(b) a means to represent or identify information using a specific symbolic form that can be recognized by a computer.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

КОД

Урьдчилан тогтсон дүрмийн дагуу янз бүрийн хэлбэрт хувиргасан өгөгдөл (мэдээлэл) буюу янз бүрийн хэлбэрээр төлөөлүүлэн илэрхийлсэн өгөгдөл (мэдээлэл). Худалдааг хөнгөвчлөх зорилгоор болон цахим бизнест код гэдгийг дараах байдлаар ойлгоно:
(а) мэдээллийг бүртгэх болон таних товчилсон арга болгож ашигласан ямар нэг тэмдэгт бүхий мөр; эсхүл
(b) мэдээллийг төлөөлүүлэн илэрхийлэх, эсхүл таних зорилгоор ямар ч компьютер хүлээн авах боломжтой тодорхой нэг бэлэг тэмдгийн хэлбэр ашигласан арга.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CODE LISTS

Codified information is an integral part of data exchange in international business whether this is on paper documents or electronic data exchange. UN/ CEFACT develops, maintains and publishes for free of charge a number of code lists used extensively in business transactions.

Note: UN/CEFACT/Code lists

КОДЫН ЖАГСААЛТУУД

Кодчилсон мэдээлэл гэдэг нь цаасан бичиг баримтын хэлбэртэй, эсхүл өгөгдлийн цахим солилцоо хэлбэртэй байхаас үл хамааран олон улсын бизнесийн хүрээнд мэдээлэл солилцох ажиллагааны салшгүй нэг хэсэг болдог. НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв нь бизнесийн хэлцлүүдэд өргөнөөр ашиглаж буй хэд хэдэн кодын жагсаалт боловсруулж, засч залруулан үнэ төлбөргүй нийтэлж байдаг.

Жич: НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Кодын жагсаалтууд

CODE OF CONDUCT

Voluntary guidelines for business behavior (or treatment of workers).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Бизнесийн зан төлөв (эсхүл ажилчдын харьцаа)-т төлөвшүүлэх сайн дурын заавар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COLLECTION ORDER

Document whereby a bank is instructed (or requested) to handle financial and/or commercial documents in order to obtain acceptance and/ or payment, or to deliver documents on such other terms and conditions as may be specified.

(ICC Uniform Rules for Collections).

ИНКАССЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ ОРДЕР

Акцепт болон/эсхүл төлбөр хүлээн авах, эсхүл санхүүгийн болон/эсхүл худалдааны бичиг баримтуудыг хүргэх үүднээс тэдгээр бичиг баримттай хэрхэн харьцах талаар банкинд зааварчилсан бичиг баримт. Энэхүү бичиг баримтад тэдгээр санхүүгийн болон/ эсхүл худалдааны бичиг баримтыг хүргэх хугацаа болон нөхцөлийг өөрөөр заасан байж болно.

(Олон улсын худалдааны танхимын Инкассын төлбөр тооцооны нэгдсэн журам)
.

COLLECTIVE PAPER

All documents (commercial invoices, bills of lading, etc.) submitted to a buyer for the purpose of receiving payment for a shipment.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ИНКАССЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ БИЧИГ БАРИМТ

Аль нэг ачилтын төлбөрийг нэхэмжлэхийн тулд худалдан авагчид гаргаж өгсөн бүх бичиг баримт (худалдааны үнийн нэхэмжлэх, тээврийн баримт, г.м.)
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COMBINED TRANSIT DUTY

Customs duty, combining ad valorem and specific types of Customs duties.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАМЖИН ӨНГӨРӨХ БАРААНД НОГДУУЛДАГ ГААЛИЙН НЭГДМЭЛ ТАТВАР

Адвалорем болон биет хэмжигдэхүүнээр тогтоосон гаалийн татварын төрлүүдийг нэгтгэсэн гаалийн татвар.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COMBINED TRANSPORT

Intermodal transport where the journey is carried out by a combination of rail, inland waterways, sea or road; the shortest leg being typically by road

ХОСОЛСОН ТЭЭВЭР

Тээврийн олон төрлөөр хийгдэх (холимог) тээвэр. Аялал нь төмөр зам, хуурай газрын (дотоодын) усан зам, далай тэнгисийн зам, эсхүл авто замыг хослуулан туулна. Хамгийн богино зам нь гол төлөв авто зам байдаг.

COMMERCIAL CODE

Published code designed to reduce the total number of words required in a cablegram.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АРИЛЖААНЫ (ХУДАЛДААНЫ) КОД

Цахилгаан мэдээний үгийн нийт тоог багасгах зориулалттай, хэвлэсэн нийтэлсэн код.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COMMERCIAL CONVOY

Traffic of goods by several trucks.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АРИЛЖААНЫ (ХУДАЛДААНЫ) ЦУВАА

Ачааны хэд хэдэн машинаар зэрэг бараа тээвэрлэх.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COMMERCIAL FRAUD

Any offence against statutory or regulatory provisions which Customs is responsible for enforcing, committed in order to:

- evade, or attempt to evade, payment of duties/levies/taxes on movements of commercial goods;
and/or
- evade, or attempt to evade, any prohibition or restrictions applicable to commercial goods;
and/or
- receive, or attempt to receive, any repayments, subsidies or other disbursements to which there is no proper entitlement;

ХУДАЛДААНЫ ЛУЙВАР

Гаалийн байгууллагаас сахиулахаар үүрэг хүлээсэн аливаа хууль болон хуульчилсан актын заалтыг зөрчиж, дараах зорилгоор үйлдсэн аливаа зөрчил:

- арилжааны шинжтэй бараанд ногдуулах гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх, эсхүл зайлсхийхийг завдах; мөн/эсхүл
- арилжааны шинжтэй бараанд хамаарах аливаа хориг, хязгаарлалтаас зайлсхийх, эсхүл зайлсхийхийг завдах;
мөн/эсхүл
- татвар буцаан авах, татаас авах, эсхүл өөр бусад хэлбэрээр төлбөр авах эрхгүй мөртлөө уг эрхийг эдлэх, эсхүл эдлэхийг завдах;

and/or
- obtain, or attempt to obtain, illicit commercial advantage injurious to the principle and practice of legitimate business competition.

Note:
A list of commercial fraud case types is included in Chapter II of the CCC Manual on measures to combat commercial fraud.

мөн/эсхүл
- бизнесийн шударга өрсөлдөөний практик, зарчимд харш байдлаар худалдааны хууль бус давуу тал олж авах, эсхүл олж авахыг завдах.

Жич:
Худалдааны луйврын хэргийн төрлүүдийг Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс гаргасан Худалдааны луйвартай тэмцэх арга хэмжээний тухай гарын авлагын II бүлэгт жагсаан оруулсан байдаг.

COMMERCIAL INVOICE

Document claiming payment for goods supplied under conditions agreed between seller and buyer.

(UN/ECE/FAL)

ХУДАЛДААНЫ ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ

Худалдагч болон худалдан авагчийн хооронд тохиролцсон нөхцөлийн дагуу нийлүүлсэн барааны төлбөрийг нэхэмжилсэн бичиг баримт.

(НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

COMMON CARRIER

A firm or individual that transports persons or goods for compensation.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЕРДИЙН ТЭЭВЭРЛЭГЧ

Зорчигч, эсхүл бараа төлбөртэй тээвэрлэдэг компани буюу хувь хүн
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COMMUNICATION

Any statement, declaration, demand, notice or request, including an offer and the acceptance of an offer,that the parties are required to make or choose to make in connection with the formation or performance of a contract.
Note: UNCITRAL Electronic Communications Convention

ЗАХИДАЛ ХАРИЛЦАА

Гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэхтэй холбогдуулан талуудын зүгээс зайлшгүй, эсхүл сонголтоор үйлдэх ёстой аливаа мэдэгдэл, мэдүүлэг, шаардлага, сануулга, хүсэлт, түүний дотор захиалга болон захиалгын акцепт.
Жич: НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим мэдээллийн (цахим харилцааны) тухай конвенц

COMPENSATING PRODUCTS

Products:
(a) obtained within a country and resulting from the manufacturing, processing or repair of the goods for which the use of the inward processing procedure is authorized; or

(b) obtained abroad and resulting from the manufacturing, processing or repair of goods for which the use of the outward processing procedure is authorized.

ОРЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН

Дараах бүтээгдэхүүн байна:
(a) дотоодод боловсруулах горим ашиглахыг зөвшөөрсөн барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварын үр дүнд аливаа нэг улсад бий болсон бүтээгдэхүүн; эсхүл
(b) гадаадад боловсруулах горим ашиглахыг зөвшөөрсөн барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварын үр дүнд гадаадад бий болсон бүтээгдэхүүн.

Note:
In some countries the products obtained from the treatment of imported, exported or domestic goods identical in description, quality and technical characteristics to those temporarily admitted for inward processing or temporarily exported for outward processing, as the case may be, are deemed to be compensating products (setting-off with equivalent goods).
Annexes E.6. and E.8. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex B, Chapter 2 and Specific Annex F, Chapters 1 and 2 of the revised Kyoto Convention.

Жич:
Зарим улс оронд дотоодод, эсхүл гадаадад боловсруулахаар түр хугацаагаар оруулсан буюу гаргасан бараатай тодорхойлолт, чанар болон техникийн үзүүлэлтээрээ ижил дотоодын, импортын, эсхүл экспортын бараанаас гаргаж авсан бүтээгдэхүүнийг (адил бараанаас өөрөөр үзэж) орлогч бүтээгдэхүүнд тооцдог.
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт E.6, E.8, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт B-гийн 2 дугаар бүлэг болон Тусгай хавсралт F-ийн 1, 2 дугаар бүлэг.

COMPENSATION AGREEMENT

Agreement on the reimbursement of international loans and services at certain times and on defined terms.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НӨХӨН ТӨЛБӨР ХИЙХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Олон улсын зээл, үйлчилгээг тодорхой хугацаанд, мөн тодорхой нөхцөлөөр нөхөн олгох тухай хэлэлцээр.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COMPETENT COURT

A court in a Contracting State that, according to the rules on the internal allocation of jurisdiction among the courts of that State, may exercise jurisdiction over the dispute.

Note: Rotterdam Rules

ЭРХ БҮХИЙ ШҮҮХ

Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч тухайн Улсын бүх шүүх байгууллага дундаас шүүхийн харъяаллыг дотроо хуваарилах дүрмийн дагуу тухайн маргааныг таслан шүүх эрхтэй байж болох шүүх.

Жич: Роттердамын дүрэм

COMPLIANCE IMPROVEMENT

The philosophy of seeking to continually improve the level of voluntary compliance with Customs laws.

ХУУЛЬ САХИЛТЫГ САЙЖРУУЛАХ

Гаалийн хууль тогтоомжийг сайн дураараа сахиж мөрдөж буй түвшинг байнга дээшлүүлэхэд чиглэсэн философ.

COMPLIANCE MANAGEMENT

The systematic application of procedures and practices that are designed to manage compliance with Customs laws.

ХУУЛЬ САХИЛТЫН МЕНЕЖМЕНТ

Гаалийн хууль тогтоомж сахиж мөрдөх явдлыг удирдан чиглүүлэх зорилготой горим журам болон практик туршлагыг системтэй (цэгцтэй) мөрдөх.

COMPLIANT TRADERS

Economic agents whose trading practices comply with the existing regulations and rules regarding trade procedures.

ЖУРАМТ ХУДАЛДАА ЭРХЛЭГЧ

Худалдааны практик үйл ажиллагаа нь худалдааны горим журамтай холбоотой бөгөөд тухайн үед мөрдөж буй дүрэм, журамд нийцдэг ах ахуйн нэгж.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COMPOUND DUTY RATE

A rate of duty incorporating both an ad valorem rate and a specific rate; e.g. 10% + $20/ton.

ГААЛИЙН ТАТВАРЫН ХОСОЛМОЛ (ХОЛИМОГ, НИЙЛМЭЛ) ХУВЬ ХЭМЖЭЭ

Адвалорем (үнийн дүнгээс хувиар тогтоосон) хувь хэмжээ болон барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон хувь хэмжээг хамтатгасан гаалийн болон бусад татварын хувь хэмжээ. Жишээ нь, 10% + $20/тонн.

COMPROMISE SETTLEMENT

An agreement under which the Customs, being so empowered, consent to waive proceedings in respect of a Customs offence subject to compliance with certain conditions by the person(s) implicated in that offence.

Notes:
1. Annex H.2.to the Kyoto Convention of 1974 and Specific Annex H, Chapter 1 of the revised Kyoto Convention.

2. See also “Administrative settlement of a Customs offence”.

ХАРИЛЦАН ЗӨВШИЛЦӨХ ЗАМААР ШИЙДВЭРЛЭХ

Гаалийн зөрчилд холбогдсон этгээд (этгээдүүд) тодорхой болзол нөхцөлийг ханган биелүүлэх тохиолдолд гаалийн байгууллага өөрт олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд уг зөрчлийг шүүн шийдвэрлэх ажиллагаанаас татгалзахаар зөвшөөрсөн тохиролцоо.
Жич:
1. 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт H.2, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт H-ийн 1 дүгээр бүлэг.
2. Мөн “Гаалийн зөрчлийг захиргааны журмаар шийдвэрлэх” гэсэн нэр томьёог үз.

COMPULSORY LICENSING

For patents: when the authorities license companies or individuals other than the patent owner to use the rights of the patent — to make, use, sell or import a product under patent (i.e. a patented product or a product made by a patented process) — without the permission of the patent owner. Allowed under the WTO’s TRIPS (intellectual property) Agreement provided certain procedures and conditions are fulfilled.

АЛБАН ЖУРМЫН ЗӨВШӨӨРӨЛ (ЛИЦЕНЗ) ОЛГОХ

Патентын хувьд: патент эзэмшигчээс бусад компани буюу хувь хүн патентын эрхийг ашиглах – патенттай бүтээгдэхүүн (өөрөөр хэлбэл, патент олгосон бүтээгдэхүүн, эсхүл патенттай поцессоор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн) үйлдвэрлэх, ашиглах, борлуулах, эсхүл импортлох – тохиолдолд тэдэнд төрийн байгууллагаас зөвшөөрөл олгох. Зарим дүрэм журам, болзол нөхцөл хангагдсан бол ийнхүү зөвшөөрөл олгохыг ДХБ-ын ТРИПС-ийн (оюуны өмчийн) хэлэлцээрээр зөвшөөрдөг.

CONFIRMED LETTER OF CREDIT

A letter of credit, issued by a foreign bank, whose validity has been confirmed by a domestic bank. An exporter with a confirmed letter of credit is assured of payment even if the foreign buyer or the foreign bank defaults.

БАТАЛГААЖСАН АККРЕДИТИВ

Гадаадын банкнаас нээж, хүчин төгөлдөр болох нь дотоодын банкаар баталгаажсан аккредитив. Баталгаажсан аккредитивтай экспортлогч нь гадаадын худалдан авагч, эсхүл гадаадын банк үүрээ эс биелүүлсэн ч төлбөр нь төлөгдөх баталгаатай байна.

CONFORMITY ASSESSMENT PROCEDURES

Any procedure used, directly or indirectly, to determine that a technical regulation or standard has been fulfilled.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НИЙЦЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Техникийн дүрэм журам буюу техникийн стандарт хангагдсан болохыг тогтоох зорилгоор шууд буюу шууд бусаар ашиглах аливаа горим журам.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSEQUENCE OF RISK

The potential impact on Customs objectives in the event that a risk occurs.

ЭРСДЭЛИЙН ҮР ДАГАВАР

Эрсдэл учирсан тохиолдолд гаалийн зорилтод нөлөөлж болзошгүй байдал.

CONSIGNEE

The individual or company to whom a seller or shipper sends merchandise and who, upon presentation of necessary documents, is recognized as the merchandise owner for the purpose of declaring and paying Customs duties

ХҮЛЭЭН АВАГЧ

Худалдагч, эсхүл ачаа бэлтгэгч (ачигч компани)-ээс барааг нэр дээр нь илгээсэн хувь хүн, эсхүл компани. Энэхүү хувь хүн буюу компани шаардлагатай бичиг баримтыг гаргаж үзүүлснээр тухайн барааг мэдүүлж, гаалийн татвар төлөх зорилгоор тухайн барааны эзэн гэж хүлээн зөвшөөрөгддөг.

CONSIGNEE MARK

A symbol stamped on packages for identification purposes; generally consisting of a triangle, square, circle, diamond, cross, with letters and/or numbers together with port of discharge.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮЛЭЭН АВАГЧИЙН ТЭМДЭГЛЭГЭЭ (МАРК)

Бараг ялган таних зорилгоор сав боодол дээр тавьсан ялгах тэмдэг; ерөнхийдөө ачаа буух боомтын нэртэй зэрэгцүүлэн тавьсан гурвалжин, квадрат, тойрог, ромбо, чагт, үсэг, тоо байдаг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSIGNMENT

A separately identifiable collection of consignment items (available to be) transported from one consignor to one consignee via one or more modes of transport as specified in one single transport service contractual document.

Note: UN/CEFACT/CCL

КОНСИГНАЦИ

Тээврийн үйлчилгээний гэрээний нэгдсэн нэг бичиг баримтад заасны дагуу нэг илгээгчээс нэг хүлээн авагчид тээврийн нэг буюу хэд хэдэн төрлөөр тээвэрлэсэн (тээвэрлэхэд бэлэн байгаа) консигнацийн барааны тусдаа ялгаран танигдах цуглуулга.

Жич: НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан

CONSIGNMENT AGREEMENT

A form of agreement, in which one party (the "seller") provides goods to another party (the "company") for sale by that company. The Seller gets paid only after the Company has sold the goods to an end-consumer purchaser. The form of this agreement tends to be proseller. Goods release from the consignment warehouse always takes place with the permission and under the control of Customs

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

КОНСИГНАЦИЙН (КОМИССЫН) ГЭРЭЭ

Нэг тал (худалдагч) барааг нөгөө тал (компани)-д өгөх бөгөөд уг компани тухайн барааг цааш нь борлуулдаг гэрээний хэлбэр. Худалдагч төлбөрөө зөвхөн уг компани тухайн барааг эцсийн хэрэглэгч болох худалдан авагчид борлуулсаны дараа авна. Энэхүү гэрээний хэлбэр нь проселлер хэлбэртэй болох чиг хандлагатай байна. Консигнацын агуулахаас бараа олгох явдлыг зөвхөн гаалийн байгууллагын зөвшөөрөлтэй, түүний хяналтын дор гүйцэтгэнэ.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSIGNMENT ITEM

A separately identifiable quantity of products grouped together by Customs tariff code or packaging for transport purposes. A consignment item is the lowest level of information within a consignment.

Note: UN/CEFACT/CCL

КОНСИГНАЦИЙН БАРААА

Гаалийн тарифын кодоор нь, эсхүл тээвэрлэх зорилгоор савласан байдлаар нь хамтад нь хэсэглэсэн бүтээгдэхүүний тусдаа ялгарах тоо хэмжээ. Консигнацийн бараа нь ямар нэг консогнацийн доторх мэдээллийн хамгийн бага түвшин юм.

Жич: НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан

CONSIGNMENT NOTE

Document accompanying goods during carriage.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧААНЫ ДАГАЛДАХ ХУУДАС

Тээвэрлэлтийн явцад бараа дагалдах бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSIGNMENT SECURITY DECLARATION (CSD)

The Consignment Security Declaration (CSD) provides regulators with an audit trail of how, when and by whom cargo has been secured along the supply chain. Its objective is to meet ICAO requirements, ensuring that each consignment received by an aircraft operator or a regulated agent comes with documentation, either on the e-Air Waybill or on a separate declaration. To avoid a plethora of different security declarations, IATA developed a standard CSD in cooperation with the industry and regulators.

АЧААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДҮҮЛЭГ

Ачааны аюулгүй байдлын мэдүүлэг нь бараа нийлүүлэх тухайн сүлжээний турш ачааны аюулгүй байдлыг хэрхэн, хэзээ, хэн хамгаалж байгааг аудитын мөрөөр хянах боломжийг зохицуулагч нар (аюулгүй байдлын хяналтын албад)-т олгодог. Түүний зорилт нь нисэх онгоцны операторын, эсхүл зөвшөөрөгдсөн гэрээт агент (аюулгүй байдлын хяналтын агент)-ын хүлээж авсан ачаа бүрийг агаарын тээврийн цахим баримтад, эсхүл салангид мэдүүлэгт бичиж бичиг баримттай болгох замаар Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага

(Олон улсын иргэний нислэгийн байгууллага)-ын шаардлагыг хангахад оршино. Агаарын тээврийн олон улсын агентлаг (Олон улсын агаарын тээврийн нийгэмлэг) нь аюулгүй байдлын элдэв янзын бичиг баримтаас зайлсхийх үүднээс холбогдох салбар болон зохицуулагч нар (аюулгүй байдлын хяналтын албад)-тай хамтран Ачааны аюулгүй байдлын стандарт мэдүүлгийг боловсруулсан юм.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSIGNOR

Any person who consigns goods to himself or to another party in a Bill of Lading or equivalent document. A consignor may be the owner of the goods, or a freight forwarder who consigns goods on behalf of his principal.

ИЛГЭЭГЧ

Барааг өөртөө, эсхүл тээврийн баримтад буюу түүнтэй адилтгах бичиг баримтад дурдсан өөр бусад этгээдэд илгээж буй аливаа этгээд. Илгээгч нь барааны эзэн, эсхүл барааг өөрийн удирдлагын нэрийн өмнөөс илгээж буй тээвэр зууч байж болно.

CONSOLIDATED SHIPMENT

An arrangement whereby various shippers pool their boxed goods on the same shipment, sharing the total weight charge for the shipment.

ЦУГЛУУЛБАР (ТҮҮВЭР) АЧАА

Хэд хэдэн ачаа бэлтгэгч (ачигч компани) өөр өөрсдийн хайрцагтай ачааг нийлүүлэн нэг ачилт болгон, ачилтын төлбөрийг нийт жингээс бодож хуваажтөлөхөөр тохиролцох.

CONSOLIDATION OF GOODS

The grouping together of several compatible consignments into a full container load. Also referred to as grouping.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЦУГЛУУЛБАР (ТҮҮВЭР) АЧАА БЭЛДЭХ

Өөр хоорондоо нийцтэй хэд хэдэн ачааг нэг чингэлэг дүүргэх зорилгоор хамтад нь бүлэглэх.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSOLIDATOR

An agent who brings together a number of shipments bound for a single destination to qualify for preferential airline rates.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

КОНСОЛИДАТОР (ЦУГЛУУЛБАР (ТҮҮВЭР) АЧАА НЭГТГЭН БЭЛТГЭГЧ)

Авиакомпанийн тээврийн тарифын хөнгөлөлттэй хувь хэмжээг эдлэхийн тулд нэг чиглэлд тээвэрлэх хэд хэдэн ачилтыг хамтатган нэгтгэдэг аливаа нэг агент.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSULAR DECLARATION

A formal statement, made to the consul of a foreign country, describing goods to be shipped.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

КОНСУЛЫН ГАЗРЫН МЭДҮҮЛЭГ

Ачуулах гэж байгаа барааг тодорхойлж, гадаад улсын консулд өгдөг албан ёсны мэдүүлэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONSULAR INVOICE

Document to be prepared by an exporter in his country and presented to a diplomatic representation of the importing country for endorsement and subsequently to be presented by the importer in connection with the import of the goods described therein.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

КОНСУЛЫН ГАЗРЫН ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ

Экспортлогч өөрийн улсдаа бэлдэж, импортлогч улсын дипломат төлөөлөгчийн газарт хүргүүлэн баталгаажуулсан бичиг баримт. Энэ бичиг баримтыг импортлогч дараа нь түүнд дурдсан барааг импортлохтой холбогдуулан гаргаж үзүүлдэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTAINER

An article of transport equipment (lift -van, movable tank or other similar structure):

(i) fully or partially enclosed to constitute a compartment intended for containing goods,

(ii) of a permanent character and accordingly strong enough to be suitable for repeated use,

(iii) specially designed to facilitate the carriage of goods, by one or more modes of transport, without intermediate reloading,

(iv) designed for ready handling, particularly when being transferred from one mode of transport to another,

(v) designed to be easy to fill and to empty, and

(vi) having an internal volume of one cubic metre or more.

ЧИНГЭЛЭГ

Ачаа тээвэрлэх хэрэгсэл (төмөр торон хайрцаг, дугуйтай буюу хөлтэй торх, эсхүл тэдгээртэй адилтгах бусад төхөөрөмж). Энэ нь дараах шаардлагыг хангасан байна:

(i) дотор нь бараа хийх зориулалттай, авдар савны шинжийг бүрдүүлсэн, битүү, эсхүл хагас хаалттай,

(ii) олон дахин хэрэглэхэд тохиромжтой байх үүднээс бат бөх чанартай, мөн тийм болохоор удаан эдэлгээтэй,

(iii) бараг замд нь буулгаж, дахин ачилгүйгээр нэг төрлийн, эсхүл хэд хэдэн төрлийн тээврийн хэрэгсэл дамжуулан тээвэрлэх явдлыг хөнгөвчлөх зорилгоор хийгдсэн,

(iv) зөөхөд бэлэн, ялангуяа, нэг төрлийн тээврийн хэрэгслээс өөр төрлийн тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачихад хялбар байхаар хийгдсэн,

(v) дүүргэх болон хоослоход хялбар байхаар хийгдсэн, мөн

(vi) дотор талын эзлэхүүн нь 1 куб.метр болон түүнээс дээш байх.

“Чингэлэг” гэдэгт тухайн чингэлгийн төрөлд тохирсон, түүнийг дагалдах тоног хэрэгсэл хамаарна.

"Container" shall include the accessories and equipment of the container, appropriate for the type concerned, provided that such accessories and equipment are carried with the container. The term "container" shall not include vehicles, accessories or spare parts of vehicles, or packaging or pallets. "Demountable bodies" shall be regarded as containers.

"Чингэлэг" гэдэгт автотээврийн хэрэгсэл, түүний туслах болон дагалдах хэрэгсэл, эсхүл сэлбэг хэрэгсэл, эсхүл сав боодол, эсхүл ачааны тавиур хамаарахгүй. "Салгаж аваад, буцаагаад тавьдаг тэвш"-ийг чингэлэг гэж үзнэ.

Notes:

1. Istanbul Convention (Annex B.3.) and the Customs Convention on Containers, 1972. The latter Convention also stipulates the conditions for the acceptance of containers for international transport under Customs seal.

2. The Customs Convention on the international transport of goods under cover of TIR carnets, 1975, also deals with the use of containers in international Customs transit.

Жич:

1. Стамбулын конвенцийн хавсралт А.3, мөн 1972 оны Чингэлгийн тухай гаалийн конвенц. Мөн Чингэлгийн тухай гаалийн конвенцид гаалийн битүүмжлэлтэйгээр олон улсын тээвэрлэлтэд ашиглах чингэлгийг хүлээн зөвшөөрөх нөхцлүүдийг заасан байдаг.

2. TIP карней ашиглан барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай 1975 оны гаалийн конвенцид гаалийн олон улсын дамжуулан өнгөрүүлэх горимд чингэлэг ашиглах талаар бас заасан байдаг.

CONTAINER CONVENTION

The expression commonly used to refer to the Customs Convention on Containers, concluded in Geneva in 1972 under the auspices of the United Nations and administered by the Customs Co-operation Council.

ЧИНГЭЛГИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

1972 онд НҮБ-ын ивээл дор Женев хотноо байгуулагдаж, Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс хяналт тавин хэрэгжүүлж буй Чингэлгийн тухай гаалийн конвенцийн түгээмэл нэр.

CONTAINER FREIGHT STATION (CFS)

At loading port "CFS" means the location designated by carriers for the receiving of cargo to be packed into containers by the carrier. At discharge ports, "CFS" means the bonded location designated by carriers in the port area for unpacking and delivery of cargo.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ӨРТӨӨ

Ачаа ачих боомт дээр яривал "чингэлэг тээврийн өртөө" гэж тээвэрлэгч өөрийн чингэлэгт ачих барааг хүлээн авах зорилгоор тогтоосон зориулалтын газрыг хэлнэ. Ачаа буулгах боомт дээр яривал "чингэлэг тээврийн өртөө" гэж ачааг задлах болон хүргэх зорилгоор тээвэрлэгчээс тухайн боомтын бүсэд тогтоосон зориулалтын баталгаат газрыг хэлнэ.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTAINER MANIFEST (UNIT PACKING LIST)

Document specifying the contents of particular freight containers or other transport units, prepared by the party responsible for their loading into the container or unit.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЧИНГЭЛГИЙН МАНИФЕСТ (ТОДОРХОЙ НЭГ АЧААНЫ БАГЛАА БООДЛЫН ЖАГСААЛТ)

Тодорхой нэг тээврийн чингэлэг буюу өөр бусад тээврийн хэрэгсэлд ачсан ачааг тодорхойлсон, уг чингэлэг буюу тээврийн хэрэгсэлд ачаа ачсан талаас бэлтгэсэн бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTAINER POOL

The use in common of containers established by an agreement as per the Container Pool Convention.
Note: UNECE/WCO/CCC

ЧИНГЭЛГИЙН ПУЛ (ФОНД)

Чингэлгийн пул (фонд)-ын тухай конвенцын дагуу нэг бүрчлэн тохиролцож байгуулсан чингэлгүүдийг хамтран ашиглах.
Жич: НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/Дэлхийн гаалийн байгууллага/Чингэлгийн тухай гаалийн конвенц

CONTAINER SECURITY INITIATIVE (CSI)

The US Container Security Initiative was launched in January 2002 to prevent global containerized cargo from being exploited by terrorists. CSI is designed to enhance security of the sea cargo container, a vital link in global trade. CSI has four key elements:

- using automated information to identify and target high risk containers;
- pre-screening those containers identified as high risk before they arrive at US ports;
- using detection technology to quickly pre-screen high risk containers;
- using smarter, tamper proof containers.

Initial objective is to implement CSI at ports that send large volumes of cargo containers to US in a way that will facilitate detection of potential security concerns at the earliest opportunity.

ЧИНГЭЛГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САНААЧИЛГА

Дэлхийн дахинд чингэлэгтэй ачааг алан хядагчид тонон дээрэмдэхээс сэрэмжлэх зорилгоор АНУ-аас Чингэлгийн аюулгүй байдлын санаачилгыг 2002 оны 1 дүгээр сард эхлүүлсэн байдаг. CSI нь дэлхийн худалдааны гол шугам болох далайн тээврийн чингэлгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилготой болно. CSI нь дараах дөрвөн үндсэн элементийг агуулдаг:

- өндөр эрсдэлтэй чингэлгийг таньж, онилох автоматжуулсан мэдээлэл ашиглах,
- өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон чингэлгүүдийг АНУ-ын боомтод орж ирэхээс өмнө урьдчилан шалгах,
- өндөр эрсдэлтэй чингэлгийг богино хугацааанд түргэн шалгах зорилгоор илрүүлэгч төхөрөөмж ашиглах,
- илүү ухаалаг, гадны халдлагаас хамгаалалттай чингэлэг ашиглах.

Эхний зорилт бол болзошгүй аюулыг эртнээс олж илрүүлэхэд дөхөмтэй байхаар АНУ-руу их хэмжээний ачаатай чингэлэг илгээдэг боомтуудад CSI-ийг нэвтрүүлх явдал юм.

CONTAINER TERMINAL

An area designated for the stowage of cargo in containers, usually accessible by truck, railroad, and marine transportation, where containers are picked up, dropped off, maintained, and housed.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЧИНГЭЛГИЙН ТЕРМИНАЛ

Ачааг чингэлэгт эмх цэгцтэй өрж ачих зориулалттай, гол төлөв ачааны машин орох, төмөр замын болон далайн тээврээр тээвэрлэх боломжтой газар. Тэнд чингэлгийг ачиж, буулгаж, засч сэлбэн, хадгалдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTAINERIZATION

Use of containers on a large scale for the transport of goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЧИНГЭЛЭГЖҮҮЛЭХ

Бараа тээвэрлэх зорилгоор маш олон тооны чингэлэг өргөнөөр ашиглах.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTAINER YARD

A materials handling/storage facility used for completely unitized loads in containers and/ or empty containers.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЧИНГЭЛГИЙН ХАШАА

Ачаатай чингэлэг болон/эсхүл хоосон чингэлэгт зориулагдсан, бараа материал арчлан хамгаалах (зөөвөрлөх) болон хадгалах зориулалттай байгууламж.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTRACT

Document evidencing an agreement between the seller and the buyer for the supply of goods. (UN/ECE/FAL)

Its effects are equivalent to those of an Order followed by an Acknowledgement of order

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГЭРЭЭ

Бараа нийлүүлэх зорилгоор худалдагч ба худалдан авагчийн хооронд тохиролцсоныг нотлох бичиг баримт.
(НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

Түүний үр нөлөө нь дараа нь хүлээн зөвшөөрөгдөх захиалгын үр нөлөөтэй адил байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTRACT IN FOREIGN TRADE

The main commercial document in a foreign trade operation, proving that an agreement has been reached between the participating parties. The subject of a foreign trade contract can be the purchase and sale of goods, execution of contract works, leasing, licensing, granting of the right to sell, consignment, etc.

ГАДААД ХУДАЛДААНД МӨРДДӨГ ГЭРЭЭ

Гадаад худалдааны үйл ажиллагаанд мөрддөг, хэлэлцэн тохирогч талууд хоорондоо тохиролцоонд хүрсэн болохыг заасан, арилжааны үндсэн бичиг баримт. Гадаад худалдааны гэрээний зохицуулах зүйл нь бараа худалдан авах болон худалдах, гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх,

Payments for the supply of goods and services under a foreign trade contract can be made in foreign, international, and national currency, and on no currency basis.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

бараа түрээслэх, лиценз олгох, бараа худалдах эрх олгох, консигнаци г.м. байж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTRACTING PARTIES

Countries that are a party to a convention through signature, ratification or accession.

ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУД

Гарын үсэг зурах, соёрхон батлах, эсхүл нэгдэн орох замаар ямар нэг конвенцийн тал болсон улс орнууд.

CONTRACT OF CARRIAGE

A contract in which a carrier, against the payment of freight, undertakes to carry goods from one place to another. The contract shall provide for carriage by sea and may provide for carriage by other modes of transport in addition to the sea carriage.
(Rotterdam Rules).

ТЭЭВРИЙН ГЭРЭЭ

Тээвэрлэгч тээврийн төлбөр төлсөн тохиолдолд барааг нэг газраас нөгөөд тээвэрлэх үүрэг хүлээсэн гэрээ. Уг гэрээнд ачааг далайн тээврээр тээвэрлэх тухай заах бөгөөд далайн тээврээс гадна тээврийн бусад төрлөөр тээвэрлэх талаар зааж болно.
(Роттердамын дүрэм)

CONTRACT PARTICULARS

Any information relating to the contract of carriage or to the goods (including terms, notations, signatures and endorsements) that is in a transport document or an electronic transport record.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ ЗААЛТУУД

Тухайн гэрээтэй холбоотой, эсхүл тухайн бараатай холбоотой (тухайлбал, болзол нөхцөл, бичлэг, гарын үсэг, баталгаажуулалтын тухай) мэдээлэл. Энэ мэдээлэл нь тээврийн бичиг баримт буюу тээврийн цахим бүртгэлд байдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTRACT RESPONSIBILITY

Liability arising from a breach of contractual obligations. The causes for such a liability can be delays in fulfilling or failure to fulfil obligations, if the debtor cannot prove that the breach of obligations was not his fault.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГЭРЭЭНД ЗААСАН ХАРИУЦЛАГА

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдэлтэй хариуцлага. Ийм хариуцлага хүлээх шалтгаан нь үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байх, эсхүл үүргээ биелүүлээгүй байх явдал болно. Гэхдээ өртэй этгээд үүргээ биелүүлээгүй болох нь түүний буруу биш гэдгийг нотолж чадахгүй байх тохиолдолд тийм хариуцлага хүлээнэ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CONTROLLING PARTY

The person is entitled to exercise the right of control.
Note: Rotterdam Rules

ХЯНАЛТ ТАВЬЖ БУЙ ТАЛ

Хяналт тавих эрхээ хэрэгжүүлж буй этгээд.
Жич: Роттердамын дүрэм

CONTROL OF COMPLIANCE WITH TECHNICAL STANDARDS

Control to ensure that goods meet the minimum international or national standards specified by relevant laws and regulations.
International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods, 1982, Chapter I

ТЕХНИКИЙН СТАНДАРТЫН (ХЭРЭГЖИЛТИЙН) ХЯНАЛТ

Бараа нь холбогдох хууль тогтоомж, журмаар тогтоосон олон улсын, эсхүл дотоодын стандартын наад захын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох хяналт.
Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он), 1 дүгээр бүлэг.

CONTROL SERVICES

Any service responsible for carrying out all or part of the controls defined above or any other controls regularly applied to the importation, exportation or transit of goods.
International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods, 1982, Chapter I.

ХЯНАЛТЫН АЛБАД

Техникийн стандартын хяналтыг бүгдийг нь, эсхүл заримыг нь хийж гүйцэтгэх үүрэг бүхий, эсхүл бараа оруулах, гаргах, эсхүл дамжуулан өнгөрүүлэхэд тогтмол хийх бусад аливаа төрлийн хяналт шалгалтыг хийх үүрэг бүхий аливаа алба.
Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он), 1 дүгээр бүлэг.

CONVENTION

An international treaty, usually with a number of Contracting Parties.

КОНВЕНЦ

Хэлэлцэн тохирогч хэд хэдэн талтай олон улсын гэрээ.

COORDINATED BORDER MANAGEMENT (CBM)

The term refers to a coordinated approach by border control agencies, both domestic and international, in the context of seeking greater efficiencies over managing trade and travel flows, while maintaining a balance of the interests and functions of the various stakeholders (while maintaining a balance with compliance requirements). The term “coordinated border management” may include information exchange, collocated (co-located) facilities, close interagency cooperation, the delegation of administrative authority, and the cross designation of officials.
The term “integrated border management” has been widely in use, but has been more-and-more substituted by “coordinated border management”.

ХИЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ МЕНЕЖМЕНТ

Энэ нэр томьёо нь янз бүрийн оролцогч талуудын ашиг сонирхол, чиг үүргийн тэнцвэрийг хадгалан (хууль дүрэм мөрдөн сахих шаардлагад нийцүүлэн) худалдаа болон зорчигчдын урсгалыг илүү үр дүнтэй удирдан зохицуулах зорилгоор хилийн хяналтын дотоодын болон олон улсын байгууллагууд ажлаа уялдуулан зохицуулах арга хэмжээг илэрхийлдэг. “Хилийн зохицуулалттай менежмент” гэдэг нэр томьёонд мэдээлэл солилцох, нэгдсэн барилга байгууламжтай байх, байгууллагууд хоорондоо нягт хамтран ажиллах, нэг нь нөгөөдөө захиргааны эрх мэдлээ шилжүүлэх болон ажилтнуудын чиг үүргийг дамнуулж солих зэргийг хамруулж болно.
Анх “хилийн цогц менежмент” гэдэг нэр томьёог өргөн хэрэглэж байсан бол одоо “хилийн зохицуулалттай менежмент” гэдэг нэр томьёог илүүтэй хэрэглэх болсон.

The semantics of the word "integrated" suggests the merger of two or more agencies which might reflect the situation in some countries (e.g., in the United States), but is not the case in many others. While some experts still refer to the concept by using the term "integrated" or "collaborative" border management, the World Customs Organization (WCO) prefers to use "coordinated border management". (UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms).

"Цогц" гэдэг үг нь хоёр буюу хэд хэдэн агентлагыг нийлүүлэх гэсэн утгатай бөгөөд энэ зарим улс (жишээлбэл, АНУ)-ын нөхцөл байдалд тохирч байсан бол өөр бусад олон оронд тохирохгүй байсан юм. Хэдийгээр зарим шинжээчид "цогц", хилийн "хамтарсан" менежмент гэсэн нэр томьёог ашиглан дээрх ойлголтыг одоо гэсэн хамгаалсаар байгаа боловч ДГБ "хилийн зохицуулалттай менежмент" гэдэг нэр томьёо ашиглахыг илүүд үзсэн болно.
(Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт)

CONVEYANCE REPORT

A Conveyance Report permits the transfer of data from a carrier to a Customs administration for the purpose of meeting Customs reporting requirements in respect of the means of transport on which cargo is carried. The UN/EDIFACT Customs Conveyance Report Message (CUSREP) permits this transfer of data from a carrier to a Customs administration.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТАЙЛАН МЭДЭЭ

Тээврийн хэрэгслийн тайлан мэдээ нь ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлтэй холбогдуулан, гаалийн байгууллагад тайлан мэдээ гаргаж өгөх шаардлагад нийцүүлэх зорилгоор, мэдээллийг тээвэрлэгчээс гаалийн байгууллагад дамжуулах боломж олгодог. Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрмийн Гаалийн байгууллагын тээврийн хэрэгслийн тайлан мэдээний мессеж (CUSREP) нь мэдээллийг тээвэрлэгчээс гаалийн байгууллагад дамжуулах боломж олгодог.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COPYRIGHT

An exclusive right conferred by a government for a specified period to the creator of literary or artistic works such as books, maps, articles, drawings, charts, photographs, musical compositions, motion pictures, recordings or computer programs. The Uruguay Round accord on trade-related aspects of intellectual property (TRIPS) incorporates all substantive trade-related protection afforded under the Berne Convention for the Protection of Literary and Artistic Works, clarifying that computer

ЗОХИОГЧИЙН ЭРХ

Ном, газрын зураг, нийтлэл, уран зураг, график зураг, гэрэл зураг, хөгжмийн зохиол, хөдөлгөөнт зураг (кино зураг), бичлэг, компьютерийн програм зэрэг утга зохиол туурвигч буюу уран сайхны (урлагийн) бүтээл бүтээгч нарт Засгийн газраас (төрөөс) тодорхой хугацаагаар олгосон онцгой эрх. Уругвайн үе шатанд байгуулагдсан Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр (TRIPS) нь Утга зохиол болон уран сайхны

programs are protected as literary works and compilation of databases as intellectual creation. Protection extends for the duration of the life of the author plus 50 years, and includes rights of translation, reproduction, public performance, broadcasting, adaptation and arrangement, and rental.

(урлагийн) бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцид заасан худалдаатай холбоотой хамгаалалтын бүхий л материаллаг заалтыг өөртөө багтаан агуулж байгаа. Үүгээр компьютерийн програмыг утга зохиолын адилаар хамгаалж байгаа бол мэдээллийн санг оюуны бүтээлийн нэгэн адилаар хамгаалж байгаа гэдгийг тод томруун болгож өгсөн. Эрхийн хамгаалалт нь зохиогчийн амьдралын турш, мөн түүнээс хойш 50 жил үргэлжлэх бөгөөд үүнд орчуулах, хуулбарлах, нийтийн өмнө тоглох, эфирээр дамжуулах, зохиолыг хялбаршуулан найруулах, хөгжмийг тохируулан найруулах, түрээслэх эрхүүд багтана.

CORE COMPONENTS

Syntax-neutral and technology independent building blocks of data that can be used for data modelling. The Core Components Technical Specification (CCTS) and Core Components Library (CCL), developed by UN/CEFACT, provide a basis for business semantics across sectors. Major benefits of the CCTS include improved reuse of existing data artefacts, improved enterprise interoperability, and consistency across vertical industry standards.

Note: UN/CEFACT/CCL

ҮНДСЭН БҮРДЭЛ ХЭСГҮҮД

Өгүүлбэр зүй (syntax)-н хувьд төвийг сахисан бүтэцтэй бөгөөд технологиос хамааралгүй, мэдээллийн загвар гаргахад ашиглаж болох мэдээллийн үндсэн элементүүд. НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвөөс боловсруулсан энэхүү Үндсэн бүрдэл хэсгүүдийн техникийн тодорхойлолт болон Үндсэн бүрдэл хэсгийн сан нь нийт салбарын бизнесийн утгыг илтгэх үндсийг гаргаж өгдөг. Энэхүү Үндсэн бүрдэл хэсгүүдийн техникийн тодорхойлолтын гол ашиг тус нь тухайн үеийн мэдээллийн артефакт (бүтээгдэхүүн)-ыг дахин ашиглах явдлыг нэмэгдүүлж, байгууллагууд хоорондоо харилцан холбогдох боломжтой байдлыг сайжруулж, салбарын стандарттай босоо байдлаар нийцсэн байхад оршино.

Жич: НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан

CORRESPONDING ISSUING ASSOCIATION

An issuing association established in another Contracting Party and affiliated to the same guaranteeing chain.

Note:

Annex A to the Istanbul Convention.

КАРНЕЙН БАТАЛГАА ОЛГОГЧ ХОЛБОГДОХ ХОЛБОО

Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талд байгуулагдсан бөгөөд баталгаа гаргагч ижил сүлжээнд хамаарах, карней олгогч холбоо.

Жич:

Стамбулын конвенцийн хавсралт А.

COST AND FREIGHT

Terms and conditions of shipments according to the Incoterms (see CFR).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ӨРТӨГ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ ШИНГЭСЭН

ИНКОТЕРМС-ийн дагуу томьёолсон ачилтын болзол, нөхцөл (CFR нөхцөлийг үз).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

COUNTERFEIT

Unauthorized representation of a registered trademark carried on goods identical or similar to goods for which the trademark is registered, with a view to deceiving the purchaser into believing that he/she is buying the original goods.

ХУУРАМЧААР (ДУУРИАЛГАН) ҮЙЛДЭХ

Худалдан авагч жинхэнэ бараа худалдан авч байна гэсэн итгэл үнэмшил төрүүлэхээр хууран мэхлэх зорилгоор, бүртгэлтэй барааны тэмдгийг тийм тэмдэг бүхий бараатай адил буюу төстэй бараан дээр зөвшөөрөлгүй хэрэглэх.

COUNTERVAILING DUTIES

Specific duties imposed on imports to offset the benefits of subsidies to producers or exporters in the exporting country. GATT Article VI permits the use of such duties.

НӨХӨН ТӨЛӨӨСИЙН (САРМАГЖУУЛАХ) ТАТВАР

Экспортлогч улс дахь үйлдвэрлэгч буюу экспортлогч нарт тусах татаасын ашиг тустай тэнцэх хэмжээний алдагдлыг нөхөх зорилгоор импортын барааND ногдуулдаг, биет хэмжигдэхүүнээр тогтоосон татвар. ГАТТ-ын VI зүйлийн дагуу ийм татвар ногдуулахыг зөвшөөрдөг.

COUNTERVAILING MEASURES

Action taken by the importing country, usually in the form of increased duties to offset subsidies given to producers or exporters in the exporting country.

НӨХӨН ТӨЛӨӨСИЙН (САРМАГЖУУЛАХ) АРГА ХЭМЖЭЭ

Экспортлогч улс дахь үйлдвэрлэгч буюу экспортлогч нарт тусах татаасын ашиг тустай тэнцэх хэмжээний алдагдлыг нөхөх зорилгоор татварыг нэмэх хэлбэрээр импортлогч оронд авдаг арга хэмжээ.

COUNTRY OF DESTINATION

Data element present in many documents referring to goods or means of transport. It is defined as the name of the country to which a consignment of goods is to be or has been delivered (UNTDED).

БАРАА ХҮЛЭЭН АВАГЧ УЛС

Олон бичиг баримтад агуулагдаж байдаг бөгөөд бараа буюу тээврийн хэрэгсэлд хамаарах мэдээллийн элемент. Түүнийг ачаа бараа хүргэх, эсхүл хүргэсэн улсын нэр гэж тодорхойлсон байдаг.
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

COUNTRY OF ORIGIN OF GOODS

Country in which the goods have been produced or manufactured, according to the criteria laid down for the purposes of application of the Customs tariff, of quantitative restrictions or of any other measure related to trade.

БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙН УЛС

Тухайн барааг гаалийн тариф, тоо хэмжээний хязгаарлалт, эсхүл худалдаанд холбогдох аливаа бусад арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор тогтоосон шалгуурын дагуу үйлдвэрлэсэн буюу хийсэн улс.

Note:
In this definition the word “country” may include a group of countries, a region or a part of a country.
Annex. D.1. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex K, Chapter 1 of the revised Kyoto Convention.

Жич:
1. Энэ тодорхойлолтод дурдсан “улс” гэдэгт бүлэг улс, аль нэг бүс нутаг, эсхүл нэг улсын тодорхой хэсгийг хамааруулан ойлгож болно.
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.1, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт К-ийн 1-р бүлэг
.

COVER NOTE

Document issued by an insurer (insurance broker, agent, etc.) to notify the insured that his insurance has been carried out.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДААТГАЛЫН БАРИМТ

Даатгал хийгдсэн болохыг мэдэгдэж, даатгагч (даатгалын зуучлагч, агент, г.м.)-аас даатгуулагчид олгосон бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CPD CARNET

An international Customs document which incorporates an internationally valid guarantee and may be used, in lieu of national Customs documents and as security for import duties and taxes, to cover the temporary admission of means of transport and, where appropriate, the transit of means of transport. It may be accepted for controlling the temporary exportation and re-importation of means of transport but, in this case, the international guarantee does not apply.

CPD КАРНЕЙ

Үндэсний гаалийн бичиг баримтуудыг орлуулан, мөн импортын гаалийн болон бусад татвар төлөх баталгаа болгон тээврийн хэрэгсэлийг түр хугацаагаар оруулах, мөн боломжтой бол, тээврийн хэрэгслийг дамжуулан өнгөрүүлэх горимд ашиглаж болох олон улсын гаалийн бичиг баримтыг хэлнэ. Түүнийг тээврийн хэрэгслийг түр хугацаагаар гаргах болон буцаан оруулахад хяналт тавих зорилгоор хүлээн зөвшөөрч болно. Гэвч энэ тохиолдолд олон улсын баталгаа гэдэг утгаараа хэрэглэгдэхгүй

Note:
The CPD (Carnet de Passage en Douane) carnet is issued under the terms of the Istanbul Convention, the Customs Convention on the temporary importation of private road vehicles, the Customs Convention on the temporary importation of commercial road vehicles and the Customs Convention on the temporary importation for private use of aircraft and pleasure boats.

Жич:
CPD карнейг Стамбулын конвенц, Хувийн автотээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц, мөн Нисэх онгоц болон чөлөөт аяллын завийг хувийн хэрэглээнд зориулан түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенцид заасан нөхцлөөр олгодог.

CPT (CARRIAGE PAID TO) [INSERT NAMED PLACE OF DESTINATION]

Incoterms rule under which the seller delivers the goods to the carrier contracted by the seller or procures the goods so delivered. The seller may do so by giving the carrier physical possession of the goods in the manner and at the place appropriate to the means of transport used. When CPT, CIP, CFR or CIF are used, the seller fulfils its obligation to deliver when it hands the goods over to the carrier and not when the goods reach the place of destination. This rule has two critical points, because risk passes and costs are transferred at different places. CPT requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out import Customs formalities. It may be used irrespective of the mode of transport selected and may also be used where more than one mode of transport is employed.
[ICC/INCOTERMS 2020]

CPT – (ТЭЭВРИЙН ЗАРДЛЫГ … ХҮРТЭЛ ТӨЛСӨН) [НЭР ЗААСАН ХҮРЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч бараагөөрийн гэрээт тээвэрлэгчид хүргэсэн буюу ийнхүү нийлүүлсэн барааг худалдаж авсан гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм. Худалдагч барааг холбогдох тээврийн хэрэгсэлд тохиромжтой хэлбэрээр болон тохиромжтой газарт тээвэрлэгчийн эзэмшилд ийнхүү биетээр шилжүүлэн өгч болно. Хэрэв CPT, CIP, CFR, CIF нөхцлийг ашигласан бол бараа хүрэх газарт очсоноор бус, харин худалдагч барааг тээвэрлэгчид шилжүүлэн өгсөнөөр худалдагч өөрийн үүргээ гүйцэтгэсэн гэж үзнэ. Энэ дүрэм нь хоёр чухал үеийг онцолдог. Эрсдэл болон өртөг нь хоёр өөр үед шилждэг. CPT нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно.
[ОУХТ/ИНКОТЕРМС]

CREDIT ADVICE

A document or message sent by an account-servicing institution to one of its account owners, to inform the account owner of an entry which has been or will be credited to its account for a specified amount on the date indicated.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

МӨНГӨ ШИЛЖҮҮЛСЭН МЭДЭГДЭЛ

Дансны үйлчилгээний байгууллагаас түүний нэг данс эзэмшигчид илгээсэн, тодорхой хэмжээний мөнгөн дүн тухайн данс эзэмшигчийн данс руу заасан хугацаанд орсон болохыг, эсхүл орно гэдгийг мэдэгдсэн бичиг баримт буюу мессеж.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CREW MEMBER

The master and any person occupied on board a ship, with functions connected to the steering, exploitation and servicing of the vessel, and who is included in the crew list of this vessel during the period of the voyage.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАГИЙН ГИШҮҮН

Аль нэг усан онгоцон дээр ажиллаж байгаа, тухайн усан онгоцыг жолоодох, ашиглах, үйлчлэхтэй холбогдсон чиг үүрэгтэй, аяллын хугацаанд тухайн усан онгоцны багийн гишүүдийн жагсаалтад нэр нь заагдсан хөлгийн дарга болон аливаа этгээд.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CREW'S EFFECTS

Items in everyday use and any other articles belonging to the crew, carried on board a means of transport, and which may be required to be declared to Customs.

Notes:

1. The Annex to the Convention on Facilitation of International Maritime Traffic, London, 1965, provides for a Crew's effects declaration (Model Form IMO FAL Form 4).

2. 2. The declaration required by the Customs may be oral or in written form.

БАГИЙН ГИШҮҮДИЙН ЭД ЗҮЙЛ

Тээврийн хэрэгсэлд авч яваа бөгөөд гаалийн байгууллагад мэдүүлэх шаардлагатай байж болох, багийн гишүүд өдөр тутам хэрэглэдэг эд зүйл, мөн тэдний хувийн хэрэглээний бусад эд хэрэглэл.

Жич:

1. 1965 онд Лондон хотноо батлагдсан Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенцийн хавсралтад Багийн гишүүдийн эд зүйлийн мэдүүлэг (Олон улсын далайн тээврийн байгууллагын Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц (IMCO FAL)-ийн загвар маягт 4)-ийн талаар заасан байдаг.

2. Гаалийн байгууллагаас шаарддаг уг мэдүүлэг нь аман, эсхүл бичгийн хэлбэртэй байж болно.

CROSS-BORDER RECOGNITION

The legal recognition of, e.g., data, processes, methods and standards across national borders.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХИЛ ДАМНАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

Жишээлбэл, мэдээлэл, процесс, арга барил, стандартыг улсын хил дамнуулан эрх зүйн үүднээс хүлээн зөвшөөрөх.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CURRENCY

A medium of exchange of value to define by reference to the geographical location of the authorities responsible for it. In a coded format, a currency is represented by a three-character ISO and UN/CEFACT code.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ВАЛЮТ

Үнэт зүйлийг солилцох хэрэгсэл. Тэр нь түүнийг хариуцсан байгууллагын газар зүйн байршлаар тодорхойлогддог. Кодолсон форматад валютыг Олон улсын стандартчиллын байгууллагын болон НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн гурван тэмдэгт бүхий кодоор илэрхийлдэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CURRENCY CONTROL; FOREIGN EXCHANGE CONTROL

Integral part of the foreign exchange policy of a State focused on monitoring and control of compliance with foreign exchange and foreign trade legislation: control of cross border movements of foreign currency, of currency transactions; or of the fulfilment by residents of foreign currency obligations to the State.

ВАЛЮТЫН ХЯНАЛТ; ГАДААД ВАЛЮТЫН ХЯНАЛТ

Аль нэг улсын гадаад валютын бодлогын салшгүй нэг хэсэг. Энэ нь гадаад валютын болон гадаад худалдааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихад чиглэгддэг. Үүнд: гадаад валютын болон валютын хэлцлийн хил дамнасан хөдөлгөөний

хяналт; эсхүл оршин суугчид тухайн улсын гадаад валютад холбогдох үүргээ биелүүлж байгаа эсэхэд тавих хяналт.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CURRENCY OFFENCES

Violation of rules on currency transactions.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ВАЛЮТЫН ЗӨРЧИЛ

Валютын хэлцлийн тухай дүрмийн зөрчил.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CURRENCY TERMS AND CONDITIONS OF A CONTRACT

Conditions agreed in foreign trade contracts: such as currency of the contract price; currency of payment; rate of conversion of the currency of the price to the currency of payment; reservations protecting the parties from foreign exchange risks

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГЭРЭЭНД ЗААСАН ВАЛЮТЫН БОЛЗОЛ, НӨХЦӨЛ

Гадаад худалдааны гэрээгээр тохиролцсон нөхцөл: тухайлбал, гэрээний үнийг тохиролцсон валют; төлбөр хийх валют; гэрээний үнийг тохиролцсон валютыг төлбөр хийх валютад шилжүүлэх ханш; холбогдох талуудыг гадаад валютын эрсдэлээс хамгаалахаар хийсэн тайлбарууд.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS

The Government Service which is responsible for the administration of Customs law and the collection of duties and taxes and which also has the responsibility for the application of other laws and regulations relating to the importation, exportation, movement or storage of goods.

Notes:

1. This term is also used when referring to any part of the Customs
Service or its main or subsidiary offices.

2. This term is also us ed adjectivally in connection with officials of the Customs, duties and taxes or control on goods, or any other matter within the purview of the Customs (Customs officer, Customs duties, Customs office, Customs declaration).

General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА

Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гаалийн болон бусад татвар хураан авах, түүнчлэн бараа оруулах, гаргах, хөдөлгөх, эсхүл хадгалахтай холбоотой бусад хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдүүлэх чиг үүрэг бүхий төрийн алба.

Жич:

1. Энэхүү нэр томьёо нь гаалийн албаны аль нэг хэсэг, эсхүл түүний үндсэн болон харъяа байгууллагад нэгэн адил хамаарна.

2. Энэхүү нэр томьёо нь гаалийн албан тушаалтан, барааны экспорт, импортын гаалийн албан татварын хяналт, эсхүл гаалийн байгууллагын эрх хэмжээнд хамаарах аливаа бусад асуудал (гаалийн байцаагч, гаалийн татвар, гаалийн газар, байгууллага, гаалийн мэдүүлэг)-д мөн адил хамаарна.

Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 1-р бүлэг.

CUSTOMS APPLICANT

Any person who makes a goods declaration or in whose name such a declaration is made.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН МЭДҮҮЛЭГЧ

Барааны мэдүүлэг бичсэн этгээд, эсхүл нэр дээр нь тийм мэдүүлэг бичигдсэн этгээд.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS APPROVED ROUTE

Any road, railway, waterway, airway and any other route (pipeline, etc.), which must be used for the importation, Customs transit and exportation of goods.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГААС ЗӨВШӨӨРСӨН ЗАМ

Бараг оруулах, дамжуулан өнгөрүүлэх болон гаргахад ашиглах ёстой аливаа авто зам, төмөр зам, усан зам, агаарын зам болон өөр бусад зам (дамжуулах хоолой, гэх мэт).

CUSTOMS AREA

An area designated for storage of commercial goods that have not yet cleared Customs. It is surrounded by a customs border.

ГААЛИЙН БҮС

Гаалиар бүрдүүлэлт хийлгэж хараахан амжаагүй байгаа худалдааны бараг хадгалах зориулалттай газар. Энэ бүс нь гаалийн хилээр хүрээлэгдсэн байна.

CUSTOMS BARRIER

A Customs barrier, or trade barrier, acts to limit trade across borders by creating and enforcing various restrictions. These restrictions can come in the form of tariffs, levies, duties and trade embargoes and are put in place with the intentions to discourage trade.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН СААД ТОТГОР

Гаалийн саад тотгор буюу худалдааны саад тотгор. Энэ нь янз бүрийн хязгаарлалт бий болгож, түүнийг албан журмаар хэрэгжүүлэх замаар хилээр нэвтрэх худалдааг хязгаарладаг. Эдгээр хязгаарлалт нь тариф, татвар, гаалийн татвар болон худалдааны эмбарго хэлбэрээр илэрч болох бөгөөд тэдгээрийг худалдааг өргөжүүлэн хөгжүүлэх сонирхлыг буурлах зорилгоор амьдралд нэвтрүүлдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS BORDER

Border of the territory on which Customs legislation applies. When creating free economic zones, the Customs border may not coincide with the State border.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ХИЛ

Гаалийн хууль тогтоомж мөрдөгдөх нутаг дэвсгэрийн хил. Чөлөөт эдийн засгийн бүс байгуулснаар гаалийн хил улсын хилтэй давхцахгүй болж магадгүй юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS BROKER

Customs brokers are defined in the Revised Kyoto Convention as “third parties” in the meaning of any person who deals directly with the Customs, for and on behalf of another person, relating to the importation, exportation, movement or storage of goods.

As stipulated by Standard 8.1 of the Revised Kyoto Convention, importers, exporters and any other person concerned shall have the choice of either transacting business with the Customs directly or of designating a third party to act on their behalf. This freedom of choice will lead to a healthy business environment where competition will result in fair service charges, which will help reduce the cost of trading internationally.

ГААЛИЙН ЗУУЧЛАГЧ

Гаалийн зуучлагчийг Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцид бараа импортлох, экспортлох, хөдөлгөх, эсхүл хадгалахтай холбоотой асуудлаар өөр бусад этгээдийн төлөө болон тэдний нэрийн өмнөөс гаальтай шууд харьцах “гуравдагч талууд” гэж тодорхойлсон болно. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Стандарт 8.1-д заасны дагуу импортлогч, экспортлогч болон холбогдох бусад этгээд гаалийн байгууллагатай шууд харьцах, эсхүл тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулах гуравдагч талыг томилохын аль нэгийг сонгох ёстой. Ийм чөлөөт сонголттой байх нь үйлчилгээний шударга төлбөрөөр өрсөлдөх бизнесийн эрүүл орчинг бүрдүүлж, олон улсын хэмжээнд худалдааны зардлыг бууруулахад тус дөхөмтэй байх болно.

CUSTOMS CARRIER

The Customs carrier is entitled to transport goods under Customs control without Customs escort and payment of Customs payments. The relations of a Customs carrier and a consignor of goods are built on a contractual basis.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ТЭЭВЭРЛЭГЧ

Гаалийн тээвэрлэгч нь барааг гаалийн хяналтын дор, гаалийн харгалзагчгүйгээр, мөн гаалийн төлбөргүйгээр тээвэрлэх эрхтэй байдаг. Гаалийн тээвэрлэгч, бараа илгээгч хоёрын харилцаа гэрээний үндсэн дээр тогтдог.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS CLEARANCE

The documented permission to pass that a national Customs authority grants to imported goods so that they can enter the country or to exported goods so that they can leave the country. Customs clearance is the procedure of completing formalities required by the Customs legislation of a country and necessary for the importation of goods into the domestic market for consumption, for exportation or for placing them under another Customs procedure. Customs clearance of goods includes Customs operations, payment of Customs duties, and other types of administrative actions related to the legalization of goods necessary for their importation/ exportation; permission for the importation (exportation) of goods.

ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ

Үндэсний гаалийн байгууллага импортын барааг тухайн улсад оруулах, эсхүл экспортын барааг тухайн улсаас гаргахыг зөвшөөрч хилээр нэвтрүүлэхээр баримтжуулсан зөвшөөрөл. Гаалийн бүрдүүлэлт гэдэг нь аль нэг улсын гаалийн хууль тогтоомжоор шаардсан ёс журмын ажиллагааг дуусгавар болгох, мөн барааг дотоодын зах зээлд хэрэглэх зорилгоор оруулахад, эсхүл гаргахад, эсхүл гаалийн өөр горимд байршуулахад шаардагдах горим журам юм. Барааны гаалийн бүрдүүлэлт гэдэгт гаалийн операцууд, гаалийн татвар төлөлт, барааг оруулах, гаргахад явдлыг хууль ёсны болгохтой холбогдсон захиргааны байгууллагын өөр бусад төрлийн үйлдлүүд, бараа оруулах (гаргах) зөвшөөрөл хамаарна.

The Customs clearance is typically given to a shipping agent to prove that all applicable Customs duties have been paid and the shipment has been approved.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

Гаалийн бүрдүүлэлт хийлгэх эрхийг ерөнхийдөө ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн агентад өгсөн байдаг. Тэр нь гаалийн холбогдох бүх татвар төлөгдсөн, мөн ачааны зөвшөөрөл авсан болохыг нотлох үүрэг хүлээдэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS CLEARANCE CHARGES

Binding or non-binding, permanent or temporary payments (for statistical, vintage, license, parcel post, sealing, stamping, warehousing, goods safety or other services) levied in a prescribed manner when moving goods across the Customs border of a country.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ТӨЛБӨР (ХУРААМЖ)

Барааг аль нэг улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тогтоосон журмын дагуу ногдуулдан албан журмын, эсхүл албан журмын бус, тогтмол, эсхүл түр хугацааны төлбөрүүд (статистикийн, үйлдвэрлэсэн хугацааны, лицензийн, шуудан илгээмжийн, битүүмжлэлийн, тэмдэгтийн, агуулахын, барааны аюулгүй байдлыг хамгаалах, эсхүл өөр бусад үйлчилгээний хураамж).

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS CLEARING AGENT

A person who carries on the business of arranging for the Customs clearance of goods and who deals directly with the Customs for and on behalf of another person.

Notes:
1. Examples of Customs clearing agents are Customs agents, Customs brokers and freight forwarders.
2. Some countries require that Customs clearing agents or Customs brokers be approved or licensed by the Customs.

3. See also the term “Third party”.
Annex G.2 to the Kyoto Convention of 1974.

ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН АГЕНТ

Бусад этгээдийн төлөө, эсхүл түүний нэрийн өмнөөс гаалийн байгууллагатай харьцаж, барааны гаалийн бүрдүүлэлт хийх ажил эрхэлдэг этгээд.

Жич:
1. Гаалийн бүрдүүлэлтийн агентийн жишээ нь гаалийн агент, гаалийн зуучлагч болон тээвэр зууч юм.
2. Зарим улсад гаалийн бүрдүүлэлтийн агент буюу гаалийн зуучлагч гаалийн байгууллагаас лиценз буюу зөвшөөрөл авсан байх шаардлагатай байдаг.
3. “Гуравдагч тал” гэсэн нэр томьёог үз.
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт G.2

CUSTOMS CONTROL

Measures applied by the Customs to ensure compliance with Customs law.

ГААЛИЙН ХЯНАЛТ

Гаалийн хууль тогтоомжийг мөрдлөг болгох явдлыг хангах зорилгоор гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.

Measures applied to ensure compliance with the laws and regulations which the Customs are responsible for enforcing.

Note:
The measures may be general, e.g., in relation to all goods entering the Customs territory, or may be specifically related to, e.g.:
(a) the location of the goods;
(b) the nature of the goods (liable to a high rate of duty, etc.);
© the Customs procedure applied to the goods (Customs transit, etc.).

General Annex, Chapters 2 and 6 of the revised Kyoto Convention.

Harmonization of Frontier Controls of Goods, 1982, Chapter I

Гаалийн байгууллагаас биелэлтийг нь хангах талаар хариуцаж буй хууль тогтоомж, журмыг мөрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.

Жич:
Уг арга хэмжээ нь гаалийн нутаг дэвсгэрт орж байгаа бүх бараанд хамаарах ерөнхий шинжтэй, эсхүл зөвхөн дараах зүйлсэд хамаарах тусгайлсан шинжтэй байж болно:
(a) тухайн барааны байршил;
(b) тухайн барааны мөн чанар (өндөр татвартай бараа, г.м);
© тухайн бараанд хамаарах гаалийн горим (гаалийн дамжуулан өнгөрүүлэх горим, г.м).
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2, 6 дугаар бүлэг.
Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он), 1 дүгээр бүлэг.

CUSTOMS CONVENTION ON CONTAINERS, 1972

Done in Geneva on 2 December 1972 under the auspices of the United Nations and the International Maritime Organization (IMO, UNECE/WCO/CCC)

1972 ОНЫ ЧИНГЭЛГИЙН ТУХАЙ ГААЛИЙН КОНВЕНЦ

Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Олон улсын далайн тээврийн байгууллагын ивээл дор 1972 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Женев хотноо байгуулагдсан.
(Олон улсын далайн тээврийн байгууллага, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/Дэлхийн гаалийн байгууллага/Чингэлгийн тухайн гаалийн конвенц)

CUSTOMS CONVENTIONS ON TEMPORARY IMPORTATION OF PRIVATE AND COMMERCIAL ROAD VEHICLES, 1954 AND 1956

(UNECE/TRANS/107] [UNECE/TRANS/108)

ХУВИЙН АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ ТУХАЙ 1954 ОНЫ ГААЛИЙН КОНВЕНЦ ХУДАЛДААНЫ (ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ ЗОРИУЛАЛТТАЙ) АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ ТУХАЙ 1956 ОНЫ ГААЛИЙН КОНВЕНЦ

(НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/Тээвэр/107] [НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/Тээвэр/108)

CUSTOMS CONVENTION ON THE INTERNATIONAL TRANSPORT OF GOODS UNDER COVER OF TIR CARNETS; "TIR CONVENTION"

(UNECE/TIR)

ТИР КАРНЕЙ АШИГЛАН БАРААГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦ (ТИР КОНВЕНЦ)

(НҮБ-ын Европын эдийн засгийн комисс / ТИР)

CUSTOMS DECLARATION

Any statement or action, in any form prescribed or accepted by the Customs, giving information or particulars required by the Customs.

Notes:
1. This term includes declarations made through electronic means.
2. This term also covers action required on the part of passengers under the dual -channel (red/green) system.

ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

Гаалийн байгууллагаас шаардсан мэдээллийг тусгасан, гаалийн байгууллагаас тогтоосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн аливаа маягтаар/хэлбэрээр үйлдсэн аливаа мэдэгдэл.

Жич:
1. Энэ нэр томьёонд цахим хэрэгслээр мэдүүлсэн мэдүүлэг хамаарна.
2. Энэ нэр томьёонд бас хос гарц (улаан/ногоон гарц)-ын системийн дагуу зорчигчдоос хийх ёстой үйлдэл хамаарна.

CUSTOMS DECLARATION (POST PARCELS)

Document which, according to Article 106 of the “Agreement concerning Postal Parcels” under the Universal Postal Union Convention, must accompany post parcels and in which the contents of such parcels are specified (UPU).

ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ (ШУУДАН ИЛГЭЭМЖ)

Дэлхийн шуудангийн холбооны тухай конвенцийн хүрээнд байгуулагдсан “Шуудан илгээмжийн тухай хэлэлцээр”-ийн 106 дугаар зүйлийн дагуу шуудан илгээмжийг дагалдах ёстой бөгөөд тухайн илгээмж дотор агуулагдаж байгаа зүйлийг тодорхойлсон бичиг баримт
(Дэлхийн шуудангийн холбоо)

CUSTOMS DELIVERY NOTE

Document whereby a Customs authority releases goods under its control to be placed at the disposal of the party concerned.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРГЭЖ ӨГСӨН ТУХАЙ ГААЛИЙН БИЧИГ

Гаалийн байгууллага барааг өөрийн хяналтын дор холбогдох талын мэдэлд хүргэж өгсөн тухай бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS DUTIES

Duties laid down in the Customs tariff to which goods are liable on entering or leaving the Customs territory.

Note:
General Annex, Chapters 2 and 4 of the revised Kyoto Convention.

ГААЛИЙН ТАТВАР

Гаалийн нутаг дэвсгэрт орж байгаа, эсхүл түүнээс гарч байгаа барааанд гаалийн тарифын дагуу ногдуулах татвар.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2, 4 дүгээр бүлэг.

CUSTOMS ENFORCMENT NETWORK (CEN)

The global web-based, automated Customs enforcement system developed by the World Customs Organization (WCO) for gathering non-nominal data and information which also acts as a central depositary for enforcement-related information at global level.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ СҮЛЖЭЭ

Тодорхой нэр, хаяггүй мэдээ, мэдээлэл цуглуулах зорилгоор ДГБ-аас хөгжүүлсэн, веб-д суурилсан, гаалийн байгууллагын хууль сахиулах дэлхийн автоматжуулсан систем. Эдгээр мэдээ, мэдээлэл нь дэлхийн хэмжээнд хууль сахиулах чиг үүрэгтэй холбогдсон мэдээллийн төв бааз болдог.

CUSTOMS ENFORCEMENT NETWORK COMMUNICATION (CEN Comm)

A web-based, automated communication tool developed by the World Customs Organization (WCO) to enable law enforcement agencies and other parties to exchange and disseminate information securely within a Closed User Group.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ (CEN Comm)

Хууль сахиулах агентлагууд болон бусад талууд Хаалттай хэрэглэгч бүлгийн хүрээнд мэдээллийг аюулгүй хэлбэрээр солилцож, түгээх боломжийг бүрдүүлэх зорилгоор ДГБ-аас хөгжүүлсэн, веб-д суурилсан харилцаа холбооны автоматжуулсан хэрэгсэл

CUSTOMS EXAMINATION ZONE

The facility and its adjacent territory, where Customs officials carry out Customs control, as well as the territory and premises of companies and organizations engaged in the storage of goods and other items under Customs control.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС

Гаалийн байгууллагын ажилтнууд гаалийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг байгууламж болон түүнтэй залгаа орших нутаг дэсвгэр, мөн түүнчлэн гаалийн хяналтанд байгаа бараа болон бусад зүйлийг хадгалах ажил эрхэлдэг компани, байгууллагын нутаг дэвсгэр, байр байгууламж.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS FACILITIES

a) Customs buildings, equipment or, an even narrower meaning, offices, x-ray facilities, etc.
b) Customs preferences or privileges
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БАЙР БАЙГУУЛАМЖ

a) Гаалийн байгууллагын барилга, тоног төхөөрөмж, эсхүл явцуу утгаараа, аулын байр, рентген төхөөрөмжүүд, г.м.
b) гаалийн байгуулагын давуу эрх буюу эрх ямба.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS FEE

Fee collected by Customs more than Customs duties.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ХУРААМЖ

Гаалийн татвараас илүүтэй гаалийн байгууллагын хураан авдаг хураамж.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS FORMALITIES

All the operations which must be carried out by the persons concerned and by the Customs in order to comply with the Customs law.

Notes

1. These formalities may include those relating to phytosanitary, veterinary, immigration, currency and licensing regulations.

2. The Customs formalities in connection with various Customs procedures and practices are dealt with in the Kyoto Convention.

General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ГААЛИЙН ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА

Гаалийн хууль тогтоомжийг мөрдлөг болгох үүднээс холбогдох этгээд болон гаалийн байгууллагаас хийж гүйцэтгэвэл зохих бүхий л үйл ажиллагаа.

Жич:

1. Эдгээр ёс журмын ажиллагаанд ургамлын хорио цээр, мал эмнэлэг, шалган нэвтрүүлэх, валют болоод лицензийн журамд хамаарах ёс журмын ажиллагаа багтаж болно.

2. Гаалийн төрөл бүрийн горим, парктик ажиллагаанд хамаарах гаалийн ёс журмын ажиллагааны талаар Киотогийн конвенцид тусгасан байдаг.

Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

CUSTOMS FORMALITIES APPLICABLE TO MEANS OF TRANSPORT FOR COMMERCIAL USE

All the operations to be carried out by the person concerned and by the Customs in respect of means of transport for commercial use arriving in or departing from the Customs territory and during their stay therein.

ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ ЗОРИУЛАЛТТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ХАМААРАХ ГААЛИЙН ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА

Гаалийн нутаг дэвсгэрт орж ирж байгаа, эсхүл түүнээс гарч явж байгаа худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгслийн хувьд, мөн уг тээврийн хэрэгсэл тухайн гаалийн нутаг дэвсгэрт байх хугацаанд холбогдох этгээд болон гаалийн байгууллагаас хийж гүйцэтгэвэл зохих бүхий л үйл ажиллагаа.

CUSTOMS FORMALITIES APPLICABLE TO STORES

All the operations to be carried out by the person concerned and by the Customs in respect of stores.

ОЛОН УЛСЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРААНД ХАМААРАХ ГААЛИЙН ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА

Олон улсын тээврийн үйлчилгээний барааны хувьд холбогдох этгээд болон гаалийн байгууллагаас хийж гүйцэтгэвэл зохих бүхий л үйл ажиллагаа.

CUSTOMS FORMALITIES IN RESPECT OF POSTAL ITEMS

All the operations to be carried out by the interested party and the Customs in respect of postal traffic.

ШУУДАН ИЛГЭЭМЖИД ХАМААРАХ ГААЛИЙН ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА

Шуудан тээвэртэй холбогдуулан сонирхогч тал болон гаалийн байгууллагаас хийж гүйцэтгэвэл зохих бүхий л үйл ажиллагаа.

CUSTOMS FORMALITIES PRIOR TO LODGEMENT OF GOODS DECLARATION

All the operations to be carried out by the person concerned and by the Customs from the time goods are introduced into the Customs territory until goods are placed under a Customs procedure.

БАРААНЫ МЭДҮҮЛЭГ ГАРГАЖ ӨГӨХӨӨС ӨМНӨХ ГААЛИЙН ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА

Бараа гаалийн нутаг дэвсгэрт орж ирсэн цагаас уг барааг гаалийн аль нэг горимд байршуулах хүртэлх хугацаанд холбогдох этгээд болон гаалийн байгууллагаас хийж гүйцэтгэвэл зохих бүхий л үйл ажиллагаа.

CUSTOMS FRAUD

Any act by which a person deceives, or attempts to deceive, the Customs and thus evades, or attempts to evade, wholly or partly, the payment of duties and taxes or the application of prohibitions or restrictions laid down by Customs law or obtains, or attempts to obtain, any advantage contrary to Customs law, thereby committing a Customs offence.

Notes:
1. In some countries, deceiving Customs constitutes Customs fraud only when it is intentional.
2. Deceit through an act of omission may or may not be regarded as Customs fraud.
3. In some countries or Customs territories, certain offences against statutory and regulatory provisions enforced or administered by Customs administrations on behalf of other government agencies are not considered as Customs fraud.

Nairobi Convention

ГААЛИЙН ЛУЙВАР

Аливаа этгээд гаалийн байгууллагыг хууран мэхлэх, эсхүл хууран мэхлэхийг завдах замаар импортын, эсхүл экспортын гаалийн болон бусад татварыг бүрэн, эсхүл хэсэгчлэн төлөхөөс, эсхүл гаалийн хууль тогтоомжид заасан хориг, хязгаарлалтыг мөрдөхөөс зайлсхийх, эсхүл тийнхүү зайлсхийхийг завдах, эсхүл гаалийн хуулийн заалтыг зөрчин аливаа давуу байдал олж авах, эсхүл олж авахыг завдах, ингэснээр гаалийн зөрчил үйлдэж буй аливаа үйлдэл.

Жич:
1. Зарим улсад гаалийн байгууллагыг хууран мэхэлсэн үйлдэл нь зөвхөн олон улсын шинжтэй байх тохиолдолд гаалийн луйвар гэж үздэг.
2. Эс үйлдлийн хэлбэрээр хууран мэхлэх явдлыг гаалийн луйварт тооцож, эсхүл эс тооцож болно.
3. Зарим улс буюу зарим гаалийн нутаг дэвсгэрт гаалийн байгууллага нь төрийн бусад байгууллагын нэрийн өмнөөс сахиулан, мөрдөж буй хууль болон хуульчилсан актын заалтыг зөрчсөн зарим зөрчлийг гаалийн луйвар гэж үздэггүй.

Найробийн конвенц

CUSTOMS FRONTIER

The boundary of a Customs territory.

ГААЛИЙН ХИЛ

Гаалийн нутаг дэвсгэрийн хил

CUSTOMS HOUSE

Premises in a port or border checkpoint, where cargo is inspected, Customs clearance is carried out and Customs fees are collected.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА (ГААЛИЙН ГАЗАР, ХОРОО)

Аль нэг боомт буюу хилийн хяналтын цэгт байгаа байр байгууламж. Тэнд ачааг шалгаж, гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хураамж хураан авдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS IMMEDIATE RELEASE DECLARATION

Document issued by an importer notifying Customs that goods have been removed from an importing means of transport to the importer's premises under a Customs-approved arrangement for immediate release, or requesting authorization to do so.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААГ НЭН ДАРУЙ ОЛГОХ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

Барааг нэн даруй олгох зорилгоор, эсхүл тийнхүү олгох зөвшөөрөл хүсэх зорилгоор гаалийн байгуулагаас зөвшөөрсөн баримт нөхцөлийн дагуу импортын тээврийн хэрэгслээс буулгаж, импортлогчийн байр агуулах руу тээвэрлэсэн болохыг нотолж, импортлогчоос олгосон бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS ITEM

A Customs Item is a Consignment Item, a Trade Item or an aggregation of Consignment or Trade Items with distinct Customs tariff code for reporting to Customs.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН БАРАА

Гаалийн бараа гэж консигнацийн бараа, худалдааны бараа, эсхүл консиганцийн буюу худалдааны барааг хамтад нь хэлнэ. Тэдгээр нь гаалийн байгууллагад мэдүүлэх (тайлагнах) зорилготой гаалийн тарифын тусдаа нэг кодтой байна.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS INVOICE

Document required by Customs in an importing country in which an exporter states the invoice or other price (e.g. selling price, price of identical goods), and specifies costs for freight, insurance and packing, etc., terms of delivery and payment, for the purpose of determining the Customs value in the importing country of goods consigned to that country.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ

Импортлогч улсын гаалийн байгууллагаас шаарддаг, экспортлогч импортлогч улс руу ачуулсан барааны гаалийн үнийг тухайн улсад тодорхойлох зорилгоор үнийн нэхэмжлэхийн үнэ, эсхүл өөр бусад үнэ (жишээлбэл, бараа худалдсан үнэ, нэг төрлийн барааны үнэ)-ийг зааж, тээврийн зардал, даатгалын хураамж, сав боодлын г.м. зардал, бараа хүргэх болон төлбөр гүйцэтгэх нөхцөлийг тодорхойлсон бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS LAW

The statutory and regulatory provisions relating to the importation, exportation, movement or storage of goods, the administration and enforcement of which are specifically charged to the Customs, and any regulations made by the Customs under their statutory powers.

ГААЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

Бараа оруулах, гаргах, хөдөлгөх, хадгалахад хамаарах, хэрэгжилтэд нь хяналт тавьж, сахиулах үүргийг гаалийн байгууллагад тусгайлан даалгасан хууль болон хуульчилсан актын заалтууд, мөн хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаалийн байгууллагаас гаргасан аливаа журам.

Note:
Customs law generally includes pr ovisions concerning:
- the functions, powers and responsibilities of the Customs, as well as the rights and obligations of the persons concerned,
- the various Customs procedures, together with the conditions and formalities relating to their application,
- the factors relating to the application of import and export duties and taxes,
- the nature and legal consequences of Customs offences,
- the ways and means of appeal.
- General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

Жич:
Гаалийн хууль тогтоомжид гол төлөв дараах асуудлыг зохицуулсан заалтууд байдаг:
- гаалийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, эрх мэдэл болон хариуцлага (үүрэг), мөн холбогдох этгээдийн эрх, үүрэг,
- гаалийн төрөл бүрийн горимууд, тэдгээрийг ашиглахад хамаарах болзол, нөхцөл, ёс журмын ажиллагаа,
- импорт, экспортын гаалийн болон бусад татвар ногдуулахад хамаарах хүчин зүйлс,
- гаалийн зөрчлийн шинж байдал, эрх зүйн үр дагавар,
- давж заалдах арга, зам.
- Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

CUSTOMS MARITIME ZONE

The sea area under the control of the Customs in accordance with their domestic legislation.

Note 1
The sea area under Customs control may also include a zone continuous to the territorial sea.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТАД БАЙХ ТЭНГИСИЙН БҮС

Аливаа улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гаалийн байгууллагын хяналтад байх тэнгисийн бүс нутаг.

Жич:
Гаалийн байгууллагын хяналтад байх тэнгисийн бүсэд тухайн улсын нутаг дэвсгэрийн уснаас цааш үргэлжлэх далай, тэнгисийн бүсийг оруулан тооцож болно.

CUSTOMS OFFENCE

Any breach, or attempted breach, of Customs law.

Note:
Nairobi Convention and Annex H.2. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex H, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ГААЛИЙН ЗӨРЧИЛ

Гаалийн хууль тогтоомж зөрчсөн, эсхүл зөрчихийг завдсан аливаа үйлдэл.

Жич:
Найробын конвенц, 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Н.2, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт, 1-р бүлэг.

CUSTOMS OFFICE

The Customs administrative unit competent for the performance of Customs formalities, and the premises or other areas approved for that purpose by the competent authorities.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ГААЛИЙН ГАЗАР

Гаалийн ёс журмын ажиллагааг хийж гүйцэтгэх эрх бүхий гаалийн байгууллагын зохион байгуулалтын нэгж, түүнчлэн уг зорилгоор эрх бүхий байгууллагаас тогтоосон барилга байгууламж, эсхүл өөр бусад талбай.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг

CUSTOMS OFFICE OF DEPARTURE

Any Customs office at which a Customs transit operation commences.

Note:
Specific Annex E, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ИЛГЭЭГЧ ГААЛИЙН АЛБА

Дамжуулан өнгөрүүлэх гаалийн ажиллагаа эхэлж буй гаалийн аливаа байгууллага.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е-гийн 1 дүгээр бүлэг

CUSTOMS OFFICE OF DESTINATION

Any Customs office at which a Customs transit operation is terminated.

Note:
Specific Annex E, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ХҮЛЭЭН АВАГЧ ГААЛИЙН АЛБА

Дамжуулан өнгөрүүлэх гаалийн ажиллагаа дуусгавар болж буй гаалийн аливаа байгууллага.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е-гийн 1 дүгээр бүлэг

CUSTOMS OR ECONOMIC UNION

A Union constituted by and composed of Members of the CCC (WCO), of the United Nations or its specialized agencies, which has competence to adopt its own legislation that its binding on its Members, in respect of matters governed by the Convention to which it wishes to accede, and has competence to decide, in accordance with its internal procedures, to sign, ratify or accede to that international instrument.

Note:
The content of the term “Customs or Economic Union” is included in several Conventions, drawn up within the United Nations, under the term “regional economic integration organization”.

ГААЛИЙН БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл (Дэлхийн гаалийн байгууллага), Нэгдсэн үндэстний байгууллага, эсхүл түүний төрөлжсөн байгууллагын Гишүүн орнуудын байгуулсан, мөн тэднээс бүрдсэн, өөрийн нэгдэн орохыг хүссэн конвенцид заасан асуудлаар түүний Гишүүд нь заавал дагаж мөрдөх өөрийн гэсэн хууль тогтоомж батлах эрх бүхий, мөн өөрийн дотоод журмын дагуу олон улсын тэрхүү баримт бичигт гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орох эрх бүхий холбоо.

Жич:
“Гаалийн буюу эдийн засгийн холбоо” гэсэн нэр томьёоны утга агуулга “бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллага” гэсэн нэршлийн дор, НҮБ-аас гаргасан хэд хэдэн конвенцид тусгагдсан байдаг.

CUSTOMS PAPERS

Documents required for processing the movement of goods across the Customs border. (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН БИЧИГ БАРИМТ

Гаалийн хилээр нэвтрэх барааны хөдөлгөөний бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS PAYMENT

Customs duties, taxes, fees, license fees, and other payments levied in accordance with a procedure established by Customs authorities.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ТӨЛБӨР

Гаалийн байгууллагаас тогтоосон горим журмын дагуу ногдуулах гаалийн татвар, бусад татвар, хураамж, лицензийн хураамж, бусад төлбөр.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS PROCEDURE

Treatment applied by the Customs to goods which are subject to Customs control.
Notes:
1. The reference to “goods” includes means of transport.
2. There are various Customs procedures which are dealt with in the Kyoto Convention: clearance for home use, Customs warehousing, inward processing, temporary admission, Customs transit, etc.

ГААЛИЙН ГОРИМ

Гаалийн хяналтад байгаа барааанд гаалийн байгууллагын зүгээс мөрдөх журам.
Жич:
1. “Бараа” гэсэн нэр томьёонд тээврийн хэрэгсэл хамаарна.
2. 2. Киотогийн конвенцид заасан төрөл бүрийн гаалийн горим байдаг: дотоодын хэрэглээнд зориулан оруулах, гаалийн баталгаат агуулах, дотоодод боловсруулах, түр хугацаагаар оруулах, дамжуулан өнгөрүүлэх гаалийн горим, г.м)

CUSTOMS REGULATION

Set of Customs rules established to regulate the movement of goods across the Customs border, transportation and/or storage of goods under Customs control in the country’s Customs territory; Customs clearance of goods; use of goods in accordance with the declared Customs control procedure.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ДҮРЭМ ЖУРАМ

Дараах зорилгоор батлагдсан гаалийн цогц дүрэм: гаалийн хилээр нэвтрэх барааны хөдөлгөөнийг зохицуулах, тухайн орны гаалийн нутаг дэвсгэрт барааг гаалийн хяналтын дор тээвэрлэх болон/эсхүл хадгалах, барааанд гаалийн бүрдүүлэлт хийх, барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн гаалийн хяналтын журмын дагуу ашиглах.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS SEAL

An assembly consisting of a seal and a fastening which are joined together in a secure manner. Customs seals are affixed in connection with certain Customs procedures (Customs transit, in particular) generally to prevent or to draw attention to any unauthorized interference with the sealed items.

“Electronic seal” means a Customs seal equipped with a mechanism for online tracking of the means of transport to which the electronic seal is affixed.

ГААЛИЙН БИТҮҮМЖЛЭЛ

Лац, ломбо, бэхэлгээ утас (татлага)-ыг бат бэх байдлаар холбож угсарсан иж бүрдэл. Гаалийн битүүмжлэлийг ерөнхийдөө битүүмжилсэн зүйлд зөвшөөрөлгүй нэвтрэх явдлаас урьдчилан сэргийлэх, эсхүл тийм зүйлд анхаарлаа хандуулах зорилгоор зарим нэг гаалийн горим (ялангуяа, дамжин өнгөрүүлэх гаалийн горим) мөрдөхтэй холбогдуулан тавьдаг.
“Цахим ломбо” гэж цахим ломбо тавьсан тээврийн хэрэгслийг цахимаар хянах зориулалттай механизмаар тоноглосон гаалийн битүүмжлэлийг хэлнэ.

Note:
Customs seals are generally affixed to packages, containers, load compartments of means of transport, etc. They may also be used as means of identification of the goods themselves.

Жич:
Гаалийн битүүмжлэлийг ихэвчлэн баглаа боодол, чингэлэг, тээврийн хэрэгслийн ачааны хэсэг зэрэгт тавьдаг. Мөн барааг ялган таних зорилгоор түүнийг хэрэглэж болно.

CUSTOMS SYSTEM

Subsystem of a State's regulation of foreign economic activity via control of imports and exports of goods moved across the country's border.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН СИСТЕМ

Тодорхой нэг улсын хилээр нэвтрэн хөдөлж буй барааны импорт, экспортод хяналт тавих явдлаар дамжин хэрэгждэг гадаад эдийн засгийн үйл ажиллагаанд хамаарах аль нэг улсын дүрэм журмын дэд систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS TARIFF

Tax on the importation (in some cases on exportation or transit) of specified goods across national borders. It is charged by a national government and payable to it when the item/ goods cross the national customs border (Trade Facilitation: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ТАРИФ

Тодорхой нэр төрлийн барааг оруулахад (зарим тохиолдолд гаргахад, эсхүл дамжуулан өнгөрүүлэхэд) ногдуулах татвар. Үүнийг засгийн газраас ногдуулдаг бөгөөд тухайн бараа үндэсний гаалийн хилээр нэвтрэх үед засгийн газарт төлнө.

CUSTOMS TERMINAL

The point at which the entry or exit of people and the clearance of goods undergoing Customs control are carried out.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ТЕРМИНАЛ

Гаалийн хяналтын дор хүмүүс орж, гардаг, барааND бүрдүүлэлт хийдэг цэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS TERRITORY

The territory in which the Customs law of a Contracting Party applies (General Annex, Chapter 2, to the Revised Kyoto Convention).

ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭР

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын гаалийн хууль тогтоомж мөрдөж буй нутаг дэвсгэр (шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралт, 2 дугаар бүлэг).

CUSTOMS TRANSIT

Customs procedures under which goods are transported under Customs control from one Customs office to another.

ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГААЛИЙН ГОРИМ

Барааг гаалийн нэг газраас нөгөөд гаалийн хяналтан дор тээвэрлэх гаалийн горим.

Notes:
1. The Customs normally allow goods to be transported under Customs transit in their territory:
(a) from an office of entry into the Customs territory to an office of exit from the Customs territory (through transit);
(b) from an office of entry into the Customs territory to an inland Customs office (inward transit);
(c) from an inland Customs office to an office of exit from the Customs territory (outward transit);
(d) from one inland Customs office to another inland Customs office (interior transit).

Customs transit movements as described in (a) - (c) above are termed "international Customs transit" when they take place as part of a single Customs transit operation during which one or more frontiers are crossed in accordance with a bilateral or multilateral agreement.

2. Customs transit is dealt with in Annex E.1. to the Kyoto Convention of 1974, Specific Annex E, Chapter 1 of the revised Kyoto Convention and the Customs Convention on the international transport of goods under cover of TIR carnets, 1975.

Жич:
1. Гаалийн байгууллага дамжуулан өнгөрүүлэх гаалийн горимын дагуу барааг өөрийн нутаг дэвсгэрт ерөнхийдөө дараах чиглэлээр тээвэрлэхийг зөвшөөрдөг:
(a) хилийн гаалийн нэг байгууллагаас хилийн гаалийн нөгөө байгууллагад (нэвт дамжуулан өнгөрүүлэх)
(b) хилийн (гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагад (орох чиглэлийн дамжуулан өнгөрүүлэх)
(c) гүний гаалийн байгууллагаас хилийн гаалийн байгууллагад (гарах чиглэлийн дамжуулан өнгөрүүлэх)
(d) гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллагад (дотоодод дамжуулан өнгөрүүлэх)
Дээрх (a)-(c)-д заасан гаалиар дамжин өнгөрөх хөдөлгөөн нь хоёр талт буюу олон талт хэлэлцээрийн дагуу нэг буюу түүнээс дээш хил нэвтрэх гаалийн дамжуулан өнгөрүүлэх нэгдсэн нэг ажиллагааны нэг хэсэг болж байвал түүнийг "гаалийн олон улсын дамжуулан өнгөрүүлэх" гэж томьёолно.

2. Гаалийн дамжуулан өнгөрүүлэх горимын талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е.1-д, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е-гийн 1 дүгээр бүлэгт, мөн ТИР карней ашиглан олон улсын хэмжээнд бараа тээвэрлэх тухай 1975 оны гаалийн конвенцид заасан байдаг.

CUSTOMS TRANSIT OPERATION

Transport of goods from an office of departure to an office of destination under Customs transit.
Annex E.1.to the Kyoto Convention of 1974 and Specific Annex E, Chapter 1 of the revised Kyoto Convention.

"Principal (holder) of transit procedure" means a natural or legal person on whose behalf the transit declaration is made, or a natural or legal person to whom the rights and obligations in respect of transit procedure have been transferred (The WCO Transit Guidelines, 2017).

ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГААЛИЙН АЖИЛЛАГАА

Барааг илгээгч гаалийн албанаас хүлээн авагч гаалийн алба хүртэл гаалийн хяналтанд тээвэрлэх.
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е1 болон шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е-гийн 1 дүгээр бүлэг.

"Дамжин өнгөрөх горимын зөвшөөрөлтэй этгээд" гэж дамжин өнгөрөх мэдүүлгийг нэр дээр нь үйлдсэн аль нэг хувь хүн буюу хуулийн этгээд, эсхүл дамжин өнгөрөх горимын дагуу эдлэх эрх болон хүлээх үүрэг шилжин очсон аль нэг хувь хүн буюу хуулийн этгээдийг хэлнэ.

“Factual office of transit”	“Бараа бодитоор дамжин өнгөрсөн гаалийн алба”
“Office of departure” means any Customs office at which a Customs transit operation commences.	“Илгээгч гаалийн алба” гэж дамжин өнгөрүүлэх гаалийн ажиллагаа эхэлж буй гаалийн аливаа байгууллагыг хэлнэ.
“Office of destination” means any Customs office at which a Customs transit operation is terminated.	“Хүлээн авагч гаалийн алба” гэж дамжин өнгөрүүлэх гаалийн ажиллагаа дуусгавар болж буй гаалийн аливаа байгууллагыг хэлнэ.
“Office en route”/ “Office of transit” means any Customs office located on the route of Customs transit operations**.	“Зам дагуу байрлах гаалийн газар (Дамжин өнгөрөх гаалийн газар)” гэж дамжуулан өнгөрүүлэх гаалийн ажиллагааны замд байрлах гаалийн аливаа газар.
“Office of entry” means any office en route where transit goods enter a Customs territory.	“Оруулах гаалийн газар” гэж дамжин өнгөрөх барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах зам дагуу байрлах гаалийн аливаа газрыг хэлнэ.
“Office of exit” means any office en route where transit goods leave a Customs territory.	“Гаргах гаалийн газар” гэж дамжин өнгөрөх барааг гаалийн нутаг дэвсгэрээс гаргах зам дагуу байрлах гаалийн аливаа газрыг хэлнэ.
“National Customs transit”: when the transit procedure applies to one country or Customs territory only and the office of departure and the office of destination are in the same territory. Any security required relates only to the transit movements in the Customs territory concerned.	“Дотоодод (үндэсний хэмжээнд) дамжуулан өнгөрүүлэх гаалийн горим”: хэрэв дамжуулан өнгөрүүлэх үйл ажиллагаа нь зөвхөн нэг улс оронд, эсхүл гаалийн нэг нутаг дэвсгэрт хамаарч байгаа бөгөөд, илгээгч гаалийн алба болон хүлээн авагч гаалийн алба нь тухайн нэг нутаг дэвсгэр дээр байх явдал болно. Шаардлагатай гэсэн аливаа баталгаа нь зөвхөн тухайн гаалийн нутаг дэвсгэрийн хүрээнд явагдах тээврийн хөдөлгөөнд хамаарна.
“International Customs transit”: when the transit movements are part of a single Customs transit operation during which one or more Customs frontiers are crossed in accordance with a bilateral or multilateral agreement. This agreement generally sets 10 out the form of the Goods declaration for Customs transit and, if required, a security acceptable in each of the administrations which are parties to this agreement.	“Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх гаалийн горим”: дамжуулан өнгөрүүлэх тээврийн үйл ажиллагаа нь хоёр талт, эсхүл олон талт хэлэлцээрийн дагуу нэг, эсхүл хэд хэдэн улсын хил нэвтрэн дамжуулан өнгөрүүлэх гаалийн ажиллагааны нэг хэсэг нь болох тохиолдол болно. Энэ хэлэлцээрт ерөнхийдөө дамжуулан өнгөрүүлэх Барааны мэдүүлгийн маягтыг тогтоож өгсөн байдаг бөгөөд шаардлагатай бол энэ хэлэлцээрийн талууд болох (гаалийн) байгууллага тус бүр хүлээн зөвшөөрөх битүүмжлэлийг тогтоож өгдөг.
“Transit Operator” means any natural or legal person performing a Customs transit operation**.	“Транзит оператор” гэж дамжуулан өнгөрүүлэх гаалийн ажиллагаа гүйцэтгэж буй аливаа хувь хүн буюу хуулийн этгээдийг хэлнэ.
“Transport unit” means any means of transporting goods suitable for use in a Customs transit operation or under a Customs seal.	“Тээврийн хэрэгсэл” гэж дамжуулан өнгөрүүлэх гаалийн ажиллагаанд, эсхүл гаалийн битүүмжлэл тавьж ашиглах боломжтой, бараа тээвэрлэх аливаа хэрэгслийг хэлнэ.

CUSTOMS TREATMENT OF STORES

All the facilities to be accorded and all the Customs formalities applicable to stores.

ОЛОН УЛСЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРААНЫ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ

Олон улсын тээврийн үйлчилгээний бараанд хамаарах бүх хөнгөлөлт, мөн түүнд хамаарах гаалийн ёс журмын бүхий л ажиллагаа.

CUSTOMS UNION

Entity forming a Customs territory replacing two or more territories and having in its ultimate state the following characteristics:

- a common Customs tariff and a common or harmonized Customs legislation for the application of that tariff;
- the absence of any Customs duties and charges having equivalent effect in trade between the countries forming the Customs Union in products originating entirely in those countries or in products of other countries in respect of which import formalities have been complied with and Customs duties and charges having equivalent effect have been levied or guaranteed and if they have not benefited from a total or partial drawback of such duties and charges.
- the elimination of restrictive regulations of commerce within the Customs Union.

ГААЛИЙН ХОЛБОО

Хоёр буюу түүнээс дээш нутаг дэвсгэрийг нэгтгэн, гаалийн нэг нутаг дэвсгэр болгосон бөгөөд эцсийн дүнд дараах шинжийг агуулсан тогтоц:

- гаалийн нэг тарифтай байх бөгөөд уг тарифыг мөрдөх нийтлэг нэг, эсхүл уялдсан нэг гаалийн хууль тогтоомжтой байх;
- тухайн Гаалийн холбооны бүрэлдэхүүнд багтах улсуудын хооронд бүхэлдээ тэдгээр улсын гарал үүсэлтэй (тэдгээр улсад бүхэлд нь үйлдвэрлэсэн) барааг худалдахад, эсхүл өөр улсын гарал үүсэлтэй боловч импортын ёс журмын ажиллагааг зохих ёсоор мөрдөж, гаалийн татвар болон түүнтэй ижил үр нөлөө бүхий төлбөр төлсөн, эсхүл тэдгээрийг төлөх баталгаа гаргасан бөгөөд уг гаалийн татвар болон төлбөрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаан олгох ёсгүй барааг худалдахад аливаа гаалийн татвар болон түүнтэй ижил үр нөлөө бүхий төлбөр байхгүй байх;
- тухайн Гаалийн холбооны дотоод худалдаанд хязгаарлалт тогтоосон дүрэм журам байхгүй болсон байх.

CUSTOMS VALUATION

- A customs procedure applied to determine the customs value of imported goods. If the rate of duty is ad valorem, the customs value is essential to determine the duty to be paid on an imported good.

ГААЛИЙН ҮНЭЛГЭЭ

- Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох зорилгоор мөрддөг гаалийн горим журам. Хэрэв гаалийн татварын хувь хэмжээ нь адвалорем бол ямар нэг импортын бараанд төлөх гаалийн татварыг тодорхойлоход гаалийн үнэ нь чухал ач холбогдолтой байдаг.

- The appraisal of the worth of imported goods by customs officials for the purpose of determining the amount of duty payable in the importing country. The GATT Customs Valuation Code obligates governments that sign it to use the "transaction value" of imported goods—or the price actually paid or payable for them—as the principal basis for valuing the goods for customs purposes. The transaction price may include several additional costs to the buyer (commission and brokerage costs, license fees, the cost of packaging and containers, payment of services, which the importer resorts to when importing goods). The conditions determining the price of the transaction are clearly indicated in the WTO Agreement on the Application of Article VII of GATT 1994.

- Гаалийн ажилтан импортлогч улсад төлөх гаалийн татварын хувь хэмжээг тодорхойлох зорилгоор импортын барааг үнэлэх. ТХЕХ-ийн Гаалийн үнэлгээний кодекс гаалийн зорилгоор барааг үнэлэх үндсэн суурь болгож импортын барааны "хэлцлийн үнэ" – буюу тухайн бараанд төлсөн буюу төлбөл зохих бодит үнэ ашиглахыг засгийн газруудад үүрэг болгосон байгаа. Хэлцлийн үнэд худалдан авагчийн төлсөн хэд хэдэн нэмэлт зардал (импортлогч бараа оруулахдаа төлсөн комиссын болон зуучлалын хөлс, лицензийн хураамж, сав боодлын болон чингэлгийн зардал, үйлчилгээний төлбөр)-ыг оруулан тооцож болно. Хэлцлийн үнийг тодорхойлох нөхцөлүүдийг 1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай ДХБ-ын хэлэлцээрт тодорхой зааж өгсөн байдаг.

CUSTOMS VALUE

- The customs value of imported goods shall be, mainly, the transaction value, that is, the price actually paid for the goods when sold for export to the country of importation. It is based on the price agreed upon price for the goods when they are sold.

ГААЛИЙН ҮНЭ

- Импортын барааны гаалийн үнэ нь үндсэндээ хэлцлийн үнэ, өөрөөр хэлбэл тухайн барааг импортлогч орон руу экспортоор худалдахад бодитоор төлсөн буюу төлбөл зохих үнэ юм. Энэ үнэ нь тухайн барааг борлуулахад тохиролцсон үнэд суурилна.

- Amount declared for Customs purposes of those goods in a consignment which are subject to the same Customs procedure, and have the same tariff/statistical heading, country information and duty regime. [UNTDED]

- Гаалийн нэг горимд хамаарах, мөн тарифын/статистикийн ангиллын нэг зүйлд хамаарах, улсын мэдээлэл болон гаалийн татварын дэглэм нь нэг ижил байх барааны гаалийн зорилгоор мэдүүлсэн дүн
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

CUSTOMS WAREHOUSE

Particularly allocated and equipped premises or other place where specific Customs procedures are carried out. Customs warehousing means the Customs procedure under which imported goods are stored under Customs control in a designated place (a customs warehouse) without payment of import duties and taxes.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН АГУУЛАХ

Гаалийн тодорхой горимуудыг хэрэгжүүлэх зориулалтаар тусгайлан гаргаж, тоноглосон байр байгууламж буюу тийм зориулалттай өөр бусад газар. Барааг гаалийн агуулахад байршуулах гэдэг нь импортын барааг зориулалтын газар (гаалийн агуулах)-т гаалийн хяналтын дор, импортын гаалийн болон бусад татваргүйгээр хадгалах гаалийн горим юм.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

CUSTOMS WAREHOUSING PROCEDURE

Customs procedure under which imported goods are stored under Customs control in a designated place (a Customs warehouse) without payment of import duties and taxes.

Notes:

1. Customs warehouses may be for general use (public Customs warehouses) or for the use of specified persons only (private Customs warehouses).

2. The Customs warehousing procedure is dealt with in Annex E.3. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex D, Chapter 1 of the revised Kyoto Convention.

A warehouse authorized by Customs authorities for storage of goods on which payment of duties and or taxes is deferred until the goods are removed; a Customs bond has likely been put in place.

ГААЛИЙН АГУУЛАХЫН ГОРИМ

Импортын барааг импортын гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хяналтын дор зориулалтын газар (гаалийн агуулахад) хадгалах гаалийн горим.

Жич:

1. Гаалийн агуулах нь нийтэд зориулагдсан (гаалийн нээлттэй агуулах), эсхүл зөвхөн тодорхой нэг хэсэг этгээд ашиглахад зориулагдсан (гаалийн хаалттай агуулах) байж болно.

2. Гаалийн агуулахын горимын талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е.3-т, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт D-гийн 1 дүгээр бүлэгт заасан байдаг.

Холбогдох барааг агуулахаас гаргах хүртэл гаалийн татварын төлбөрийг нь хойшлуулсан бараа хадгалахыг гаалийн байгууллагаас зөвшөөрсөн агуулах; Ерөнхийдөө гаалийн бонд (өр төлөх баталгаа) гаргаж өгсөн байдаг

D

DANGEROUS GOODS (ROAD TRANSPORT)

Goods considered as dangerous according to the European Agreement concerning the International Carriage of
Dangerous Goods by Road (ADR) of 1957.

АЮУЛТАЙ БАРАА (АВТО ТЭЭВЭР)

Аюултай барааг олон улсын хэмжээнд авто замаар тээвэрлэх тухай Европын (1957 оны) хэлэлцээрийн дагуу аюултайд тооцогдох бараа.

DANGEROUS GOODS DECLARATION

Document issued by a consignor in accordance with applicable conventions or regulations, describing hazardous goods or materials for transport purposes, and stating that the latter have been packed and labelled in accordance with the provisions of the relevant conventions or regulations
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЮУЛТАЙ БАРААНЫ МЭДҮҮЛЭГ

Бараа илгээгч аюултай бараа, материалыг тээвэрлэлтийн зорилгоор тодорхойлж, тэдгээр барааг холбогдох конвенц, дүрэм журмын заалтын дагуу савлаж, шошго тавьсан болохыг илтгэж, холбогдох конвенц, дүрэм журмын дагуу үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DANGEROUS GOODS SHIPPER'S DECLARATION (DGD)

A document managed by IATA. To ship dangerous goods, consignors are required to prepare a form certifying that the cargo has been packed, labeled and declared according with the IATA Dangerous Goods Regulations (DGR). An electronic version – the electronic Dangerous Goods Shipper's Declaration (e-DGD) has been developed. [IATA/DGR]

АЮУЛТАЙ БАРААНЫ ТУХАЙ АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)-ИЙН МЭДҮҮЛЭГ

Агаарын тээврийн олон улсын агентлаг (Олон улсын агаарын тээврийн нийгэмлэг)-аас удирдан зохицуулдаг бичиг баримт. Аюултай бараа ачуулахын тулд бараа илгээгч нь холбогдох ачааг Агаарын тээврийн олон улсын агентлагийн Аюултай барааны журмын дагуу савласан, шошго тавьсан болон мэдүүлсэн болохыг гэрчилсэн маягт бөглөх ёстой. Энэ маягтын цахим хувилбар болох Аюултай барааны тухай ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн мэдүүлэг (e-DGD)-ийг боловсруулж байна.
[Агаарын тээврийн олон улсын агентлаг (Олон улсын агаарын тээврийн нийгэмлэг)/ Аюултай барааны тухай ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн мэдүүлэг]

DAF (DELIVERED AT FRONTIER) [INERT NAMED PLACE]

This rule used to be in INCOTERMS 2000, but it was not included in INCOTERMS 2010 or INCOTERMS 2020. DAF rule means that the seller delivers when the goods are placed at the disposal of the buyer on the arriving means of transport not unloaded, cleared for export, but not cleared for import at the named point and place at the frontier, but before the Customs border of the adjoining country. Suitable for rail/road transport.

[ICC/INCOTERMS]

DAF (ХИЛ ДЭЭР ХҮРГЭСЭН) [НЭР ЗААСАН ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Энэ дүрэм нь ИНКОТЕРМС 2000-д байсан. Харин ИНКОТЕРМС 2010 буюу ИНКОТЕРМС 2020-д байхгүй. DAF дүрэм гэдэг нь худалдагч барааг ирэх тээврийн хэрэгсэлд ачиж, буулгалгүйгээр худалдан авагчийн мэдэлд шилжүүлэхээр, экспортын бүрдүүлэлтийг хийлгэн, гэвч хил дээрх нэр заасан боомт болон газарт импортын бүрдүүлэлт хийлгэлгүйгээр зэргэлдээ орших улсын гаалийн хилийн наана хүргэж өгнө гэсэн утгатай юм. Төмөр зам/авто замын тээвэрт хэрэглэхэд тохиромжтой.

[ОУХТ/ИНКОТЕРМС]

DAP (DELIVERED AT PLACE) [INSERT NAMED PLACE OF DESTINATION]

An Incoterms rule, under which the seller delivers when the goods are placed at the disposal of the buyer on the arriving means of transport ready for unloading at the named place of destination or at the agreed point within that place, if any such point is agreed. The seller bears all risks involved in bringing the goods to the named place of destination or to the agreed point within that place. DAP requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer must clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out Customs formalities for importation. Therefore, if the buyer fails to clear the goods for importation, the goods might be held up at the point of entry in the destination country. Therefore, if the parties wish to avoid such scenarios, ICC recommends considering selling and buying under DDP (Delivered Duty Paid) rule. This rule may be used irrespective of the mode of transport selected and may also be used where more than one mode of transport is employed.

[ICC/INCOTERMS 2020]

DAP – (ЗААСАН ГАЗАРТ ХҮРГЭСЭН) [НЭР ЗААСАН ХҮРЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч барааг нэр заасан хүрэх газарт, эсхүл уг газрын тохиролцсон цэгт хүргэхээр тохиролцсон бол тэнд буулгахад бэлэн болсон ирэх тээврийн хэрэгсэлд ачиж худалдан авагчийн мэдэлд шилжүүлэхээр хүргэж өгнө гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм. Худалдагч нь барааг нэр заасан хүрэх газарт, эсхүл уг газрын тохиролцсон цэгт хүргэхтэй холбогдсон бүх эрсдэлийг үүрнэ. DAP нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг. Тэгэхээр, хэрэв худалдан авагч тухайн барааг оруулах бүрдүүлэлтийг хийлгэж чадахгүй бол холбогдох бараа хүрэх улсын орох боомт дээр саатах болно. Тэгэхээр хэрэв талууд ийм байдлаас зайлсхийхийг хүсч байгаа бол бараа худалдах, худалдан авах явдлыг DDP (Гаалийн татвар төлж хүргэсэн) дүрмийн дагуу авч үзэхийг Олон улсын худалдааны танхимаас зөвлөдөг. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно.

[ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

DAT (DELIVERED AT TERMINAL) [INSERT NAMED TERMINAL AT PORT OR PLACE OF DESTINATION]

Incoterms rule included for the first time in INCOTERMS 2010, but then substituted by DPU in INCOTERMS 2020. DAT envisaged that the seller delivered when the goods, once unloaded from the arriving means of transport, were placed at the disposal of the buyer at a named terminal at the named port or place of destination. “Terminal”, in this term, included any place, whether covered or not, such as a quay, warehouse, container yard or road, rail or air cargo terminal. The seller bore all risks involved in bringing the goods to and unloading them at the terminal at the named port or place of destination. This rule could be used irrespective of the mode of transport selected and where more than one mode of transport was employed.

[ICC/INCOTERMS]

DAT (ТЕРМИНАЛ ДЭЭР ХҮРГЭСЭН) [БООМТЫН, ЭСХҮЛ ХҮРЭХ ГАЗРЫН НЭР ЗААСАН ТЕРМИНАЛ БИЧИГДЭНЭ]

ИНКОТЕРМС-ийн энэ дүрмийг анх ИНКОТЕРМС 2010-т оруулсан байдаг. Дараа нь ИНКОТЕРМС 2020-д DPU гэж өөрчилсөн байгаа. DAT нөхцөл нь худалдагч ирэх тээврийн хэрэгслээс нэгэнт буулгасан ачааг нэр заасан боомтын буюу хүрэх газрын нэр заасан терминал дээр байгаа худалдан авагчийн мэдэлд шилжүүлэхээр хүргэж өгнө гэсэн утгатай юм. Энэ нэр томьёон дахь “терминал” гэдэгт усан онгоцны зогсоол, агуулах, чингэлгийн хашаа, эсхүл авто тээврийн, төмөр замын, эсхүл агаарын тээврийн ачааны терминал зэрэг битүү буюу задгай аливаа газар хамаарна. Худалдагч нь нэр заасан боомтын буюу хүрэх газрын терминал дээр барааг авчрах, буулгахтай холбоотой бүх эрсдэлийг хариуцна. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно.

[ОУХТ/ИНКОТЕРМС]

DATA

A representation of facts, concepts or instructions in a formalized manner suitable for communication, interpretation, or processing by humans or automatic means. [Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, 2019]

МЭДЭЭЛЭЛ (ӨГӨГДӨЛ)

Механик, эсхүл автомат аргаар дамжуулж, тайлж, боловсруулахад тохиромжтой албаны хэлбэрт оруулсан баримт, ойлголт, зааврын илэрхийлэл.

[Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он]

DATA CAPTURE

Data capture, or electronic data capture, is the process of extracting information from a document and converting it into data readable by a computer.

[Hyland]

МЭДЭЭЛЭЛ ТАТАХ

Мэдээлэл татах, эсхүл мэдээллийг цахимаар татах гэж мэдээллийг ямар нэг бичиг баримтаас татаж, компьютер унших боломжтой мэдээлэл болгон хувиргахыг хэлнэ.

[Hyland]

DATA CARRIER

A data medium that is designed for storage and/or transportation of data.

МЭДЭЭЛЭЛ ТЭЭГЧ ХЭРЭГСЭЛ

Мэдээлэл хадгалах болон/эсхүл тээвэрлэх зориулалттай мэдээлэл зөөгч хэрэгсэл

DATA ELEMENTS

A unit of data that in a certain context is considered indivisible.

МЭДЭЭЛЛИЙН ЭЛЕМЕНТ

Мэдээллийн нэг нэгж. Энэ нь зарим нэг тохиолдолд үл үзэгдэх хэлбэртэй байдаг.

DATA ELEMENT DIRECTORY
A listing of identified, named and described data element attributes, with specifications as to how the corresponding data element values shall be represented. (see UNTDED)

МЭДЭЭЛЛИЙН ЭЛЕМЕНТИЙН ЛАВЛАХ
Танигдсан, нэрлэсэн болон тодорхойлогдсон мэдээллийн элементийн атрибут (өвөрмөгц шинж)-ын жагсаалт. Үүнд мэдээллийн элементийн өгөгдлийг хэрхэн илэрхийлэх вэ гэдгийг зааж өгсөн байдаг.
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлахыг үз)

DATA ELEMENT VALUES
DATA INTEGRITY
A concept related to the validity of data and its representational faithfulness to the true state of the object that the data represents.
[Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, 2019]

МЭДЭЭЛЛИЙН ЭЛЕМЕНТИЙН ӨГӨГДӨЛ
МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ
Мэдээллийн үндэслэлтэй байдал, мөн тухайн мэдээллийн илэрхийлж буй обьектын үнэмшилтэй үнэн зөв байдалд хамаарах ойлголт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DATA MESSAGE
Any information generated, sent, received or stored by electronic, magnetic, optical or similar means, including, but not limited to, electronic data interchange, electronic mail, telegram, telex or telecopy. [UNCITRAL Electronic Communications Convention]

МЭДЭЭЛЭЛ БҮХИЙ МЕССЕЖ
Цахим, соронзон, шилэн, эсхүл тэдгээртэй адилтгах өөр бусад арга замаар боловсруулсан, илгээсэн, хүлээн авсан, хадгалсан аливаа мэдээлэл. Үүнд дараах зүйлс хамаарна, гэхдээ түүгээр хязгаарлагдахгүй: мэдээллийг цахимаар харилцан солилцох, цахим шуудан, телеграм, телекс, телекопи (гэрэл зургийн аргаар олшруулсан мэдээлэл).
[НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим мэдээллийн (цахим харилцааны) тухай конвенц]

DATA MINING
The process of discovering patterns in large data sets involving methods at the intersection of machine learning, statistics, and database systems. Data mining is an interdisciplinary subfield of computer science, which can be used in electronic business, with an overall goal to extract information (with intelligent methods) from a data set and transform the information into a comprehensible structure for further use (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, 2019)

МЭДЭЭЛЭЛ ОЛБОРЛОХ
Их хэмжээний мэдээллийн багц дахь мэдээллийн төлөвүүдийг нээж илрүүлэх процесс. Үүнд дараах солбицлын аргуудыг хэрэглэнэ: машин сургалт, статистик, мэдээллийн баазын системүүд. Мэдээлэл олборлох гэдэг нь компьютерийн шинжлэх ухааны салбар дундын дэд талбар юм. Энэ арга техникийг техникийг цахим бизнест ашиглаж болно. Үүний эцсийн зорилго нь мэдээллийн багцаас (мэдээлэл боловсруулах аргуудыг ашиглан) мэдээлэл уудлан гаргаж, уг мэдээллийг цааш нь ашиглах зорилгоор энгийн ойлгомжтой бүтцэд хувиргах явдал юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DATA MODEL

See WCO Data Model.

ДАТА МОДЕЛЬ (МЭДЭЭЛЛИЙН ЗАГВАР)

ДГБ-ын Дата моделийг үз.

DATA PIPELINE

In ICT, a pipeline is a set of data processing elements connected in series, where the output of one element is the input of the next. In international trade logistics, the term data pipeline denotes a means for capturing, at the source, existing information from systems used by the parties in the international supply chain, and then used under certain conditions by both businesses and governments. A data pipeline is a means to improve visibility and traceability of transactions and goods in international supply chains. The original commercial data are captured as far upstream as possible, preferably at the Consignment Completion Point (or even earlier), and complemented by data on the movement of the goods.

[Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, 2019]

МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ХООЛОЙ

Мэдээлэл харилцааны технологид, ямар нэг дамжуулах хоолой (конвейер) гэдэг нь хэд хэдэн цувралаар холбогдсон мэдээлэл боловсруулах элементүүдийн нэг багц юм. Энд нэг элементийн гарц (хариулт) дараагийн элементийн орц (асуулт) болж байдаг. Олон улсын худалдааны ложисткикийн хувьд мэдээлэл дамжуулах хоолой гэдэг нь бараа нийлүүлэх олон улсын сүлжээнд оролцогч талуудын ашигладаг (компьютерийн) системүүдээс байгаа мэдээллийг нь (эх үүсвэр дээрээс нь) татах арга юм. Уг мэдээллийг дараа нь тодорхой болзол нөхцөлийн дагуу бизнесийхэн болон төрийнхэн хоёулаа ашигладаг. Мэдээлэл дамжуулах ямар нэг хоолой нь бараа нийлүүлэх олон улсын сүлжээн дэх хэлцэл болон барааг тодорхой болгох, ул мөрийг нь тодруулах арга юм. Худалдааны жинхэнэ (оригинал) мэдээллийг аль болох эхээс нь, болж өгвөл Ачаа цуглуулах цэг (эсхүл бүр түүнээс ч өмнөх цэг)-ээс татаж, дараа нь тухайн барааны хөдөлгөөний талаарх мэдээллээр баяжуулдаг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DATA PRIVACY

Data Privacy (Persons). Any and all personal and sensitive data including names, surname, telephone number, address, visa information, passport information should be secure and safe at all times and should not be shared without consent of the person it relates to. Data Protection is the process of safeguarding important information from corruption, compromise or loss. The importance of data protection increases as the amount of data created and stored continues

[Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, 2019]

МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

Мэдээллийн нууцлал (Хувь этгээд). Нэр, овог, утасны дугаар, хаяг, визийн мэдээлэл, пасспортын мэдээлэл зэрэг хувийн болоод эмзэг аливаа болон бүх мэдээлэл хэзээ ямагт аюул, осолгүй байх ёстой бөгөөд түүнийг түүнд хамаатай эртгээдийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулж болохгүй.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DATA PROTECTION

Data Protection is the process of safeguarding important information from corruption, compromise or loss. The importance of data protection increases as the amount of data created and stored continues.
[Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, 2019]

МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ

Мэдээллийг хамгаалах гэж чухал ач холбогдолтой мэдээллийг бусдад (хууль бусаар) худалдах, найр тавин өгөх, эсхүл тийм мэдээлэл алдагдахаас хамгаалах процессыг хэлнэ. Бий болгосон болон хадгалж буй мэдээллийн хэмжээ өсөх тусам мэдээлэл хамгаалахын ач холбогдол өсдөг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DATA PROTECTION AND CONFIDENTIALITY, FREEDOM OF INFORMATION

When providing specific information, Customs administrations should ensure that confidential or commercially sensitive information is not divulged. Furthermore, appropriate freedom of information would enhance transparency and predictability for traders.

МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ, НУУЦЛАХ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Тусгай мэдээлэл өгөхдөө гаалийн байгууллагууд нууц буюу худалдааны нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх нөхцөлийг хангавал зохино. Түүнээс гадна, мэдээллийн зохих ёсны эрх чөлөөг эрхэмлэх нь худалдаа эрхлэгчдийн хувьд ил тод байдал, урьдчилан таамаглах боломжийг нэмэгдүүлдэг.

DATA RETENTION

A concept covering the policies, legislative instruments and procedures for recording and storing data for legal and other purposes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

МЭДЭЭЛЭЛ ХАДГАЛАХ

Мэдээллийг эрх зүйн болоод бусад зорилгоор бүртгэж, хадгалах зориулалттай бодлого, хууль эрх зүйн акт, горим журмыг хамарсан ойлголт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DATE OF DELIVERY

Date and optionally time when the shipper expect that the goods will be at the place of acceptance.

[UNTDED]

БАРАА ХҮРГЭХ ӨДӨР

Ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн тооцоолсоноор бараа түүнийг хүлээн авах газарт очих өдөр, мөн зарим тохиолдолд цаг минут.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

DATE OF ISSUE

Date when a document was issued and when appropriate, signed or otherwise authenticated.
[UNTDED]

БИЧИГ БАРИМТ ОЛГОСОН ӨДӨР

Аливаа нэг бичиг баримтыг олгосон, шаардлагатай бол гарын үсэг зурсан, өөрөөр хэлбэл, баталгаажуулсан өдөр.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

DDP (DELIVERED DUTY PAID) [INSERT NAMED PLACE OF DESTINATION]

Incoterms rule under which the seller delivers the goods when the goods are placed at the disposal of the buyer, cleared for import on the arriving means of transport ready for unloading at the named place of destination or at the agreed point within that place, if any such point is agreed. The seller bears all the costs and risks involved in bringing the goods to the named place of destination or to the agreed point within that place. DDP represents the maximum obligation for the seller. DDP requires the seller to clear the goods for export (if applicable) and for import and to pay any import duties or carry out any import formalities. Thus if the seller is unable to obtain import clearance and would rather leave that side of things in the buyer's hands in the country of import, ICC recommends choosing DAP (Delivery at Place) or DPU (Delivery at Place Unloaded) rules. This rule may be used irrespective of the mode of transport selected and may also be used where more than one mode of transport is employed. [ICC/INCOTERMS 2020]

DDP (DELIVERED DUTY PAID) [НЭР ЗААСАН ХҮРЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч барааг нэр заасан хүрэх газарт, эсхүл уг газрын тохиролцсон цэгт хүргэхээр тохиролцсон бол тэнд буулгахад бэлэн байгаа ирэх тээврийн хэрэгсэлд ачиж, импортын бүрдүүлэлтийг хийлгэн, худалдан авагчийн мэдэлд шилжүүлэхээр хүргэж өгнө гэсэн үг. Худалдагч нь барааг нэр заасан хүрэх газарт, эсхүл уг газрын тохиролцсон цэгт хүргэхтэй холбогдсон бүх зардал, эрсдэлийг хариуцах бөгөөд тухайн барааны зөвхөн экспортын төдийгүй импортын бүрдүүлэлтийг хийлгэж, экспорт, импортын аливаа гаалийн татварыг төлөх, мөн гаалийн ёс журмын бүх ажиллагааг хийх үүрэгтэй. DDP нь худалдагчийн хувьд хамгийн их үүрэг хүлээлгэдэг. DDP нь барааны экспортын (хэрэв тэгэх шаардлагатай бол), мөн импортын бүрдүүлэлтийг хийлгэх, мөн импортын гаалийн аливаа татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдагчид хүлээлгэдэг. Хэрэв худалдагч импортын бүрдүүлэлтийг хийлгэж чадахгүй байх, энэ үүргээ импортлогч улс дахь худалдан авагчид шилжүүлэх бол DAP (Нэр заасан газарт хүргэх), эсхүл DPU (Нэр заасан газарт хүргэж буулгасан) дүрэм сонгохыг Олон улсын худалдааны танхимаас зөвлөдөг. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно. [ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

DEAD FREIGHT

Dead freight is an amount a shipper needs to pay, when the shipper does not utilize the space he or she has reserved on a truck or a vessel. Late amendments or cancellations may result in dead freight fees, or late cancellation fees.
(Logistics Glossary)

ТЭЭВРИЙН ҮХМЭЛ ЗАРДАЛ

Тээврийн үхмэл зардал гэж ачаа бэлтгэгч (ачигч компани) ачааны машинд, эсхүл автомашинд захиалсан зай талбайг ашиглаагүй тохиолдолд төлдөг төлбөр. Захиалгаа өөрчлөх буюу цуцлах хугацаа хэтэрсний дараа захиалгаа өөрчлөх буюу цуцалсан бол тээврийн үхмэл зардлын хураамж буюу хугацаа хоцорсон цуцлалтын хураамж төлөх хариуцлага хүлээлгэж болох юм.
(Ложистикийн глоссари)

Freight charges paid by the charter of vessel for the contracted space, which is left partially unoccupied.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

Гэрээлсэн зай талбайг дүүрэн бус ачаатай явуулсны төлөө усан онгоцны дүрмийн дагуу төлдөг тээврийн төлбөр.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DECISION

The individual act by which the Customs decide upon a matter relating to Customs law.

ШИЙДВЭР

Гаалийн байгууллага гаалийн хууль тогтоомжид хамааралтай асуудлыг шийдэж буй тухайлсан акт (үйлдэл).

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

DECLARANT

Any person who makes a Goods declaration or in whose name such a declaration is made.

МЭДҮҮЛЭГЧ

Барааны мэдүүлэг үйлдсэн, эсхүл уг мэдүүлгийг өөрийнхөө нэрээр үйлдүүлсэн аливаа этгээд.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

DECLARATION OF ARRIVAL or DECLARATION OF DEPARTURE

Any declaration required to be made or produced to the Customs upon the arrival or departure of means of transport for commercial use, by the person responsible for the means of transport for commercial use, and containing the necessary particulars relating to the means of transport for commercial use and to the journey, cargo, stores, crew or passengers.

ИРЭХ ҮЕИЙН БУЮУ ЯВАХ ҮЕИЙН МЭДҮҮЛЭГ

Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэл ирэх буюу явах үед уг тээврийн хэрэгслийг хариуцагч этгээдээс гаалийн байгууллагад гаргаж өгөх шаардлагатай, эсхүл гаргаж өгсөн бөгөөд тухайн тээврийн хэрэгсэл, түүний аяллын маршрут, ачаа тээш, олон улсын тээврийн үйлчилгээний бараа болоод зорчигч, багийн гишүүдийн талаарх мэдээллийг агуулсан аливаа мэдүүлэг.

Notes:
Specific Annex J, Chapter 3 of the revised Kyoto Convention.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн
1 дүгээр бүлэг.

DECLARATION OF ORIGIN

An appropriate statement as to the origin of the goods made, in connection with their exportation, by the manufacturer, producer, supplier, exporter or other competent person on the commercial invoice or any other document relating to the goods.

ГАРАЛ ҮҮСЛИЙН МЭДҮҮЛЭГ

Бараа экспортлохтой холбогдуулан үйлдвэрлэгч, хийгч, нийлүүлэгч, экспортлогч, эсхүл эрх бүхий бусад этгээд үнийн нэхэмжлэх дээр, эсхүл тухайн бараатай холбогдох аливаа бусад бичиг баримтад уг барааны гарал үүслийг зохих ёсоор тодорхойлсон байх.

Notes:
Annex D.2. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex K, Chapters 2 and 3 of the revised Kyoto Convention.

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.2, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт К-ийн 2, 3 дугаар бүлэг.

DECLARATION ON GLOBAL ELECTRONIC COMMERCE

Adopted at the Second WTO Ministerial Conference, (Geneva 1998) following the growth of electronic commerce globally. This Declaration was the basis for the establishment of the WTO Work Programme on e-commerce (adopted in September 2019). The periodic review of this Work Programme is conducted by the WTO General Council based on reports from the WTO bodies responsible for implementing the programme. (WTO/ECOM)

ДЭЛХИЙН ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТУНХАГЛАЛ

Цахим худалдаа дэлхийн түвшинд хүртэл хөгжсөний дараа ДХБ-ын Сайд нарын 2 дугаар Бага хурал (Женев, 1998 он) дээр батлагдсан. Энэ Тунхаглал нь ДХБ-ын Цахим худалдааны тухай Ажлын хөтөлбөр (2019 оны 9 дүгээр сард батлагдсан)-ийг боловсруулах үндэс суурь болсон. Энэ Ажлын хөтөлбөрийг түүнийг хэрэгжүүлэх үүрэгтэй ДХБ-ын нэгжүүдийн тайланг үндэслэн ДХБ-ын Ерөнхий зөвлөлөөс тогтмол хянан үздэг.
(ДХБ/Цахим худалдаа)

DEDUCTIONS

Amount that is subtracted from the payable sum (UNTDED).

ХАСАГДАХ ДҮН

Төлбөл зохих дүнгээс хасагдах дүн.
(НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах)

DEFERRED DUTY/TAX PAYMENT

Deferred duty/tax payment refers to the payment of duties and taxes for goods declared over a specified period, e.g. 14 days, after the release of the goods, in one amount by bank transfer or other non-cash payment method, to the Customs bank account or by withdrawal by Customs from the trader's Customs account. Standards 4.15 to 4.17 of the Revised Kyoto Convention (RKC), provide for deferred duty/tax payment and require Customs to make this procedure available without interest charges and for a period of a minimum of 14 days.

ХОЙШЛУУЛСАН ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРЫГ ТӨЛӨХ

Хойшлуулсан гаалийн болон бусад татварыг төлөх гэж бараа олгосоноос хойш тодорхой хугацааны дараа, жишээлбэл, 14 хоногийн дараа мэдүүлсэн барааны гаалийн болон бусад татваыг банкны шилжүүлгээр, эсхүл бэлэн бус төлбөрийн өөр бусад аргаар нэг мөсөн банкин дахь гаалийн дансанд шилжүүлэх, эсхүл худалдаа эрхлэгчийн гаалийн данснаас гаалийн байгууллага татан авах замаар төлөхийг хэлнэ. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн стандарт 4.15- 4.17-д хойшлуулсан гаалийн болон бусад татвар төлөх талаар заасан байдаг бөгөөд гаалийн байгууллага энэ гориыг хүүгийн төлбөргүйгээр, доод тал нь 14 хоногийн хугацаанд гүйцэтгэхийг шаарддаг.

DEFERRED PAYMENT CREDIT; DEFERRED PAYMENT LETTER OF CREDIT

Type of letter of credit providing for payment some time after presentation of shipping documents by exporter.

ХОЙШЛУУЛСАН ТАТВАР ТӨЛӨХ КРЕДИТ; ХОЙШЛУУЛСАН ТАТВАР ТӨЛӨХ АККРЕДИТИВ

Экспортлогч тээврийн бичиг баримт гаргаж өгсөнөөс хойш тодорхой хугацааны дараа татвар төлөх аккредитивын хэлбэр

DELIVERY

Shipping arrangements between buyer and seller about movement of products and/or services including dispatch and delivery. A delivery is an identifiable collection of one or more Trade Items (available to be) transported together from the Seller (Original Consignor/ Shipper), to the Buyer (Final/ Ultimate Consignee).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА (ҮЙЛЧИЛГЭЭ) ХҮРГЭХ

Бараа болон/эсхүл үйлчилгээний хөдөлгөөний талаар, түүний дотор тэдгээрийг илгээх болон хүргэх талаар худалдан авагч болон худалдагчийн хооронд байгуулсан ачилтын гэрээ. Хүргэлт гэдэг нь Худалдагч (Анхны илгээгч/Ачаа бэлтгэгч (Ачигч компани))-аас Худалдан авагч (Эцсийн/ Сүүлчийн Хүлээн авагч) хүртэл хамтад нь тээвэрлэх (тээвэрлэхэд бэлэн байгаа) нэг буюу хэд хэдэн худалдааны барааны ялгаран танигдах цуглуулга юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DELIVERY INSTRUCTIONS

Document issued by a buyer giving instructions regarding the details of the delivery of goods ordered.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРГҮҮЛЭХ ЗААВАР

Захиалсан барааг хэрхэн хүргэх тухай нарийвчлан мэдээлэл бүхий заавар өгч, худалдан авагчаас үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DELIVERY NOTICE (GOODS)

Notification in writing, sent by the carrier to the sender, to inform him at his request of the actual date of delivery
of the goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРГЭХ ХУГАЦААГ МЭДЭГДЭХ

Тээвэрлэгчээс бараа хүргэх бодит хугацааг бараа илгээгч этгээдэд түүний хүсэлтээр бичгээр мэдэгдэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DELIVERY ORDER

Document issued by a party entitled to authorize the release of goods specified therein to a named consignee, to be retained by the custodian of the goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРГҮҮЛЭХ ЗАХИАЛГА

Тухайн бичиг баримтад заасан барааг нэрлэсэн хүлээн авагч руу илгээхийг зөвшөөрөх эрх бүхий талаас үйлдсэн бичиг баримт. Уг бараа нь бараа асран хамгаалагчийн мэдэлд үлдэнэ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DELIVERY PARTY

The party to which goods should be delivered, if not identical with consignee such as the place where a container is to be, or has been, positioned. [UNTDED]

БАРААГ ХҮРГЭЖ ӨГӨХ ТАЛ

Барааг хэнд хүргэж өгөх ёстой тэр тал. Гэхдээ тэр нь яг бараа хүлээн авагч байх албагүй. Чингэлэг буух буюу буусан зэрэг газар байж болно.

[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

DELIVERY RELEASE

Document issued by a buyer releasing the dispatch of goods after receipt of a ready for dispatch advice note from the seller.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ИЛГЭЭХИЙГ ЗӨВШӨӨРӨХ

Барааг илгээхэд бэлэн болгосон тухай мэдэгдлийг худалдагчаас хүлээн авсаны дараа түүнийг илгээхийг зөвшөөрч, худалдан авагчаас үйлдсэн бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DE MINIMIS

This is a Latin term, which is a shortened form of the expression de minimis non curat lex meaning 'the law does not care about very small matters'. It is often considered more efficient to waive very small amounts of duties and taxes rather than collect them.

The ICC Customs Guideline #11 defines "de minimis" as a valuation ceiling for goods, including documents and trade samples, below which no duty or tax is charged and clearance procedures, including data requirements, are minimal. Transitional Standard 4.13 of the RKC, Customs administrations shall specify a minimum value or minimum amount of duties and taxes below which no duties and taxes will be collected.

ДЕ МИНИМИС (ҮЛ ТООЦОХ ХУВЬ)

Энэ нь латин үг бөгөөд de minimis non curat lex буюу "маш өчүүхэн жижиг зүйлийг хууль авч хэрэгсдэггүй" гэсэн хэллэгийн товчилсон хэлбэр юм. Гаалийн болон бусад татварын хэт бага дүнг ногдуулж барагдуулснаас зүгээр л хэрэгсэхгүй орхисон нь илүү үр ашигтай гэж үздэг.

Олон улсын худалдааны танхимын Гаалийн заавар #11-д "de minimis"-ийг барааны, түүний дотор бичиг баримт болон худалдааны дээжийн гаалийн болон бусад татвар ногдуулахгүй үнийн дээд хязгаар гэж тодорхойлсон байдаг бөгөөд бүрдүүлэлтийн горим журмын шаардлага, түүний дотор мэдээлэл гаргаж өгөх шаардлага нь хамгийн бага хэмжээнд байна.

Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн шилжилтийн стандартын 4.13-ын дагуу гаалийн байгууллагууд түүнээс доош бол гаалийн болон бусад татвар
хураан авахгүй байх үнийн доод дүн буюу гаалийн болон бусад татварын доод хэмжээг заасан байна.

DEMURRAGE

The agreed sum payable for delay beyond the time stipulated.

ХУГАЦАА ХЭТЭРСНИЙ ТӨЛБӨР

Заасан хугацаа хэтэрч саатсан тохиолдолд төлөхөөр тохиролцсон дүн.

DEPOSIT

БАРЬЦАА БУЮУ БАРЬЦААНД ТАВЬСАН ЗҮЙЛ

A sum of money provisionally paid (French: “consignation”), or title deeds, bearer bonds, etc. lodged as security for the payment of such duties, taxes or other sums as may become chargeable.

Төлж болзошгүй гаалийн болон бусад татвар, эсхүл өөр бусад төлбөрийг төлөх баталгаа болгон урьдчилан төлсөн мөнгөн дүн (францаар “consignation” гэнэ), эсхүл тийм зорилгоор тавьсан өмчлөх эрхийн бичиг, эзэмшигчийн нэргүй бонд (үнэт цаас), г.м.

DEQ (DELIVERED EX QUAY) [INSERT NAMED PORT OF DESTINATION]

This rule used to be in INCOTERMS 2000, but it is not included in INCOTERMS 2010 or INCOTERMS 2020. This rule means that the seller delivers when the goods are placed at the disposal of a buyer not cleared for import on the quay (wharf) at the named port of destination. The seller has to bear costs and risks involved in bringing the goods to the named port of destination and discharging the goods on the quay (wharf). The DEQ term requires the buyer to clear the goods for importation and to pay for all formalities, duties, taxes and other charges upon import.

[ICC/INCOTERMS]

DEQ (УСАН ОНГОЦНЫ ЗОГСООЛД ХҮРГЭЭД ЧӨЛӨӨТЭЙ) НЭР ЗААСАН ХҮРЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Энэ дүрэм нь ИНКОТЕРМС 2000-д байсан. Харин ИНКОТЕРМС 2010 буюу ИНКОТЕРМС 2020-д байхгүй. Энэ дүрэм нь худалдагч барааг импортын бүрдүүлэлт хийлгэлгүйгээр, нэр заасан хүрэх боомтод байгаа усан онгоцны зогсоол дээр худалдан авагчийн мэдэлд шилжүүлэхээр хүргэж өгнө гэсэн утгатай юм. Худалдагч барааг нэр заасан хүрэх боомтод аваачихтай холбогдсон зардал, эрсдэлийг хариуцаж, барааг уг зогсоол дээр үлдээнэ. DEQ нөхцөлийн дагуу худалдан авагч тухайн барааны импортын бүрдүүлэлтийг хийлгэж, ёс журмын бүх ажиллагааны төлбөр, түүнийг оруулахад ногдуулах гаалийн болон бусад татвар, өөр бусад төлбөрийг төлнө.

[ОУХТ/ИНКОТЕРМС]

DESCRIPTION OF GOODS

Description of the nature of a goods item sufficient to identify it for Customs, statistical or transport purposes. [UNTDED]

БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Гаалийн, статистикийн, эсхүл тээврийн зорилгоор барааны мөн чанарыг тодорхойлох.

[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

DESPATCH ADVICE

Document by means of which the seller or consignor informs the consignee about the dispatch of goods.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ИЛГЭЭСЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Худалдагч буюу илгээгч бараа илгээсэн тухай бараа хүлээн авагчид мэдээлж байгаа бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DESPATCH ORDER (ALSO DISPATCH ORDER)

Document issued by a supplier initiating the dispatch of goods to a buyer (consignee).

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ИЛГЭЭХ ЗАХИАЛГА

Барааг худалдан авагч (хүлээн авагч) руу илгээхийг зөвшөөрч бараа нийлүүлэгчээс үйлдсэн бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DESPATCH NOTE (POST PARCELS)

Document which, according to Article 106 of the “Agreement concerning Postal parcels” under the UPU Convention, is to accompany post parcels.
[UPU]

ШУУДАН ИЛГЭЭМЖИЙН ДАГАЛДАГ ХУУДАС

Дэлхийн шуудангийн холбооны конвенцын дагуу байгуулагдсан “Шуудан илгээмжийн тухай хэлэлцээр”-ийн 106 дугаар зүйлийн дагуу шуудан илгээмжийг дагалдах бичиг баримт. [Дэлхийн шуудангийн холбоо]

DESPATCH PARTY

The party where goods are collected or taken over by transport services provider.
UNTDED]

БАРАА ИЛГЭЭГЧ ТАЛ

Барааг цуглуулсан, эсхүл тээврийн үйлчилгээ үзүүлэгч компанид хүлээлгэн өгсөн тал.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

DESTINATION CONTROL STATEMENT (DCS)

A statement made by the exporter or consignor that must be entered on the invoice, and Bill of Lading, air waybill, or other export control document that accompanies the shipment to its ultimate consignee or end-user abroad.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЧИГЛЭЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Экспортлогчийн, эсхүл илгээгчийн үйлдсэн, үнийн нэхэмжлэх болон тээврийн баримт, агаарын тээврийн баримтад хавсрагдах хуудас. Эсхүл сүүлчийн хүлээн авагч буюу гадаад дахь эцсийн хэрэглэгч хүртэл ачааг дагалдах экспортын хяналтын өөр бусад бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DESTINATION STATION

Seaport, airport, freight terminal, rail station or other place at which goods are unloaded from the means of transport having been used for their carriage.
[UNTDED]

БАРАА ХҮЛЭЭН АВАХ ӨРТӨӨ

Бараа тээвэрлэхэд ашигласан тээврийн хэрэгслээс барааг буулгах далайн боомт, нисэх онгоцны буудал, тээвэр зуучийн терминал, төмөр замын өртөө, эсхүл өөр бусад газар. [НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

DIGITAL CERTIFICATE
An electronic document connecting a party's identity to a public key. The certificate includes various identification information related to the party.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДИЖИТАЛ ГЭРЧИЛГЭЭ
Аль нэг талын хувийн мэдээллийг нийтийн (нээлттэй) түлхүүртэй холбосон цахим бичиг баримт. Энэ гэрчилгээнд тухай талтай холбогдсон хувийн янз бүрийн мэдээлэл тусгагдсан байдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DIGITAL CUSTOMS
Any automated or electronic activity that contributes to the effectiveness, efficiency, and coordination of Customs activities, such as automated Customs clearance systems, the Single Window concept, electronic exchange of information, websites to communicate information and promote transparency, and the use of smart phones.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДИЖИТАЛ ГААЛЬ
Гаалийн үйл ажиллагааны үр өгөөж, үр ашигт хувь нэмэр болох, түүнчлэн гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан систем, Нэг Цонхны систем, мэдээллийг цахимаар солилцох, мэдээлэл дамжуулах болон ил тод байдлыг хөхүүлэн дэмжих вэбсайтууд, ухаалаг утас ашиглах зэрэг гаалийн үйл ажиллагааг зохицуулахад хувь нэмэр болох аливаа автоматжуулсан, эсхүл цахим үйл ажиллагаа.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DIGITAL GOODS
In electronic commerce, digital goods is a general phrase used to describe any goods that are stored, delivered and used in its electronic format. Digital goods are shipped electronically to the consumer through email or downloaded from the Internet.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДИЖИТАЛ БАРАА
Цахим худалдааны хувьд, дижитал бараа гэж цахим форматаар (хэлбэрээр) хадгалж, хүргэж, ашиглаж байгаа аливаа барааг илэрхийлэхэд ашигладаг ерөнхий хэллэг. Дижитал барааг хэрэглэгчид цахим шуудангаар дамжуулан цахимаар илгээдэг, эсхүл Интернэтээс татаж авдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DIGITAL SIGNATURE
Technological applications using asymmetric cryptography, also referred to as public key encryption systems that ensure the authenticity of electronic messages and guarantee the integrity of the contents of these messages. The digital signature has many different appearances, such as fail-stop digital signatures, blind signatures and undeniable digital signatures.
[UN/CEFACT/Rec. 14]

ДИЖИТАЛ ГАРЫН ҮСЭГ
Тэгш хэмт бус (тэгш хэмгүй) криптограф ашигладаг технологийн програмууд. Түүнийг бас нийтийн (нээлттэй) түлхүүр ашиглан нууцыг тайлах систем гэдэг. Энэ нь жинхэнэ цахим мессежийг хамгаалж, эдгээр мессежийн агуулгыг задруулахгүй байх баталгаа болдог. Дижитал гарын үсэг нь fail-stop (бүтэлгүйтвэл болих) дижитал гарын үсэг, сохор (харанхуй) гарын үсэг, үл няцаагдах дижитал гарын үсэг зэрэг олон янзын дүр төрхтэй байдаг.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан/Зөвлөмж №14]

DISCRIMINATION IN TRADE

Legal regime providing to legal and private entities from a certain country more limited rights than to entities from another country.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААН ДАХЬ ЯЛГАВАРЛАЛ

Тодорхой нэг улсын хуулийн этгээд болон хувь хүнд өөр нэг улсын хуулийн этгээд болон хувь хүнээс илүү хязгаарлагдмал эрх олгодог эрх зүйн дэглэм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DISPUTE SETTLEMENT

This refers to the process by which any trade disputes among WTO Members can be settled in the WTO following a specific set of rules and procedures, ranging from bilateral consultations, to mediation and arbitration, to the actual initiation and continuation of a trial-like proceeding in which the disputing parties get to present their evidence and argue their case before an panel of trade law experts acting as “judges.”

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Энэ нь ДХБ-ын гишүүн орнуудын хооронд үүссэн худалдааны маргааныг тодорхой нэг цргц дүрэм, журмын дагуу ДХБ-д шийдвэрлэх процесст хамаарна. Энэ процесс нь хоёр тал зөвшихөөс эхлээд эвлэрүүлэн зуучлал, арбитр хүртэл, маргаантай талууд нотлох баримтаа “шүүгч” маягаар ажиллах худалдааны хуулийн мэргэжилтнүүдийн өмнө танилцуулж, тэдний өмнө мэтгэлцэх шүүх ажиллагаатай төстэй ажиллагаа бодитоор эхэлж, үргэлжлэх хүртэл явагдана.

DISTORTION

Situation in which price and production levels are higher or lower than those that would normally exist in a competitive market.

(ХУДАЛДААНЫ) ХАЗАЙЛТ (ГАЖИЛТ)

Үнэ болон үйлдвэрлэлийн түвшин өрсөлдөөнт зах зээл дээр байдаг хэвийн хэмжээнээс өндөр, эсхүл бага байх нөхцөл байдал.

DISTRIBUTOR

A foreign agent who sells directly for a manufacturer and maintains an inventory on hand.

ДИСТРИБЮТОР (ТҮГЭЭГЧ)

Барааг үйлдвэрлэгчийг төлөөлөн шууд борлуулж, бараа материалын тооцоог гар дээрээ хөтөлдөг гадаадын төлөөлөгч.

DOCK RECEIPT

When cargo is delivered to a steamship company at the pier, the receiving clerk issues a dock receipt.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УСАН ОНГОЦНЫ ЗОГСООЛЫН БАРИМТ (ТАСАЛБАР)

Ачааг далан (тавцан) дээр байгаа (уурын) усан онгоцны компанид хүргэх үед ачаа хүлээн авагч ажилтан зогсоолын баримт (тасалбар) олгодог.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DOCUMENT

Any medium designed to carry and actually carrying a record of data entries, it includes magnetic tapes and disks, microfilms, etc.

БИЧИГ БАРИМТ

Мэдээлэл тээх зориулалттай, мөн мэдээ баримтын бичлэг бүхий аливаа хэрэгсэл. Түүнд соронзон хальс, хуурцаг, диск, бичил хальс зэрэг зүйлс хамаарна.

Note:
This term is defined in Annex J.1.to the Kyoto Convention of 1974.

Жич:
Энэ нэр томьёог 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт J.1-д тодорхойлсон байдаг.

DOCUMENT AGAINST ACCEPTANCE

Instructions given by a shipper to a bank indicating that documents transferring title goods should be delivered to the buyer (or drawee) only upon the buyer's acceptance of the attached draft.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЗӨВШӨӨРСӨН ТОХИОЛДОЛД БИЧИГ БАРИМТ ОЛГОХ

Бараа өмчлөх эрх шилжүүлж буй бичиг баримтыг зөвхөн худалдан авагч хавсралт чек (вексель, тратта)-ийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд худалдан авагч (төлбөр хариуцагч)-д өгөхийг зааж, ачаа бэлтгэгч (ачигч компани)-ээс банкинд өгсөн заавар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DOCUMENT ALIGNMENT

Documentary requirements can be simplified by the alignment of trade documents based on internationally accepted standards and best practices. Alignment entails the visual aspects of documents, including paper size, margins and form design, and the alignment of the presentation of data. Standard aligned documents can be extended into electronic documents for paperless trade and Single Window systems. Document alignment aims to limit errors in filling out the documents, reduce time and costs related to management of the documents and preparation of the information, and set the basis for automation.

БИЧИГ БАРИМТЫГ ИЖИЛТГЭХ

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, шилдэг туршлагад үндэслэн худалдааны бичиг баримтуудыг ижилтгэн бичиг баримтын шаардлагыг хялбарчилж болно. Бичиг баримт ижилтгэх гэдэг нь бичиг баримтын харагдах байдлыг хамаарч болно, үүнд цаасны хэмжээ, хүрээ, хэлбэр загвар, өгөгдлийн байдлыг ижилтгэдэг. Стандартад нийцүүлэн ижилтгэсэн бичиг баримтыг цаасгүй худалдаа, нэг цонхны системд шилжүүлэх зэрэгт ашиглах боломжтой. Бичиг баримтыг ижилтгэх нь бичиг баримт бөглөхөд гаргадаг алдааг хязгаарлах, бичиг баримт боловсруулах, мэдээлэл бэлтгэхэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах, автоматжуулалтын үндэс суурийг тавихад чиглэгддэг.

DOCUMENTARY EVIDENCE OF ORIGIN

A certificate of origin, a certified declaration of origin or a declaration of origin.

Note:
Annex D.2.to the Kyoto Co nvention of 1974 and Specific Annex K, Chapters 2 and 3 of the revised Kyoto Convention.

ГАРАЛ ҮҮСЛИЙГ НОТЛОХ БАРИМТ

Барааны гарал үүслийн гэрчилгээ, гарал үүслийн баталгаажуулсан мэдүүлэг, эсхүл гарал үүслийн мэдүүлэг.

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.2, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт К-гийн 2, 3 дугаар бүлэг.

DOCUMENT LINE

A collection of data for a line on a piece of written, printed or electronic matter that provides information or evidence.

[UN/CEFACT/CCL]

БИЧИГ БАРИМТЫН НЭГ МӨР

Бичгээр үйлдсэн, хэвлэмэл, эсхүл цахим хэлбэртэй ширхэг материалын нэг мөрөнд зориулагдсан, мэдээлэл буюу нотлох баримт агуулж буй үгсийн цуглуулбар (үгсийн чуулган).

[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах] [НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/ Үндсэн бүрдэл хэсгийн сан]

DOCUMENTARY CREDIT APPLICATION

Document whereby a bank is requested to issue a documentary credit.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАРИМТАТ АККРЕДИТИВ (АККРЕДИТИВ) НЭЭЛГЭХ ӨРГӨДӨЛ

Баримтат аккредитив (баримтат зээл, аккредитив) нээлгэхээр банканд гаргасан хүсэлт буюу өргөдлийн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DOCUMENTARY CREDIT (DOCUMENTARY LETTER OF CREDIT)

A Documentary Letter of Credit (DLC) is an undertaking of the bank, which has opened a letter of credit on request of a buyer (applicant) to pay an amount to the seller (beneficiary) as specified in the letter of credit upon the provision of documents by the seller (beneficiary) that meet the conditions of the letter of credit and confirm the shipment of commodities (the provision of services) within the prescribed time frame.

The term “Letter of Credit” or the abbreviation “L/C” is predominantly used in the USA while Europeans prefer to use “Documentary Credit” or the abbreviation “D/C”. A letter of credit is also known as a sight letter of credit (Sight LC), bankers’ commercial credit, or letter of undertaking (LoU).
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАРИМТАТ АККРЕДИТИВ (АККРЕДИТИВ)

Баримтат аккредитив (аккредитив) гэж худалдан авагч (өргөдөл гаргач)-ийн хүсэлтээр аккредитив нээсэн банк уг аккредитивт нэр заасан худалдагч (төлбөр хүлээн авагч буюу нэхэмжлэгч) уг аккредитивт заасан болзол нөхцөлийг хангасан бичиг баримтыг гарган өгч, барааг тогтоосон хугацаанд ачуулсан (үйлчилгээг тогтоосон хугацаанд үзүүлсэн) болохыг баталсан тохиолдолд уг худалдагч (төлбөр хүлээн авагч буюу нэхэмжлэгч)-д тодорхой нэг мөнгөн дүнг төлөх үүрэг амлалтыг хэлнэ.

Аккредитивыг ихэвчлэн АНУ-д “Letter of Credit” (товчлол нь “L/C”) гэдэг бол Европт “Documentary Credit” (товчлол нь “D/C”) гэдэг. Аккредитивыг зарим улсад бас “sight letter of credit (Sight LC)”, “bankers’ commercial credit”, эсхүл “letter of undertaking (LoU)” гэдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DOCUMENTARY PROCEDURES

"Documentary procedures" encompass all activities ranging from the ordering of goods, physical transfer of goods, and payment for goods along the supply chain, which are usually carried out through handling paper and electronic documents. These are the procedures for submitting documents required for a trade transaction to take place, reviewing them, making decisions on them, and announcing those decisions to the owner of the goods or his/ her agent.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

"Бичиг баримт бүрдүүлэх ажиллагаа" гэдэг нь бараа нийлүүлэх сүлжээний турш бараа захиалах, барааг биетээр шилжүүлэх, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг хамрана. Эдгээр бүх ажиллагаа нь үндсэндээ цаасан болон цахим бичиг баримт бүрдүүлэх үндсэн дээр явагддаг. Эдгээр нь худалдааны хэлцэл явагдахад шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлэх, тэдгээрийг хянан үзэх, тэдгээрийн талаар шийдвэр гаргах, гаргасан шийдвэрээ холбогдох барааны эзэнд, эсхүл түүний төлөөлөгчид танилцуулахтай холбогдсон ажиллагаа болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DOCUMENTARY SHIPPER

A person, other than the shipper, that accepts to be named as "shipper" in the transport document or electronic transport record. [Rotterdam Rules]

БИЧИГ БАРИМТАД ЗААСАН АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)

Ачаа бэлтгэгч (ачигч компани)-ээс өөр, тээврийн бичиг баримтад, эсхүл тээврийн цахим бүртгэлд ачаа бэлтгэгч (ачигч компани) гэж дурдагдахыг хүлээн зөвшөөрсөн этгээд. [Роттердамын дүрэм]

DOHA ROUND OF WTO NEGOTIATIONS; "MILLENNIUM ROUND"

A round of negotiations within the WTO process, which was launched at the WTO Ministerial Conference in Doha, Qatar, in November 2001.

ДХБ-ЫН ХЭЛЭЛЦЭЭНИЙ ДОХАГИЙН ҮЕ ШАТ (МЯНГАНЫ ҮЕ ШАТ)

2001 оны 11 дүгээр сард Катар Улсын Доха хотноо хуралдсан ДХБ-ын Сайд нарын Бага хурлын үеэр эхэлсэн ДХБ-ын олон талт худалдааны хэлэлцээний үе шат.

DOHA WORK PROGRAMME

The work programme adopted at the WTO Ministerial Conference in Doha in November 2001. It marked the beginning of a new round of multilateral trade negotiations on a number of issues, including agriculture, non-agricultural market access, services, rules on anti-dumping measures, subsidies and countervailing measures, fisheries subsidies, regional trade agreements, trade facilitation, protection of intellectual property rights and the improvement of the WTO dispute settlement mechanism.

ДОХА РАУНДЫН АЖЛЫН ХӨТӨЛБӨР

2001 оны 11 дүгээр сард Катар Улсын Доха хотноо хуралдсан ДХБ-ын Сайд нарын Бага хурлаар батлагдсан Ажлын хөтөлбөр. Энэ үеэс олон талт худалдааны хэлэлцээний шинэ үе шат эхэлсэн. Уг хөтөлбөрт хэд хэдэн асуудал, түүний дотор хөдөө аж ахуй салбар, хөдөө аж ахуйн бус барааны зах зээлд нэвтрэх асуудал, үйлчилгээ, татаас болон саармагжуулах арга хэмжээ, загасны аж ахуйн татаас, бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүд, худалдааг хөнгөвчлөх асуудал, оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудал, ДХБ-ын маргаан шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгох асуудал орсон байдаг.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

DOMICILE

(a) A place where a company or other legal person or association of natural or legal persons has its

(i) statutory seat or place of incorporation or central registered office, whichever is applicable,

(ii) central administration or

(iii) principal place of business, and

(b) the habitual residence of a natural person.

(c) [Rotterdam Rules]

ОРШИН СУУГАА ГАЗАР

(a) Ямар нэг компани, өөр бусад хуулийн этгээд, эсхүл хувь хүн буюу хуулийн этгээдийн холбоо (нийгэмлэг)-ны дараах газар:

(i) хуулиар тогтоосон оршин суугаа газар, компанийг бүртгүүлсэн газар, эсхүл удирдах төв байгууллагыг бүртгүүлсэн газар (аль тохирох нь),

(ii) удирдах байгууллага, эсхүл

(iii) бизнесийн үндсэн үйл ажиллагаа явагдаж буй газар; мөн

(b) хувь хүний тухайн үед оршин суугаа газар.

[Роттердамын дүрэм]

DPU (DELIVERY AT PLACE UNLOADED) [INSERT NAMED PLACE OF DESTINATION]

An Incoterms rule included in 2010 as DAT (Delivery at Terminal) and renamed in INCOTERMS 2020 to DPU (Delivery at Place Unloaded). Under DPU the seller delivers when the goods once unloaded from the arriving means of transport are placed at the disposal of the buyer at a named place of destination or at the agreed point within that place, if any such point is agreed. The seller bears all risks involved in bringing the goods to and unloading them at the named place of destination or to the agreed point within that place. DPU is the only INCOTERM that requires the seller to unload goods at destination. If the seller cannot ensure such unloading and the parties intend seller to avoid such costs and risks, ICC recommends using DAP instead. DPU requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for importation or for transit, to pay import duties and carry out import Customs formalities. Therefore, if the buyer fails to clear the goods for import, the goods might be held up at the point of entry in the destination country.

DPU (НЭР ЗААСАН ГАЗАРТ ХҮРГЭЖ БУУЛГАСАН) [НЭР ЗААСАН ХҮРЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

ИНКОТЕРМС 2010-т DAT (Терминал дээр хүргэсэн) гэж орсон бөгөөд ИНКОТЕРМС 2020-д DAP (Нэр заасан газарт хүргэж буулгасан) гэж орсон ИНКОТЕРМС-ийн дүрэм. DPU нөхцөлийн дагуу худалдагч барааг ирэх тээврийн хэрэгслээс нэгэнт буулгасан бол нэр заасан хүрэх газарт байгаа, эсхүл уг газрын тохиролцсон цэгт хүргэхээр тохиролцсон бол тэнд байгаа худалдан авагчийн мэдэлд шилжүүлэхээр хүргэж өгнө гэсэн утгатай юм. Худалдагч барааг нэр заасан хүрэх газарт аваачиж, тэнд буулгах, эсхүл уг газрын тохиролцсон цэгт хүргэхтэй холбогдсон бүх эрсдэлийг үүрнэ. DPU нь худалдагч барааг хүрэх газарт нь буулгахыг шаарддаг ИНКОТЕРМС-ийн ганц нөхцөл юм. Хэрэв худалдагч тийнхүү буулгаж чадахгүй, мөн холбогдох талууд худалдагчийг тийм зардал, эрсдэлээс зайлсийхийг хүсч байгаа бол Олон улсын худалдааны танхимаас DAP нөхцөл ашиглахыг зөвлөдөг. DPU нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг.

Therefore, if the parties wish to avoid such a scenario, ICC recommends considering selling and buying under DDP (Delivered Duty Paid) rule. This rule may be used irrespective of the mode of transport selected and may also be used where more than one mode of transport is employed.
[ICC/INCOTERMS 2020]

Тэгэхээр, хэрэв худалдан авагч тухайн барааг оруулах бүрдүүлэлтийг хийлгэж чадахгүй бол холбогдох бараа хүрэх улсын орох боомт дээр саатах болно. Тэгэхээр хэрэв талууд ийм байдлаас зайлсхийхийг хүсч байгаа бол бараа худалдах, худалдан авах явдлыг DDP (Гаалийн татвар төлж хүргэсэн) дүрмийн дагуу авч үзэхийг Олон улсын худалдааны танхимаас зөвлөдөг. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно.
[ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

DRAWBACK

Amount of import duties and taxes repaid under the drawback procedure.

Note:
Annex E.4. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex F, Chapter 3 of the revised Kyoto Convention.

БУЦААН ОЛГОХ ТАТВАР

Импортын гаалийн болон бусад татварыг татвар буцаан олгох горимын дагуу буцаан өгсөн мөнгөн дүн.

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е.4 болон шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт F-ийн 3 дугаар бүлэг.

DRAWBACK PROCEDURE

The Customs procedure which, when goods are exported, provides for a refund (total or partial) to be made in respect of the import duties and taxes charged on the goods, or on materials contained in them or consumed in their production.

Note:
Annex E.4. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex F, Chapter 3 of the revised Kyoto Convention.

ТАТВАР БУЦААН ОЛГОХ ГОРИМ

Барааг гаргасан тохиолдолд тухайн барааанд, эсхүл түүнийг бүрдүүлж байгаа буюу түүнийг үйлдвэрлэхэд ашиглаж үгүй болсон материалд төлсөн импортын гаалийн болон бусад татварыг (бүхэлд нь, эсхүл түүний хэсгийг) буцаан өгөх гаалийн горим.

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е.4 болон шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт F-ийн 3 дугаар бүлэг.

DRAWEE; CREDIT DRAWEE

Party on whom any draft is to be drawn from the documentary credit and who owes the stated amount to the drawer.
[UNTDED]

ТӨЛБӨР ХАРИУЦАГЧ

Аккредитиваас мөнгө шилжүүлэхийг зөвшөөрч, заасан мөнгөн дүнг төлбөр хүлээн авагчид төлөх этгээд.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

DUAL-CHANNEL SYSTEM (RED/GREEN)

Simplified Customs control system allowing travellers on arrival to make a Customs declaration by choosing between two types of channel. One, identified by green symbols, is for the use of travellers carrying goods in quantities or values not exceeding those admissible duty-free and which are not subject to import prohibition or restriction. The other, identified by red symbols, is for other travellers.

Note:
The purpose of this system is to facilitate rapid baggage clearance and traveller flow.

ХОС ГАРЦ (УЛААН/ НОГООН ГАРЦ)-ЫН СИСТЕМ

Ирж буй зорчигчдод 2 төрлийн гарцын аль нэгийг сонгох замаар гаалийн байгуулагад мэдүүлэх гаалийн хяналтын хялбарчилсан систем. Ногоон өнгөөр ялгасан нэг гарц нь гаалийн татваргүй нэвтрүүлэх тоо хэмжээ, үнийн дүнгээс хэтрээгүй, мөн импортын хориг, хязгаарлалтад хамрагдаагүй бараа авч яваа зорчигчид ашиглах зориулалттай байна. Улаан өнгөөр ялгасан нөгөө гарц нь бусад зорчигчид ашиглах зориулалттай байна.

Жич:
Энэ систем нь зорчигчдын урсгал, ачаа тээшийн бүрдүүлэлтийг түргэсгэхэд тус дөхөм үзүүлэх зорилготой болно.

DUE DATE

The date when payment of duties and taxes is due.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ЭЦСИЙН ӨДӨР

Гаалийн болон бусад татвар төлөх эцсийн өдөр.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

DUMPING

Occurs when goods are exported at a price less than their normal value, generally meaning they are exported for less than they are sold in the domestic market or third-country markets, or at less than production cost.

ДЕМПИНГ

Барааг ердийн үнээс нь бага үнээр, ерөнхийдөө дотоодын эсхүл гуравдагч орны зах зээлд борлуулж байснаас бага үнээр, эсхүл үйлдвэрлэлийн өртгөөс бага үнээр экспортлох үед үүсдэг.

DUTIES AND TAXES

Import duties and taxes and/or export duties and taxes.

Note:
General Annex, Chapters 2 and 4 of the revised Kyoto Convention.

ГААЛИЙН ТАТВАР БОЛОН БУСАД ТАТВАР

Импортын гаалийн болон бусад татвар болон/ эсхүл экспортын гаалийн болон бусад татвар.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2, 4 дүгээр бүлэг.

DUTY-FREE SHOPS

A premise under Customs control at which goods may be acquired free of Customs duties and taxes.

ГААЛИЙН ТАТВАРГҮЙ БАРААНЫ ДЭЛГҮҮР

Барааг гаалийн болон бусад татваргүй худалдан авах боломжтой, гаалийн хяналтын дор үйл ажиллагаа явуулдаг байр байгууламж.

Note:
Some countries limit the sale of tax -free goods to travellers leaving for abroad. (See the Recommendation of 16 June 1960 concerning tax – free shops).

Жич:
Зарим улсад татваргүй бараа худалдах явдлыг зөвхөн гадаад явж байгаа зорчигчдоор хязгаарласан байдаг (“Татваргүй барааны дэлгүүр”-ийн тухай 1960 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн Зөвлөмжийг үз).

E

ebXML

Project of UN/CEFACT for interoperable e-business solutions; is a modular suite of specifications that enables enterprises of any size and in any geographical location to conduct business over the Internet. Using ebXML, companies have a standard method to exchange business messages, conduct trading relationships, communicate data in common terms and define and register business processes. Even if the eXtensible Markup Language (XML) is mentioned in the title, the project is technology neutral.

(UN/CEFACT and OASIS – ISO 15000-5)

ebXML

Харилцан холбогдох боломжтой цахим бизнесийн шийдэл гаргах НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн төсөл; энэ нь жижиг, том ямар ч компани газар зүйн хувьд хаана байрладгаас үл хамааран Интернэтээр дамжуулан бизнес хийх боломж олгодог модульчлагдсан багц техникийн тодорхойлолт юм. Компаниуд ebXML ашиглан бизнесийн мессеж солилцох, худалдааны харилцаагаа өрнүүлэх, нийтлэг нөхцөлөөр мэдээлэл дамжуулах, бизнес процессыг тодорхойлж, бүртгэх нэг стандарт аргатай болно. Энэ төслийн нэрийг хэдийгээр ebXML (the eXtensible Markup Language (XML)) гэсэн боловч уг төсөл нь угтаа технологиос хамааралгүй юм.

(НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв болон Бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй) мэдээллийн стандартыг боловсронгуй болгох байгууллага – ISO (Олон улсын стандартчиллын байгууллага) 15000-5)

EDI (ELECTRONIC DATA INTERCHANGE)

A set of standards controlling the transfer of business documents such as purchase orders and invoices between companies.

(UN/EDIFACT)

МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМААР ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ

Бараа худалдан авах захиалга, үнийн нэхэмжлэх зэрэг бизнесийн бичиг баримтыг компани хооронд дамжуулах явдлыг хянах багц стандарт.

(Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэм)

EDIFACT; UN/EDIFACT (ELECTRONIC DATA INTERCHANGE FOR ADMINISTRATION, COMMERCE AND TRANSPORT)

The only global standard for Electronic Data Interchange (EDI), supported by UN/CEFACT, the UN body developing standards for trade facilitation and electronic business. EDIFACT consists of a number of Standard messages in electronic form.
(UN/EDIFACT)

ЗАХИРГААНЫ, ХУДАЛДААНЫ БОЛОН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНД МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМААР ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ ДҮРЭМ; ЗАХИРГААНЫ, ХУДАЛДААНЫ БОЛОН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНД МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМААР ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ НҮБ-ЫН ДҮРЭМ

Мэдээллийг цахимаар харилцан солилцох зориулалттай дэлхийн хэмжээний цорын ганц стандарт. Үүнийг Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэм болон НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвөөс дэмжин ажилладаг. Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох дүрэм нь цахим хэлбэртэй хэд хэдэн стандарт мессэжээс бүрддэг.
(Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэм)

ELECTRONIC BUSINESS; E-BUSINESS

The exchange of any commercial transaction by means of telecommunication. Electronic business may involve connecting the computer systems of two or more independent organizations/agencies/ firms, where the facilitation of business processes and the opportunities offered by information and communication technologies (ICT) converge. In international trade e-business helps integrate the electronic exchange of information, and is considered as part of international trade facilitation.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЦАХИМ БИЗНЕС

Аливаа худалдааны хэлцлийг цахилгаан холбооны хэрэгслээр дамжуулан солилцох. Цахим худалдаа гэдэгт бизнес процессыг хөнгөвчлөх болон мэдээлэл харилцаа холбооны технологиос олгосон боломжууд нь нийцэж буй хоёр буюу түүнээс дээш тооны бие даасан байгууллага, агентлаг, компанийн компьютерийн системийг холбох явдал хамаарна. Олон улсын худалдаанд, цахим бизнес нь мэдээллийг цахимаар солилцох явдлыг харилцан холбоотой нэг систем болгон нэгтгэхэд тус дөхөм болох бөгөөд түүнийг бас худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааны нэг хэсэг гэж үздэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

E-BUSINESS SOLUTIONS

E-business solutions support business and government processes that are automated and integrated using information and communication technology (ICT). This involves the electronic exchange of documents and data that are transported to and processed by disparate systems as part of a supply chain. In order to ensure their inter-operability, the use of available and widely ecognized standards and tools is essential.

ЦАХИМ БИЗНЕСИЙН ШИЙДЭЛ

Цахим бизнесийн шийдлүүд нь мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан автоматжуулсан болон нэгтгэсэн (интеграцчилсан) бизнесийн болон төрийн байгууллагын үйл ажиллагааг дэмждэг. Үүнд бараа нийлүүлэх сүлжээний нэг хэсэг болох, эрс тэс ялгаатай системүүдээр дамжуулан боловсруулсан мэдээ мэдээлэл, бичиг баримтыг цахимаар солилцох явдал хамаарна. Эдгээр систем хоорондын нийцлийг хангахын тулд бэлэн байгаа бөгөөд өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болон хэрэгсэлтэй байх шаардлагатай байдаг.

E-GOVERNMENT

The use of ICTs to more effectively and efficiently deliver government services to citizens and business.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЦАХИМ ТӨР

Төрийн үйлчилгээг иргэд болон бизнесийнхэнд илүү үр нөгөөтэй бөгөөд үр ашигтай аргаар хүргэх зорилгоор мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ELECTRONIC ARCHIVING

The electronic retention and upkeep of data records often in accordance with data retention norms.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЦАХИМ АРХИВ

Мэдээллийн бүртгэлийг мэдээлэл хадгалах журмын дагуу цахим хэлбэрээр үлдээн хадгалах.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ELECTRONIC COMMERCE; ELECTRONIC TRADE

Online-initiation; crossborder transaction/ shipment; and destined to consumers (commercial and noncommercial). Often referred to simply as e-commerce, the term is used to describe business that is conducted over the Internet using any of the applications that rely on the Internet, such as e-mail, instant messaging, shopping carts, Web services, UDDI, FTP, and EDI, among others. Electronic commerce can be between two businesses transmitting funds, goods, services and/or data or between a business and a customer.

ЦАХИМ ХУДАЛДАА

Онлайн сэдэл (эхлэл); хил дамнасан хэлцэл/ачилт (тээвэрлэлт); тэгээд (худалдаа эрхэлдэг болон худалдаа эрхэлдэггүй) хэрэглэгч нарт хүргэх (нийлүүлэлт). Ихэвчлэн цахим худалдаа гэдэг. Энэ томьёог Интернетээр хийгддэг бизнесийг тодорхойлох зорилгоор ашигладаг. Интернэт гэдэгт цахим шуудан, яаралтай зурвас, худалдааны сагс, вэб үйлчилгээ, UDDI (Universal Description, Discovery, and Integration – Түгээмэл тодорхойлолт, нээлт, интеграци), FTP (File Transfer Protocol - Файл дамжуулах протокол), EDI (Electronic data interchange -мэдээллийг цахимаар харилцан дамжуулах) г.м. зүйлс хамаарна.

Цахим худалдааг хөрөнгө, бараа, үйлчилгээ болон/эсхүл мэдээлэл дамжуулж буй хоёр компанийн хооронд, эсхүл аль нэг кормпани, хэрэглэгчийн хооронд явуулж болно.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ECO-LABELING

This refers to packaging or labeling requirements that indicate the environmental origin, performance, or characteristics of a particular product.

ЭКО ШОШГО ЗҮҮХ

Энэ нь тодорхой нэг бүтээгдэхүүний гарал үүсэл, гүйцэтгэлийн үзүүлэлт, эсхүл шинж байдал нь байгаль орчинд ээлтэй болохыг заасан сав боодол, шошгожилтод хамаарна.

ECOSYSTEM

A dynamic complex of plant, animal, and micro-organism communities and their non-living environment interacting as a functional unit.
Convention on Biological Diversity

(Biodiversity Convention)

ЭКОСИСТЕМ

Амьтан ургамал, бичил организмын бүлгэмдэл болон тэдгээртэй бүхэл бүтэн нэгдмэл байдлаар харилцан үйлчлэгч амьгүй орчны динамик цогцолбор.
Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

ELECTRONIC COMMERCE

The production, advertising, sale and distribution of products via telecommunications networks

ЦАХИМ ХУДАЛДАА

Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зар сурталчилгаа, борлуулалт ба түгээлтийг харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан хийх.

ELECTRONIC COMMUNICATION

Any communication that the parties make by means of data messages. [UNCITRAL Electronic Communications Convention]

ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

Талууд өгөгдлийн мессеж ашиглан дамжуулсан аливаа мэдээлэл
[НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим мэдээллийн (цахим харилцааны) тухай конвенц]

ELECTRONIC CUSTOMS

The use of Information Technology to carry out Customs compliance using electronic communications channels replacing paper format Customs procedures, thus creating a more efficient and modern Customs environment.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЦАХИМ ГААЛЬ

Гаалийн байгууллагын цаасан бүрдүүлэлтийн горим журмыг халж, цахим мэдээллийн суваг ашиглан гаалийн хууль тогтоомж мөрдөх зорилгоор мэдээллийн технологи ашиглах. Ингэснээр илүү үр ашигтай, орчин үеийн гаалийн орчин бүрдэнэ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ELECTRONIC CUSTOMS DECLARATION

Lodging of a Customs declaration in the prescribed form and manner electronically, according to the specifications made for such purposes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН ЦАХИМ МЭДҮҮЛЭГ

Гаалийн мэдүүлгийг зориулагдсан зааврын дагуу, батлагдсан маягт, арга хэлбэрээр цахимаар гаргаж өгөх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ELECTRONIC DATA INTERCHANGE (EDI)

Structured computer to computer transmission of data in a standard format.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

МЭДЭЭЛЛИЙГ (ӨГӨДЛИЙГ) ЦАХИМААР ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ

Мэдээллийг (өгөдлийг) бүтэцлэн стандарт форматаар нэг компьютерээс нөгөөд дамжуулах
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ELECTRONIC PAYMENT OF CUSTOMS DUTIES AND TAXES

Electronic duty/tax payment refers to the use of e-payment methods such as credit and debit cards, electronic funds transfer or online payments for the settlement of duties, taxes and fees associated with the clearance formalities of goods declared for import or export. Standard 4.6 of the Revised Kyoto Convention (RKC) requires Customs administrations to specify the methods of payment allowed for duty/tax payment purposes by national law. The Guidelines to this RKC Standard strongly recommend that Customs should accept payment of duties and taxes in forms other than cash, such as travellers cheques, money orders, certified cheques, uncertified cheques (in specified circumstances), bonds, credit cards, securities, etc. The Guidelines to Standard 4.6 also strongly encourage the use of electronic funds transfer as an important method for quick and efficient payment.

ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРЫГ ЦАХИМААР ТӨЛӨХ

Гаалийн болон бусад татварыг цахимаар төлөх гэж оруулах буюу гаргахаар мэдүүлсэн барааны бүрдүүлэлтийн ёс журмын ажилагаанд хамаарах гаалийн болон бусад татвар, хураамжийг барагдуулах зорилгоор зээлийн (кредит) болон дебит карт, цахим мөнгөний гуйвуулга, эсхүл онлайн төлбөрийн хэрэгсэл зэрэг цахим төлбөр тооцооны арга ашиглахыг хэлнэ. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн стандарт 4.6 нь гаалийн байгууллагууд гаалийн болон бусад татвар төлөх зорилгоор зөвшөөрөгдсөн төлбөр тооцооны аргуудыг үндэсний хууль тогтоомжид зааж өгсөн байхыг шаарддаг. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн энэхүү стандартыг хэрэгжүүлэх зааварт аяллын (аялагчийн) чек, мөнгөн гуйвуулга, баталгаажсан чек, баталгаажаагүй чек (тодорхой тохиолдолд), бонд, зээлийн (кредит) карт, үнэт цаас гэх мэт бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр гаалийн болон бусад татвар төлөх явдлыг гаалийн байгууллага хүлээн зөвшөөрөхийг зөвлөсөн байдаг. Энэхүү стандарт 4.6-г хэрэгжүүлэх заавар нь төлбөрийг түргэн шуурхай бөгөөд үр ашигтай байдлаа гүйцэтгэх чухал арга болох цахим мөнгөний гуйвуулга ашиглахыг бас хатуу зөвлөсөн байдаг.

ELECTRONIC SIGNATURE

Data in electronic form in, affixed to or logically associated with, a data message, which may be used to identify the signatory in relation to the data message and to indicate the signatory's approval of the information contained in the data message.
[UNCITRAL Model Law on Electronic Signatures 2001] [UN/CEFACT/ Rec. 14, para 41]

ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ

Цахим хэлбэртэй, дата мессежэд хавсрагдсан, эсхүл логикийн хувьд түүнтэй холбогдсон мэдээлэл. Үүнийг тухайн дата мессежтэй холбогдуулан гарын үсэг зурсан этгээдийг танихад, мөн гарын үсэг зурсан этгээд уг дата меесежэд агуулагдаж байгаа мэдээллийг зөвшөөрч байгаа болохыг мэдэхэд ашиглаж болно.
[НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим гарын үсгийн тухай загвар хууль, 2001 он]
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан/ Зөвлөмж №14, заалт 41]

ELECTRONIC TRANSPORT RECORD

Information in one or more messages issued by electronic communication under a contract of carriage by a carrier, including information logically associated with the electronic transport record by attachments or otherwise linked to the electronic transport record contemporaneously with or subsequent to its issue by the carrier, so as to become part of the electronic transport record, that: (a) Evidences the carrier's or a performing party's receipt of goods under a contract of carriage; and (b) Evidences or contains a contract of carriage. [Rotterdam Rules]

ТЭЭВРИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ

Тээвэрлэгч тээврийн гэрээний дагуу харилцаа холбооны цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн нэг буюу хэд хэдэн мессежийн мэдээлэл. Үүнд логикийн хувьд тээврийн цахим бүртгэлд хавсрагдсан, эсхүл тээврийн цахим бүртгэлтэй холбогдсон мэдээлэл багтана. Энэ нь тээврийн цахим бүртгэлийн нэг хэсэг болж:
(a) тээвэрлэгчийн, эсхүл гүйцэтгэгч талын тээврийн гэрээний дагуу бараа хүлээн авсаныг нотолдог; мөн
(b) тээврийн гэрээг нотолдог, эсхүл агуулдаг.
[Роттердамын дүрэм]

END-TO-END DATA PROCESSING

A system that performs a business process from beginning to end, including all intermediate steps, such as data capture, data processing, analysis, and the generation of outputs.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭХНЭЭС НЬ ДУУСТАЛХ БҮХ ШАТНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

Бизнес процессыг эхнээс нь дуустал гүйцэтгэх систем. Үүнд мэдээлэл татах, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх зэрэг завсрын шатны бүх алхмууд, мөн түүнчлэн эцсийн үр дүнг тооцон гаргах явдал хамаарна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

END-USER LICENSE AGREEMENTS

An agreement between the licensor and the licensee establishing the licensee's rights to use the licensed software.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭЦСИЙН ХЭРЭГЛЭГЧИД ЛИЦЕНЗ ОЛГОХ ГЭРЭЭ

Лиценз олгогч болон лиценз эзэмшигчийн хооронд байгуулсан, лицензтэй програм ашиглах эрхийг лиценз эзэмшигчид эзэмшүүлэх гэрээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ENHANCED CONTROLS OR INSPECTIONS

A system of issuing notifications or guidance to the WTO Member's concerned authorities for enhancing the level of controls or inspections at the border in respect of foods, beverages, or feedstuffs covered under the notification or guidance for protecting human, animal, or plant life or health within its territory. [Art. 5.1 TFA]

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ӨНДӨРЖҮҮЛСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд хүн, амьтан, эсхүл ургамлын амь нас буюу эрүүл мэндийг хамгаалах мэдэгдэл буюу заавар чиглэлд дурдсан хүнсний зүйл, ундаа, эсхүл мал, амьтны тэжээлийн хувьд хил дээр тавих хяналт, шалгалтыг чангатгах зорилгоор ДХБ-ын тухайн гишүүний холбогдох байгууллагуудад мэдэгдэл буюу заавар чиглэл хүргүүлэх систем.
[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 1 дэх заалт]
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ENQUIRY

Document issued by a party interested in the purchase of goods specified therein and indicating particulars, desirable conditions regarding delivery terms, etc., addressed to a prospective supplier with a view to obtaining an offer.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЛАВЛАГАА

Бараа худалдан авах сонирхолтой байгаа талын үйлдсэн, тухайн барааг тодорхойлж, түүний талаарх мэдээлэл, түүнийг нийлүүлэх нөхцөлтэй холбогдуулан өөрийн хүсч буй нөхцөлүүд зэргийг зааж, оферт (санал) хүлээн авах зорилгоор хэтийн бараа нийлүүлэгчид хаягласан бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ENQUIRY POINT

The establishment of enquiry points would contribute to improving transparency and predictability in the context of facilitating accessibility to trade-related information for the private sector. Article 1.3 of the TFA requires Members to establish and/or maintain one or more enquiry points within their available resources.

ЛАВЛАХ ЦЭГ

Лавлах цэг бий болгох нь хувийн хэвшил худалдаатай холбоотой мэдээлэлд нэвтрэх явдлыг хөнгөвчилж өгдөг учир тийм мэдээллийн ил тод бөгөөд урьдчилан таамаглах боломжтой байдлыг нэмэгдүүлэхэд ихээхэн ач тустай юм.

The enquiry points must answer enquiries and provide the forms and documents for importation, exportation and transit, within a reasonable time period. Chapter 9 of the General Annex to the Revised Kyoto Convention also contains standards requiring Customs to provide specific information or decisions as quickly as possible and in sufficient detail.	Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт нь гишүүн орнууд нэг буюу хэд хэдэн лавлах цэгийг өөрсдийн нөөц бололцооны хүрээнд байгуулж, эсхүл одоо байгаагаа үргэлжлүүлэн ажиллуулахыг шаардсан байдаг. - Лавлах цэгүүд нь асуулт лавлагаанд хариулт өгч, импорт, экспорт, дамжин өнгөрөхөд шаардлагатай маягт болон бичиг баримтыг боломжит цаг хугацаанд багтаан гаргаж өгөх ёстой юм. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 9 дүгээр бүлэгт бас гаалийн байгууллага тодорхой мэдээлэл буюу шийдвэрийг аль болох түргэн шуурхай, хангалттай дэлгэрэнгүй байдлаар хүргэхийг шаардсан стандартууд байдаг.
A Customs office or information portal providing all relevant information of general and/or specific application pertaining to Customs to any interested person for predictability and accessibility.	- Сонирхогч аливаа этгээдийг гаалийн холбогдолтой бөгөөд нийтийн зориулалттай болон/эсхүл тусгай зориулалттай бүх мэдээллээр хангаж, урьчдилан тааварлах боломжтой бөгөөд хүртээмжтэй байлгах гаалийн байгууллага буюу мэдээллийн портал
Notes; 1. The Guidelines to Chapter 9 of the General Annex of the Revised Kyoto Convention provide sufficient guidance on enquiry points/offices. The Guidelines to Chapter 7 of the General Annex of the Revised Kyoto Convention also include guidance on how to set up a Help Desk (which is equivalent to an enquiry point/office) and its components.	Жич: 1. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 9 дүгээр бүлгийн зааварт лавлах цэг/байгууллагын талаар хангалттай зааварчилгаа өгсөн байгаа. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 7 дугаар бүлгийн зааварт бас Харилцагч (үйлчлүүлэгч) нарт туслалцаа үзүүлэх цэг (энэ нь лавлах цэг/байгууллагатай ижил утгатай юм) хэрхэн байгуулах заавар, түүний бүрдэл хэсгийн талаар тусгагдсан байгаа.
2. Information portal may be composed of various factors, for example, „Custom Law information portal, „Customs Practice portal", „FTA counselling corner", „FAQ", „Q&A for foreigners", „Friendly Facebook or YouTube", „interactive voice response (IVRs) systems", „virtual voice assistants" etc.	2. Мэдээллийн портал нь янз бүрийн зүйлээс бүрдэж болно: жишээлбэл, “Гаалийн хууль тогтоомжийн мэдээллийн портал”, “Гаалийн практик ажиллагааны портал”, “Чөлөөт худалдааны бүсийн талаар зөвлөгөө өгөх булан”, “Байнга тавьдаг асуулт, хариулт”, “Гадаадынханд зориулсан асуулт, хариулт”, “Нөхөрсөг фэйсбуук буюу YouTube”, “харилцан ярилцаж, хариулт өгөх системүүд”, “онлайнаар дамжуулан дуу хоолойгоор туслалцаа үзүүлэх”, г.м.
The Chapter 9 in the revised Kyoto Convention and Transparency and Predictability Guidelines (Mar, 2017)	Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 9 дүгээр бүлэг, Ил тод, урьдчилан тааварлах боломжтой байх заавар (2017 оны 3 дугаар сар)

EQUIVALENT COMPENSATION

System allowing, under certain Customs procedures, the exportation or importation of goods identical in type, description, quality and technical characteristics to those previously imported or exported.

Notes:

1. In the context of the ECE Convention on Customs treatment of pool containers used in international transport, this term means the system that allows the re-exportation or re-importation of a container of the same type as that of another container previously imported or exported.

2. In certain countries, this system only allows a temporary admission for inward processing procedure or a temporary exportation for outward processing procedure to be discharged on presentation of a compensating product obtained from goods equivalent to those that have been exported or imported.

3. In certain countries, this system can also be applied to goods that will be imported or exported.

See the Guidelines to Chapters 1 and 2 of Specific Annex F to the Revised Kyoto Convention.

АДИЛ БАРААГААР ОРЛУУЛАХ

Гаалийн зарим горимын дагуу, нэр төрөл, тодорхойлолт, чанар болон техникийн үзүүлэлтээрээ өмнө нь импортлосон буюу экспорлосон бараатай ижил барааг гаргах буюу оруулахыг зөвшөөрдөг систем.

Жич:

1. НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын Олон улсын тээвэрт ашигладаг пуул чингэлэг (дундын хэрэглээний чингэлэг)-т гаалийн бүрдүүлэлт хийх тухай конвенцийн утгаар, өмнө нь оруулсан, эсхүл гаргасан чингэлэгтэй ижил төрлийн чингэлгийг буцаан гаргах буюу буцаан оруулахыг зөвшөөрдөг системийг уг нэр томьёогоор илэрхийлдэг.

2. Зарим улсад энэ систем нь зөвхөн экспортолсон, эсхүл импортолсон бараатай ижил бараанаас гаргаж авсан орлогч бүтээгдэхүүнийг үзүүлсэн тохиолдолд дотоодод боловсруулахаар түр хугацаагаар оруулах, эсхүл гадаадад боловсруулахаар түр гаргах горимыг дуусгавар болгохыг зөвшөөрдөг байна.

3. Зарим улсад энэ системийг маргааш (ирээдүйд) импортлох, эсхүл экспортлох барааND бас хэрэглэж болдог байна.

Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт F-ийн 1, 2 дугаар бүлгийн зааврыг үз.

EQUIVALENT GOODS

Goods identical in description, quality and technical characteristics to those imported or exported for inward or outward processing.

Notes:

1. This term or this concept is used in Annexes E.4.(drawback), E. 6 (temporary admission for inward processing), E.7.(duty-free replacement of goods) and E. 8. (temporary exportation for outward processing) to the Kyoto Convention of 1974.

Specific Annex F, Chapters 1 and 2 of the revised Kyoto
Convention.

АДИЛ БАРАА

Тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд дотоодод боловсруулахаар оруулсан бараатай ижил бөгөөд түүнийг орлох дотоодын буюу импортын бараа.

Жич:

1. Энэхүү нэр томьёо буюу энэхүү ойлголтыг 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е-гийн 4 дүгээр бүлэг (татвар буцаан олгох), Е-гийн 6 дугаар бүлэг (барааг дотоодод боловсруулахаар түр хугацаагаар оруулах), Е-гийн 7 дугаар бүлэг (барааг гаалийн татваргүйгээр солих горим) болон Е-гийн 8 дугаар бүлэг (барааг гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргах)-т хэрэглэсэн байдаг.

Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт F-ийн 1 болон 2 дугаар бүлэг.

E-TRADING

E-trading or paperless trading is a method of trading securities (such as stocks, and bonds), foreign exchange or financial derivatives electronically.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЦАХИМ ХУДАЛДАА

Цахим худалдаа буюу цаасгүй худалдаа гэж үнэт цаас (хувьцаа, бонд, г.м.), гадаад валютын болон санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг цахимаар худалдаалах арга.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EUROPEAN AGREEMENT CONCERNING THE INTERNATIONAL CARRIAGE OF DANGEROUS GOODS BY ROAD (ADR)

[UNECE/ADR]

АЮУЛТАЙ БАРААГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД АВТО ЗАМААР ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ ЕВРОПЫН КОНВЕНЦ

[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс / Аюултай бараг авто замаар тээвэрлэх тухай конвенц]

EUROPEAN AGREEMENT ON MAIN INTERNATIONAL RAILWAY LINES (AGC)

[UNECE/AGC] [UNECE/TRANS/SC.2/165]

ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ГОЛ ШУГАМУУД

[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс / Аюултай бараг авто замаар тээвэрлэх тухай конвенц] [НҮБ-ын Европын эдийн засгийн комисс /Тээвэр/SC.2/165]

EXAMINATION OF GOODS

Physical inspection of goods by the Customs to satisfy themselves that the nature, origin, condition, quantity and value of the goods are in accordance with the particulars furnished in the Goods declaration.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

БАРАА ШАЛГАХ

Тухайн барааны мөн чанар, гарал үүсэл, байгаа нөхцөл байдал, тоо хэмжээ, үнэ нь холбогдох Гаалийн мэдүүлэгт заасантай нийцэж буй эсэхийг бататган тогтоохоор гаалийн байгууллагаас тухайн бараанд биет шалгалт хийх.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

EXCHANGE CONTROL DECLARATION (EXPORT)

Document completed by an exporter/seller as a means whereby the competent body may control that the amount of foreign exchange accrued from a trade transaction is repatriated in accordance with the conditions of payment and exchange control regulations in force.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ВАЛЮТЫН ХЯНАЛТЫН МЭДҮҮЛЭГ (ЭКСПОРТ)

Экспортлогчийн/худалдагчийн бөглөсөн, түүгээр эрх бүхий байгууллага худалдааны ямар нэг хэлцлийн үр дүнд тодорхой хэмжээний гадаад валют төлбөрийн нөхцөлийн дагуу, мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй валютын хяналтын дүрэм журмын дагуу орж ирсэн болохыг хянаж болох бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXCHANGE CONTROL DECLARATION (IMPORT)

Document completed by an importer/buyer as a means for the competent body to control that a trade transaction for which foreign exchange has been allocated has been executed and that money has been transferred in accordance with the conditions of payment and the exchange control regulations in force.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ВАЛЮТЫН ХЯНАЛТЫН МЭДҮҮЛЭГ (ИМПОРТ)

Импортлогчийн/худалдан авагчийн бөглөсөн, түүгээр эрх бүхий байгууллага гадаад валют хуваарилагдсан худалдааны ямар нэг хэлцэл хийгдсэн бөгөөд тэр мөнгийг төлбөрийн нөхцөлийн дагуу, мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй валютын хяналтын дүрэм журмын дагуу шилжүүлсэн болохыг хянаж болох бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPEDITED SHIPMENTS

Expedited release of at least those goods entered through air cargo facilities to persons who apply for such treatment, while maintaining Customs control. The WTO Trade Facilitation Agreement requires WTO Members to minimize the documentation required for the release of expedited shipments; provide for expedited shipments to be released under normal circumstances as rapidly as possible after arrival; provide to the extent possible for a de minimis shipment value or dutiable amount for which Customs duties and taxes will not be collected, aside from certain prescribed goods. [Art. 7.8.2 TFA]

ТҮРГЭВЧИЛСЭН БҮРДҮҮЛЭЛТ ХИЙЛГЭХ АЧАА

Түргэвчилсэн бүрдүүлэлт хийлгэх хүсэлт тавьсан этгээдийн хувьд, гаалийн хяналтыг сулруулалгүйгээр, ядахдаа агаарын ачаа тээшний газраар дамжин орж ирсэн бараанд түргэвчилсэн бүрдүүлэлт хийж олгох журам. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрээр түргэвчилсэн бүрдүүлэлт хийлгэх ачааг олгоход шаардагдах бичиг баримтын тоог цөөлөх; түргэвчилсэн бүрдүүлэлт хийлгэх ачааг ирсэн даруйд нь ердийн тохиолдолд аль болох түргэн олгодог журам тогтоох; тусгайлан заасан зарим бараанаас бусад тохиолдолд, боломжийнхоо хэрээр, ачааны de minimis үнэ буюу гаалийн болон бусад татвар ногдуулах боловч хураан авахгүй байх хэмжээ тогтоохыг ДХБ-ын гишүүдээс шаардаж байгаа.
[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 2]

EXPORT AGENT

An intermediary who acts on behalf of a company to open up or develop a market in a foreign country.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН АГЕНТ

Гадаад оронд зах зээл нээх буюу хөгжүүлэх зорилгоор аль нэг компанийн нэрийн өмнөөс ажилладаг завсрын этгээд.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT BROKER

Individual who brings together buyer and seller for a fee, eventually withdrawing from any transaction.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН ЗУУЧЛАГЧ

Худалдан авагч, худалдагч хоёрыг төлбөртэйгөөр холбон өгөөд, дараа нь аливаа хэлэлцээнд үл оролцох хувь хүн.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT CONTROL

A system of organizational, legal and economic measures of control of exports of various goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН ХЯНАЛТ

Янз бүрийн барааны экспортын хяналтын зохион байгуулалтын, эрх зүйн болон эдийн засгийн арга хэмжээний систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT DECLARATION

A document describing the complete particulars of a specific shipment (also known as the shipper's export declaration or SED). It is required by the relevant government agencies (e.g. the Department of Commerce) in order to control exports and for statistical purposes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН МЭДҮҮЛЭГ

Тодорхой нэг ачилтын бүх мэдээллийг тодорхойлсон бичиг баримт (Үүнийг бас ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн экспортын мэдүүлэг ч гэдэг). Энэ мэдүүлэг нь экспортыг хянах зорилгоор, мөн статистикийн зорилгоор төрийн холбогдох байгууллага (жишээлбэл, Худалдааны яам)-д хэрэгтэй байдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT DUTIES AND TAXES

Customs duties and all other duties, taxes or charges which are collected on or in connection with the exportation of goods, but not including any charges which are limited in amount to the approximate cost of services rendered or collected by the Customs on behalf of another national authority.
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ЭКСПОРТЫН ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР

Барааг экспортлох үед, эсхүл экспортлохтой холбогдуулан хураан авах гаалийн болон бусад бүх татвар, төлбөр. Гэвч үүнд гаалийн байгууллагын үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй ойролцоо хэмжээгээр хязгаарлагдах, эсхүл гаалийн байгууллага болон дотоодын бусад байгууллагын нэрийн өмнөөс хураасан аливаа төлбөр хамаарахгүй.
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

EXPORTATION

The act of taking out or causing to be taken out any goods from the Customs territory.

ЭКСПОРТЛОХ (ГАРГАХ)

Аливаа барааг гаалийн нутаг дэвсгэрээс авч гарах, эсхүл авч гарах нөхцлийг бүрдүүлэх үйлдэл.

Note:
Specific Annex C, Chapter 1 of the revised Kyoto Convent ion.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт С-гийн 1 дүгээр бүлэг.

EXPORT DUTIES AND TAXES

Customs duties and all other duties, taxes or charges which are collected in connection with the exportation of goods, but not including any charges which are limited in amount to the approximate cost of services rendered or collected by the Customs on behalf of another national authority. Export duties are allowed by the current WTO standards.
(Article I of GATT 1994) (General Annex, Chapter 2, to the Revised Kyoto Convention)

ЭКСПОРТЫН ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР

Барааг экспортлох үед, эсхүл экспортлохтой холбогдуулан хураан авах гаалийн болон бусад бүх татвар, төлбөрийг хэлнэ. Гэвч үүнд гаалийн байгууллагын үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй ойролцоо хэмжээгээр хязгаарлагдах, эсхүл гаалийн байгууллага үндэсний бусад байгууллагын нэрийн өмнөөс хураасан аливаа төлбөр хамаарахгүй. Экспортын гаалийн татвар ногдуулахыг ДХБ-ын одоогийн стандартаар зөвшөөрч байгаа.
(1994 оны ТХЕХ-ийн I зүйл) (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг)

EXPORTER

Party who makes, or on whose behalf the export declaration is made, and who is the owner of the goods or has similar rights of disposal over them at the time when the declaration is accepted.
[UNTDED]

ЭКСПОРТЛОГЧ

Экспортын мэдүүлэг бөглөсөн, эсхүл нэр дээр нь экспортын мэдүүлэг бөглөгдсөн, тухайн мэдүүлгийг хүлээн зөвшөөрөх үед бараа өмчлөгч, эсхүл бараа эзэмших эрхтэй байсан тал.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

EXPORT FACTORING

Lending to exporting customers by factoring companies against prospective export earnings, while providing the customer with a guarantee against currency and credit risks.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН ФАКТОРИНГ

Факторингийн компаниас экспортлогч-үйлчлүүлэгч нартаа ирээдүйн экспортын орлогыг нь барьцаалан зээл олгож, түүний зэрэгцээ тэдгээр үйлчлүүлэгч нарт валютын болон зээлийн эрсдэлийн баталгаа гаргаж өгөх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT FINANCING

Financing of exporters to ship goods to other countries, including with the condition of granting credits to buyers and sellers.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Экспортлогч бараагаа бусад орон руу ачуулах ажлыг санхүүжүүлэх. Үүнд худалдан авагч болон худалдагчид зээл олгох нөхцөл хамаарна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT FINANCING CREDIT

Bank credit to finance additional costs in the importing country related to the exportation of goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЗЭЭЛ

Бараа экспортлохтой холбогдуулан импортлогч оронд гарсан нэмэлт зардлыг санхүүжүүлэх банкны зээл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT GUARANTEE

A guarantee that the importer will execute payments to the exporter on terms determined by the foreign trade contract.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН БАТАЛГАА

Импортлогч төлбөрийг гадаад худалдааны гэрээнд заасан нөхцөлөөр экспортлогчид төлөх баталгаа.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT LICENCE

Document granting permission to export goods as detailed within a specific time (UN/ECE/FAL).

Application for permission to export specified goods of a specified value to a specific destination.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН ЛИЦЕНЗ

Тодорхой хугацааны дотор экспортлох барааанд олгосон зөвшөөрлийн бичиг баримт (НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц).

Тодорхой үнэ бүхий тодорхой барааг тодорхой чиглэлд экспортлох зөвшөөрөл авах өргөдөл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT OF GOODS

Export of goods for sale on the foreign market.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ЭКСПОРТЛОХ

Барааг гадаадын зах зээл дээр худалдахаар экспортлох.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT PRICE CALCULATION

An internal document drawn up by a foreign trade enterprise to justify the effectiveness of the planned export operation.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН ҮНИЙГ ТООЦООЛОХ

Экспортын төлөвлөсөн үйл ажиллагаа үр өгөөжтэй эсэхийг тогтоохоор гадаад худалдааны үйлдвэрийн газраас үйлдсэн дотоодын бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT PROCESSING ZONE (EPZ)

Zone with duty-free import of goods for the purpose of processing and subsequent re-export.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЫН БАРАА БОЛОВСРУУЛАХ БҮС

Импортын барааг боловсруулах зорилгоор гаалийн татваргүй оруулж, дараа нь буцаан гаргах бүс.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXPORT/IMPORT TAX

Compulsory tax payment levied by the state from exporters and importers and credited to the state or local budgets.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТ/ИМПОРТЫН ТАТВАР

Экспорт, импортлогч нараас төр хураан авч, улсын, эсхүл орон нутгийн төсөвт оруулдаг албан журмын татвар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EXTENSIBLE MARK-UP LANGUAGE (XML)

A metalanguage, which was approved as a World Wide Web Consortium (W3C) recommendation, and which represents a set of general syntax rules. XML is designed for storing “structured” data (as opposed to existing “static” databases) and for the creation of more specialized programming languages (e.g. XHTML), sometimes called dictionaries.

XML allows for presenting the same sets of data in different formats, which makes it suitable for use for electronic trade documents exchanged over the Internet.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ӨРГӨТГӨСӨН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ХЭЛ (ӨРГӨТГӨХ БОЛОМЖТОЙ БИЧЛЭГИЙН ХЭЛ, XML)

Дэлхий дахины вебийн консорциумын зөвлөмж гэж зөвшөөрөгдсөн, өгүүлбэр зүйн ерөнхий багц дүрэм болох дээд хэл. XML нь “бүтэцлэгдсэн“ (шаталсан бүтэцтэй) мэдээлэл (одоогийн “статик” мэдээллийн баазыг орлож байгаа)-ийг хадгалах, мөн програмын илүү мэргэжлийн хэл (жишээлбэл, XHTML) бүтээх зориулалттай юм. Эдгээрийг заримдаа толь бичиг гэдэг.

XML нь яг адил багц мэдээллийг янз бүрийн форматад хувиргах боломж олгодог. Тэгэхээр түүнийг худалдааны цахим баримтуудыг интернэтээр солилцоход ашиглавал их тохиромжтой юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

EX-SITU CONSERVATION

The conservation of components of biological diversity outside their natural habitats.

Convention on Biological Diversity
(Biodiversity Convention)

EX-SITU ХАДГАЛАХ

Биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгийг түүний амьдардаг нутаг орны нь гадна хадгалах.
Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

EXW (EX WORKS) [INSERT NAMED PLACE OF DELIVERY]

Incoterms rule under which the seller delivers when it places the goods at the disposal of the buyer at a named place (e.g. a factory or a warehouse) and that named place may or may not be the seller's premises. The seller does not need to load the goods on any collecting vehicle, nor does it need to clear the goods for export, where such clearance is applicable. The buyer bears all costs and risks involved in taking the goods from the agreed point, if any, at the named place of delivery. EXW represents the least set of obligation for the seller. This rule may be used irrespective of the mode of transport selected and may also be used where more than one mode of transport is employed. It is suitable for domestic trade, while FCA is usually more appropriate for international trade. [ICC/INCOTERMS 2020]

EXW (ФРАНКО-АГУУЛАХ, ФРАНКО-ЗАВОД (АГУУЛАХ БУЮУ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР ХҮРГЭЭД ЧӨЛӨӨТЭЙ) [ХҮРГЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч барааг худалдагчийн байранд, эсхүл нэр заасан өөр газар (өөрөөр хэлбэл, ажлын байр, үйлдвэр, агуулах гэх мэт)-т худалдан авагчийн мэдэлд шилжүүлэхээр хүргэж өгнө гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм юм. Худалдагч барааг ямар нэг төлбөртэй тээврийн хэрэгсэлд ачих, эсхүл тухайн барааанд экспортын бүрдүүлэлт хийлгэх ёстой байлаа гэхэд тийм бүрдүүлэлт хийлгэх үүрэг хүлээхгүй. Худалдан авагч тухайн барааг хэрэв тийнхүү тохиролцсон бол нэр заасан хүргэх газарт байгаа тохиролцсон цэгт хүргэхтэй холбогдсон бүх зардал, эрсдэлийг хариуцна. EXW нь худалдагчийн хувьд хамгийн бага үүрэг хүлээлгэдэг. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно. Энэ дүрмийг дотоод худалдаанд хэрэглэхэд тохиромжтой байдаг бол FCA-г гол төлөв олон улсын худалдаанд хэрэглэхэд тохиромжтой байдаг.
Жич:
[ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

F

FAS (FREE ALONGSIDE SHIP) [INSERT NAMED PORT OF SHIPMENT]

Incoterms rule under which the seller delivers when the goods are placed alongside the vessel (e.g., on a quay or a barge) nominated by the buyer at the named port of shipment or when the seller procures goods already so delivered. The risk of loss of or damage to the goods passes when the goods are alongside the ship, and the buyer bears all costs from that moment onwards. FAS requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out import Customs formalities. This rule is to be used only for sea or inland waterway transport and where more than one mode of transport is to be used; the appropriate rule to use is FCA (Free Carrier).
[ICC/INCOTERMS 2020]

FAS (УСАН ОНГОЦНЫ ДЭРГЭД АВЧРААД ЧӨЛӨӨТЭЙ) [НЭР ЗААСАН АЧИХ БООМТЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч барааг нэр заасан ачих боомтод байгаа, худалдан авагчийн санал болгосон усан онгоцны дэргэд (жишээлбэл, усан онгоцны зогсоол дээр, эсхүл ачааны хөвөгч чиргүүл дээр) аваачихаар хүргэж өгнө гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм юм. Бараа алдагдах, гэмтэх эрсдэл нь барааг усан онгоцны дэргэд авчирсанаар шилжих бөгөөд худалдан авагч энэ үеэс цааш бүх зардлыг хариуцна. FAS нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг. Энэ дүрмийг зөвхөн далайн буюу усан тээвэрт хэрэглэнэ. Тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах бол FCA (Тээвэрлэгчид хүргээд чөлөөтэй) нөхцөлийг ашиглах нь тохиромжтой байдаг.
[ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

FCA (FREE CARRIER) [INSERT NAMED PLACE OF DELIVERY]

Incoterms rule under which the seller delivers the goods in one of the two ways: a) when the named place is the seller's premises, the goods are delivered when they are loaded on the means of transport arranged by the buyer. b) when the named place is another place, the goods are delivered when, having been loaded on the seller's means of transport, they reach the named other place and are ready for unloading from that seller's means of transport and at the disposal of the carrier or of another person nominated by the buyer. Whichever of the two is chosen as the place of delivery, that place identifies where risk transfers to the buyer and the time from which costs are for the buyer's account.

FCA (ТЭЭВЭРЛЭГЧИД ХҮРГЭЭД ЧӨЛӨӨТЭЙ) [НЭР ЗААСАН ХҮРГЭХ ГАЗРЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдааг барааг дараах хоёр замын нэгээр хүргэж өгнө гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм юм: а) хэрэв нэр заасан газар нь худалдагчийн байр бол барааг худалдан авагчийн гэрээлсэн тээврийн хэрэгсэлд ачуулахаар хүргэж өгөх. b) хэрэв нэр заасан газар нь өөр газар бол барааг худалдагчийн тээврийн хэрэгсэлд ачуулж, тэрхүү нэр заасан өөр газарт хүргэж өгөх, худалдагчийн тээврийн хэрэгслээс буулгахад бэлтгэж, худалдан авагчийн санал болгосон тээвэрлэгч буюу түүний санал болгосон өөр этгээдийн мэдэлд шилжүүлэн өгөх. Энэ хоёрын алиныг нь ч бараа хүргэх газар гэж сонгосон хамаагүй тухайн газар нь эрсдэл хэзээ худалдан авагчид шилжихийг, бас зардлыг худалдан авагч хэзээнээс эхлэн өөрөө хариуцахыг зааж өгнө.

FCA requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out import formalities. This rule may be used irrespective of the mode of transport selected and may also be used where more than one mode of transport is employed.
[ICC/INCOTERMS 2020]

FCA нь барааны экспортын (хэрэв тэгэх шаардлагатай бол), мөн импортын бүрдүүлэлтийг хийлгэх, мөн импортын гаалийн аливаа татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдагчид хүлээлгэдэг. Энэ дүрмийг тээврийн ямар ч төрөлд хэрэглэж болно. Мөн тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах тохиолдолд бас хэрэглэж болно.
[ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

FEES AND FORMALITIES RELATED TO IMPORTATION AND EXPORTATION

Article VIII of GATT 1994, entitled “Fees and Formalities Related to Importation or Exportation”, contains an important legal rule requiring simplification of import and export formalities and reducing them to a minimum, as well as simplifying the requirements for import and export documentation. According to the same article, all fees and charges (other than duties and taxes) associated with the import and export of goods should be limited to the approximate cost of the services rendered, and not serve as an indirect protection for domestic goods or a means of taxing imports or exports for fiscal purposes. The issues of simplification of export and import, as well as Customs formalities, subject to the measures of the WTO Trade Facilitation Agreement (notably art. 10.1).

БАРАА ОРУУЛАХ, ГАРГАХАД ХАМААРАХ ХУРААМЖ БА ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА

1994 оны ТХЕХ-ийн “Бараа оруулах, гаргахад хамаарах хураамж ба ёс журмын ажиллагаа” гэсэн гарчигтай VIII зүйлд импорт, экспортын ёс журмын ажиллагааг хялбарчилж, хамгийн доод хэмжээнд хүртэл багасгах, мөн түүнчлэн импорт, экспортын бичиг баримтын шаардлагыг хялбарчлахыг шаардсан эрх зүйн нэн чухал ач холбогдолтой заалт байдаг юм. Мөн энэ зүйлийн дагуу бараа оруулах, гаргахтай холбогдсон бүх хураамж, төлбөр (гаалийн болон бусад татвараас бусад) нь үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй ойролцоо хэмжээгээр хязгаарлагдах ёстой бөгөөд тэдгээрийг дотоодын барааг шууд бусаар хамгаалах хэрэгсэл болгож, эсхүл төсвийн зорилгоор импортын буюу экспортын бараанд татвар ногдуулах арга хэрэгсэл болгож болохгүй. Экспорт, импортыг хялбарчлах, түүний дотор гаалийн ёс журмын ажиллагааг хялбарчлах асуудал ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн дагуу (ялангуяа түүний 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу) авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарна.

FEES AND CHARGES FOR CUSTOMS PROCESSING IMPOSED ON OR IN CONNECTION WITH IMPORTATION AND EXPORTATION

All fees and charges other than import and export duties and other than taxes within the purview of Article III of GATT 1994 imposed by WTO Members on or in connection with the importation or exportation of goods (Art. 6.1.1 TFA).

БАРАА ОРУУЛАХ, ГАРГАХАД ҮЕД, ЭСХҮЛ ТҮҮНТЭЙ ХОЛБОГДУУЛАН НОГДУУЛАХ ХУРААМЖ БА ТӨЛБӨР

1994 оны ТХЕХ-ийн III зүйлийн хүрээнд, бараа оруулах, гаргахад үед, эсхүл түүнтэй холбогдуулан ДХБ-ын гишүүдээс ногдуулах, импортын болон экспортын гаалийн татвараас бусад, бас бусад татвараас бусад бүх хураамж болон төлбөр (Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 1.1 дэх заалт).

Fees and charges shall be limited in amount to the approximate cost of the services rendered on or in connection with the specific import or export operation in question; and are not required to be linked to a specific import or export operation provided they are levied for services that are closely connected to the Customs processing of goods (Art. 6.2 TFA).

Төлбөр, хураамж нь холбогдох импортын, эсхүл экспортын тодорхой нэг үйл ажиллагааныүед,эсхүлтүүнтэйхолбогдуулан үзүүлсэн үйлчилгээний зардалтай ойролцоо хэмжээгээр хязгаарлагдсан байх бөгөөд хэрэв тэдгээрийг тухайн барааны гаалийн бүрдүүлэлттэй ойрхон холбогдол бүхий үйлчилгээнд ногдуулдаг бол тэдгээрийг импортын, эсхүл экспортын ямар нэг үйл ажиллагаатай холбож болохгүй (Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалт).

FINAL CONSIGNEE; ULTIMATE CONSIGNEE

The party to whom goods or services are sold as stipulated in a sales order contract.
(Trade Facilitation Terms: An English - Russian -* Chinese Glossary, UNECE, 2019)

ЭЦСИЙН ХҮЛЭЭН АВАГЧ; СҮҮЛЧИЙН ХҮЛЭЭН АВАГЧ

Бараа худалдах, худалдан авах захиалгын гэрээнд заасны дагуу бараа, үйлчилгээг худалдан авсан тал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FINAL DELIVERY PARTY; ULTIMATE DELIVERY PARTY

The party to whom goods will be or have been ultimately shipped.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРЭХ ЭЦСИЙН ТАЛ; БАРАА ХҮРЭХ СҮҮЛЧИЙН ТАЛ

Барааг хаягаар нь ачуулах буюу ачсан сүүлчийн тал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FLIGHT MANIFEST

A document listing the cargo, passengers, and crew of an aircraft for the use of Customs and other officials.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НИСЛЭГИЙН МАНИФЕСТ

Гаалийн болон бусад байгууллагын ажилтнуудад зориулсан, ямар нэг нисэх онгоцны ачаа, зорчигч, багийн гишүүдийн нэрсийг жагсаасан бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FOB – FREE ON BOARD

“Free On Board” means that the seller delivers the goods on board the vessel nominated by the buyer at the named port of shipment or procures the goods already so delivered.

FOB – УСАН ОНГОЦНЫ ТАВЦАН ДЭЭР ГАРГААД ЧӨЛӨӨТЭЙ

“Усан онгоцны тавцан дээр гаргаад чөлөөтэй” гэдэг нь худалдагч барааг нэр заасан ачих боомтод байгаа, худалдагчийн санал болгосон усан онгоцны тавцан дээр гаргахаар хүргэж өгнө, эсхүл ийм нөхцөлөөр нийлүүлсэн барааг худалдаж авна гэсэн утгатай юм.

The risk of loss of or damage to the goods passes when the goods are on board the vessel, and the buyer bears all costs from that moment onwards.

Бараа алдагдах, гэмтэх эрсдэл нь барааг усан онгоцонд ачуулсан үед шилжих бөгөөд худалдан авагч энэ үеэс цааш бүх зардлыг хариуцна.

FOB (FREE ON BOARD) [INSERT NAMED PORT OF SHIPMENT]

Incoterms rule under which the seller delivers the goods to the buyer on board the vessel nominated by the buyer at the named port of shipment or procures the goods already so delivered. The risk of loss of or damage to the goods passes when the goods are on board the vessel, and the buyer bears all costs from that moment onwards. FOB requires the seller to clear the goods for export (if applicable), while the buyer has to clear the goods for import or for transit as well as to pay import duties and carry out import Customs formalities. This rule is to be used only for sea or inland waterway transport. Where more than one mode of transport is to be used, the appropriate rule to use is FCA (Free Carrier). [ICC/INCOTERMS 2020]

FOB (УСАН ОНГОЦНЫ ТАВЦАН ДЭЭР ГАРГААД ЧӨЛӨӨТЭЙ) [НЭР ЗААСАН АЧИХ БООМТЫН НЭР БИЧИГДЭНЭ]

Худалдагч барааг нэр заасан ачих боомтод байгаа, худалдагчийн санал болгосон усан онгоцны тавцан дээр гаргахаар хүргэж өгнө, эсхүл ийм нөхцөлөөр нийлүүлсэн барааг худалдаж авна гэсэн утгатай ИНКОТЕРМС-ийн дүрэм. Бараа алдагдах, гэмтэх эрсдэл нь барааг усан онгоцонд ачуулсан үед шилжих бөгөөд худалдан авагч энэ үеэс цааш бүх зардлыг хариуцна. FOB нь барааны экспортын бүрдүүлэлт хийлгэх үүргийг худалдагчид (хэрэв тэгэх шаардлагатай бол), импортын, эсхүл дамжин өнгөрөх бүрдүүлэлт хийлгэх, мөн импортын гаалийн татвар төлөх, импортын гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэтгэх үүргийг худалдан авагчид хүлээлгэдэг. Энэ дүрмийг зөвхөн далайн буюу усан тээвэрт хэрэглэнэ. Тээврийн нэгээс дээш төрлийг ашиглах бол FCA (Тээвэрлэгчид хүргээд чөлөөтэй) нөхцөлийг ашиглах нь тохиромжтой байдаг. [ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

FORCE MAJEURE

The title of a common clause in contracts, exempting the parties for non-fulfilment of their obligations as a result of conditions beyond their control, such as earthquakes, floods or war.

ГЭНЭТИЙН БОЛОН (БАЙГАЛИЙН) ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Газар хөдлөлт, үер, дайн зэрэг гэрээний талуудын хяналтаас гадуур орших нөхцөл байдлын үр дүнд талууд үүргээ биелүүлэхээс чөлөөлөгддөг, гэрээний нийтлэг заалтын нэр.

FOREIGN EXCHANGE PERMIT/ LICENSE

Document issued by the competent body authorizing an importer/buyer to transfer an amount of foreign exchange to an exporter/ seller in payment for goods.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ГАДААД ВАЛЮТЫН ЗӨВШӨӨРӨЛ/ ЛИЦЕНЗ

Барааны төлбөр гүйцэтгэх зорилгоор тодорхой хэмжээний гадаад валют экспортлогч/худалдагчид шилжүүлэхийг импортлогч/худалдан авагчид зөвшөөрдөг эрх бүхий байгууллагаас үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FOREIGN TRADE BANK

Special credit institution (commercial bank), which provides credits for import and export operations, export credit insurance and mutual foreign trade settlements.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ГАДААД ХУДАЛДААНЫ БАНК

Импорт, экспортын үйл ажиллагаа эрхлэх, экспортын зээлийн даатгал хийлгэх, талуудын хоорондын гадаад хуралдааны төлбөр тооцоог барагдуулахад зээл олгодог зээлийн тусгай байгууллага (арилжааны bank)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FOREIGN TRADE RESTRICTIONS

Trade policy measures that create impediments to the sale of foreign goods on the domestic market of a country. These measures take the form of tariffs or quotas on the importation and sale of foreign goods, as well as non-tariff barriers.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ГАДААД ХУДАЛДААНЫ ХЯЗГААРЛАЛТ

Гадаадын барааг аль нэг улсын дотоодын зах зээлд борлуулахад саад учруулж буй худалдааны бодлогын арга хэмжээ. Ийм арга хэмжээнд импортод болон гадаадын бараа борлуулахад ногдуулдаг тариф, квот, мөн түүнчлэн тарифын бус саад тотгор хамаарна.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FORMALITIES

Regulatory administrative procedures and related legal provisions on controls of crossborder import, export and transit activities. These include provisions prescribed by laws, rules, regulations or instructions issued by the regulatory administrative authorities of States and Customs territories, which cover procedures of official controls and the granting of clearance, licenses, permits; prohibitions and restrictions; as well as methods of verification and analysis.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА

Хил дамнасан импорт, экспорт, транзитын үйл ажиллагаанд хяналт тавих тухай хэм хэмжээ тогтоосон захиргааны байгууллагын горим журмууд. Эдгээр горим журамд улсуудын болон гаалийн нутаг дэвсгэрүүдийн төрийн захиргааны тохируулагч байгууллагуудаас гаргасан хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын дараах зохицуулалттай холбогдсон заалтууд хамаарна: албан ёсны хяналт шалгалт, бүрдүүлэт, лиценз, зөвшөөрөл; хориг, хязгаарлалт; мөн түүнчлэн шалгаж тогтоох болон дүн шинжилгээ хийх аргууд.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FORMAL TRADE CONSULTATION

Formal trade consultations are regular meetings of Customs administrations with representatives of local, regional and country-wide trading and transport communities to discuss new developments and problem areas with a view to increase the efficiency and effectiveness of Customs processes and procedures.

ХУДАЛДАА ЭРХЛЭГЧ НАРТАЙ ХИЙХ АЛБАН ЁСНЫ ЗӨВЛӨГӨӨН

Худалдаа эрхлэгч нартай хийх албан ёсны зөвлөгөөн гэдэг нь гаалийн байгууллага гаалийн үйл ажиллагаа болон горим журмын үр ашиг, үр дагаварыг дээшлүүлэх зорилгоор шинээр нэвтрүүлж буй ажил болон тулгамдсан асуудлаа хэлэлцэх үүднээс орон нутгийн, бүс нутгийн, мөн улс орны

Formal consultative relationships with the trade are required by Standard 1.3 of the Revised Kyoto Convention. As described in the ICC Customs Guidelines in particular Guideline 29 on trade consultation, the ideal solution is a formal consultative committee representing all major trade partners, including exporters/ importers, agents, banks, carriers and insurers.

хэмжээний худалдаа, тээврийн салбарын төлөөлөгчидтэй хийдэг тогтмол уулзалтууд юм. Худалдаа эрхлэгч нартай зөвлөлдөх албан ёсны харилцаатай байх талаар шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн стандарт 1.3-т дурдсан байдаг. Олон улсын худалдааны танхимаас гаргасан Гаалийн хөтөч, ялангуяа, түүний худалдаа эрхлэгч нартай хийх зөвлөгөөний тухай заавар 29-д зааснаар, хамгийн зөв шийдэл бол албан ёсны зөвлөлдөх хороо байгуулж, түүний бүрэлдэхүүнд худалдааны бүх томоохон түншүүд, түүний дотор экспортлогч, импортлогч, тэдний агентууд, банк, тээвэрлэгч, даатгалын байгууллын төлөөллийг оролцуулах явдал юм.

FORWARDER

Party undertaking forwarding of goods.
[UNTDED]

ЭКСПЕДИТОР (ТЭЭВЭР ЗУУЧ)

Бараа явуулах үүрэг хүлээсэн тал.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

FORWARDER'S CERTIFICATE OF RECEIPT (FIATA-FCR)

Non-negotiable document issued by a freight forwarder to certify that he has assumed control of a specified consignment, with irrevocable instructions to send it to the consignee indicated in the document or to hold it at his disposal. [FIATA]

АЧАА ХҮЛЭЭЖ АВСАН ТУХАЙ ЭКСПЕДИТОР (ТЭЭВЭР ЗУУЧ)-ЫН ГЭРЧИЛГЭЭ (ТЭЭВЭР ЗУУЧДЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОО- АЧАА ХҮЛЭЭЖ АВСАН ТУХАЙ ЭКСПЕДИТОРЫН ГЭРЧИЛГЭЭ)

Ачаа хүлээж авсаныг гэрчилж экспедитор (тээвэр зууч)-ын үйлдсэн бичиг баримт. Энэ нь төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) биш юм. Энэ гэрчилгээ нь экспедитор (тээвэр зууч – илгээгч) түүнд заасан тодорхой нэг ачааг хүлээн авагч руу илгээх буцаан үл дуудагдах зааврын хамт хяналтандаа авсан болохыг, эсхүл өөрийн эзэмшилд байлгаж байгаа болохыг гэрчилнэ. [Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

FORWARDER'S CERTIFICATE OF TRANSPORT (FIATA-FCT)

Document issued by a freight forwarder to certify that he has taken charge of a specified consignment for dispatch and delivery in accordance with the consignor's instructions, as indicated in the document, and that he accepts responsibility for delivery of the goods to the holder of the document through the intermediary of a delivery agent of his choice. The document is negotiable if issued "to order". [FIATA]

ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ ЭКСПЕДИТОР (ТЭЭВЭР ЗУУЧ)-ЫН ГЭРЧИЛГЭЭ (ТЭЭВЭР ЗУУЧДЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОО- ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ ЭКСПЕДИТОРЫН ГЭРЧИЛГЭЭ)

Тээвэр зуучаас үйлдсэн, тэр нь тодорхой нэг ачааг уг бичиг баримтад зааснаар бараа илгээгчийн зааврын дагуу илгээх болон хүргэх үүрэг хүлээсэн, мөн тэр нь тухайн барааг түүний сонгосон ачаа хүргэх агентаар зуучлуулан хүргэх хариуцлагыг энэ бичиг баримтыг эзэмшигчийн өмнө хүлээж байгааг гэрчлэх бичиг баримт. Энэ бичиг баримт нь хэрэв "зааврын дагуу" гэж бичсэн бол төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болно.

[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

FORWARDER'S WAREHOUSE RECEIPT (FIATA-FWR)

Document issued by a freight forwarder acting as Warehouse Keeper acknowledging receipt of goods placed in a warehouse, and stating or referring to the conditions which govern the warehousing and the release of goods. The document contains detailed provisions regarding the rights of holdersby-endorsement, transfer of ownership, etc. (FIATA).

ЭКСПЕДИТОР (ТЭЭВЭР ЗУУЧ)-ЫН АГУУЛАХЫН БАРИМТ/ТАСАЛБАР (ТЭЭВЭР ЗУУЧДЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОО- ЭКСПЕДИТОРЫН АГУУЛАХЫН БАРИМТ/ ТАСАЛБАР)

Агуулах эрхэлдэг экспедитор (тээвэр зууч)-ын үйлдсэн, барааг агуулахад байршуулсаныг хүлээн зөвшөөрч, агуулахын болон бараа олгох нөхцөлийг зааж, түүнийг үндэслэсэн бичиг баримт. Энэ бичиг баримтад энэхүү бичиг баримт эзэмшигчийн эрх, өмчийн эрх шилжүүлэх тухай, г.м. дэлгэрэнгүй заалтууд байдаг.

[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

FORWARDING INSTRUCTIONS; FIATA FORWARDING INSTRUCTIONS (FIATA-FFI)

Document issued to a freight forwarder, giving instructions regarding the action to be taken by the forwarder for the forwarding of goods described therein. [FIATA]

ЭКСПЕДИТОР (ТЭЭВЭР ЗУУЧ)-ЫН ЗААВРУУД; ТЭЭВЭР ЗУУЧДЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБООНЫ ЗААВРУУД (ТЭЭВЭР ЗУУЧДЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОО- АЧАА ИЛГЭЭХ ЗААВРУУД)

Тээвэр зуучид олгосон бичиг баримт. Түүнд заасан барааг явуулахын тулд экспедитор (тээвэр зууч) юу хийх ёстойг уг бичиг баримтад заасан байдаг.

[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

FOUL BILL OF LADING

A receipt for goods issued by a carrier with an indication that the goods were damaged when received.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТАЙЛБАР БҮХИЙ ТЭЭВРИЙН БАРИМТ

Барааг хүлээн авах үед эвдэрч гэмтсэн болохыг зааж, тийм бараанд зориулж тээвэрлэгчээс үйлдсэн баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FRAME CONTRACT

A trade transaction based on two contracts, which require that partners carry out a second purchase within the agreed period.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ПАРАЛЛЕЛЬ ГЭРЭЭ, ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

Хоёр гэрээг үндэслэсэн худалдааны хэлцэл. Энэ хэлцэл нь түншүүд тохиролцсон хугацаанд хоёр дахь худалдан авалт хийхийг шаарддаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FRAMEWORK OF STANDARDS TO SECURE AND FACILITATE GLOBAL TRADE

A regime, developed at the World Customs Organization, expected to enhance the security and facilitation of international trade. This global supply chain security initiative, on the part of the international Customs community, is aimed at protecting world trade from the threats posed by international terrorism, organized crime and ever-increasing Customs offences. At the same time it will provide a structured platform to facilitate the movement of legitimate goods being traded internationally. The Framework aims at providing a new approach to partnership between Customs and the business community, which commit together to the implementation of a series of 17 Standards regulating the security and facilitation of international trade. Worldwide implementation of the Framework is supported by a sustainable capacity-building programme.

ДЭЛХИЙН ХУДАЛДААГ АЮУЛГҮЙ БАЙЛГАХ БОЛОН ХӨНГӨВЧЛӨХ БАГЦ СТАНДАРТ

Дэлхийн гаалийн байгууллагаас боловсруулсан энэхүү зөвлөмж нь олон улсын худалдааны аюулгүй байдлыг хангах, худалдааг хөнгөвчлөхөд чиглэгдсэн байна. Олон улсын гаалийн байгууллагын хувьд бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлын талаарх энэхүү санаачлага нь дэлхийн худалдааг олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, улам бүр нэмэгдэж буй гаалийн зөрчлөөс хамгаалах зорилготой юм. Үүний зэрэгцээ энэ нь олон улсын хэмжээнд худалдаалагдаж буй хууль ёсны бараа бүтээгдэхүүний хөдөлгөөнийг хөнгөвчлөх бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй) платформоор хангаж өгдөг. Энэхүү багц стандарт нь олон улсын худалдааны аюулгүй байдал, худалдааг хөнгөвчлөх үйл явцыг зохицуулдаг 17 стандартыг хамтдаа хэрэгжүүлэх гааль болон бизнесийн түншлэлийн шинэ хандлагыг бий болгоход чиглэгдэнэ. Багц стандартыг дэлхий даяар хэрэгжүүлэхийн тулд чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг тууштай дэмжих болно.

FREE IN AND OUT (F.I.O.)

The cost of loading and unloading are for the account of the shipper, and not the carrier.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА АЧИХ БОЛОН БУУЛГАХ ЗАРДЛААС ЧӨЛӨӨТЭЙ

Ачаа ачих, буулгах зардлыг тухайн тээвэрлэгч биш, ачаа бэлтгэгч (ачигч компани) хариуцна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREE OF CAPTURE AND SEIZURE (F.C & S)

A clause which exempts the marine insurance company from paying losses caused by capture or seizure by enemies of a country.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

СААТУУЛАХ БОЛОН БАРИВЧЛАХААС ЧӨЛӨӨТЭЙ

Хууль ёсны дагуу болон хууль бусаар саатуулах, баривчилах, хураан авах, мөн түүнчлэн зэвсэгт мөргөлдөөн болон далайн дээрмээс үүдэлтэй хохирлыг далайн тээврийн даатгалын компани нөхөн төлөхгүй гэсэн тайлбар бүхий даатгалын гэрээний заалт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREE-TRADE AGREEMENT (FTA)

An arrangement which establishes unimpeded exchange and flow of goods and services between trading partners regardless of national borders.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Худалдааны түншүүдийн хооронд улсын хилийг үл харгалзан бараа, үйлчилгээ саадгүй солилцох, нэвтрүүлэх тухай хэлэлцээр.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREE TRADE AREA

Entity formed by the Customs territories of an association of States and having in its ultimate state the following characteristics:
- the elimination of Customs duties in respect of products originating in any of the countries of the area,
- each State retains its Customs tariff and Customs law,
- each State of the area remains autonomous in matters of Customs and economic policy,
- trade is based on the application of rules of origin, to take account of the different Customs tariffs and prevent deflection of trade,
- the elimination of restrictive regulations of commerce within the free trade area.

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БҮС

Улс орнуудын аль нэг нийгэмлэгийн гаалийн нэг нутаг дэвсгэрээс бүрдсэн бөгөөд эцсийн дүнд дараах шинжийг агуулсан тогтоц:
- тухайн бүсийн аль нэг улсын гаралтай (тэндээс ирсэн) бүтээгдэхүүн гаалийн татваргүй байх,
- улс бүр өөрийн гаалийн тариф болон гаалийн хууль тогтоомжоо хэвээр сахин үлдэх,
- тухайн бүсийн улс бүр гаалийн болон эдийн засгийн бодлогын асуудалд бие даасан байр суурьтай хэвээр үлдэх,
- гаалийн өөр өөр тариф мөрдөж байгааг анхааралдаа авч, худалдааг гажуудуулахгүй байх үүднээс худалдаа хийхдээ гарал үүслийн дүрмийг үндэслэх,
- худалдааны чөлөөт бүсийн хүрээнд хийгдэх худалдааг хязгаарласан журам байхгүй байх.

FREE TRADE AREA OF THE AMERICAS (FTAA) [ALCA FTAA]

АМЕРИКИЙН УЛСУУДЫН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР [Brea de Libre Comercio de las Amйricas – ALCA FTAA]

FREEDOM OF TRANSIT

One of the important legal norms of the WTO, contained in the Article V of the GATT 1994. The means that goods and vehicles can travel through the territory of each WTO Member country on the routes which are the most convenient for transit traffic. At the same time, goods and vehicles are exempted from Customs duties and from all transit or other charges established with respect to the transit, with the exception of shipping fees or charges commensurate with administrative costs caused by transit or with the cost of the services provided.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ДАМЖИН ӨНГӨРӨХ ЭРХ ЧӨЛӨӨ

1994 оны ТХЕХ-ийн V зүйлд байдаг, ДХБ-ын эрх зүйн чухал хэм хэмжээнүүдийн нэг. Энэ нь бараа болон тээврийн хэрэгсэл ДХБ-ын Гишүүн орнуудын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд хамгийн таатай маршрутаар явж болох арга юм. Мөн түүний зэрэгцээ, бараа болон тээврийн хэрэгсэл гаалийн татвараас, мөн дамжин өнгөрөхтэй холбогдсон дамжин өнгөрөх буюу бусад бүх төлбөрөөс чөлөөлөгдөх юм. Харин үүнд дамжин өнгөрөх захиргааны зардалтай тэнцэх, эсхүл үзүүлсэн үйлчилгээний зардалтай тэнцэх ачилтын хураамж буюу төлбөр хамаарахгүй.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREE ZONE

A part of the Customs territory of a Contracting Party where any goods introduced are generally regarded, insofar as import duties and taxes concerned, as being outside this territory.

Notes:
1. A distinction may be made between commercial and industrial free zones. In commercial free zones, goods are admitted pending subsequent disposal and pr ocessing or manufacture is normally prohibited. Goods admitted to industrial free zones may be subjected to uthorized processing operations.
2. Free zones are dealt with in Annex F.1. to the Kyoto Convention.
3. In some countries free zones are also known unde r various other names, such as “free ports”, “free warehouses” or “foreign trade zones”.
Specific Annex D, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ЧӨЛӨӨТ БҮС

Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрийн нэг хэсэг. Түүнд оруулсан аливаа барааг импортын гаалийн болон бусад татварын хувьд ерөнхийдөө гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцно.

Жич:
1. Чөлөөт бүсийг худалдааны болон үйлдвэрлэлийн гэж ялгаж болно. Худалдааны чөлөөт бүсэд оруулсан барааг даруй захиран зарцуулах ёстой бөгөөд тэнд боловсруулалт буюу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахыг ерөнхийдөө хориглосон байдаг. Үйлдвэрлэлийн чөлөөт бүсэд оруулсан барааND зөвшөөрөгдсөн хэмжээнд боловсруулалт хийж болно.
2. Чөлөөт бүсийн талаар (1974 оны) Киотогийн конвенцийн хавсралт F.1-д заасан байдаг.
3. Зарим улсад чөлөөт бүсийг бас “чөлөөт боомт”, “чөлөөт агуулах”, эсхүл “гадаад худалдааны бүс” гэдэг.
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт D-гийн 2 дугаар бүлэг.

FREIGHT

The remuneration payable to the carrier for the carriage of goods under a contract of carriage. [Rotterdam Rules]

ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

Тээврийн гэрээний дагуу бараа тээвэрлэсний төлөө тээвэрлэгчид төлөх төлбөр.
[Роттердамын дүрэм]

FREIGHT CHARGE

Costs incurred by the shipper in moving goods, by whatever means, from one place to another under the terms of the contract of carriage. In addition to transport costs, this may include such elements as packing, documentation, loading, unloading, and insurance (to the extent that they relate to the freight cost). [UNTDED]

ТЭЭВРИЙН ТӨЛБӨР

Тээврийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу барааг нэг газраас нөгөөд ямар нэгэн аргаар зөөхөд ачаа бэлтгэгч (ачигч компани)-гээс гарсан зардал. Үүнд тээврийн зардлаас гадна баглаа боодлын жагсаалт, бичиг баримт бүрдүүлэлтийн, ачаа ачих, буулгах, мөн даатгалын зардал (тэдгээр нь тээврийн зардалд хамаарах хэмжээгээр) багтаж болно.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

FREIGHT DECLARATION

See Cargo declaration.

ТЭЭВРИЙН МЭДҮҮЛЭГ

“Ачааны мэдүүлэг”-ийг үз.

FREIGHT FORWARDER

Person or company who arranges for the carriage of goods and associated formalities on behalf of a shipper. The duties of a forwarder include booking space on a ship, providing all the necessary documentation and arranging Customs clearance.

ТЭЭВЭР ЗУУЧ

Барааг тээвэрлэхэд бэлтгэх болон холбогдох ёс журмын ажиллагааг ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн нэрийн өмнөөс гүйцэтгэдэг этгээд буюу компани. Экспедитор (тээвэр зууч)-ын үүрэгт усан онгоцонд ачаа ачих захиалга өгөх, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийлгэх зэрэг ажил багтана.

FREIGHT FORWARDER COMMISSION

Payment in compensation for freight forwarding services.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭР ЗУУЧИЙН КОМИССЫН ХУРААМЖ

Тээвэр зуучийн үйлчилгээ авсаны төлөө төлөх төлбөр.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT FORWARDER’S ADVICE TO EXPORTER

Document issued by a freight forwarder informing an exporter of the action taken in fulfilment of instructions received.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭР ЗУУЧААС БАРАА ЭКСПОРТЛОГЧИД ОЛГОСОН БАРИМТ

Экспортлогчийн зааврын дагуу ажилласан талаар мэдээлж, тээвэр зуучаас үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT FORWARDER'S ADVICE TO IMPORT AGENT

Document issued by a freight forwarder in an exporting country advising his counterpart in an importing country about the forwarding of goods described therein.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭР ЗУУЧААС ИМПОРТЛОГЧИЙН АГЕНТАД ОЛГОСОН БАРИМТ

Түүнд заасан барааг явуулсан тухай импортлогч улсад байгаа нөгөө талдаа мэдэгдэж, экспортлогч улс дахь тээвэр зуучаас үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT FORWARDER'S INVOICE

Invoice issued by a freight forwarder specifying services rendered and costs incurred and claiming payment therefore.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭР ЗУУЧИЙН ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ

Үзүүлсэн үйлчилгээ болон гарсан зардлыг зааж, төлбөр нэхэмжилсэн, тээвэр зуучаас үйлдсэн үнийн нэхэмжлэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT FORWARDING

Arranging for the carriage of goods and associated formalities.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА ЯВУУЛАХ

Ачааг тээвэрлэлтэд бэлтгэх болон холбогдох ёс журмын ажиллагааг гүйцэтгэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT INVOICE

Document issued by a transport operation specifying freight costs and charges incurred for a transport operation and stating conditions of payment.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ

Тээврийн үйл ажиллагаанд зориулж зарцуулсан тээврийн зардал болон төлбөрийг заасан, мөн төлбөр хийх нөхцөлийг заасан, ачаа тээврийн оператороос үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT MANIFEST

Document containing the same information as a cargo manifest, and additional details on freight amounts, charges, etc.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН МАНИФЕСТ

Ачааны манифестын адил мэдээлэл агуулсан, тээврийн төлбөрийн дүн, хөлс зэргийг нэмэлт байдлаар дэлгэрэнгүй оруулсан бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT PAYABLE AT DESTINATION

Method of paying the freight often used for shipment of bulk cargo whose weight is established on discharge from the ship.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХҮЛЭЭН АВАХ ГАЗАР ТӨЛӨГДӨХ ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

Задгай ачааг усан онгоцноос буулгаж, жинг тогтоосны дараа хэрэглэдэг, тээврийн зардал төлөх арга.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FREIGHT RATE

Rate or price per unit of quantity, or percentage, on which freight charges and other charges are calculated.
[UNTDED]

ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Тээврийн зардал болон бусад төлбөрийг тооцох хувь хэмжээ, хэмжих нэгжийн үнэ, хувь.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

FRONTIER CONTROL

A system of control of the admission of goods to a country's national territory. Frontier control includes: Customs, health, veterinary, phytosanitary, and quality control, control of compliance with technical standards, etc.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХИЛИЙН ХЯНАЛТ

Аль нэг улсын нутаг дэвсгэрт бараа оруулахад тавих хяналтын систем. Гаалийн, эрүүл мэндийн, мал эмнэлгийн, ургамлын хорио цээрийн, чанарын хяналт, техникийн стандартын нийцлийн хяналт, г.м.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FRONTIER TRAFFIC

Importations and exportations carried out by frontier zone inhabitants between two adjacent frontier zones.

Notes:

1. Frontier traffic may be subject to special Customs regulations.
2. Customs facilities applicable to frontier traffic are dealt with in Annexes B.8.and D to the Istanbul Convention and in Annex F.3. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex J.1 to the revised Kyoto Convention.

ХИЛИЙН ТЭЭВЭР

Хилийн бүсийн оршин суугч хил залгаа хоёр хилийн бүсийн хооронд бараа тээвэрлэн оруулах болон гаргах.

Жич:

1. Хилийн тээврийг гаалийн тусгай журмаар зохицуулж болно.
2. Хилийн тээвэрт хамаарах гаалийн таатай нөхцлийн талаар Стамбулын конвенцийн хавсралт B.8 болон D-д, 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт F.3, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J.1-д заасан байдаг.

FRONTIER ZONE

An area of the Customs territory adjacent to the land frontier, the extent of which is determined in national legislation and whose limits serve to distinguish frontier traffic from other traffic.

ХИЛИЙН БҮС

Гаалийн нутаг дэвсгэрийн хуурай газрын хил залгаа орших зурвас газар. Түүний хэмжээг дотоодын хууль тогтоомжоор тогтоосон байна. Түүний зааг нь хилийн тээврийг бусад тээврээс ялгах боломж олгоно.

Note:
This term is defined in Annexes B.8 and D to the Istanbul Convention.

Жич:
Энэ нэр томьёог Стамбулын конвенцийн хавсралт B.8-д заасан байдаг.

FRONTIER ZONE INHABITANTS

Persons established or resident in a frontier zone.

Notes:
1. This term is defined in Annexes B.8 and D to the Istanbul Convention.
2. Both natural and legal persons qualify as frontier zone inhabitants.

ХИЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧ

Хилийн бүсэд байгуулагдсан, эсхүл тэнд оршин суудаг этгээд.

Жич:
1. Энэ нэр томьёог Стамбулын конвенцийн хавсралт B.8 болон D-д тодорхойлсон байдаг.
2. Хувь хүн болон хуулийн этгээдийн аль алиныг нь хилийн бүсийн оршин суугчид хамааруулж үзнэ.

FULFILMENT OF THE CONTRACT

Situation where the seller has delivered the goods specified in the contract, and the buyer accepted them, and paid for them.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГЭРЭЭ БИЕЛҮҮЛЭХ

Худалдагч гэрээнд заасан барааг нийлүүлсэн, худалдан авагч түүнийг хүлээн авч, төлбөрийг гүйцэтгэсэн байх нөхцөл байдал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

FUNCTIONAL EQUIVALENCE

Identity of legal treatment provided, under certain conditions, to paper-based documents and electronic communications.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙН АДИЛ ТЭНЦҮҮ БАЙДАЛ

Цаасан бичиг баримт болон цахим мэдээллийг тодорхой нөхцөлд эрх зүйн хувьд адилхан хүлээн зөвшөөрөх
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

G

GATE PASS

Document authorizing goods specified therein to be brought out of a fenced-in port or terminal area.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХААЛГААР ГАРАХ ҮНЭМЛЭХ

Заасан барааг боомтын хашаанаас, эсхүл терминалын бүсээс гаргах зөвшөөрөл бүхий бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GATEWAY

A point at which freight moving from one territory to another is interchanged between transportation lines.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАМЖЛАГЫН ГАЗАР

Нэг нутаг дэвсгэрээс нөгөө рүү тээвэрлэж буй ачааг тээврийн шугамууд хооронд сольж сэлгэх цэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GENERAL AGREEMENT ON TARIFFS AND TRADE (GATT)

An international agreement, signed in 1947, which acted as the basis for an international trade rules-based organization before it was replaced by the WTO. An updated General Agreement is now the WTO agreement governing trade in goods (GATT 1994).
Three GATT articles are taken as the basis for trade facilitation negotiations in the WTO negotiation process: art. V (freedom of transit); art. VIII (fees and formalities); and art. X (publication of all trade rules).

ТАРИФ, ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР (ТХЕХ)

1947 онд гарын үсэг зурсан олон улсын хэлэлцээр (1947 оны ТХЕХ) бөгөөд ДХБ байгуулагдахаас өмнө олон улсын худалдааны дүрэм журамд суурилсан байгууллагын суурь үндэс болж ирсэн. Шинэчилсэн Ерөнхий хэлэлцээр нь одоо барааны худалдааг зохицуулсан ДХБ-ын хэлэлцээр (1994 оны ТХЕХ) юм. ДХБ-ын хэлэлцээний явцад ТХЕХ-ийн дараах гурван зүйлийг худалдааг хөнгөвчлөх хэлэлцээ хийх суурь болгон авч үзсэн байдаг: V зүйл (дамжин өнгөрөх эрх чөлөө); VIII зүйл (хураамж ба ёс журмын ажиллагаа); X зүйл (худалдааны бүх дүрэм журмыг хэвлэн нийтлэх).

GENERAL CARGO; BREAK BULK CARGO

Goods that must be loaded individually, and not in intermodal containers nor in bulk as with oil or grain. Ships that carry this sort of cargo are called general cargo ships.
[FIATA]

ЕРДИЙН АЧАА; ЖИЖИГЛЭН САВЛАСАН ЗАДГАЙ АЧАА

Нефть, үр тариа шиг тээврийн олон төрлийн (холимог тээврийн) зориулалттай чингэлгээр, эсхүл задгайгаар тээвэрлэдэг бус, тус тусад нь ачих ёстой бараа. Ийм бараа тээвэрлэж буй усан онгоцыг ердийн ачаатай усан онгоц гэдэг.
[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

GENERALIZED SYSTEM OF PREFERENCES (GSP)

A system of preferential Customs treatment, in which goods imported into developed countries from developing countries are subject to Customs duties at reduced rates or enjoy duty-free treatment; the general principle of such a system was recommended by the United Nations Conference on Trade and Development in 1968 and embodied in particular in the national preferential schemes in the EU countries, Australia, Belarus, Canada, Japan, New Zealand, Norway, Russia, Switzerland, Turkey and the USA. Such preferences contradict the principle of most-favored-nation treatment, but exist due to the permanent withdrawal from the most-favored-nation treatment on the basis of the Enabling Clause, which is the WTO legal basis for the GSP.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМ

Хөгжиж буй орнуудаас хөгжингүй орнуудад импортлох барааны гаалийн татварын багасгасан хувь хэмжээгээр татвар ногдуулдаг, эсхүл гаалийн татваргүй нэвтрүүлдэг гаалийн хөнгөлөлтийн систем; Энэ системийн ерөнхий зарчмыг 1968 онд хуралдсан НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлаас зөвлөсөн байдаг. Энэ зарчим нь ялангуяа Европын холбооны улсууд, Австри, Беларус, Канад, Япон, Шинэ Зеланд, Норвеги, Орос, Швейцарь, Турк, АНУ-ын үндэсний хөнгөлөлтийн схемд суусан байдаг. Энэ хөнгөлөлт нь нэн тааламжтай нөхцөлийн зарчимтай нийцдэггүй. Гэвч Хөнгөлөлтийн ерөнхий систем нэвтрүүлэх ДХБ-ын эрх зүйн үндэс болох “эрх олгосон заалт”-ын үндсэн дээр нэн тааламжтай нөхцөлөөс бүрмөсөн татгалзах замаар энэхүү хөнгөлөлтийн системийг нэвтрүүлдэг. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GENERIC

Copy of a patented medicine or a medicine whose patent has expired (may also apply to trademarks or brands).

ПАТЕНТГҮЙ ХЭРЭГСЭЛ (НИЙТЭЭР ХЭРЭГЛЭЖ ЗАНШСАН ЭМ)

Патенттай эм, эсхүл патентын хугацаа нь дууссан эмийг хуулбарлах (бас барааны тэмдэг буюу брэнд нэрэнд хамааралтай байж болно)

GENETIC MATERIAL

Any material of plant, animal, microbial or other organ containing functional units of heredity.
Convention on Biological Diversity
(Biodiversity Convention)

ГЕНЕТИКИЙН МАТЕРИАЛ

Ургамал, амьтан, бичил биетний, эсхүл удамшлын функционал нэгжийг агуулсан өөр гарлын материал.
Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

GENETIC RESOURCES

Genetic material of actual or potential value.

Convention on Biological Diversity
(Biodiversity Convention)

ГЕНЕТЕКИЙН НӨӨЦ

Бодит, эсхүл боломжит үнэ цэнэ бүхий генетикийн материал.
Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

GEOGRAPHICAL INDICATION

Names of places (or words related to a location) used to identify a product (for example "Champagne" "Tequila" or "Roquefort") which have a quality, reputation or other specific characteristics because they originate from this location.

ГАЗАРЗҮЙН ЗААЛТ

Тодорхой нэг газар нутгаас гарал үүсэлтэй гэдэг шалтгаанаар чанар, нэр хүнд, эсхүл өөр бусад өвөрмөгц шинж байдал агуулсан бүтээгдэхүнийг ялган танихад ашигладаг газрын нэр (эсхүл тийм газартай холбоотой үгс) (жишээлбэл, "Шампань" "Текила", эсхүл "Рокфор").

GEOGRAPHIC INFORMATION SYSTEM (GIS)

ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

GLOBALLY NETWORKED CUSTOMS (GNC)

Systematic exchange of information between Customs administrations to enhance Border Agencies' ability to deliver regulatory services in a more timely and efficient manner for improved risk assessment and control, enhanced data quality; improving re-use of data already available in import, export or transit declarations and similar data transfers from trade community to Customs.

Note:

This term is defined in line with the coverage of GNC handbook, subject to deleting "of commercial nature.

ДЭЛХИЙ ДАЯАР СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ГААЛЬ

Эрсдэлийн тооцоо болон хяналтыг сайжруулах, мэдээллийн (өгөгдлийн) чанарыг дээшлүүлэх, импортын, экспортын, эсхүл дамжин өнгөрөх мэдүүлэгт нэгэнт тусгагдсан бэлэн мэдээллийг (өгөгдлийг) дахин ашиглах явдлыг, мөн тэдгээртэй адилтгах мэдээллийг (өгөгдлийг) худалдаа эрхлэгч нараас гаалийн байгууллагад илгээх явдлыг боловсронгуй болгох үүднээс хилийн (хяналтын) албадын хянан зохицуулах ажил үйлчилгээг аль болох цаг алдалгүй, илүү үр ашигтай хэлбэрээр хүргэх чадавхыг дээшлүүлэх зорилгоор гаалийн байгууллагууд хоорондоо мэдээлэл байнга солилцох

Жич:

Энэ нэр томьёог "Дэлхий даяар сүлжээнд холбогдсон гааль" хөтөлбөрийн гарын авлагын агуулгаар, "арилжааны шинжтэй хэсгийг хасч томьёолов.

GLOBAL VALUE CHAIN

The global value chain describes the people and activities involved in the production of a good or service and its supply, distribution, and post-sales activities (also known as the supply chain) when activities must be coordinated across geographies. GVC is similar to Industry Level Value Chain but encompasses operations at the global level. Inward and outward processing procedures are a part of the GVC.

ДЭЛХИЙН ҮНИЙН СҮЛЖЭЭ

Дэлхийн үнийн сүлжээ (ДҮС) нь аливаа нэг бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, борлуулалтын дараах үйл ажиллагаа (эдгээрийг бараа нийлүүлэх сүлжээ гэдэг)-г газарзүйн түвшинд зохицуулах шаардлагатай тохиолдолд, тэдгээрт оролцсон хүмүүс болон үйл ажиллагааг тодорхойлдог. ДҮС нь үйлдвэрлэлийн түвшний үнийн сүлжээтэй адил боловч дэлхийн түвшний үйл ажиллагааг хамардаг. Бараг дотоодод болон гадаадад боловсруулах горимууд нь ДҮС-ний нэг хэсэг юм.

GOOD GOVERNANCE

Correct relationship between managers and managed on the basis of lack of corruption, respect and transparency.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

САЙН ЗАСАГЛАЛ

Авилгаас хол, хүндлэл, ил тод байдалд үндэслэсэн, менежерүүд хоорондын зөв харилцаа.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GOODS

The products, wares, merchandise, articles and services which can command a price when sold.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА

Борлогдсон тохиолдолд үнийг удирдаж чадах бүтээгдэхүүн, эд агуурс, бараа, эд зүйл болон үйлчилгээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GOODS CONTROL CERTIFICATE

Document issued by a competent body evidencing the quality of the goods described therein, in accordance with national or international standards, or conforming to legislation in the importing country, or as specified in the contract.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААНЫ ХЯНАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

Түүнд заасан барааны чанар үндэсний, эсхүл олон улсын стандартад тохирсон, эсхүл импортлогч улсын хууль тогтоомжид нийцсэн, эсхүл гэрээнд заасан ёсоор болохыг гэрчлэх бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GOODS DECLARATION

A statement made in the form prescribed by Customs, by which the persons interested indicate the Customs procedure to be applied to the goods and furnish the particulars which the Customs require to be declared for the application of that procedure.

Note:
The persons interested may be the importer, the exporter, the owner, the consignee, the carrier, etc., of the goods or their legal representative, according to the country concerned.

БАРААНЫ МЭДҮҮЛЭГ

Холбогдох этгээд бараг гаалийн аль горимд байршуулахыг зааж, уг горимыг мөрдөхөд гаалийн байгууллагад шаардлагатай мэдээллийг тусгаж, гаалийн байгууллагаас тогтоосон маягтын дагуу үйлдсэн мэдэгдэл.

Жич:
Холбогдох этгээд гэдэг нь тухайн улс орноос хамаарч тухайн барааны импортлогч, экспортлогч, өмчлөгч/эзэмшигч, хүлээн авагч, тээвэрлэгч, г.м. этгээд, эсхүл тэдний хууль ёсны төлөөлөгч байж болно.

GOODS DECLARATION FOR CUSTOMS TRANSIT

Document by which the sender declares goods for Customs transit.

ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГААЛИЙН ГОРИМЫН БАРААНЫ МЭДҮҮЛЭГ

Бараа илгээгч этгээд бараг дамжуулан өнгөрүүлэхээр мэдүүлж буй бичиг баримт.

GOODS DECLARATION FOR EXPORTATION

Document by which goods are declared for export Customs clearance.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЭКСПОРТЛОХ БАРААНЫ МЭДҮҮЛЭГ

Экспортын гаалийн бүрдүүлэлт хийлгэх зорилгоор барааг мэдүүлсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GOODS DECLARATION FOR IMPORTATION

Document by which goods are declared for import Customs clearance.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ИМПОРТЛОХ БАРААНЫ МЭДҮҮЛЭГ

Импортын гаалийн бүрдүүлэлт хийлгэх зорилгоор барааг мэдүүлсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GOODS EXPORTED WITH NOTIFICATION OF INTENDED RETURN

'Goods exported with notification of intended return' means goods specified by the declarant as intended for re-importation, in respect of which identification measures may be taken by the Customs to facilitate re-importation in the same state.

Note:
Specific Annex B, Chapter 2 of the revised Kyoto Convention.

БУЦААН ОРУУЛАХ МЭДЭГДЭЛТЭЙГЭЭР ГАРГАСАН БАРАА

Холбогдох мэдүүлэгч нь түүнийг буцаан оруулах зорилготой болохоо мэдэгдсэн, үүнтэй холбогдуулан түүнийг өөрчлөлт оруулахгүйгээр буцаан оруулах үйл ажиллагааг хөнгөвчлөх үүднээс гаалийн байгууллага ялгаж таних арга хэмжээ авсан байж болох бараа.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт В-гийн 2 дугаар бүлэг.

GOODS IMPORTED IN CONNECTION WITH A COMMERCIAL OPERATION

Containers, pallets, packings, samples, advertising films and any other goods imported in connection with a commercial operation but whose importation does not in itself constitute a commercial operation.

ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ОРУУЛАХ БАРАА

Худалдааны үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан оруулах чингэлэг, ачааны тавиур, сав боодол, загвар, сурталчилгааны кино болон өөр бусад бараа. Эдгээрийг оруулах нь өөрөө худалдааны үйл ажиллагаа биш юм.

GOODS IMPORTED WITH PARTIAL RELIEF

Goods which are mentioned in the other Annexes to the Istanbul Convention but which do not fulfil all the conditions stipulated therein for the granting of temporary admission with total relief from import duties and taxes, and goods which are not mentioned in such other Annexes and which are imported to be temporarily used for, for example, production or work projects. Istanbul convention on temporary admission, Annex E.

ТАТВАРААС ХЭСЭГЧЛЭН ЧӨЛӨӨЛЖ ОРУУЛАХ БАРАА

Стамбулын конвенцийн бусад хавсралтад заасан боловч түр хугацаагаар оруулахад импортын гаалийн болон бусад татвараас бүрэн чөлөөлөх бүх нөхцөлийг хангаагүй бараа, мөн тэрхүү бусад хавсралтад заагаагүй боловч үйлдвэрлэлийн, эсвэл боловсруулалтын явцад түр ашиглах бараа. Түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенц, Хавсралт Е.

GOODS IN FREE CIRCULATION

Goods which may be disposed of without Customs restriction.

Note:
Specific Annex B, Chapters 1 and 2 of the revised Kyoto Convention.

ЧӨЛӨӨТ ЭРГЭЛТЭД БАЙГАА БАРАА

Гаалийн зүгээс тавьсан ямар нэг хязгаарлалтгүйгээр захиран зарцуулах боломжтой бараа.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт В-гийн 1, 2 дугаар бүлэг.

GOODS RECEIPT

Document issued by a port, warehouse/shed, or terminal operator acknowledging receipt of goods specified therein on conditions stated or referred to in the document.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮЛЭЭЖ АВСАН БАРИМТ (ТАСАЛБАР)

Түүнд заасан барааг уг бичиг баримтад заасан буюу тусгагдсан нөхцөлөөр хүлээн авсаныг нотолж боомт, агуулах, саравч, эсхүл терминалын операторын үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

GOODS RECEIPT (CARRIAGE)

Document issued by a carrier or a carrier's agent, acknowledging receipt for carriage of goods specified therein on conditions stated or referred to in the document, enabling the carrier to issue a transport document.
(UN/ECE/FAL)

БАРАА ХҮЛЭЭЖ АВСАН БАРИМТ (ТАСАЛБАР) (ТЭЭВЭР)

Тээвэрлэгчээс, эсхүл тээвэрлэгчийн төлөөлөгчөөс олгосон, барааг түүнд дурдсан буюу заасан нөхцөлөөр тээвэрлэхээр хүлээн авснаа нотолж буй баримт. Тээвэрлэгч энэхүү баримтыг үндэслэн тээврийн баримт үйлдэнэ.
(НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

GROSS WEIGHT

Weight (mass) of all goods including packing but excluding carrier's equipment as declared in a document.

[UNTDED] [UN/CEFACT/CCL]

БОХИР ЖИН

Ямар нэгэн бичиг баримтад заасан, баглаа боодлыг оруулан тооцсон, гэхдээ тээвэрлэгчийн тоног төхөөрөмжийг хассан бүх барааны жин (масс).
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах] [НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан]

GROUPAGE

Transporting a shipment with other goods in the container (see also Less than Container Load, LCL). That means that multiple LCL shipments with different Bills of Lading and different owners can be loaded in a single container.

БҮЛЭГЛЭХ

Ачааг өөр бараатай нийлүүлэн чингэлгээр тээвэрлэх (бас "Дүүрэн биш ачаатай чингэлэг"-ийг үз). Энэ нь тээврийн өөр өөр баримттай, өөр өөр эзэнтэй дүүрэн биш ачаатай чингэлэг дэх ачааг нэг чингэлгээр тээвэрлэж болно.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)	(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)
GUARANTEE	**БАТАЛГАА**
Undertaking by which the surety assumes obligations towards the Customs (an undertaking which ensures to the satisfaction of the Customs that obligations towards the Customs will be fulfilled).	Батлан даагчийн гаалийн байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалт (Гаалийн байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхээр гаалийн байгууллагын шаардлага хангасан хэлбэрээр гаргасан үүрэг амлалт).
“Individual guarantee” means a Customs guarantee furnished for only one transit transaction in a predefined Customs territory/ territories*.	“Нэг удаагийн баталгаа” гэж урьдчилан тогтсон гаалийн нэг буюу хэд хэдэн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зөвхөн нэг удаагийн үйлдэлд зориулан олгосон гаалийн баталгааг хэлнэ (Зөвхөн энэхүү зааврын зорилгоор тодорхойлсон);
“Comprehensive guarantee” means a Customs guarantee covering a number of transit transactions through a predefined Customs territory/territories*.	“Олон удаагийн баталгаа” урьдчилан тогтсон гаалийн нэг буюу хэд хэдэн нутаг дэвсгэрээр хэд хэдэн удаа дамжин өнгөрөх үйлдэлд зориулан олгосон гаалийн баталгааг хэлнэ (Зөвхөн энэхүү зааврын зорилгоор тодорхойлсон);
“National guarantee” means a Customs guarantee legally applicable only within one country according to national legislation of that country*.	“Үндэсний баталгаа” гэж эрх зүйн хувьд зөвхөн нэг улсад тухайн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу хэрэглэх гаалийн баталгааг хэлнэ (Зөвхөн энэхүү зааврын зорилгоор тодорхойлсон);
“Regional guarantee” means a Customs guarantee legally applicable within the Customs territory of several countries, that is legally binding pursuant to any regional agreement between the respective countries*.	“Бүс нутгийн баталгаа” гэж эрх зүйн хувьд хэд хэдэн улсын гаалийн нутаг дэвсгэрт хэрэглэх, холбогдох улсуудын хооронд байгуулсан бүс нутгийн аливаа нэг хэлэлцээрийн дагуу заавал шаардах гаалийн баталгааг хэлнэ (Зөвхөн энэхүү зааврын зорилгоор тодорхойлсон);
“International guarantee” means a Customs guarantee legally applicable in several Customs territories that is legally binding pursuant to international agreements or conventions*.	“Олон улсын баталгаа” гэж эрх зүйн хувьд хэд хэдэн гаалийн нутаг дэвсгэрт хэрэглэх, олон улсын хэлэлцээр буюу конвенцийн дагуу заавал шаардах гаалийн баталгааг хэлнэ (Зөвхөн энэхүү зааврын зорилгоор тодорхойлсон).
“Guarantee waiver” means conditional revocation of the requirement to furnish a Customs transit guarantee for economic operators meeting specific requirements or for specific types of transport*.	“Баталгаа шаардахгүй байх” гэж тодорхой шаардлага хангасан аж ахуйн нэгжээс, эсхүл тодорхой төрлийн дамжин өнгөрөх ажиллагааны хувьд дамжин өнгөрөх гаалийн горимын баталгаа түр шаардахгүй байхыг хэлнэ (Зөвхөн энэхүү зааврын зорилгоор тодорхойлсон).

"Guarantor" means a natural or legal person who guarantees to pay the Customs debt of the economic operator in the event he or she fails to fulfil his/her obligations to Customs*.

"Баталгаа гаргагч" гэж холбогдох аж ахуйн нэгж (эдийн засгийн оператор) гаалийн байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд түүний гаалийн өрийг төлөхөөр баталгаа гаргасан аль нэг хувь хүн буюу хуулийн этгээдийг хэлнэ (Зөвхөн энэхүү зааврын зорилгоор тодорхойлсон).

GUARANTEEING ASSOCIATION

An association which is approved by the Customs of a Contracting Party to an international agreement to guarantee the payment of any sums legally due, under the terms of this agreement, to the Customs of that Contracting Party, and which is affiliated to a guaranteeing chain.

Notes:

1. Guaranteeing associations are established under international agreements destined to facilitate temporary admission or international transit of goods, for example the ATA, Istanbul and TIR Conventions.
2. There is a link between the terms 'guaranteeing chain', 'guaranteeing association' and 'issuing association'.

БАТАЛГАА ГАРГАГЧ ХОЛБОО

Аль нэг олон улсын хэлэлцээрийн Хэлэлцэн тохирогч аль нэг Талын гаалийн байгууллагад хууль ёсны дагуу төлбөл зохих аливаа мөнгөн дүнг уг хэлэлцээрийн нөхцлийн дагуу төлөх баталгаа гаргахыг Хэлэлцэн тохирогч тухайн Талын гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн бөгөөд баталгаа гаргагч аль нэг сүлжээнд харъяалагдах холбоо.

Жич:

1. Баталгаа гаргагч холбоод нь барааг түр хугацаагаар оруулах, эсхүл улс хооронд дамжуулан өнгөрүүлэх явдлыг хөнгөвчлөхөд чиглэсэн АТА карнейн тухай конвенц, Стамбулын конвенц, ТИР конвенц гэх зэрэг олон улсын хэлэлцээрийн дагуу байгууллагддаг.
2. "Баталгаа гаргагч сүлжээ", "баталгаа гаргагч холбоо" болон "карней олгогч холбоо" хэмээх нэр томьёонууд хоорондоо холбоотой болно.

GUARANTEEING CHAIN

A guaranteeing scheme administered by an international organization to which guaranteeing associations are affiliated.

Notes:

1. Guaranteeing chains are usually established under international agreements destined to facilitate temporary admission or international transit of goods, for example the ATA, Istanbul and TIR Conventions.
2. There is a link between the terms 'guaranteeing chain',
'guaranteeing association' and 'issuing association'.

БАТАЛГАА ГАРГАГЧ СҮЛЖЭЭ

Баталгаа гаргагч холбоог харьяалах олон улсын байгууллагаас тогтоосон баталгаа гаргагч сүлжээ.

Жич:

1. Баталгаа гаргагч холбоод нь барааг түр хугацаагаар оруулах, эсхүл улс хооронд дамжуулан өнгөрүүлэх явдлыг хөнгөвчлөхөд чиглэсэн АТА карнейн тухай конвенц, Стамбулын конвенц, ТИР конвенц гэх зэрэг олон улсын хэлэлцээрийн дагуу байгууллагддаг.
2. "Баталгаа гаргагч сүлжээ", "баталгаа гаргагч холбоо" болон "карней олгогч холбоо" хэмээх нэр томьёонууд хоорондоо холбоотой болно.

HABITAT

The place or type of site where an organism or population naturally occurs.

Convention on Biological Diversity (Biodiversity Convention)

АМЬДРАХ НУТАГ ОРОН

Аливаа организм, бүлгэмдлийн амьдардаг байгалиас заяасан газар юмуу нутаг орны төрөл.

Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

H

HANDLING INSTRUCTIONS

Free form description of a set of handling instructions. For example, how specified goods, packages or transport equipment (container) should be handled.
[UNTDED]

БАРААТАЙ ХАРЬЦАХ (АРЧЛАН ХАМГААЛАХ) ЗААВАР

Бараатай харьцах (арчлан хамгаалах) чөлөөт хэлбэрийн бичиглэлтэй цогц заавар. Жишээлбэл, заасан бараа, сав боодол, тээврийн тоног төхөөрөмж (чингэлэг)-тэй хэрхэн хэрхэн харьцах ёстойг заасан заавар.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

HANDLING ORDER

Document issued by a cargo handling organization (port administration, terminal operator, etc.) for the removal or other handling of goods under their care.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААТАЙ ХАРЬЦАХ (АРЧЛАН ХАМГААЛАХ) ОРДЕР

Бараатай харьцах (арчлан хамгаалах) байгууллага (боомтын захиргаа, терминалын оператор, г.м.)-ын үйлдсэн, түүний хяналтын дор барааг зөөх (нүүлгэх), эсхүл өөр бусдаар харьцах (арчлан хамгаалах) бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

HARBOUR DUES

Fees levied from ships on entry into port, port processing, and departure from port.
[FIATA]

БООМТЫН ХУРААМЖ

Усан онгоц боомт руу орох, боомтод боловсруулалт хийх, боомтоос гарах үед ногдуулах хураамж.
[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

HARMONIZATION

(1) Changing government regulations and practices, as a result of an international agreement, in order to make those of different countries the same or more compatible.

(2) “Data harmonization” means collecting, analysing and making similar data requirements in trade and transport documents/ forms, as well as mapping and aligning them to international standards, code lists and the Core Component Library, in order to build Single Window systems or electronic document exchange.

УЯЛДУУЛАХ

(1) олон улсын хэлэлцээрийн үр дүнд, янз бүрийн улсын дүрэм журам, практикийг нэг мөр, эсхүл илүү нийцтэй болгох зорилгоор дотоодын дүрэм журам, практикийг өөрчлөх

(2) “Мэдээллийг уялдуулах” гэдэг нь Нэг цонхны систем нэвтрүүлэх, эсхүл цахим бичиг баримт солилцох зорилгоор худалдааны болон тээврийн бичиг баримт/маягт дээрх мэдээллийн шаардлагыг цуглуулах, дүн шинжилгээ хийх, ижил болгох, мөн түүнчлэн олон улсын стандарт, кодын жагсаалтууд болон Үндсэн бүрдэл хэсгийн сантай маппинг (зэрэгцүүлэлт) хийж, ижилсүүлэх явдал болно.

(3) Harmonization of national standards is the prevention or elimination of differences in the technical content of standards having the same scope, particularly those differences that may cause hindrances to trade.

(3) Үндэсний стандартыг уялдуулах гэж нэг хүрээний техникийн стандарт агуулгын ялгаатай байхаас сэргийлэх, эсхүл тэдгээрийн агуулгын ялгааг, ялангуяа худалдаанд саад учруулж болзошгүй ялгааг арилгахыг хэлнэ.

(4) In the case of tariffs, this means making tariff rates more similar across industries and/or across countries.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

(4) тарифын хувьд, энэ нь тарифын хувь хэмжээг салбаруудын хэмжээнд болон/эсхүл улс орнууд даяар илүү ижил (ойролцоо) болгох.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

HARMONIZED CODE

An internationally accepted and uniform description system for classifying goods for Customs, statistical and other purposes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УЯЛДУУЛСАН КОД

Гаалийн, статистикийн болон өөр бусад зорилгоор барааг ангилах зорилготой, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, мөн нэгдсэн байдлаар тодорхойлох систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

HARMONIZED SYSTEM (HS)

An international nomenclature for the description, classification, and coding of commodities, established and developed/administered by the WCO. The system covers all the goods that are traded and is arranged in six-digit codes. Beyond the six-digit level, Members are free to introduce national distinctions for tariffs and many other purposes. The Members of the WTO use it to identify the products in their concessions, and also for tariff negotiations.

УЯЛДУУЛСАН СИСТЕМ

Барааг тодорхойлох, ангилах, кодлох зорилгоор ДГБ-аас бий болгож, боловсруулж, хяналт тавин хэрэгжүүлж буй олон улсын ангиллын жагсаалт. Энэхүү систем нь худалдааны бүх барааг хамардаг бөгөөд зургаан оронтой кодоос бүрдэнэ. Зургаан оронгоос цааш гишүүн орнууд тарифын болон өөр бусад олон зорилгоор үндэсний задаргаа хийх боломжтой. ДХБ-ын гишүүн улсууд үүнийг тарифын хөнгөлөлт (концесс) үзүүлэх бараагаа тодорхойлох, мөн тарифын хэлэлцээ хийх зорилгоор ашигладаг.

HARMONIZED SYSTEM CONVENTION (HS)

The expression commonly used to refer to the international Convention of the Harmonized Commodity Description and Coding System, adopted by the Customs Co-operation Council in 1988.

УЯЛДУУЛСАН СИСТЕМИЙН КОНВЕНЦ

Энэ нэр томьёо нь Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 1983 онд баталж, 1988 онд хүчин төгөлдөр болсон Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенцийн түгээмэл нэр.

HAULAGE

Transportation; delivery.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА ЗӨӨХ

Ачаа тээвэрлэх; хүргэх
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

HAULIER
Party providing the transport of goods between named points. [UNTDED]

АЧАА ЗӨӨГЧ
Барааг заасан цэгүүдийн хооронд тээвэрлэдэг тал. [НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

HOLDER OF A NEGOTIABLE TRANSPORT DOCUMENT

(a) A person that is in possession of a negotiable transport document; and

(i) if the document is an order document, is identified in it as the shipper or the consignee, or is the person to which the document is duly endorsed; or

(ii) if the document is a blank endorsed order document or bearer document, is the bearer thereof; or

(b) The person to which a negotiable electronic transport record has been issued or transferred in accordance with the procedures. [Rotterdam Rules]

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БОЛОХ ТЭЭВРИЙН БАРИМТЫН ЭЗЭМШИГЧ

(a) Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн баримтыг эзэмшиж буй этгээд; мөн

(i) хэрэв уг баримт нь ордерын баримт бол уг этгээдийг түүнд ачаа бэлтгэгч (ачигч компани), эсхүл хүлээн авагч, эсхүл уг баримтад нэр зааж зохих ёсоор баталгаажуулсан эзэмшигч этгээд гэж бичсэн байдаг; эсхүл

(ii) хэрэв уг баримт нь тодорхой нэр заалгүй баталгаажуулсан хоосон ордерын баримт буюу нэхэмжлэгчийн (гарган үзүүлэгчийн) баримт бол түүнийг эзэмшигч; эсхүл

(b) Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн цахим бүртгэлийг холбогдох журмын дагуу нэр дээр нь үйлдсэн, эсхүл шилжүүлсэн этгээд. [Ротердамын дүрэм]

HOMOLOGATION
The certification of a product or specification to indicate that it meets regulatory standards.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГЭРЧИЛГЭЭ
Аливаа нэг бүтээгдэхүүн хэм хэмжээ тогтоосон стандартын шаардлага хангасан болохыг заасан гэрчилгээ буюу тодорхойлолт
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

HOUSE AIR WAYBILL (HAWB)

(see Air Waybill)
A transport document, which is used in air shipments, issued and signed by a freight forwarder, generally on a natural air waybill format, evidences the terms and conditions of the carriage of goods as specified by the freight forwarder.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АГААРЫН ТЭЭВРИЙН ХАВСРАЛТ БАРИМТ
(Агаарын тээврийн баримтыг үз)
Агаарын ачаанд ашигладаг, тээвэр зуучаас олгож, баталгаажуулсан (гарын үсэг зурсан), ерөнхийдөө агаарын тээврийн баримтын жинхэнэ маягт дээр үйлддэг тээврийн баримт. Энэ нь тухайн тээвэр зуучаас тогтоосон бараа тээвэрлэх болзол, нөхцлийг гэрчилдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

I

ICC RULES FOR THE USE OF DOMESTIC AND INTERNATIONAL TRADE TERMS (INCOTERMS)

(see also INCOTERMS 2020) [ICC/INCOTERMS]

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМЫН ДОТООДЫН БОЛОН ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛҮҮД (ИНКОТЕРМС)

(бас ИНКОТЕРМС 2020-ыг үз) [ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

Name of a specific means of transport such as the vessel name.
[UNTDED]

Усан онгоцны нэр зэрэг тодорхой нэг тээврийн хэрэгслийн нэр.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

IMPORT COST

Cost indicated in prices in invoices issued by foreign supplier, plus the cost of delivering goods to the border and other overhead costs.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ИМПОРТЫН ЗАРДАЛ

Гадаадын нийлүүлэгчээс үйлдсэн үнийн нэхэмжлэх дэх үнээр заасан зардал, мөн барааг хил хүргэх зардал, өөр бусад нэмэгдэл зардал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

IMPORT DEPOSIT

Interest-free deposit that the importer is required to deposit in convertible currency before purchasing goods abroad. The import deposit is established depending on the rates of the import duty and other parameters of the goods. Import deposit stands for restriction of imports.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ИМПОРТЫН ДЕПОЗИТ

Импортлогч гадаадаас бараа худалдан авахаас өмнө чөлөөтэй хөрвөдөг валют барьцаанд тавихыг шаарддаг хүүгүй депозит. Импортын депозитын хэмжээг импортын гаалийн татварын хувь хэмжээ болон тухайн барааны бусад үзүүлэлтийг харгалзан тогтоодог. Импортын депозит нь импортыг хязгаарлах хэрэгсэл болдог.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

IMPORT DUTIES AND TAXES

Customs duties and all other duties, taxes or charges which are collected on or in connection with the importation of goods, but not including any charges which are limited in amount to the approximate cost of services rendered or collected by the Customs on behalf of another national authority.

ИМПОРТЫН ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР

Барааг импортлох үед, эсхүл импортлохтой холбогдуулан хураан авах гаалийн болон бусад бүх татвар, төлбөр. Гэвч үүнд гаалийн байгууллагын үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй ойролцоо хэмжээгээр хязгаарлагдах, эсхүл гаалийн байгууллага болон дотоодын бусад байгууллагын нэрийн өмнөөс хураасан аливаа төлбөр хамаарахгүй.

Note: General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

Жич: Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

IMPORT LICENSE

Official document that authorizes an economic agent to import goods. It may establish the quantity authorized and the country of origin of the goods to be imported. It is used as an instrument for regulating and supervising the flow of imports.

ИМПОРТЫН ЛИЦЕНЗ

Аж ахуйн нэгжид бараа бүтээгдэхүүн импортлох эрх олгосон албан ёсны бичиг баримт. Үүнд нь импортын барааны тоо хэмжээ, тухайн барааны гарал үүслийн улсыг зааж өгсөн байж болно. Үүнийг импортын урсгалыг зохицуулах, хянах хэрэгсэл болгон ашигладаг.

IMPORT/EXPORT LICENCE (OR IMPORT/ EXPORT PERMIT)

Authorization issued by a competent authority for the importation or exportation of goods subject to restriction.

ИМПОРТ/ЭКСПОРТЫН ЛИЦЕНЗ (ИМПОРТ/ЭКСПОРТЫН ЗӨВШӨӨРӨЛ)

Хязгаарласан барааг импортлох, эсхүл экспортлох зорилгоор эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл.

IMPORT LICENSING

The need to obtain a permit for importing a product; administrative procedures for obtaining an import licence.

ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ

Бүтээгдэхүүн импортлох зорилгоор зөвшөөрөл авах шаардлага; импортын лиценз авах захиргааны журам.

IMPORT PENETRATION

Increase in the share of imports in domestic consumption.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ИМПОРТЫН БАРАА ХҮЧ ТҮРЭН ОРЖ ИРЭХ

Дотоодын хэрэглээнд импортын барааны эзлэх хувь нэмэгдэх
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

IMPORT REGULATION

A set of tariff and non-tariff measures aimed at streamlining the importation of goods and services in the interests of the national economy.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ИМПОРТЫН ЗОХИЦУУЛАЛТ

Үндэсний эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс бараа, үйлчилгээний импортыг цэгцтэй болгох зорилготой тарифын болон тарифын бус цогц арга хэмжээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

IMPORTATION

The act of bringing or causing any goods to be brought into a Customs territory.

ИМПОРТЛОХ (ОРУУЛАХ)

Аливаа барааг гаалийн нутаг дэвсгэрт авч ирэх, эсхүл авч ирэх нөхцлийг бүрдүүлэх үйлдэл.

IMPORT RESTRICTIONS

Tariff and not-tariff measures that a country imposes to limit the entry (importation) of foreign goods.

ИМПОРТЫН ХЯЗГААРЛАЛТ

Гадаадын бараа оруулах (импортлох)-ыг хязгаарлах зорилготой тарифын болон тарифын бус арга хэмжээ.

IN-BOND CARGO

Cargo moving under Customs control where duty has not yet been paid.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАТАЛГААТ БҮСЭД БАЙГАА БАЙГАА АЧАА

Гаалийн татвар төлөөгүй, гаалийн хяналтын дор хөдөлгөж байгаа ачаа.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INCOTERMS

The Incoterms or International Commercial Terms are a series of pre-defined commercial terms published by the International Chamber of Commerce (ICC) relating to international commercial law. The Incoterms rules are accepted by governments, legal authorities, and practitioners worldwide for the interpretation of most commonly used terms in international trade. They are intended to reduce or remove altogether uncertainties arising from different interpretation of the rules in different countries. As such they are regularly incorporated into sales contracts worldwide.
The first work published by the ICC on international trade terms was issued in 1923, with the first edition known as Incoterms published in 1936. the Incoterms rules were amended in 1953, 1967, 1976, 1980, 1990, and 2000, with the eighth version— Incoterms 2010 — having been published on January 1, 2011 which contains a set of 11 international standard trade terms (also known as delivery terms) used in international trade contracts.

ИНКОТЕРМС

Инкотермс буюу олон улсын худалдааны нөхцөл нь Олон улсын худалдааны танхимаас (ICC) хэвлэн нийтэлсэн бөгөөд олон улсын худалдааны эрх зүйн холбогдолтой, худалдааны урьдчилан тодорхойлсон цуврал нөхцөлүүд юм. Инкотермсийн дүрмүүдийг (нөхцөлүүдийг) олон улсын худалдаанд хамгийн их хэрэглэдэг нэр томьёонуудыг тайлбарлах зорилгоор засгийн газар, хуулийн байгууллага, хуулийн ажилтнууд дэлхий даяар ашигладаг. Эдгээр дүрэм нь тэдгээрийг янз бүрийн улсад янз бүрээр тайлбарладгаас үүсэх тодорхойгүй байдлыг бүхэлд нь багасгах буюу арилгах зорилготой. Ийм учраас эдгээр нэр томьёог дэлхий даяар бараа худалдах, худалдан авах гэрээнд байнга тусгаж өгдөг.
Олон улсын худалдааны танхимаас олон улсын худалдааны нэр томьёог анх 1923 онд гаргаж, 1936 онд Инкотермс нэртэй анхны хэвлэл нийтлэгдсэн байдаг. Инкотермсийн дүрэмд 1953, 1967, 1976, 1980, 1990 2000 онуудад нэмэлт өөрчлөлт оруулж байсан. Инкотермс 2010 нь найм дахь хувилбар бөгөөд 2011 оны 1-р сарын 1-нд нийтлэгдсэн. Энэ хувилбарт олон улсын худалдааны гэрээнд ашигладаг олон улсын худалдааны 11 стандарт нөхцөл (бас бараа хүргэх нөхцөл гэж нэрлэдэг) нэг цогц болон багтсан байдаг. Одоо Инкотермс 2020 буюу 9 дэх хувилбар гарсан байгаа. Инкотермс 2020-ыг үз.

INCOTERMS 2020; INTERNATIONAL COMMERCIAL TERMS 2020

(ICC rules for the use of domestic and international trade terms) A set of 11 international standard trade terms (also known as delivery terms) used in sales contracts, created and maintained by the International Chamber of Commerce. The Incoterms® rules explain a set of three-letter trade terms reflecting business-to-business practice in contracts for the sale of goods. The Incoterms rules describe mainly the tasks, costs and risks involved in the delivery of goods from sellers to buyers.
[ICC/INCOTERMS 2020]

ИНКОТЕРМС 2020; ОЛОН УЛСЫН ХУДАЛДАААНЫ НӨХЦӨЛ 2020

(Дотоодын болон олон улсын худалдааны нөхцөлүүдийг ашиглах Олон улсын худалдааны танхимын дүрэм) Бараа худалдах, худалдан авах гэрээнд ашигладаг, Олон улсын худалдааны танхимаас боловмруулж, боловсронгуй болгодог олон улсын худалдааны нэг цогц 11 стандарт нөхцөл (бас бараа хүргэх нөхцөл гэж нэрлэдэг). Энэхүү Incoterms® дүрэм нь компани хоорондын практикийг бараа худалдах, худалдан авах гэрээнд тусгаж буй гурван үсэг бүхий худалдааны нөхцөлүүдийг тайлбарлаж өгдөг. Энэхүү Инкотермсийн дүрэм нь үндсэндээ барааг худалдагчаас худалдан авагчид хүргэхэд гардаг үүрэг, зардал, эрсдэлийг тайлбарлаж өгдөг.
[ОУХТ/ИНКОТЕРМС 2020]

INDIRECT EXPORT

A situation in which a company sells its products to customers in another country using an intermediary.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ШУУД БУС ЭКСПОРТ

Ямар нэг компани өөрийн бүтээгдэхүүнийг ямар нэг завсрын этгээд ашиглан өөр нэг улсад байгаа үйлчлүүлэгчид худалдах нөхцөл байдал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INDIRECT IMPORT

A situation in which a company buys products from someone in another country using an intermediary.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ШУУД БУС ИМПОРТ

Ямар нэг компани ямар нэг завсрын этгээд ашиглан өөр нэг улсад байгаа хэн нэгнээс бүтээгдэхүүн худалдан авах нөхцөл байдал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INFORMATION AND COMMUNICATION TECHNOLOGY (ICT)
INFORMATION REPOSITORY

An information repository is a collection of interrelated information maintained across a network on multiple servers. It creates a unified resource for anyone connected with the system to access when they need information.

МЭДЭЭЛЭЛ, (ХАРИЛЦАА) ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ
МЭДЭЭЛЭЛ ХАДГАЛАХ ГАЗАР

Мэдээлэл хадгалах газар нь олон сервер дээр сүлжээнд хадгалагдаж буй харилцан хамааралтай мэдээллийн цуглуулга юм. Энэ нь системтэй холбогдсон бүх хүмүүст мэдээлэл шаардлагатай үед хандах нэгдсэн эх үүсвэрийг бий болгодог.

Numerous organizations use information repositories to handle their data and may network with others to share material as necessary. The underlying information technology may need to be very robust to handle the volume of information and requests. This term can also be used to refer to a specific kind of data management.
https://www.wisegeek.com/what-is-an-information-repository.htm

Олон тооны байгууллага мэдээллийн санг ашиглахдаа мэдээлэл хадгалах газрыг ашигладаг бөгөөд шаардлагатай бол материалыг бусадтай хуваалцах боломжтой. Мэдээллийн технологи нь олон тооны мэдээлэл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхийн тулд маш эрүүл чийрэг байх ёстой байж магадгүй юм. Энэ нэр томьёог бас ямар нэг тусгай төрлийн мэдээллийн менежментэд хэрэглэж болох юм.
https://www.wisegeek.com/what-is-an-information-repository.htm

INFORMATION SYSTEM

A system for generating, sending, receiving, storing or otherwise processing data messages. [UNCITRAL Electronic Communications Convention]

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Мэдээлэл бүхий мессеж бичих, илгээх, хүлээн авах, хадгалах, эсхүл боловсруулах систем.
[НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим мэдээллийн (цахим харилцааны) тухай конвенц]

INLAND CARRIER

A transportation company that hauls export or import traffic between ports and inland points (TRACECA).

ДОТООДЫН (ГҮНИЙ) ТЭЭВЭРЛЭГЧ

(Хилийн) боомт болон дотоодын (гүний) цэгүүд хооронд экспортын буюу импортын бараа зөөдөг тээврийн компани (TRACECA)
.

INLAND CLEARANCE DEPOT (ICD)

A common user facility, other than a port or an airport, approved by a competent body, equipped with fixed installations and offering services for handling and temporary storage of any kind of goods (including containers) carried under Customs transit by any applicable mode of transport, placed under Customs control and with Customs and other agencies competent to clear goods for home use, warehousing, temporary admission, re-export, temporary storage for onward transit and outright export. The definition applies also to synonyms like Dry Port, Inland Clearance Terminal, etc.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ГҮНИЙ БҮРДҮҮЛЭЛТИЙН ДЕПО

Эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн, усан боомт, нисэх онгоцны буудлаас өөр нийтэд зориулагдсан байгууламж. Энд суурин тоног төхөөрөмжүүд байх бөгөөд тээврийн аль тохиромжтой төрлөөр дамжуулан өнгөрүүлж буй бараа (үүнд чингэлэг хамаарна)-г гаалийн хяналтын дор арчлан хамгаалах, түр хугацаагаар хадгалах үйлчилгээ үзүүлдэг. Энд гаалийн байгууллага, бусад хяналтын албад ажиллах бөгөөд бараг дотоодын хэрэглээнд зориулан оруулах, гаалийн агуулахад оруулах, түр хугацаагаар оруулах, буцаан гаргах, дамжуулан өнгөрүүлэх бараг түр хугацаагаар хадгалах, мөн бүрмөсөн гаргах бүрдүүлэлтийг хийнэ. Гүний бүрдүүлэлтийн депо гэдэг нэр томьёо нь бас хуурай боомт, гүний бүрдүүлэлтийн терминал гэх мэт ойлголттой ижил утгатай болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INLAND FREIGHT TERMINAL

Any facility, other than a port or an airport, operated on a common-user basis, at which cargo in trade is received or dispatched.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ГҮНИЙ ТЭЭВРИЙН ТЕРМИНАЛ

Усан боомт, нисэх онгоцны буудлаас өөр нийтэд зориулагдсан байгууламж. Энд худалдааны ачааг хүлээн авч, эсхүл илгээдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INLAND NAVIGATION

Movement of goods using inland waterway transport vessels which is undertaken wholly of partly on navigable inland waterways.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ГҮНИЙ УСАН ЗАМ

Дотоодын усаар тээвэр хийдэг усан онгоц ашиглан бараа тээвэрлэх. Усан онгоц явж болох дотоодын усан замыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн ашиглана.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

IN-QUOTA TARIFF

An in-quota tariff is the tariff applied on imports within a tariff-rate quota.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

КВОТЫН ХЭМЖЭЭНД ТОГТООСОН ТАРИФ

Квотын хэмжээнд тогтоосон тариф гэж импортын барааND тарифын хувь хэмжээний квотод багтаан ногдуулсан тариф.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INSPECTION CERTIFICATE; INSPECTION REPORT; CERTIFICATE OF INSPECTION

Document issued by a competent body evidencing that the goods described therein have been inspected in accordance with national or international standards, in conformity with legislation in the country in which the inspection is required, or as specified in the contract.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙСЭН ГЭРЧИЛГЭЭ (ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН МЭДЭЭ)

Түүнд заасан барааND үндэсний, эсхүл олон улсын стандартын дагуу, тийм гэрчилгээ авахыг шаардаг улсын хууль тогтоомжид нийцүүлэн, эсхүл гэрээнд заасны дагуу үзлэг шалгалт хийсэн болохыг гэрчилж, эрх бүхий байгууллагаас үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INSTRUCTIONS FOR BANKING TRANSFER

Document containing instructions from a customer to his bank to pay an amount in a specified currency to a nominated party in another country by a method either specified (e.g. tele transmission, air mail) or left to the discretion of the bank.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАНКНЫ ГУЙВУУЛГА ХИЙХ ЗААВАР

Харилцагчийн заасан хэмжээний валютыг өөр улсад байгаа (харилцагчийн) санал болгосон талд (харилцагчийн) заасан арга (жишээлбэл, теле шилжүүлгэ, агаарын шуудан)-аар, эсхүл банкны үзэмжээр төлөх тухай харилцагчаас өөрийн банканд өгсөн заавар бүхий бичиг баримт.
Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INSURANCE CERTIFICATE

Document issued to the insured certifying that the insurance is in effect and that a policy has been issued. Such a certificate for a particular cargo is primarily used when goods are insured under the terms of a floating or an open policy; at the request of the insured it can be exchanged for a policy.
(UN/ECE/FAL)

ДААТГАЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Даатгал хүчин төгөлдөр бөгөөд даатгалын гэрээ үйлдсэн болохыг гэрчилж даатгуулагчид олгосон баримт. Ийм гэрчилгээг тодорхой ачааны хувьд, барааг хөвөх (ерөнхий) буюу нээлттэй (валютжуулаагүй) даатгалын гэрээний нөхцөлийн дагуу даатгуулсан тохиолдолд голчлон ашигладаг; даатгуулагчийн хүсэлтээр үүнийг даатгалын гэрээгээр сольж болдог.
(НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

INSURANCE POLICY

Document issued by the insurer evidencing an agreement to insure and containing the conditions of the agreement concluded whereby the insurer undertakes for a specific fee to indemnify the insured for the losses arising out of the perils and accidents specified in the contract.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ДААТГАЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Даатгагчаас үйлдсэн, даатгагч тодорхой хэмжээний хураамж авч, даатгалын гэрээнд заасан аюул, ослоос үүдэлтэй хохирлыг даатгуулагчид нөхөн төлөхөөр байгуулсан нөхцөл бүхий даатгалын гэрээ болох бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INSURED; (THE) INSURANT; POLICYHOLDER

(see also named insured)
Someone who takes out an insurance policy and pays premiums, but not necessarily the person covered by the policy.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ДААТГУУЛАГЧ

(“Нэр заасан даатгуулагч”-ийг үз)
Даатгалын гэрээ байгуулсан бөгөөд даатгалын хураамж төлж буй этгээд, гэхдээ энэ нь уг даатгалын гэрээнд заасан этгээд байх албагүй.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INSURER’S INVOICE

Document issued by an insurer specifying the cost of an insurance which has been affected and claiming payment therefore.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ДААТГАГЧИЙН ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ

Даатгалын төлбөрийг зааж, төлбөр нэхэмжилсэн, даатгагчаас үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTEGRATED BORDER MANAGEMENT (IBM)

(see coordinated border management)

ХИЛИЙН ЦОГЦ МЕНЕЖМЕНТ

(“Хилийн зохицуулалттай менежмент”-ийг үз)

INTEGRITY

The WCO has been active in promoting integrity in Customs since 1993 with the publication of the Arusha Declaration. Since then, the WCO has developed a series of tools to assist its Members to enhance integrity and fight corruption. The Revised Arusha Declaration contains 10 key elements that should be part of any Customs Integrity Strategy.

АРИУН ШУДАРГА ЁС

ДГБ 1993 онд Арушагийн тунхаглалыг хэвлэн нийтэлж, гаалийн байгууллагад ариун шударга ёсыг бэхжүүлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Түүнээс хойш ДГБ ариун шударга ёсыг бэхжүүлэх, авлигатай тэмцэхэд гишүүн байгууллагууддаа туслах зорилгоор олон бичиг баримт боловсруулсан байгаа. Шинэчлэн найруулсан Арушагийн тунхаглал нь гаалийн байгууллагад ариун шударга ёсыг бэхжүүлэх стратегийн бодлогын хэсэг нь болох ёстой 10 үндсэн элементийг агуулдаг.

INTELLECTUAL PROPERTY RIGHTS

The following rights:

1. copyright and related rights;

2. trademarks: any sign, including words, names, letters, numerals, figurative elements and combinations of colours, or combinations of these used by a manufacturer or merchant to identify its goods and distinguish them from those manufactured or sold by others;

3. geographical indications, which identify a good as originating in the territory of a State, or a region or locality in that territory, where a given quality, reputation or other characteristic of the good is essentially attributable to its geographical origin;

4. industrial designs;

5. patents which shall be available for any inventions, whether products or processes, in all fields of technology, provided that they are new, involve an inventive step and are capable of industrial application;

6. layout-design (topographies) of integrated circuits: either a protected layout-design or an integrated circuit in which a protected layout -design is incorporated;

7. protection of undisclosed information such as trade secrets and other business confidential information.

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ

Дараах зүйлтэй холбогдсон эрхүүд:

1. зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхүүд;

2. барааны тэмдэг: үйлдвэрлэгч, эсхүл худалдаачин өөрийн барааг ялган таних, мөн өөрийн барааг бусдын үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараанаас ялгах зорилгоор ашигладаг үг, нэр, үсэг, тоо, дүрс, өнгөний хослол, эсхүл энэ бүхний хослол зэрэг аливаа тэмдэг;

3. газар зүйн заалт: энэ нь барааны чанар, нэр хүнд, эсхүл онцлог бусад шинж тэмдэг нь уг барааны газар зүйн гарал үүслийг илтгэж, уг бараа аль нэг улсын тодорхой нэг нутаг дэвсгэрээс, эсхүл уг нутаг дэвсгэрийн аль нэг бүс буюу суурин газраас гарал үүсэлтэй болохыг хэлж өгдөг;

4. бүтээгдэхүүний загвар;

5. патент: шинэ бүтээлд олгодог. Уг бүтээл нь шинэлэг, бүтээлч ажиллагаа орсон, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой бүтээгдэхүүн буюу технологи байна;

6. Нэгдсэн хэлхээ (интеграл микросхем)-ний загвар буюу топологи: үүнд оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан загвар дангаараа, эсхүл тийм оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан загвараас бүтсэн нэгдсэн хэлхээ (интеграл микросхем) аль аль нь хамаарна;

7. худалдааны нууц, бизнесийн бусад нууц мэдээлэл зэрэг нийтэд дэлгэгдээгүй мэдээллийг хамгаалах.

Notes:
1. This term is defined by the World Intellectual Property Organization.
2. This is an overall definition, and Customs administrations should refer to the Agreement on the Trade-Related Aspects of Intellectual Property Rights (TRIPS), including trade in counterfeit goods, in their application of legislation relating to intellectual property rights.

Жич:
1. Энэ нэр томьёог Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас тодорхойлдог.
2. Энэ нь ерөнхий тодорхойлолт бөгөөд гаалийн байгууллагууд оюуны өмчийн эрхэд хамаарах хууль тогтоомжийг дагаж мөрдөхдөө хуурамч (дууриамал) барааны худалдааг багтаасан Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр (TRIPS)-ийг барьж ажиллавал зохино.

INTERNAL TRAFFIC

The carriage of persons embarked or goods loaded in the Customs territory for disembarkation or unloading within the same Customs territory.

Notes:
1. The term 'internal transport' is also used with the same meaning.
2. Means of transport under a temporary admission procedure may be used in internal traffic, as provided for by the Customs Convention on Containers, 1972, and the Istanbul Convention (Annexes B.3. and C).

ДОТООДЫН ТЭЭВЭР

Гаалийн нутаг дэвсгэрээс суулгасан хүн (зорчигч), эсхүл ачсан барааг тухайн гаалийн нутаг дэвсгэрт буулгахаар тээвэрлэх.

Жич:
1. "Дотоодын тээвэрлэлт" (internal transport) гэсэн нэр томьёо мөн адил утгаар хэрэглэгддэг.
2. 1972 оны Чингэлгийн тухай гаалийн конвенц болон Стамбулын конвенци (хавсралт B.3 болон C)-д зааснаар, түр хугацаагаар оруулах горимд байгаа тээврийн хэрэгслийг гүний хөдөлгөөнд ашиглаж болно.

INTERMEDIARY

Within the international purchase and supply chain, an Intermediary can be any party who provides services to support either the Sales Order Contract or the Transport Service Contract. The possible roles of an Intermediary include the Transport Service Provider (e.g. Carrier, Freight Forwarder), Financial Institution or Customs Agent etc.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЗАВСРЫН ЭТГЭЭД

Олон улсын хэмжээнд бараа, үйлчилгээ худалдан авах, нийлүүлэх сүлжээнд оролцогч завсрын этгээд гэдэг нь бараа худалдах, худалдан авах захиалгын гэрээний, эсхүл тээврийн үйлчилгээний гэрээний биелэлтэд тус дөхөм болох үйлчилгээ үзүүлдэг аливаа этгээд болно. Завсрын этгээдийн үүргийг Тээврийн үйлчилгээ үзүүлэгч (жишээлбэл, тээвэрлэгч, тээвэр зууч), санхүүгийн байгууллага, эсхүл гаалийн агент, г.м. этгээд гүйцэтгэж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERMODAL CONTAINER

Container for intermodal traffic.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ОЛОН ТӨРЛИЙН (ХОЛИМОГ ТЭЭВРИЙН) ЗОРИУЛАЛТТАЙ ЧИНГЭЛЭГ

Тээврийн олон төрлөөр тээвэрлэхэд (холимог тээвэрт) зориулагдсан чингэлэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERMODAL CONTAINER TRANSFER FACILITY (I.C.T.F.)

An on-dock facility for moving containers from ship to rail or truck.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ОЛОН ТӨРЛИЙН (ХОЛИМОГ ТЭЭВРИЙН) ЗОРИУЛАЛТТАЙ ЧИНГЭЛЭГ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ

Чингэлгийг усан онгоцноос төмөр зам, эсхүл ачааны машинд шилжүүлэн ачих зориулалттай, усан онгоцны зогсоол дээр байдаг байгууламж.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERMODAL EQUIPMENT

Equipment ensuring the seamless transfer of a container from one mode of transport to another.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ОЛОН ТӨРЛИЙН (ХОЛИМОГ ТЭЭВРИЙН) ЗОРИУЛАЛТТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Чингэлгийг тээврийн нэг төрлөөс нөгөө төрөлд саадгүй шилжүүлэн ачих зориулалттай төхөөрөмж.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERMODAL TRANSPORT

The movement of goods in one and the same loading unit or road vehicle, which uses successively two or more modes of transport without handling the goods themselves when changing modes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ОЛОН ТӨРЛӨӨР ХИЙГДЭХ ТЭЭВЭР (ХОЛИМОГ ТЭЭВЭР)

Нэг болон нэг ижил ачааны хэрэгсэл, эсхүл нэг буюу хэд хэдэн автомашинд ачсан барааг хоёр буюу түүнээс дээш тээврийн төрлөөр, гэхдээ тээврийн төрлийг солихдоо барааг өөрийг тусад нь зөөхгүйгээр хөдөлгөх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERMODALITY

A system of transport whereby two or more modes of transport are used to transport the same loading unit or truck in an integrated manner, without loading or unloading, in a door-to-door transport chain.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОЛОН ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ (ХОЛИМОГ ТЭЭВЭР) АШИГЛАН ТЭЭВЭРЛЭХ

Барааг хаалганаас хаалганд тээвэрлэх сүлжээнд, нэг ижил ачааны хэрэгсэл буюу ачааны автомашиныг цогцоор нь, ачиж, буулгалгүйгээр тээвэрлэхэд хоёр буюу түүнээс дээш тээврийн төрөл ашигладаг систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERNAL TRANSPORT ORDER

Document giving instructions about the transport of goods within an enterprise.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДОТООД ТЭЭВРИЙН ЗАХИАЛГА

Барааг аль нэг аж ахуйн нэгж (үйлдвэрийн газар)-ын хүрээнд тээвэрлэх заавар бүхий бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERNATIONAL CONVENTION ON THE HARMONIZATION OF FRONTIER CONTROL OF GOODS; HARMONIZATION CONVENTION

Convention aims at reducing the requirements for completing formalities as well as the number and duration of controls, in particular by national and international co-ordination of control procedures and of their methods of application. [UNECE/TRANS/HFCG]

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААНЫ ХИЛИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УЯЛДУУЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ (1982 ОН); ХЯНАЛТЫГ УЯЛДУУЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

Энэ конвенц нь ялангуяа хяналт шалгалтын горимуудыг, мөн тэдгээрийг хэрэгжүүлэх аргуудыг үндэсний болон олон улсын хэмжээнд зохицуулах замаар ёс журмын ажиллагааг цөөрүүлэх, хяналт шалгалтын тоо болон хугацааг багасгах зорилготой болно.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээвэр/HFCG]

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERNATIONAL CUSTOMS DECLARATION FORM TIF

International document used for goods and baggage in Customs transit by rail, introduced by the two international Conventions done at Geneva on 10 January 1952 to facilitate the crossing of frontiers: for goods and for passengers and baggage carried by rail. [WCO/ TIF]

ОЛОН УЛСЫН ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ (TIF МАЯГТ)

Төмөр замаар дамжуулан өнгөрүүлэх бараа болон ачаа тээшинд ашигладаг олон улсын бичиг баримт. Энэ бичиг баримтыг төмөр замаар тээвэрлэх барааанд зориулагдсан, мөн төмөр замаар тээвэрлэх зорчигч болон ачаа тээшинд зориулагдсан, 1952 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Женев хотноо байгуулагдсан олон улсын хоёр конвенциор нэвтрүүлсэн байгаа.
[ДГБ/TIF]

INTERNATIONAL MARITIME DANGEROUS GOODS CODE (IMDG CODE) [IMO/IMDG]

АЮУЛТАЙ БАРААГ ДАЛАЙГААР ТЭЭВЭРЛЭХ ОЛОН УЛСЫН КОДЕКС

(Аюултай барааг далайгаар тээвэрлэх олон улсын кодекс) [Олон улсын далайн тээврийн байгууллага/ Аюултай барааг далайгаар тээвэрлэх]

INTERNATIONAL PRELIMINARY EXAMINATION REPORT (IPER)

ОЛОН УЛСЫН УРЬДЧИЛСАН ЭКСПЕРТИЗИЙН ДҮГНЭЛТ

INTERNATIONAL SHIP AND PORT FACILITY SECURITY CODE (ISPFS) [IMO/ ISPFS]

УСАН ОНГОЦ БОЛОН БООМТЫН БАЙГУУЛАМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН КОДЕКС

[Олон улсын далайн тээврийн байгууллага/ Усан онгоц болон боомтын байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах]

INTERNATIONAL STANDARDS FOR TRADE FACILITATION

Art.10.3 of the TFA provides for the use of international standards for trade facilitation, which include standards for the information exchange and regulatory procedures, such as document forms, box completion guidelines, standard messages (like UNEDIFACT messages), codes, standard procedures, etc. Standards are maintained by international, sectoral and regional organizations, such as UNECE (with its subsidiary body UN/CEFACT), WCO and ISO on the global level and FAO, IMO, ICC, FIATA, EU and others on the sectorial or regional level.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 3 дахь заалтад худалдааг хөнгөвчлөх олон улсын стандартуудыг ашиглах талаар заасан байгаа. Эдгээр стандарт нь мэдээлэл солилцох стандартууд болон хэм хэмжээ тогтоосон горим журмууд болно. Үүнд бичиг баримтын маягтууд, маягт бөглөх зааврууд, станпарт мессежүүд (Iзахиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэмд заасан мессежүүдтэй адил), кодууд, стандарт дүрэм журмууд, г.м. Стандартуудыг олон улсын, салбарын болон бүс нутгийн дараах байгууллагууд хөгжүүлдэг: дэлхийн хэмжээнд НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (түүний салбар байгууллага болох НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн хамт), ДГБ, Олон улсын стандартчиллын байгууллага, салбарын болон бүс нутгийн хэмжээнд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын далайн тээврийн байгууллага, Олон улсын худалдааны танхим, Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо, Европын холбоо, өөр бусад байгууллагууд.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERNATIONAL TRADE CERTIFICATE

Import license, which is in free circulation. The international trade certificate grants the buyer the right to sell goods for a specified amount in hard currency in a country with nonconvertible currency.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ГЭРЧИЛГЭЭ

Чөлөөт эргэлтэд байгаа импортын лиценз. Олон улсын худалдааны гэрчилгээ нь барааг үл хөрвөдөг валюттай улсад тодорхой хэмжээний хатуу валютаар худалдах эрхийг худалдан авагчид олгодог. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INTERNET OF THINGS

Network of sensors or smart devices that are connected to the Internet and generate a stream of data.
[UN/CEFACT White Paper on Technical Applications of Blockchain to UN/CEFACT deliverables]

ЮМСЫН ИНТЕРНЭТ

Интернэтэд холбогдсон бөгөөд мэдээллийн урсгал үүсгэдэг мэдрэгч буюу ухаалаг хэрэгслүүдийн сүлжээ.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн бүтээгдэхүүнд блокчэйн ашиглах техник арга ажиллагааны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн цагаан хуудас]

INVISIBLE TRADE

The exchange between countries of physically intangible items, such as services, income from foreign investments, etc.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮЛ ҮЗЭГДЭХ ХУДАЛДАА

Үйлчилгээ, гадаадын хөрөнгө оруулалтын орлого г.м. бие махбодын хувьд материаллаг бус эд зүйлийг улс хооронд солилцох.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INVOICE

(see also: commercial invoice; consular invoice; Customs invoice; Freight Forwarder's Invoice; freight invoice; insurer's invoice; Proforma invoice).
The party to whom an invoice is issued. [UNTDED]

ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ

(бас дараах зүйлсийг үз: худалдааны үнийн нэхэмжлэх; консулын газрын үнийн нэхэмжлэх; гаалийн үнийн нэхэмжлэх; тээвэр зуучийн үнийн нэхэмжлэх; тээврийн үнийн нэхэмжлэх; даатгагчийн үнийн нэхэмжлэх; урьдчилсан нэхэмжлэх).
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

INVOICE PRICE

The price indicated in the invoice for the delivered goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮНИЙН НЭХЭМЖЛЭХИЙН ҮНЭ

Хүргэсэн (нийлүүлсэн) барааны үнийн нэхэмжлэхэд заасан үнэ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INVOICING DATA SHEET

Document issued within an enterprise containing data about the goods sold, to be used as the basis for the preparation of a commercial invoice.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮНИЙН НЭХЭМЖЛЭХ ҮЙЛДЭХ МЭДЭЭЛЛИЙН ХҮСНЭГТ

Аль нэг аж ахуйн нэгж (үйлдвэрийн газар)-ын хүрээнд үйлдсэн, холбогдох барааны талаар мэдээлэл агуулсан, үнийн нэхэмжлэх бэлдэх үндэс болгон ашиглах бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

INWARD PROCESSING

The Customs procedure under which certain goods can be brought into a Customs territory conditionally relieved from payment of import duties and taxes, on the basis that such goods are intended for manufacturing, processing or repair and subsequent exportation.

Note:

Specific Annex F, Chapter 1 of the revised Kyoto Convention.

[Art. 10.9.2(b) TFA]

ДОТООДОД БОЛОВСРУУЛАХ

Тодорхой барааг үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварт оруулж, дараа нь экспортлох үндсэн дээр тухайн барааг импортын гаалийн болон бусад татвараас болзолтойгоор чөлөөлөн гаалийн нутаг дэвсгэрт оруулах гаалийн горим.

Жич:

Шинэчлэн боловсруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт F-ийн 1 дүгээр бүлэг.

[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 10.9.2(b)]

IRREVOCABLE LETTER OF CREDIT

A letter of credit with a fixed expiration date that carries the irrevocable obligation of the issuing bank to pay the exporter when all of the terms and conditions of the letter of credit have been met.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БУЦААН ҮЛ ДУУДАГДАХ АККРЕДИТИВ

Аккредитивын бүх болзол, нөхцөл хангагдсан тохиолдолд экспортлогчид төлбөр үйлдэх аккредитив нээгч банкны буцаан үл дуудагдах үүргийг тээж явдаг, дуусах хугацааг нь хатуу тогтоосон аккредитив.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ISO COUNTRY CODE

ISO 3166-1-alpha-2 code elements representing two-letter codes for countries (independent states and several territories) around the world.

[ISO 3166]

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОЛОН УЛСЫН СТАНДАРТЧИЛЛЫН БАЙГУУЛЛАГЫН УЛСЫН КОД

Олон улсын стандартчиллын байгууллагын 3166-1-үсэг-2 кодтой элемент. Энэ нь улсууд (тусгаар тогтносон улсууд болон зарим нэг нутаг дэвсгэр)-ын хоёр үсэгтэй код болно

[ISO 3166]

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ISSUANCE OF A NEGOTIABLE ELECTRONIC TRANSPORT RECORD

The issuance of the record in accordance with procedures that ensure that the record is subject to exclusive control from its creation until it ceases to have any effect or validity.

[Rotterdam Rules]

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БОЛОХ ТЭЭВРИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ ҮЙЛДЭХ

Энэ бүртгэл нь түүнийг үйлдсэн үеэс хучинтэй хугацаа нь дуусгавар болох хүртэл тусгай хяналтанд байх явдлыг хангасан журмын дагуу уг бүртгэлийг үйлдэнэ.

[Роттердамын дүрэм]

ISSUING ASSOCIATION

An association which is approved by the Customs authorities to issue ATA, CPD or TIR carnets and which is affiliated directly or indirectly to a guaranteeing chain.

Notes:

1. There is a link between the terms “Guaranteeing chain”, “Guaranteeing association” and “Issuing association”.
2. The issuing association must be approved by the Customs authorities of the Contracting Party on whose territory it is established.

КАРНЕЙ ОЛГОГЧ ХОЛБОО

ATA, CPD болон TIR карней олгохоор гаалийн байгууллагаас зөвшөөрөгдсөн бөгөөд баталгаа гаргагч сүлжээнд шууд болон шууд бусаар харьяалагдах холбоо.

Жич:

1. “Баталгаа гаргагч сүлжээ”, “баталгаа гаргагч холбоо” болон “карней олгогч холбоо” хэмээх нэр томьёонууд хоорондоо холбоотой болно.
2. Карней олгогч холбоо нь байгуулагдсан нутаг дэвсгэртээ хамаарах Хэлэлцэн тохирогч Талын гаалийн байгууллагаар зөвшөөрөгдсөн байна.

ISTANBUL CONVENTION

The expression commonly used to refer to the Convention on temporary admission, adopted by the Customs Co-operation Council in Istanbul in 1990.

СТАМБУЛЫН КОНВЕНЦ

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 1990 онд Стамбул хотноо баталсан Түр хугацаагаар оруулах тухай конвенцийн түгээмэл нэр.

J

JOINT BORDER CONTROLS

Joint border controls refer to the concept of two neighbouring Customs administrations entering into an agreement to operate Customs control jointly, i.e. to coordinate export and import controls, opening hours and competences. Ideally, joint controls are conducted in juxtaposed Customs offices where physical and technical infrastructures are shared.

Co-operation between Customs administrations in regard to juxtaposed offices, hours of business and competence may open the way to joint controls, as specified in Transitional Standard 3.4. These joint operations can become a one-stop Customs control. In many countries or Customs territories that share a common border, the formalities of the exporting administration could be carried out together with the import formalities in the juxtaposed Customs office. In addition, where there are no export formalities, the import data on the Goods declaration can be accepted as the export data for the exporting country or territory.

The importing administration can furnish the pertinent data to the exporting country or territory for statistical purposes. Likewise, when the goods or conveyances are selected for examination for either export or import controls, the examinations can be conducted at one time by officers representing both Customs administrations.

Where joint Customs controls cannot be established on a common border, for example where this is a river, the Customs of the juxtaposed offices can still consult one another to standardize documentation requirements and share as much of the information as possible to minimize duplication of requirements at a common border for traders.

ХИЛИЙН ХАМТАРСАН ХЯНАЛТ

Хилийн хамтарсан хяналт гэдэг нь гаалийн хөрш хоёр байгууллага гаалийн хяналтыг хамтран хийх, өөрөөр хэлбэл, экспорт, импортын хяналт, ажлын цаг, эрх хэмжээг зохицуулан ажиллах хэлэлцээр байгуулж ажиллах тухай ойлголт юм. Төгс утгаараа бол хамтарсан хяналтыг биет болон техникийн дэд бүртцүүдээ хамтран хуваалцдаг хамтарсан (зэрэгцсэн) гаалийн газруудад явуулдаг.

Гаалийн байгууллагууд хамтарсан (зэрэгцсэн) гаалийн газар байгуулан ажиллах, тэдгээрийн ажлын цаг, эрх хэмжээг уялдуулах чиглэлээр хамтран ажиллах нь Шилжилтийн стандарт 3.4-т заасан хамтарсан хяналт (joint controls)-ыг хэрэгжүүлэх замыг нээн өгч болох юм. Энэ хамтарсан ажиллагаа нь цаашлаад гаалийн нэг цэгийн хяналт (a one-stop Customs control) болон хувирч болно. Дундын хилтэй олон улс орны буюу гаалийн нутаг дэвсгэрийн хамтарсан (зэрэгцсэн) гаалийн газарт экспортлогч гаалийн байгууллагын ёс журмын ажиллагааг импортын ёс журмын ажиллагаатай хамт хийж гүйцэтгэж болох юм. Түүнээс гадна, экспортын ёс журмын ажиллагаа хийгддэггүй бол Барааны мэдүүлэг дэх импортын мэдээллийг экспортлогч улсын буюу нутаг дэвсгэрийн экспортын мэдээлэл гэж хүлээн зөвшөөрөх боломжтой юм.

Импортлогч улсын (гаалийн) байгууллага экспортлогч улс буюу нутаг дэвсгэрт статистикийн зорилгоор хэрэгтэй мэдээллийг өгч болно. Үүний нэгэн адил, хэрэв тодорхой нэг бараа буюу тээврийн хэрэгслийг экспортын, эсхүл импортын хяналтын зорилгоор шалгах шаардлагатай гэж үзсэн бол хоёр гаалийн байгууллагыг төлөөлсөн ажилтнууд шалгалтыг нэг агшинд (зэрэг) хийж болно.

Customs administrations must therefore work, in co-ordination with their counterpart Customs, to seek ways to establish single controls in juxtaposed Customs offices. This is particularly advantageous to further facilitate the movement of goods and persons. Since establishing joint controls or a single control is a matter of national policy, it can only be truly effective if the governments of the countries or territories concerned find a political method to make it work.

Хэрэв, жишээлбэл, дундуур нь гол урсдаг зэрэг шалтгаанаар хамтарсан хяналтыг дундын хил дээр хэрэгжүүлэх боломжгүй байсан ч гэсэн зэрэгцсэн газрын гаалийн байгууллагууд дундын хил дээр худалдаа эрхлэгч нарт тавигдах шаардлага нь давхардах явдлыг багасгах зорилгоор бичиг баримтын шаардлагаа нэг стандартад оруулах, мөн аль болох олон төрлийн мэдээлэл солилцох үүднээс өөр хоорондоо зөвлөлдөх боломжтой байх болно.

Тэгэхээр гаалийн байгууллага нь хамтарсан (зэрэгцсэн) гаалийн газарт нэгдсэн хяналт тогтоох арга зам хайх зорилгоор хөрш гаалийн байгууллагатайгаа хамтарч ажиллах ёстой. Энэ нь ялангуяа зорчигч болон барааны хөдөлгөөнийг улам бүр хөнгөвчлөхөд ач тустай байх болно. Хамтарсан хяналт тогтоох, эсхүл нэгдсэн хяналт тогтоох эсэх нь (холбогдох улсуудын) үндэсний бодлогын асуудал учир зөвхөн холбогдох улс орнуудын буюу нутаг дэвсгэрүүдийн засгийн газрууд нь энэ ажлыг хэрэгжүүлэх улс төрийн шийдэлд хүрвэл тэр нь үнэн хэрэгтээ үр өгөөжөө өгөх болно.

Note:
Trade Faciltation Implementation Guide, General Annex, Chapter 3 of the revised Kyoto Convention.

Жич:
Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх заавар,
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 3 дугаар бүлэг.

JOINT BORDER CROSSING

A concept which involves two neighbouring Customs administrations entering into an agreement to operate customs control jointly (i.e. to coordinate export and import controls, opening hours and competencies). Ideally, joint controls are conducted in a single Customs office where physical and technical infrastructures are shared. Even further, officers from each country are authorized to exercise law enforcement measures (e.g. penalties, seizures, arrests) in the other country's territory, within the limits of the joint Customs office.
[UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms]

ХИЛ НЭВТРЭХ ХАМТАРСАН ЦЭГ

Гаалийн хөрш хоёр байгууллага гаалийн хяналтыг хамтран хийх (өөрөөр хэлбэл, экспорт, импортын хяналт, ажлын цаг, эрх хэмжээг зохицуулан ажиллах) хэлэлцээр байгуулж ажиллах тухай ойлголт юм. Төгс утгаараа бол хамтарсан хяналтыг биет болон техникийн дэд бүртцүүдээ хамтран хуваалцдаг хамтарсан (зэрэгцсэн) гаалийн газруудад явуулдаг. Цаашилбал, хоёр орны ажилтнууд нөгөө улсын нутаг дэвсгэрт хамтарсан гаалийн байгууллагын хүрээнд хууль сахиулах арга хэмжээ (жишээлбэл, торгууль шийтгэл ногдуулах, бараа саатуулах, баривчилгаа явуулах) авч хэрэгжүүлэхийг зөвшөөрнө.
[Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт]

JOHANNESBURG CONVENTION

The expression commonly used to refer to the International Convention on Mutual Administrative Assistance in Customs Matters, adopted by the Customs Co-operation Council in Brussels in 2003.

ЙОХАННЕСБУРГИЙН КОНВЕНЦ

Гаалийн хамтын ажиллагааны завлалаас 2003 онд Брюссель хотноо баталсан Гаалийн асуудлаар байгууллагын хүрээнд харилцан туслах тухай олон улсын конвенцийн түгээмэл нэр.

JUST IN TIME (JIT)

The principle of production and inventory control in which goods arrive when needed for production or use.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЯГ ЦАГТ НЬ

Үйлдвэрлэл болон бараа материалын хяналтын зарчим. Энэ зарчмын дагуу бараа үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглах шаардлагатай үед нь ирдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

JUXTAPOSED CUSTOMS OFFICES

Where Customs offices are located at common land or waterway borders, Standard 3.3 of the RKC requires that the Customs administrations of the juxtaposed offices will arrange joint hours of business and equal competence, wherever practicable, to assist both travellers and the trade. Harmonizing the competence of corresponding Customs offices should apply to all the Customs activities of the office.
The experiences of many administrations that operate juxtaposed Customs offices clearly indicate the advantages that can accrue from such co-ordination. There has been better co-operation between officers of the two Customs territories; an easier exchange of information; more efficient control of documents, goods and means of transport; reduced building and running costs; and reduction in staff, particularly where officers of one administration are authorized to act on behalf of the other. Trade has also been facilitated through faster clearance and reduced costs due to the many conveniences provided by the juxtaposed Customs office.

ХАМТАРСАН (ЗЭРЭГЦСЭН) ГААЛИЙН ГАЗРУУД

Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн стандарт 3.3 нь хэрэв гаалийн газрууд (хоёр улсын) дундын газар, эсхүл дундын усан хил дээр байршиж байгаа бол тэдгээр зэрэгцсэн газар (the juxtaposed offices)-ын гаалийн байгууллагууд зорчигч болон худалдаанд тус дэм болох үүднээс боломжтой бол ажлын цаг адилтгах, мөн эрх хэмжээгээ тэгшитгэх арга хэмжээ авахыг шаардаж байгаа. Харгалзах (зэрэгцэн орших) гаалийн газрууд (corresponding Customs offices)-ын эрх хэмжээг уялдуулах нь тухайн газруудын гаалийн бүх үйл ажиллагаанд хамаарна.
Хамтарсан (зэрэгцсэн) гаалийн газар ажиллуулж буй олон байгууллагын туршлагаас харахад ийм төрлийн хамтын ажиллагаа олон давуу талтай болох нь тодорхой харагдаж байгаа. Хоёр гаалийн нутаг дэвсгэрийн (гаалийн) ажилтнууд илүү нягт хамтран ажилладаг; мэдээлэл солилцох явдал хялбар болдог; бичиг баримт, бараа, тээврийн хэрэгслийн хяналт илүү үр ашигтай болдог; барилга байшин барих болон урсгал засварын зардал багасдаг; мөн ялангуяа хэрэв нэг (гаалийн) байгууллагын ажилтан (ажилтнууд) нөгөө гаалийн байгууллагын нэрийн өмнөөс ажиллах эрхтэй бол цөөн хүн ажиллах боломжтой болдог. Хамтарсан (зэрэгцсэн) гаалийн газар байгуулснаар бий болсон тохь тухтай олон төрлийн үйлчилгээний үр дүнд (гаалийн) бүрдүүлэлт түргэн шуурхай болж, худалдааны зардал буурдаг бөгөөд энэ нь худалдааг бас хөнгөвчилж өгдөг.

Note: General Annex, Chapter 3 of the revised Kyoto Convention.	Жич: Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 3 дугаар бүлэг.

K

KYOTO CONVENTION

The expression commonly used to refer to the international Convention on the simplification and harmonization of Customs procedures adopted by the Customs Co-operation Council in Kyoto in 1973.

It came into force in 1974. The WCO Council adopted the Revised Kyoto Convention in June 1999 as the blueprint for modern and efficient Customs procedures in the 21st century. [WCO/RKC]

КИОТОГИЙН КОНВЕНЦ

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 1973 онд Киото хотноо баталсан Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенцийн түгээмэл нэр.

Энэ конвенц 1974 онд хүчин төгөлдөр болсон. ДГБ (Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл) 21 дүгээр зууны орчин үеийн болоод үр ашигтай гаалийн горимын загвар болгож шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийг 1999 оны 6 дугаар сард баталсан байдаг. [ДГБ/Шинэчлэн найруулсан Киотогийн конвенц]

L

LAW ENFORCEMENT OPERATIONS	**ХУУЛЬ САХИУЛАХ ОПЕРАЦИУД (ТУСГАЙ АЖИЛЛАГАА)**
WCO coordinates and co-organizes numerous law enforcement operations within the high-risk areas every year. Some recent key operations: Gryphon, Fox (Tobacco) ACIM, BalkanGate, Action IPR, AP (IPR), Tiger 3, Biyela 2 (Intellectual Property Rights) COSMO2 (Strategic goods) COCAIR IV, WESTERLIES, CATalyst (drug enforcement) Demeter VI (Waste) Amazonas (Timber)	ДГБ нь жил бүр өндөр эрсдэлтэй орчинд хууль сахиулах чиглэлээр явуулсан хэд хэдэн операцийг удирдан зохицуулж, хамтран зохион байгуулж ирсэн. Саяхан явуулсан зарим нэг томоохон тусгай ажиллагаа Грифонь, Үнэг (Тамхи) АСИМ, БалканГэйт, Action IPR, AP (IPR), Бар 3, Биеле 2 (Оюуны өмчийн эрх) КОСМО2 (Стратегийн бараа) КОКЭЙР IV, ВЕСТЕРЛИЙЗ 2, КАТалист (Хар тамхи) Деметер VI (Хаягдал) Амазанос (Мод)
Global INTERPOL-led operations to tackle the illegal trade in wildlife and timbe (coordinated jointly by INTERPOL's Environmental Security Programme and the WCO Environment Programme):	Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийн болон модны хууль бус худалдаатай тэмцэх зорилгоор дэлхийн хэмжээнд ИНТЕРПОЛ-ын удирдлага дор явагдаж буй операциуд (ИНТЕРПОЛ-ын Байгаль орчны аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, ДГБ-ын Байгаль орчныг хамгаалах хөтөлбөрөөс хамтран зохицуулсан):
"Thunder" series:	"Аянга" нэртэй цуврал операци:
Operation Thunderbird	Аянгын шувуу: 2017 оны 1 дүгээр сарын 30 – 2 дугаар сарын 19 (3 долоо хоног)
Operation Thunderstorm	Аянгын шуурга: 2018 оны 5 дугаар сарын 1 – 31 (1 сар)
Operation Thunderball	Аянгын бөмбөг: 2019 оны 6 дугаар сарын 4 – 30 (4 долоо хоног)
Operation Thunder 2020	Аянга 2020: 2020 он
Mekong Dragon	Меконг Драгон
LESS THAN CONTAINER LOAD (LCL)	**ДҮҮРЭН БИШ АЧААТАЙ ЧИНГЭЛЭГ**
The transportation of small freight shipments not requiring the full capacity of an ocean container (usually less than 20m3). A freight forwarder may create a "consolidation" by putting together multiple LCL shipments up to the full capacity of the container. (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)	Далайн тээврийн чингэлгийн багтаамжийг бүрэн ашиглалгүйгээр (ерөнхийдөө 20m3-аас бага) жижиг ачаа тээвэрлэх. Тээвэр зууч "цуглуулбар" (түүвэр) ачаа цуглуулан дүүрэн биш ачаатай чингэлгийг дүүргэж болох юм. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LETTER OF CREDIT (L/C)

A document issued by a bank per instructions by a buyer of goods, authorizing the seller to draw a specified sum of money under specified terms.

The term “Letter of Credit” or the abbreviation “L/C” is predominantly used in the USA while Europeans prefer to use “Documentary Credit” or the abbreviation “D/C”. A letter of credit is also known as a sight letter of credit (Sight LC), bankers’ commercial credit, or letter of undertaking (LoU).

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

АККРЕДИТИВ

Бараа худалдан авагчийн зааврраар банкнаас үйлддэг бичиг баримт. Энэ нь худалдагч тогтоосон нөхцөлийн дагуу тодорхой хэмжээний мөнгөн дүнг татан авах эрх олгодог.

Аккредитивыг ихэвчлэн АНУ-д “Letter of Credit” (товчлол нь “L/C”) гэдэг бол Европт “Documentary Credit” (товчлол нь “D/C”) гэдэг. Аккредитивыг зарим улсад бас “sight letter of credit (Sight LC)”, “bankers’ commercial credit”, эсхүл “letter of undertaking (LoU)” гэдэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LETTER OF INTENT

Document by means of which a buyer informs a seller that the buyer has accepted an offer in principle and intends to enter into contractual negotiations.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ БИЧИГ

Худалдан авагч оферт (санал)-ыг зарчмын хувьд хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулах хэлэлцээ хийх сонирхолтой байгаагаа худалдагчид мэдэгдсэн бичиг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LETTER-POST ITEMS

Letters, postcards, printed papers, literature for the blind and small packets described as letter-post items in the Acts of the Universal Postal Union currently in force.

Note:
According to the Acts of the Universal Postal Union certain letter-post items are required to be accompanied by a Customs declaration form CN22/CN23 as appropriate.
Annex F.4. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex J, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ЗАХИДАЛ (ШУУДАНГААР ИЛГЭЭСЭН БИЧИГ БАРИМТ)

Дэлхийн шуудангийн холбооны өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа актуудад “захидал” (шуудангаар илгээсэн бичиг баримт) гэж тодорхойлсон захидал, ил захидал, хэвлэмэл хуудас, хараагүйчүүдэд зориулсан ном болон жижиг боодол.

Жич:
Дэлхийн шуудангийн холбооны актуудад зааснаар захидлыг Гаалийн мэдүүлгийн маягт CN22/CN23-ын аль тохирох нь дагалдана.
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт F.4., шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 2 дугаар бүлэг.

LETTER OF CREDIT (L/C)

A document issued by a bank per instructions by a buyer of goods, authorizing the seller to draw a specified sum of money under specified terms

АККРЕДИТИВ

Бараа худалдан авагчийн зааврын дагуу банкнаас олгосон бичиг баримт. Энэ нь заасан нөхцөл хангасан тохиолдолд заасан хэмжээний мөнгө гаргаж авах эрхийг худалдагч олгоно.

LICENSE

A document issued by an authorized state body permitting the import or export (and sometimes transit) of goods, for which foreign trade operations are not allowed without this permission. The rules of application of import licenses are regulated by the WTO Agreement on Import Licensing Procedures.
[WTO Import Licensing]

ЛИЦЕНЗ

Төрийн эрх бүхий байгууллагаас үйлдсэн, бараа оруулахыг, эсхүл гаргахыг (заримдаа дамжуулан өнгөрүүлэхийг) зөвшөөрсөн бичиг баримт. Ийм зөвшөөрөлгүй бол гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэх боломжгүй байдаг. Импортын лиценз авах өргөдөл гаргах дүрмийг ДХБ-ын Импортын лиценз олгох журмын тухай хэлэлцээрээр зохицуулдаг.
[ДХБ-ын Импортын лиценз олгох журмын тухай хэлэлцээр]

LICENCING (IN FOREIGN TRADE)

Regulation by competent state bodies of the importation and exportation of goods across the borders of a country by issuing special permits (licenses) upon request (filing applications) by interested persons. Licensing in foreign trade is a form of state control over foreign trade activities, the rational use of export resources, and balancing of imports.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЛИЦЕНЗ ОЛГОХ (ГАДААД ХУДАЛДААНД)

Сонирхогч этгээдийн хүсэлтээр (өргөдөл гаргаснаар) тусгай зөвшөөрөл (лиценз) олгох замаар барааг аль нэг улсын хилээр нэвтрүүлэн оруулах, эсхүл гаргах тухай төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан журам.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LIFT-ON-LIFT-OFF (LO-LO)

Loading and unloading of intermodal transport units using lifting equipment.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БОСОО ТЭНХЛЭГЭЭР АЧАА АЧИХ, БУУЛГАХ АРГА (ЛО-ЛО)

Өргөгч тоног төхөөрөмж ашиглан олон төрлөөр тээврийн (холимог тээврийн) зориулалттай тээврийн хэрэгслийг ачих, буулгах.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LINER SHIPPING

The service of transporting goods by means of high capacity, ocean-going ships that transit regular routes on fixed schedules.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЛАЙНЕРИЙН (РЕЙСИЙН) АЧИЛТ

Өндөр даацтай далайн хөлөг онгоцоор тогтмол цагийн хуваариар тогтмол маршрутаар бараа тээвэрлэх үйлчилгээ. “Тэнгисийн шугамын тээвэр” гэж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LINER TRANSPORTATION

A transportation service that is offered to the public through publication or similar means and includes transportation by ships operating on a regular schedule between specified ports in accordance with publicly available timetables of sailing dates. [Rotterdam Rules]

(ТЭНГИСИЙН) ШУГАМЫН ТЭЭВЭР

Хэвлэн нийтлэх буюу өөр бусад аргаар олон нийтэд санал болгосон тээврийн үйлчилгээ. Үүнд олон нийтэд хүртээлтэй далайд гарах цагийн хуваарийн дагуу дурдсан боомтуудын хооронд тогтмол хуваариар явдаг усан онгоцны тээвэр хамаарна.
[Роттердамын дүрэм]

LIQUIDATION OF A CUSTOMS ENTRY

The final calculation of money owed to Customs based on the current duty rates and the value of the imported goods.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ГААЛИЙН МЭДҮҮЛЭГТ ЗААСАН ТАТВАРЫН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ (ХААХ)

Гаалийн байгууллагад төлөх мөнгийг гаалийн татварын одоогийн хувь хэмжээ болон импортын барааны үнийг үндэслэн эцэслэн тооцох.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LOAD MANIFEST

List of goods constituting the load (or cargo) of a method of conveyance or unit of transport. The load manifest, which gives commercial information about the goods, such as transport document numbers, consignor/consignee names, markings and numbers, number and type of packages, quantity and description of goods, may be used in place of the load declaration itself.
(see “Cargo manifest”)
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

АЧААНЫ МАНИФЕСТ

Ямар нэгэн аргаар, эсхүл аль нэг тээврийн хэрэгсэлд ачсан ачааны жагсаалт. Ачааны манифест нь тээврийн баримтын дугаар, илгээгчийн болон хүлээн авагчийн нэр, баглаа боодлын тэмдэглэгээ, тоо ширхэг, дугаар, төрөл, барааны тодорхойлолт (бичиглэл) ба тоо хэмжээ зэрэг барааны худалдааны мэдээллийг агуулна. Ачааны манифестыг ачааны мэдүүлгийн оронд хэрэглэж болно.
(“Cargo manifest”-ыг үз)
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

LOADING INSTRUCTIONS

Instructions on where or how specified packages or containers are to be loaded on a means of transport.
[UNTDED]

АЧАА АЧИХ ЗААВАР

Заасан сав боодолтой ачаа буюу чингэлгийг ямар нэг тээврийн хэрэгсэлд хаана, хэрхэн ачих талаар заасан заавар.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

LOGISTICS

The optimization of transport, storage, handling and packaging of goods and services from the point of origin to the point of consumption. Essentially, logistics is about getting the right thing, in the right place, for the right price. Logistics is the part of supply chain management encompassing transport and inventory, while only barely dealing with the production process

ЛОЖИСТИК

Бараа тээвэрлэх, хадгалах, арчлан хамгаалах (зөөвөрлөх), савлах, мөн үйлчилээ үзүүлэх ажиллагааг гарал үүслийн цэгээс хэрэглээний цэг (бараа илгээх цэгээс хүлээн авах цэг) хүртэл оновчтой зохион байгуулах. Үндсэндээ ложистик бол зөв зүйлийг зөв газар нь зөв үнээр авах тухай юм. Ложистик бол бараа нийүүлэх сүлжээнй менежметийн нэг хэсэг юм. Үүнд тээвэр болон бараа материалын үйлчилгээ хамаарна. Үйлдвэрлэлийн процесс үүнд бараг хамааралгүй юм.

LOGISTICS PACKAGE

A self-contained wrapping or container within which goods can be contained for logistics purposes, such as a box or a barrel which can be filled, partially filled or empty.
[UN/CEFACT/CCL]

ЛОЖИСТИКИЙН ЗОРИЛУЛАЛТТАЙ САВ БООДОЛ

Хайрцаг, торх гэх мэт ложистикийн зориулалтаар бараа хийх сав боодол буюу чингэлэг. Эдгээр нь дүүрэн, эсхүл дүүрэн бус ачаатай, эсхүл хоосон байж болно.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан]

LONG-TERM CONTRACT

Contract providing for the supply of goods by batches over a long period, for example, more than two years.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УРТ ХУГАЦААНЫ ГЭРЭЭ

Урт хугацааны турш, жишээлбэл, хоёр жилээс дээш хугацаанд барааг багцаар (бөөмөөр) нь нийлүүлэх тухай гэрээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

M

MACHINE-TO-MACHINE (M2M) COMMUNICATION

M2M communication is used for automated data transmission and measurement between mechanical or electronic devices, without human interaction.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

МАШИН ХООРОНДЫН ХАРИЛЦАА ХОЛБОО

Машин хоорондын харилцаа холбоог механик, эсхүл цахим хэрэгслүүдийн хооронд хүний оролцоогүйгээр автоматаар мэдээлэл дамжуулах болон хэмжилт хийхэд ашигладаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MANIFEST

A list of all goods loaded for transportation onto a means of transport in one location and which have a single certain destination (or a list of passengers). It combines all bills of lading for goods on a vessel. The number of manifests onboard a vessel should equal the number of different travel routes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

МАНИФЕСТ

Нэг газар байгаа ямар нэг тээврийн хэрэгсэлд ачуулсан бөгөөд тодорхой нэг чиглэлээр тээвэрлэх бүх ачааны жагсаалт (эсхүл бүх зорчигчийн жагсаалт). Үүнд ямар нэг усан онгоцонд байгаа барааны тээврийн бүх баримтыг нэгтгэсэн байна. Ямар нэг усан онгоцон дээр байгаа манифестын тоо нь өөр өөр аяллын маршрутын тоотой ижил байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MANUFACTURING INSTRUCTIONS

Document issued within an enterprise to initiate the manufacture of goods to be offered for sale or otherwise supplied to customers.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ЗААВАР

Худалдан борлуулах санал тавих, үгүй бол үйлчлүүлэгч нартаа нийлүүлэх зорилготой барааг үйлдвэрлэхийн тулд аль нэг аж ахуйн нэгж (үйлдвэрийн газар)-ын хүрээнд үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MARKING

Letters, numbers, and other symbols placed on cargo packages to facilitate identification. Also known as marks.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭМДЭГЛЭГЭЭ

Ялгаж таних ажлыг хөнгөвчлөх зорилгоор ачааны сав боодол дээр тавьсан үсэг, тоо, бусад ялгах тэмдэг. Бас тэмдэг гэж нэрлэдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MARITIME PERFORMING PARTY

A performing party to the extent that it performs or undertakes to perform any of the carrier's obligations during the period between the arrival of the goods at the port of loading of a ship and their departure from the port of discharge of a ship. An inland carrier is a maritime performing party only if it performs or undertakes to perform its services exclusively within a port area.
[Rotterdam Rules]

ТЭНГИСИЙН (ДАЛАЙН) ТЭЭВРИЙН ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ

Гүйцэтгэгч тал нь усан онгоцыг ачаалах боомт дээр бараа ирсэн цагаас усан онгоц чөлөөлөх боомт дээрээс барааг явуулах хүртэл хугацаанд тээвэрлэгчийн аль нэг үүргийг гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхээр үүрэг авах хэмжээнд яригдана. Гүний тээвэрлэгч нь зөвхөн аль нэг (усан) боомтын бүсэд өөрийн үйлчилгээг үзүүлэх буюу үзүүлэхээр үүрэг авсан бол тэнгисийн (далайн) тээврийн гүйцэтгэгч тал болно.
[Роттердамын дүрэм]

MASTER AIR WAYBILL (MAWB)

A transport document, which is used in air shipments, issued and signed by the air cargo carrier or its agent, generally on a pre-printed carrier's air waybill format, evidences the terms and conditions of the carriage of goods over routes of the carrier(s).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АГААРЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН БАРИМТ

Агаарын ачаанд хэрэглэдэг, ерөнхийдөө тээврлэгчээс урьдчилан хэвлэсэн агаарын тээврийн баримтын маягтанд дээр агаарын ачаа тээвэрлэгч буюу түүний агентаас үйлдэж, гарын үсэг зурсан тээврийн бичиг баримт. Энэ бичиг баримтад тухайн тээвэрлэгчийн маршрутын дагуу бараа тээвэрлэх болзол, нөхцөлийг заасан байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MASTER BILL OF LADING (MBL)

A transport document issued by main carrier of goods or his agent on receipt of goods from a freight forwarder to deliver at destination as per agreed terms, generally on a pre-printed carrier's bill of lading format. It evidences the terms and conditions of the carriage of goods between port of loading to port of discharge.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ҮНДСЭН БАРИМТ

Ерөнхийдөө тээврлэгчээс урьдчилан хэвлэсэн тээврийн баримтын маягтанд дээр үндсэн бараа тээвэрлэгч буюу түүний агентаас барааг тухайлан тохиролцсон нөхцөлийн дагуу тодорхой чиглэлээр хүргэж өгөхөөр тээвэр зуучаас хүлээн авсан даруй үйлдсэн тээврийн бичиг баримт. Энэ бичиг баримтад ачаа ачих боомтоос ачаа буулгах боомт хооронд бараа тээвэрлэх болзол, нөхцөлийг заасан байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MASTER DATA EXCHANGE STRUCTURE

A collection of information structured in such a way that it covers the data exchange structures required by users within the Reference Data Model domain, such as the Supply Chain. From the Master Data Exchange Structure Different Business Data Exchange Structures can be derived.

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ҮНДСЭН БҮТЭЦ

Үлгэрчилсэн дата модель (Үлгэрчилсэн өгөгдлийн загвар)-ын домэйны хүрээнд хэрэглэгчдийн шаардлага хангасан мэдээлэл солилцох бүтцийг, тухайлбал бараа нийлүүлэх сүлжээг хамарсан байдлаар бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй) мэдээллийн цуглуулга.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

Мэдээлэл солилцох үндсэн бүтцээс Мэдээлэл солилцох бизнесийн янз бүрийн бүтцүүдийг гаргаж авах боломжтой. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MATE'S RECEIPT

Document issued by a ship's officer to acknowledge that a specified consignment has been received on board a vessel, and the apparent condition of the goods; enabling the carrier to issue a Bill of Lading.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УСАН ОНГОЦНЫ АХЛАГЧИЙН ҮЙЛДСЭН БАРИМТ (ШТУРМАНЫ БАРИМТ) (ТАСАЛБАР)

Заасан ачааг усан онгоцон дээр хүлээн авсан болохыг, мөн холбогдох барааны гадаад байдлыг хүлээн зөвшөөрч, усан онгоцны ахлагчийн үйлдсэн бичиг баримт; Үүнийг үндэслэн тээврийн баримт үйлддэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MEANS OF TRANSPORT

Particular vehicle, vessel or other device used for transport of goods or persons.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Бараа, хүн тээвэрлэх зориулалтаар ашигладаг тодорхой нэг автомашин, усан онгоц, бусад хэрэгсэл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MEANS OF TRANSPORT FOR COMMERCIAL USE

Any vessel (including lighters and barges, whether or not shipborne, and hydrofoils), hovercraft, aircraft, road vehicle (including trailers, semi-trailers and combinations of vehicles) or railway rolling stock, which is used for the transport of persons for remuneration or for the industrial or commercial transport of goods, whether or not for remuneration.

ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ ЗОРИУЛАЛТТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Хүмүүсийг төлбөртэй тээвэрлэх, эсхүл үйлдвэрлэлийн буюу худалдааны зориулалттай барааг төлбөртэй, эсхүл төлбөргүй тээвэрлэх зориулалтаар олон улсын тээвэрт ашиглаж буй аливаа хөлөг онгоц (үүнд өөрөө явдаг, эсхүл чирэгдэж явдаг лихтёр болон ачааны чирүүл онгоц, түүнчлэн нисдэг завь хамаарна), хийлсэн агаар дээр хөвөгч онгоц, агаарын хөлөг, автомашин (үүнд чиргүүл, хагас чиргүүл, мөн автомашины хослол хамаарна), эсхүл төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн.

Notes:
1. Customs formalities applicable to means of transport for commercial use are dealt with in Annex A.3. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex J, Chapter 3 of the revised Kyoto Convention. Those Annexes cover means of transport for commercial use which are used in international traffic.

The definition of "means of transport for commercial use" in those Annexes includes normal spare parts, accessories and equipment, as well as lubrication oils and fuel contained in the normal tanks, when carried with the means of transport for commercial use.
2. In some countries, the term "conveyance" is used with the same meaning as "means of transport for commercial use".
3. See Commentary 3 to Article 1, Annex C of the Istanbul Convention.

Жич:
1. Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэлд мөрдөх гаалийн ёс журмын ажиллагааны талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт А.3-т, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 3 дугаар бүлэгт заасан байдаг. Эдгээр хавсралтад барааны олон улсын хөдөлгөөнд ашигладаг худалдааны тээврийн хэрэгсэл хамаарна.

Эдгээр хавсралтын "худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэл" гэсэн тодорхойлолтод худалдааны тухайн тээврийн хэрэгсэлд авч яваа ердийн сэлбэг, туслах, дагалдах хэрэгсэл, мөн түлшний хэвийн саванд байгаа шатахуун болон тосолгооны материал хамаарна.
2. Зарим улс оронд "зөөх хэрэгсэл" гэдэг үгийг "худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэл" гэсэн утгаар хэрэглэдэг.
3. Стамбулын конвенцийн С хавсралтын 1 дүгээр зүйлийн Тайлбарын 3-ыг үз.

MEANS OF TRANSPORT FOR PRIVATE USE

Road vehicles and trailers, boats and aircraft, together with their spare parts and normal accessories and equipment, imported or exported exclusively for personal use by the person concerned and not for the transport of persons for remuneration or the industrial or commercial transport of goods, whether or not for remuneration.

Note:
Customs facilities applicable to means of transport for private use are dealt with in Annex F.3. to the Kyoto Convention of 1974 and in Specific Annex J, Chapter 1 of the revised Kyoto Convention. These Annexes cover private means of transport which are imported or exported by travellers.

ХУВИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Холбогдох этгээд зөвхөн хувийн хэрэглээнд зориулан оруулсан, эсхүл гаргасан автомашин болон чиргүүл, завь, нисэх онгоц, тэдгээрийн сэлбэг, ердийн дагалдах болон тоног хэрэгсэл. Хүмүүсийг төлбөртэй тээвэрлэх тээврийн хэрэгсэл, мөн үйлдвэрлэлийн, эсхүл худалдааны зориулалттай барааг төлбөртэй, эсхүл төлбөргүй тээвэрлэх тээврийн хэрэгсэл үүнд хамаарахгүй.

Жич:
Хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэлд холбогдох гаалийн таатай нөхцлийн талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт F.3-т, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 1 дүгээр бүлэгт заасан байдаг. Эдгээр хавсралтад зорчигчийн оруулсан, эсхүл гаргасан хувийн тээврийн хэрэгсэл хамаарна.

MEDICO-SANITARY INSPECTION

Inspections exercised for the protection of the life and health of persons, with the exception of veterinary inspection.
International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods, 1982, Chapter I

ЭМНЭЛЭГ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ (ШАЛГАЛТ)

Мал эмнэлгийн хяналтаас бусад, хүмүүсийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гүйцэтгэж буй хяналт (шалгалт).
Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он), 1 дүгээр бүлэг.

MFN – MOST-FAVOURED-NATION TREATMENT

Article I of the GATT 1994 requiring countries not to discriminate between goods on the basis of their origin or destination.

ҮНДЭСНИЙ НЭН ТААЛАМЖТАЙ НӨХЦӨЛ

Улс орнууд бараг хаанаас ирсэн (гарал үүсэл), эсхүл хаа хүрэхийг нь үндэслэн ялгаварлан гадуурхахгүй байхыг шаарддаг 1994 оны ТХЕХ-ийн I зүйл.

METHODS OF CUSTOMS VALUATION

The methods of Customs valuation of imported goods are defined in detail under the frame of the WTO. Article VII of GATT–1994 and the Agreement on the implementation of article VII of GATT–1994 provide for legal rules in this area.
[WTO/CUSVAL]

ГААЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГУУД

Импортын барааны гаалийн үнэлгээний аргуудыг ДХБ-ын хүрээнд дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг. Энэ чиглэлийн эрх зүйн үндсийг 1994 оны ТХЕХ-ийн VII зүйл, 1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт заасан байдаг.
[ДХБ/Гаалийн үнэлгээ]

MINIMUM BILL OF LADING (MIN. B/L)

A clause in a Bill of Lading which specifies the least charge that the carrier will make for issuing a lading. The charge may be a definite sum or the current charge per ton for any specified quantity.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ХАМГИЙН БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ТЭЭВРИЙН БАРИМТ

Тээвэрлэгч тээврийн баримт үйлдэхэд мөрдөх хамгийн бага төлбөрийг заасан тээврийн баримт дахь заалт. Энэ төлбөр нь тодорхой нэг мөнгөн дүн, эсхүл тодорхой нэг тоо хэмжээнд зориулан тонноор тогтоосон одоогийн төлбөр байж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MIXED CARGO

Two or more products carried on board of one ship
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ХОЛИМОГ АЧАА

Нэг усан онгоцны тавцан дээр тээвэрлэж буй хоёр буюу түүнээс дээш бүтээгдэхүүн.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MIXED CREDIT

Financing package in which concessional rate and market rate loans are combined.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ХОЛИМОГ ЗЭЭЛ

Зээлийн хөнгөлөлттэй хувь хэмжээ болон зах зээлийн хувь хэмжээг нэгтгэсэн санхүүгийн багц.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MODALITY

A way to proceed. In WTO negotiations, modalities set broad outlines – such as formulas or approaches for tariff reductions – for final commitments.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

АРГА ЗАМ

Тариф бууруулах арга зам. Энэ нь ДХБ-ын хэлэлцээнд тариф бууруулах томьёо буюу арга зам зэрэг ерөнхий зарчмыг тогтоож өгдөг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MODE OF TRANSPORT

Method of transport used for the carriage of goods and passengers.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ТӨРӨЛ

Бараа, зорчигч тээвэрлэхэд ашигладаг тээвэрлэлтийн арга.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MODEL LAW ON ELECTRONIC COMMERCE

This model law has been prepared in the framework of UNCITRAL in 1996. It establishes the legal norms and rules for the recognition of contracts developed using electronic means. It defines: the rules for resolving disputes on such contracts, the characteristics of the original document, rules for recognizing electronic signatures and their acceptability for any legal and administrative procedures. It establishes the admissibility of documents in electronic form for judicial and arbitration proceedings.
[UNCITRAL Model Law on Electronic Signatures 2001] [UNCITRAL/EDI]

ЦАХИМ ХУДАЛДААНЫ ЗАГВАР (ҮЛГЭРЧИЛСЭН) ХУУЛЬ

Энэхүү загвар (үлгэрчилсэн) хуулийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-оос 1996 онд боловсруулсан байдаг. Үүгээр цахим арга хэрэгсэл ашиглан байгуулсан гэрээг хүлээн зөвшөөрөх эрх зүйн хэмжээ болон дүрэм журмыг тогтоосон байдаг. Энэхүү загвар (үлгэрчилсэн) хуульд дараахь зүйлийг тодорхойлсон байдаг: тийм гэрээтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх дүрэм, жинхэнэ бичиг баримтын мөн чанар, цахим гарын үсгийг хүлээн зөвшөөрөх дүрэм, тэдгээрийг аливаа эрх зүйн болон захиргааны горим журмын ажиллагаанд хүлээн зөвшөөрөх тухай. Энэ нь цахим бичиг баримтыг шүүхийн болон арбитрын шүүн таслах үйл ажиллагаанд хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлдэг.
[НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим гарын үсгийн тухай загвар хууль, 2001 он] [ЮНСИТРАЛ/Өгөгдлийг цахимаар солилцох]

MONEY LAUNDERING

Money laundering is the process by which the illegal source of proceeds is concealed by means of financial transactions or any other means to make it appear legitimate.

МӨНГӨ УГААХ

“Мөнгө угаах” гэдэг нь орлогын хууль бус эх үүсвэрийг хууль ёсны мэт харагдуулах зорилгоор санхүүгийн гүйлгээний аргаар, эсхүл аливаа бусад аргаар нуун далдлах ажиллагаа болно.

MOST-FAVOURED-NATION PRINCIPLE

The most important legal principle on which WTO activities are based. In an expanded form, the MFN principle is contained in Article I of the GATT 1994 and in Article II of the GATS: "any advantage, favour, privilege or immunity granted by any contracting party to any product originating in or destined for any other country shall be accorded immediately and unconditionally to the like product originating in or destined for the territories of all other contracting parties."
[WTO/MFN]

ҮНДЭСНИЙ НЭН ТААЛАМЖТАЙ ЗАРЧИМ

ДХБ-ын үйл ажиллагааны үндэс болсон эрх зүйн хамгийн чухал зарчим. Үндэсний нэн тааламжтай зарчим нь өргөтгөсөн хэлбэрээрээ 1994 оны ТХЕХ-ийн I зүйл, Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн II зүйлд тус тус тусгагдсан байдаг: "хэлэлцэн тохирогч аливаа нэг талаас аль нэг өөр орноос гарал үүсэлтэй, эсхүл түүнд илгээж буй аливаа бараанд олгосон давуу тал, тааламжтай нөхцөл, дархан эрх, эсхүл эрх ямбыг хэлэлцэн тохирогч бүх талын нутаг дэвсгэрээс гаралтай, эсхүл эдгээр нутаг дэвсгэрт илгээж буй ижил бараанд нэн даруй, ямар нэг болзолгүйгээр олгоно."
[ДХБ/Үндэсний нэн тааламжтай нөхцөл]

MOST-FAVOURED-NATION TREATMENT

The principle of not discriminating between one's trading partners.
[GATT Article I] [GATS Article II] [TRIPS Article 4]

ҮНДЭСНИЙ НЭН ТААЛАМЖТАЙ НӨХЦӨЛ

Өөрийн худалдааны түншүүдээ үл ялгаварлах зарчим.
[ТХЕХ-ийн I зүйл] [Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн II зүйл] [Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрийн 4 дүгээр зүйл]

MULTIMODAL TRANSPORT

Carriage of goods by at least two different modes of transport. Kind of movement of cargo using various modes of transport, as well as handling services within a single system

ХОЛИМОГ ТЭЭВЭР

Наад зах нь тээврийн хоёр өөр төрөл (авто зам ба төмөр зам, эсхүл агаарын зам ба авто зам, эсхүл усан зам ба төмөр зам, г.м.)-ийг хослуулан барааг тээвэрлэх. Ачааг тээврийн хэрэгслийн янз бүрийн төрлийг ашиглан, мөн түүнчлэн нэг системийн хүрээнд барааг арчлан хамгаалах (зөөвөрлөх) үйлчилгээ ашиглан тээвэрлэх (хөдөлгөх).

MULTIMODAL TRANSPORT BILL OF LOADING /LADING

Negotiable document evidencing a contract for the performance and/or procurement of performance of multimodal transport and delivery of goods, the taking in charge of the goods by the multimodal transport operator and an undertaking by him to deliver the goods in accordance with the terms of the contract.

ХОЛИМОГ ТЭЭВРИЙН ТЭЭВРИЙН БАРИМТ

Холимог тээврээр бараа хүргэх гэрээ болох бичиг баримт. Энэ нь төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болно. Энэ гэрээний дагуу холимог тээврийн оператор барааг өөрийн мэдэлд хүлээн авч, холбогдох гэрээний дагуу хүргэж өгөх үүрэг хүлээдэг.

The document is issued by the Baltic and International Maritime Council, subject to the UNCTAD/ICC Rules for Multimodal Transport Documents.
[UNCTAD/ICC]

Энэ бичиг баримтыг Балтийн тэнгисмйн орнуудын болон Олон улсын тэнгисийн (далайн) зөвлөлөөс Холимог тээврийн бичиг баримтын тухай НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/Олон улсын худалдааны танхимын дүрмийн дагуу үйлддэг.
[НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/Олон улсын худалдааны танхим]

MULTIMODAL TRANSPORT DOCUMENT (MTD)

Document which evidences a multimodal transport contract, the taking in charge of the goods by the multimodal transport operator, and an undertaking by him to deliver the goods in accordance with the terms of the contract (in compliance with the International Convention on Multimodal Transport of Goods, not yet in force).
[UN/A_33_45]

ХОЛИМОГ ТЭЭВРИЙН БИЧИГ БАРИМТ

Холимог тээврээр бараа хүргэх гэрээ болох бичиг баримт. Энэ нь төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болно. Энэ гэрээний дагуу холимог тээврийн оператор барааг өөрийн мэдэлд хүлээн авч, холбогдох гэрээний нөхцөлийн дагуу (одоогоор хүчин төгөлдөр болоогүй байгаа Барааг холимог тээврээр тээвэрлэх тухай олон улсын улсын конвенцид заасны дагуу) хүргэж өгөх үүрэг хүлээдэг.
[НҮБ/A_33_45]

MULTIMODAL/COMBINED TRANSPORT DOCUMENT

Generic term: a transport document used when more than one mode of transportation is involved in the movement of cargo. It is a contract of carriage and receipt of the cargo for a multimodal transport. It indicates the place where the responsible transport company in the move takes responsibility for the cargo, the place where the responsibility of this transport company in the move ends and the conveyances involved.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХОЛИМОГ/ХОСОЛСОН ТЭЭВРИЙН БИЧИГ БАРИМТ

Нийтлэг ойлголт: ачаа хөдөлгөхөд нэгээс дээш төрлийн тээвэр оролцсон тохиолдолд ашигладаг тээврийн баримт. Энэ нь тээврийн гэрээ бөгөөд холимог тээврээр тээвэрлэх ачааг хүлээн авах баримт болно. Энэ нь тухайн ачааг ямар компани хаанаас хаа хүртэл хариуцан тээвэрлэсэн, мөн ямар тээврийн хэрэгсэл ашигласныг заана.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

MUTUAL ADMINISTRATIVE ASSISTANCE

Measures taken by a Customs administration on behalf of or in collaboration with another Customs administration for the proper application of Customs law and for the prevention, investigation and repression of Customs offences.

БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭНД ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

Гаалийн хууль тогтоомжийг зөв мөрдөх, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, таслан зогсоох зорилгоор гаалийн аль нэг байгууллага гаалийн нөгөө байгууллагын нэрийн өмнөөс, эсхүл түүнтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ.

N

NAIROBI CONVENTION (amended)

The expression commonly used to refer to the international Convention on mutual administrative assistance for the prevention, investigation and repression of Customs offences adopted by the Customs Co-operation Council in Nairobi in 1977.

НАЙРОБИЙН КОНВЕНЦ (Нэмэлт өөрчлөлт оруулсан)

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 1977 онд Найроби хотноо баталсан Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, таслан зогсооход байгууллагын хүрээнд харилцан туслах тухай олон улсын конвенцийн түгээмэл нэр.

NAMED INSURED

Party which benefits from insurance coverage. [UNTDED]

НЭР ЗААСАН ДААТГУУЛАГЧ

Даатгалын нөхөн төлбөрөөс ашиг хүртэгч тал.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

NAMING AND DESIGN RULES (IN XML) (NDR)

Technical Specification that describes and specifies the rules and guidelines that will be applied by UN/CEFACT when developing XML. This technical specification provides a way to identify, capture and maximize the re-use of business information expressed as XML schema components to support and enhance information interoperability across multiple business situations.
[UN/CEFACT/NDR]

НЭРЛЭХ БОЛОН ЗАГВАР ГАРГАХ ДҮРЭМ (XML-хувьд)

НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвөөс XML боловсруулахад хэрэглэх дүрэм, зааврыг тодорхойлж, тогтоодог техникийн тодорхойлолт. Энэхүү техникийн тодорхойлолт нь бизнесийн олон тохиолдолд мэдээллийн харилцан холбогдох боломжтой байдлыг дэмжиж, дээшлүүлэх зорилгоор XML схемийн бүрдэл хэсгүүд гэж нэрлэгдэх бизнесийн мэдээллийг таних, татах, дээд зэргээр дахин ашиглах замыг гаргаж өгдөг.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Нэрлэх болон загвар гаргах дүрэм]

NATIONAL CUSTOMS ENFORCEMENT NETWORK (nCEN)

A web-based, automated system developed by the World Customs Organization (WCO) to assist Customs administrations in collecting, storing and exchanging nominal data and information at national level.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

Үндэсний хэмжээнд тодорхой нэр, хаяг бүхий мэдээ, мэдээлэл цуглуулах, хадгалах, солилцоход гаалийн байгууллагад тус дөхөм болох зорилгоор ДГБ-аас хөгжүүлсэн, веб-д суурилсан автоматжуулсан систем.

NATIONAL TRADE AND TRANSPORT FACILITATION COMMITTEE (NTTFC)

National Trade Facilitation Body; PRO organization; National Trade Facilitation Committee. An NTFB is a formally constituted body where all public and private sector parties who are interested in the country's international trade, multimodal transport, transit, logistics, finance, agriculture, sanitary and phyto-sanitary requirements, health, electronic business and related topics can present their respective views and problems, and seek, through consultation and consensus, mutually agreeable solutions.
[UN/CEFACT/Rec. 4] [Art. 23.2 TFA]

ХУДАЛДАА, ТЭЭВРИЙГ ХӨНГӨВЧЛӨХ ҮНДЭСНИЙ ХОРОО

Худалдааг хөнгөвчлөх үндэсний байгууллага; PRO байгууллага; Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо. Худалдааг хөнгөвчлөх үндэсний байгууллага нь тухайн улсын олон улсын худалдаа, холимог тээвэр, дамжуулан өнгөрүүлэх ажиллагаа, ложистикийн үйл ажиллагаа, санхүү, хөдөө аж ахуй, амьтан, ургамлын хорио цээрийн шаардлага, эрүүл мэнд, цахим бизнес болон эдгээртэй хамаарал бүхий бусад үйл ажиллагаанд хамааралтай төрийн болон хувийн хэвшлийн бүх тал өөр өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж, бэрхшээлтэй асуудлаа танилцуулж, зөвлөлдөх болон харилцан зөвшилцөх замаар харилцан хүлээн авч болохуйц шийдэлд хүрэхийн төлөө явдаг албан ёсоор байгуулагдсан байгууллага юм.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв /Зөвлөмж №4] [Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 23 дугаар зүйлийн 2 дахь заалт]

Under the TFA, each WTO Member shall establish and/or maintain a national committee on trade facilitation or designate an existing mechanism to facilitate both domestic coordination and implementation of the provisions of the Agreement.
[WTO/TFA]

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн дагуу ДХБ-ын гишүүн бүр уг Хэлэлцээрийн заалтуудыг дотооддоо уялдуулан зохицуулж, хэрэгжүүлэх явдалд тус дөхөм үзүүлэх зорилгоор худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо байгуулах, мөн/эсхүл одоо байгаагаа үргэлжлүүлэн ажиллуулах, эсхүл одоо ажиллаж байгаа ямар нэгэн механизмыг тийм болгох ёстой.

NATIONAL TREATMENT

A regime of interstate economic relations in which, on the rights of reciprocity, one State grants in its territory to another State the same rights, preferences and privileges as are accorded to its own natural and legal persons and merchant vessels.
[art. III, para. 1 GATT 1994] [WTO/NT]

ҮНДЭСНИЙ НӨХЦӨЛ (ЗАРЧИМ)

Харилцан адил байх эрхийн үндсэн дээр нэг улс өөрийн улсын хувь хүн, хуулийн этгээд, худалдааны усан онгоцонд үзүүлдгийн адил эрх, хөнгөлөлт, эрх ямбыг нөгөө улсад өөрийн нутаг дэвсгэр дээр үзүүлдэг улс хоорондын эдийн засгийн харилцааны дэглэм юм.
[1994 оны ТХЕХ-ийн III зүйлийн 1 дүгээр заалт] [ДХБ/Үндэсний нөхцөл]

NEGOTIABLE BILL OF LADING

A document evidencing a transport contract between a buyer of transport services and the provider of transport services, who undertakes to deliver the goods in accordance with the terms of the contract. This document permits delivery of the goods to any person in possession of the original endorsed negotiable bill, which itself represents title to and control of the goods. In this case the final receiver of the goods may have changed from the originally specified consignee due to a sale of the goods during the transport process. As the ownership of the goods is controlled by the carrier and is not transferred to the final consignee until actual delivery, the negotiable bill of lading can also provide protective financial controls for the seller of the goods. An example is the Negotiable FIATA Multimodal Transport Bill of Lading (FIATA-FBL), which is subject to the UNCTAD/ICC Rules for Multimodal Transport Documents, see ICC Publication No 481.
(See also Non-negotiable Bill of Lading)
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БОЛОХ ТЭЭВРИЙН БАРИМТ

Тээврийн үйлчилгээний худалдаг авагч болон тээврийн үйлчилгээ үзүүлэгч хоёрын хооронд байгуулсан тээврийн гэрээ болох бичиг баримт. Тээврийн үйлчилгээ үзүүлэгч нь уг гэрээний нөхцөлийн дагуу барааг хүргэж өгөх үүрэг хүлээдэг. Энэхүү бичиг баримт нь холбогдох барааг жинхэнэ баталгаажуулсан төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн баримтыг эзэмшиж байгаа аливаа этгээдэд хүргэх боломж олгодог. Уг тээврийн баримт нь бас өөрөө тухайн барааг өмчлөх эрх, мөн түүнд хяналт тавих хэрэгсэл болдог. Энэ тохиолдолд хэрэв тухайн барааг тээвэрлэлтийн явцад худалдан борлуулсан бол түүнийг хүлээн авч буй эцсийн этгээд нэр заасан жинхэнэ хүлээн авагч байхаа болино. Тухайн барааны өмчлөх эрхийг тээвэрлэгч хянадаг бөгөөд уг эрх нь тухайн барааг эцсийн хүлээн авагчид бодитоор хүргэх хүртэл түүнд шилжихгүй тул энэхүү төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн баримт нь бас тухайн барааг худалдсан худалдагчийн хувьд санхүүгийн хамгаалалттай хяналтын хэрэгсэл болно. Үүний нэг жишээ бол Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбооны төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох холимог тээврийн тээврийн баримт (Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо-Уг холбооны тээврийн баримт) юм. Энэхүү тээврийн баримт нь Холимог тээврийн бичиг баримтын тухай НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/Олон улсын худалдааны танхимын дүрэмд нийцсэн байна. Олон улсын худалдааны танхимын хэвлэл № 481-ийг үз.
(Бас “Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) биш тээврийн баримт”-ыг үз)
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

NEGOTIABLE ELECTRONIC TRANSPORT RECORD

An electronic transport record:
(a) That indicates, by wording such as "to order", or "negotiable", or other appropriate wording recognized as having the same effect by the law applicable to the record, that the goods have been consigned to the order of the shipper or to the order of the consignee, and is not explicitly stated as being "non-negotiable" or "not negotiable"; and
(b) The use of which meets the requirements of Rotterdam Rules.
[Rotterdam Rules]

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БОЛОХ ТЭЭВРИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ

Дараах хэлбэрийн тээврийн цахим бүртгэл:
(a) "зааврын дагуу", эсхүл "эргэлтийн" г.м. үгс бичигдсэн, эсхүл тухайн бүртгэлд хамаарах хууль тогтоомжоор дээрх үгсийн адил утгатай болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд дараах утга бүхий өөр бусад зохих хэллэг ашигласан: тухайн барааг ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн зааврын дагуу, эсхүл хүлээн авагчийн зааврын дагуу ачуулсан, мөн "эргэлтийн бус" буюу "эргэлтийн хэрэгсэл болохгүй" гэж тодорхой заагаагүй; мөн
(b) түүнийг ашиглах нь Роттердамын дүрмийг шаардлагад нийцэж байгаа.
[Роттердамын дүрэм]

NEGOTIABLE FIATA MULTIMODAL TRANSPORT BILL OF LADING (FIATA-FBL)

Document which evidences a multimodal transport contract, the taking in charge of the goods by the multimodal transport operator and an undertaking by him to deliver the goods in accordance with the terms of the contract. The document can also be issued for unimodal sea transport from port to port. The document is issued by FIATA, subject to the UNCTAD/ICC Rules for Multimodal Transport Documents, ICC Publication No 481 [UNCTAD/ICC] [FIATA]

ТЭЭВЭР ЗУУЧДЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБООНЫ ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БОЛОХ ХОЛИМОГ ТЭЭВРИЙН ТЭЭВРИЙН БАРИМТ (Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо-Уг холбооны тээврийн баримт)

Холимог тээврийн гэрээ болох бичиг баримт. Энэ гэрээний дагуу холимог тээврийн оператор барааг өөрийн мэдэлд хүлээн авч, холбогдох гэрээний нөхцөлийн дагуу хүргэж өгөх үүрэг хүлээдэг. Энэ бичиг баримтыг бас боомтоос боомтын хооронд ачаа тээвэрлэдэг дан ганц далайн тээврийн төрөлд зориулан үйлдэж болно. Энэ бичиг баримтыг Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбооноос Холимог тээврийн бичиг баримтын тухай НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/Олон улсын худалдааны танхимын дүрэм, Олон улсын худалдааны танхимын хэвлэл № 481-ийн дагуу үйлддэг.
[НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/Олон улсын худалдааны танхим] [Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

NEGOTIABLE INSTRUMENT

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС БОЛОХ ХЭРЭГСЭЛ)

NON-NEGOTIABLE INSTRUMENT

ТӨЛБӨРИЙН БУС (ЭРГЭЛТИЙН БУС) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС БУС ХЭРЭГСЭЛ)

NEGOTIABLE TRANSPORT DOCUMENT

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БОЛОХ ТЭЭВРИЙН БИЧИГ БАРИМТ

A transport document that indicates, by wording such as “to order” or “negotiable” or other appropriate wording recognized as having the same effect by the law applicable to the document, that the goods have been consigned to the order of the shipper, to the order of the consignee, or to bearer and is not explicitly stated as being “non-negotiable” or “not negotiable”.
[Rotterdam Rules]

Дараах хэлбэрийн тээврийн цахим бүртгэл: “зааврын дагуу”, эсхүл “эргэлтийн” г.м. үгс бичигдсэн, эсхүл тухайн бүртгэлд хамаарах хууль тогтоомжоор дээрх үгсийн адил утгатай болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд дараах утга бүхий өөр бусад зохих хэллэг ашигласан: тухайн барааг ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн зааврын дагуу, эсхүл хүлээн авагчийн зааврын дагуу ачуулсан, мөн “эргэлтийн бус” буюу “эргэлтийн хэрэгсэл болохгүй” гэж тодорхой заагаагүй
[Роттердамын дүрэм]

NET WEIGHT

Weight (mass) of goods without any packaging.
[UNTDED] [UN/CEFACT/CCL]

ЦЭВЭР ЖИН

Аливаа сав боодолгүй (баглаа боодолгүй) барааны жин (масс)
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах] [НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан]

NON-AGRICULTURAL MARKET ACCESS (NAMA)

Topic of negotiations in the WTO.
[WTO/NAMA]

ХӨДӨӨ АЖ АХУЙН БУС ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ АСУУДАЛ

ДХБ-ын хэлэлцээний сэдэв.
[ДХБ/Хөдөө аж ахуйн бус зах зээлд нэвтрэх асуудал]

NON-AUTOMATIC LICENSING

Usually, a one-time permit to import or export goods. Such a license is issued by a regulatory body authorized to do so, at the request of the firm importing or exporting the goods. Such a license stipulates the main parties in the trade transaction, the quantity and value of the goods for which importation or exportation is permitted, the country of origin or destination of the goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)
See “Automatic Import Licensing”.

ИМПОРТЫН ШУУД БУС ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Ерөнхийдөө бараа оруулах, гаргах нэг удаагийн зөвшөөрөл. Ийм лицензийг түүнийг олгох эрх бүхий тохируулагч байгууллага, холбогдох барааг оруулдаг, эсхүл гаргадаг компанийн хүсэлтээр олгодог. Ийм лицензэд холбогдох худалдааны хэлцлийн үндсэн талууд, оруулахыг, эсхүл гаргахыг зөвшөөрсөн барааны тоо хэмжээ, үнэ, гарал үүслийн улс, эсхүл тухайн барааг хүргэх улсыг заасан байдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он).
“Импортын шууд лиценз олгох“ гэдгийг үз.

NON-COMMERCIAL PAYMENT

International settlements on non-commercial transactions executed at international prices and tariffs or at domestic retail prices and tariffs.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АРИЛЖААНЫ БУС ТӨЛБӨР

Олон улсын худалдааны үнэ болон тарифаар, эсхүл дотоодын жижиглэн худалдаалах үнэ болон тарифаар хийгдсэн арилжааны бус хэлцлийн улс хоорондын төлбөр тооцог барагдуулах.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

NON-DISCRIMINATION

Application of uniform terms of trade to all counterparties, goods and services.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮЛ ЯЛГАРВАРЛАХ

Хамтрагч бүх тал, бүх бараа, бүх үйлчилгээнд худалдааны нэг ижил нөхцөл мөрдөх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

NON-LINER TRANSPORTATION

Any transportation that is not liner transportation. [Rotterdam Rules]

(ТЭНГИСИЙН) ШУГАМЫН БУС ТЭЭВЭР

(Тэнгисийн) шугамын тээвэр бус аливаа тээвэр.
[Роттердамын дүрэм]

NON-NEGOTIABLE BILL OF LADING OF WAY BILL

Document which evidences a multimodal transport contract, the taking in charge of the goods by the multimodal transport operator, and an undertaking by him to deliver the goods in accordance with the terms of the contract. A non-negotiable bill of lading sets out a specific consignee to whom the goods are to be shipped, and does not itself represent ownership of the goods. An example is the Nonnegotiable FIATA Multimodal Transport Way Bill (FIATA-FWB), which is subject to the UNCTAD/ ICC Rules for Multimodal Transport Documents, see ICC Publication No 481.
(see also Negotiable Bill of Lading)

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БИШ ТЭЭВРИЙН БАРИМТ

Холимог тээврийн гэрээ болох бичиг баримт. Энэ гэрээний дагуу холимог тээврийн оператор барааг өөрийн мэдэлд хүлээн авч, холбогдох гэрээний нөхцөлийн дагуу хүргэж өгөх үүрэг хүлээдэг. Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) биш болох тээврийн баримтад тухайн барааг нэр дээр нь ачуулах тодорхой нэг хүлээн авагчийг заасан байх бөгөөд тухайн барааг өмчлөх эрхийн бичиг болохгүй. Үүний нэг жишээ бол Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбооны төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) биш болох холимог тээврийн тээврийн баримт (Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо-Уг холбооны тээврийн баримт) юм. Энэхүү тээврийн баримт нь Холимог тээврийн бичиг баримтын тухай НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/ Олон улсын худалдааны танхимын дүрэмд нийцсэн байна. Олон улсын худалдааны танхимын хэвлэл № 481-ийг үз.
(Бас “Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн баримт”-ыг үз)

NON-NEGOTIABLE ELECTRONIC TRANSPORT RECORD

An electronic transport record that is not a negotiable electronic transport record. [Rotterdam Rules]

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БИШ БОЛОХ ТЭЭВРИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ

Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн цахим бүртгэл биш болох тээврийн цахим бүртгэл. [Роттердамын дүрэм]

NON-NEGOTIABLE FIATA MULTIMODAL TRANSPORT WAY BILL (FIATA-FWB)

Document which evidences a multimodal transport contract, the taking in charge of the goods by the multimodal transport operator, and an undertaking by him to deliver the goods in accordance with the terms of the contract. The document can also be issued for unimodal sea transport from port to port. The document is issued by FIATA, subject to the UNCTAD/ICC Rules for Multimodal Transport Documents, ICC Publication No 481. [UNCTAD/ICC] [FIATA]

ТЭЭВЭР ЗУУЧДЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБООНЫ ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БИШ БОЛОХ ХОЛИМОГ ТЭЭВРИЙН ТЭЭВРИЙН БАРИМТ (Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо-Уг холбооны тээврийн баримт)

Холимог тээвэрээр бараа хүргэх гэрээ болох бичиг баримт. Энэ нь төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болно. Энэ гэрээний дагуу холимог тээврийн оператор барааг өөрийн мэдэлд хүлээн авч, холбогдох гэрээний дагуу хүргэж өгөх үүрэг хүлээдэг. Энэ бичиг баримтыг бас боомтоос боомтын хооронд ачаа тээвэрлэдэг дан ганц далайн тээврийн төрөлд зориулан үйлдэж болно. Энэ бичиг баримтыг Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбооноос Холимог тээврийн бичиг баримтын тухай НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/Олон улсын худалдааны танхимын дүрэм, Олон улсын худалдааны танхимын хэвлэл № 481-ийн дагуу үйлддэг. [НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД)/Олон улсын худалдааны танхим] [Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

NON-REPUDIATION

A service that provides proof of the integrity and origin of a data message or an authentication measure that can be asserted to be genuine with high assurance.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

МАРГААНГҮЙ (ҮЛ НЯЦААГДАХ) БАЙДАЛ

Мэдээлэл бүхий мессежийн бүрэн бүтэн байдал болон гарал үүслийг нотлох үйлчилгээ, эсхүл жинхэнэ гэдэгт маш итгэлтэй байх баталгаажуулалтын арга хэмжээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

NON-TARIFF BARRIERS (NTB)

These are measures that have trade-restrictive effects on trade in goods or services, but do not involve tariffs. These include technical barriers to trade and quantitative restrictions.

Non-tariff barriers, such as quotas, import licensing systems, sanitary regulations, prohibitions, etc. “Non-tariff measures” (NTMs) become trade barriers, if they: involve red tape/ complex procedures (example, trader is requested to present a lot of documentary requirements, instances of repetitive submissions); create confusion among traders on the meaning of the measure; are constantly changed by the Government; inflate transaction cost due to long waiting times, financial expenses or other reasons.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТАРИФЫН БУС СААД ТОТГОР

Эдгээр нь бараа, үйлчилгээний худалдааны хувьд худалдааг хязгаарлах нөлөө үзүүлдэг боловч тарифтай холбоогүй арга хэмжээ юм. Үүнд худалдааны техникийн саад тотгор болон тоон хязгаарлалт хамаарна.
Квот, импортын лицензийн систем, эрүүл ахуйн дүрэм журам, хориг г.м. тарифын бус саад тотгор. “Тарифын бус арга хэмжээ” нь дараах зүйлийг агуулж байвал худалдааны саад тотгор болно: хүнд суртал/нарийн төвөгтэй горим журам (жишээлбэл, худалдаа эрхлэгчээс маш олон бичиг баримт гаргаж өгөхийг хүсэх, бичиг баримтыг олон дахин гаргаж өгөхийг хүсэх); тодорхой нэг арга хэмжээ нь утга агуулгын хувьд худалдаа эрхлэгч нарыг төөрөгдөлд оруулах; тэдгээр арга хэмжээг төр, засгаас байнга өөрчилдөг; урт удаан хугацааны хүлээлт үүсгэсний улмаас, санхүүгийн зардал өссөнөөр, эсхүл өөр бусад шалтгаанаар хэлцлийн өртөг зардал нэмэгдэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

NON-TARIFF MEASURES

Trade policy measures other than ordinary customs tariffs that can potentially have an economic effect on international trade in goods, changing quantities traded, or prices or both. These may comprise any decisions by central and local authorities, including methods for implementing laws, regulations and other normative acts (other than customs and tariff measures) that affect the import and export of goods, the volume, the commodity structure of foreign trade, prices and the competitiveness of goods, creating more restrictive conditions for the trade in goods of foreign origin in comparison with national products, or creating different regimes for goods originating from different countries. NTMs, understood as defined by the UN-MAST (the Multi-Agency Support Team) classification, are an important tool for ensuring proper addressing of incidents of market failure.

ТАРИФЫН БУС АРГА ХЭМЖЭЭ

Гаалийн жирийн тарифаас өөр, барааны олон улсын худалдаанд эдийн засгийн нөлөөтэй байж болзошгүй худалдааны бодлогын арга хэмжээ. Эдгээр арга хэмжээнд дараах зүйл хамаарч болно: төв, орон нутгийн байгууллагын аливаа шийдвэр, түүний дотор хууль, дүрэм журам, хэм хэмжээ тогтоосон бусад актуудыг хэрэгжүүлэх зорилготой бөгөөд дараах зүйлд нөлөө үзүүлэх аргууд (гаалийн болон тарифын арга хэмжээнээс бусад): барааны импорт, экспорт, гадаад худалдааны хэмжээ болон барааны бүтэц, барааны үнэ болон өрсөлдөх чадвар, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад гадаадын гарал үүсэлтэй барааны худалдааг илүүтэйгээр хязгаарласан нөхцөл бий болгох, эсхүл өөр өөр улсын гарал үүсэлтэй бараанд өөр өөр дэглэм бий болгох. НҮБ-ын Олон агентлагын төлөөлөл бүхий туслах багаас гаргасан ангиллын дагуу ойлгогдох тарифын бус арга хэмжээ нь зах зээлийн уналтын асуудлыг зөв шийдэх чухал хэрэгсэл юм.

In general, NTMs are needed to fulfil the regulatory and procedural requirements for protecting the life or health of humans, animals or plants (sanitary and phytosanitary "SPS regulation); preserving the environment and wildlife; ensuring national security; and preventing deceptive and unfair practices. In cases where these measures are needed and justified, countries need to follow specific provisions to ensure compatibility with the World Trade Organization administered multilateral trading agreements.
[UN-MAST] [WTO/UR]

Тарифын бус арга хэмжээ нь ерөнхийдөө дараах зорилготой дүрэм журам болон горимын шаардлагыг хангахад хэрэг болдог: хүн, амьтан, эсхүл ургамлын амь нас буюу эрүүл мэндийг хамгаалах (амьтан, ургамлын хорио цээрийн (SPS) журам); хүрээлэн буй орчин болон зэрлэг амьтан, ургамлыг дархлан хамгаалах; үндэсний аюулгүй байдлыг хамгаалах; хууран мэхэлсэн болон шударга бус практикийг халах. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй бөгөөд үндэслэлтэй гэж үзвэл улс орнууд Дэлхийн худалдааны байгууллагын худалдааны олон талт хэлэлцээрүүдэд нийцсэн тодорхой заалтуудыг мөрдөх ёстой.
[НҮБ-ын Олон агентлагын төлөөлөл бүхий туслах баг] [ДХБ/Уругвайн үе шат]

NORMAL TANKS

The tanks designed by the manufacturer for all means of transport of the same type as the means of transport in question and whose permanent fitting enables a fuel to be used directly, both for the purpose of propulsion and, where appropriate, for the operation, during transport, of refrigeration systems and other systems. Tanks fitted to means of transport designed for direct use of other types of fuel and tanks fitted to the other systems with which the means of transport may be equipped shall also be considered to be normal tanks (Annex C of Istanbul Convention: Annex annex concerning means of transport).

ТҮЛШНИЙ ХЭВИЙН САВ

Үйлдвэрлэгч нь тухайн тээврийн хэрэгсэлтэй адил загварын бүх тээврийн хэрэгсэлд зориулан хийсэн, мөн хөдөлгүүр ажиллуулах болон зохистой бол тээвэрлэлтийн явцад хөргөлтийн систем болон өөр бусад систем ажиллуулах зорилгоор шатахуун шууд хэрэглэх боломжтой байдлаар хөдөлгөөнгүй суурилуулсан савыг хэлнэ. Өөр төрлийн шатахуун шууд хэрэглэх зорилгоор тээврийн хэрэгсэлд суурилуулсан сав, мөн тухайн тээврийн хэрэгсэлд тавьсан тэрхүү өөр бусад системд тохируулан суурилуулсан савыг түлшний хэвийн сав гэж үзнэ (Стамбулын конвенцийн Хавсралт B.9. – Хүмүүнлэгийн зорилгоор оруулах барааны тухай хавсралт).

NOTICE OF CIRCUMSTANCES PREVENTING DELIVERY (GOODS)

Request made by the carrier to the sender or the consignee, as the case may be, for instructions as to the disposal of the consignment when circumstances prevent delivery and the return of the goods has not been requested by the consignor in the transport document.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРГЭХЭД СААД БОЛЖ БУЙ ТОХИОЛДЛЫН ТАЛААР МЭДЭГДЭХ

Тээвэрлэгч ачаа хүргэх явцад саад учирсан бөгөөд тээврийн бичиг баримтад дурдсан бараа илгээгч уг ачааг буцаан авахыг хүсээгүй тохиолдолд холбогдох барааг илгээсэн этгээд, эсхүл бараа хүлээн авагч хоёрын аль боломжтойд нь мэдэгдэж, уг ачааг хэрхэн захиран зарцуулах талаар заавар авахаар тавьсан хүсэлт.
Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

NOTICE OF CIRCUMSTANCES PREVENTING TRANSPORT (GOODS)

Request made by the carrier to the sender or the consignee, as the case may be, for instructions as to the disposal of the goods when circumstances prevent transport before departure or en route, after acceptance of the consignment concerned.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ТЭЭВЭРЛЭХЭД СААД БОЛЖ БУЙ ТОХИОЛДЛЫН ТАЛААР МЭДЭГДЭХ

Тээвэрлэгч хэрэв холбогдох ачааг хүлээн авсаны дараа түүнийг тээвэрлэхийн өмнө, эсхүл тээвэрлэх явцад саад учирсан бол холбогдох барааг илгээсэн этгээд, эсхүл бараа хүлээн авагч хоёрын аль боломжтойд нь мэдэгдэж, уг ачааг хэрхэн захиран зарцуулах талаар заавар авахаар тавьсан хүсэлт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

NUMBER OF PACKAGES

Number of individual items packaged in such a way that they cannot be divided without first undoing the packing.
[UNTDED]

САВ БООДЛЫН ТОО

Баглаа боодлыг задлахгүйгээр хэсэглэн хуваах үл болох байдлаар савласан эд зүйл тус бүрийн тоо.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

O

OFFER

Written proposal of the seller or buyer to enter into a contract. The offer contains all the main conditions of the forthcoming transaction: name of the goods, quantity, quality, price, terms of delivery, delivery time, terms of payment, nature of packaging and packaging. There are two types of offer: firm and free.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОФЕРТ БУЮУ САНАЛ

Гэрээ байгуулахаар зорилготой худалдагчаас, эсхүл худалдан авагчаас бичгээр гаргасан санал. Оферт (санал) нь ирээдүйд байгуулах гэж буй хэлцлийн дараах үндсэн нөхцөлүүдийг агуулна: барааны нэр, тоо хэмжээ, чанар, үнэ, бараа нийлүүлэх (хүргэх) нөхцөл, бараа хүргэх хугацаа, төлбөрийн нөхцөл, сав боодлын шинж байдал, сав боодол (баглаа боодол). Оферт нь дараах хоёр хэлбэртэй байна: хатуу болон чөлөөтэй.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

OFFER/QUOTATION

(see also offer; quotation)
Document which, with a view to concluding a contract, sets out the conditions under which the goods are offered.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОФЕРТ БУЮУ САНАЛ/ҮНИЙН САНАЛ

(бас “оферт буюу санал”, “үнийн санал”-ыг үз)
Гэрээ байгуулах зорилгоор бараа санал болгож буй нөхцөлүүдийг заасан бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

OFFICE EN ROUTE

Customs office where goods are imported or exported in the course of a Customs transit operation.

Note:
Annex E.1. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex E, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ЗАМ ДАГУУХ ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА

Гаалийн дамжуулан өнгөрүүлэх ажиллагааны явцад бараа импортлох, эсхүл экспортлох гаалийн байгууллага.

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е.1, шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е-гийн 2 дугаар бүлэг.

OMISSION

Failure to act or give a decision required of the Customs by Customs law within a reasonable time on a matter duly submitted to them.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention

ЭС ҮЙЛДЭЛ

Гаалийн байгууллага түүнд зохих ёсоор тавьсан асуудлын дагуу гаалийн хууль тогтоомжоор шаардсан ёсоор, боломжтой хугацаанд нь амжиж арга хэмжээ аваагүй буюу ямар нэгэн шийдвэр гаргаагүй байх явдал.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг

ONE STOP BORDER POST

A border post operated by two neighbouring countries and requiring close cooperation in its daily management, the harmonization of requested documentation, the development of an enabling legal framework covering mutual recognition of controls and the exchange of data, joint maintenance of the infrastructure, joint use of expensive non-intrusive inspection equipment, and the operation by border agency officials on an extra-territorial basis when needed. Agreements on opening hours, informal information exchange and recognition of results of controls may be the first steps towards more integrated cooperation. One stop border post is the optimal form of cross-border cooperation at the local level, namely, a "joint border crossing"].
[UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms]

НЭГ ЗОГСОЖ (НЭГ ЗОГСОЛТООР) ХИЛ НЭВТРЭХ БООМТ

Хөрш хоёр улсаас ажиллуулж буй, дараах чиглэлээр хамтран ажиллахыг шаарддаг хилийн пост: уг постын өдөр тутмын менежмент, шаардлагатай бичиг баримтыг уялдуулах, хяналт шалгалтыг харилцан хүлээн зөвшөөрч, мэдээлэл солилцох асуудлыг хамарсан эрх олгосон эрх зүйн үндсийг боловсруулах, дэд бүтцийг хамтран засч сэлбэх, хяналт шалгалтын өндөр үнэтэй рентген (ачааг задлахгүй шалгах) тоног төхөөрөмжийг хамтран ашиглах, түүнчлэн шаардлагатай бол хилийн хяналтын албаны ажилтнууд хилийн цаана гарч ажиллах. Ажлын цаг, мэдээллийг албан бусаар солилцох, хяналт шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах нь илүү цогц байдлаар хамтран ажиллах эхний алхмууд байж болох юм. Нэг зогсож (нэг зогсолтоор) хил нэвтрэх боомт нь орон нутгийн түвшин дэх хил дамнасан хамтын ажиллагааны, тодруулбал "хил нэвтрэх хамтарсан цэг"-ийн оновчтой хэлбэр болно.
[Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт]

ONE-STOP-SHOP

A One-Stop-Shop is a physical location where multiple agencies have representative offices. An economic operator can perform all of their procedures (paper or electronic) within the same physical location. A One-StopShop, in this context, does not refer to the technical solution which allows one to process all information concerning a transaction; it refers to the physical location where multiple procedures can be fulfilled, allowing traders to avoid time consuming travel from one office to another.
[UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms]

НЭГ ЦЭГИЙН ДЭЛГҮҮР (ҮЙЛЧИЛГЭЭ)

Нэг цэгийн дэлгүүр (үйлчилгээ) гэдэг нь янз бүрийн агентлагууд өөрсдийн төлөөний ажилтнуудыг биетээр байршуулсан газар. Аль нэг аж ахуйн нэгж нь тэдгээр байгууллагын бүх горим журам (цаасан буюу цахим)-ыг тухайн нэг газар гүйцэтгэх боломжтой болно. Энд дурдсан нэг цэгийн дэлгүүр (үйлчилгээ) нь ямар нэг хэлцэлтэй холбогдсон бүх мэдээллийг нэг дор боловсруулах техникийн шийдэл биш юм; энэ нь худалдаа эрхлэгч нар нэг байгууллагаас нөгөөд очиж цаг алдахаас сэргийлж, олон янзын горим журмыг нэг дор гүйцэтгэх газар юм.
[Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт]

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ONLINE DISPUTE RESOLUTION (ODR)

A branch of dispute resolution which uses Internet and other technology to facilitate the resolution of disputes between parties. It primarily involves negotiation, mediation or arbitration.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

МАРГААНЫГ ОНЛАЙНААР ШИЙДВЭРЛЭХ

Талуудын хоорондын маргааныг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгоор интернэт болон өөр бусад технологи ашигладаг маргаан шийдвэрлэх нэг салбар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

OPEN DEVELOPMENT PROCESS (ODP)

Used in the development of UN / CEFACT standards and Best Practices recommendations. [UN/CEFACT]

СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ НЭЭЛТТЭЙ ПРОЦЕСС

НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн стандартууд болон шилдэг туршлага бүхий зөвлөмжүүдийг боловсруулахад ашигладаг.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв]

ORDER

Document by means of which a buyer initiates a transaction with a seller involving the supply of goods as specified, according to conditions set out in an offer, or otherwise known to the buyer.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ЗАХИАЛГА

Худалдан авагч худалдагчтай хэлцэл эхлүүлэх арга болгон үйлдсэн бичиг баримт. Энэ бичиг баримтад түүнд дурдсан барааг оферт (санал)-д заасан, эсхүл худалдан авагчийн мэддэг өөр бусад нөхцөлийн дагуу нийлүүлэх санал тусгагдсан байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ORIGINAL CONSIGNOR/ ORIGINAL SHIPPER

The party selling goods or services as stipulated in a sales order contract.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АНХНЫ ИЛГЭЭГЧ/АНХНЫ АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)

Бараа худалдах, худалдан авах захиалгын гэрээнд заасан бараа, үйлчилгээг худалдсан тал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ORIGINAL DISPATCH PARTY

The party from whom goods will be or have been originally shipped.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АНХНЫ ИЛГЭЭГЧ ТАЛ

Барааг эхэлж ачуулах, эсхүл анх ачуулсан тал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ORIGINATOR OF AN ELECTRONIC COMMUNICATION

A party by whom, or on whose behalf, the electronic communication has been sent or generated prior to storage, if any, but it does not include a party acting as an intermediary with respect to that electronic communication.
[UNCITRAL Electronic Communications Convention]

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙГ АНХ ИЛГЭЭГЧ БУЮУ БЭЛТГЭГЧ

Цахим мэдээллийг анх илгээсэн тал. Уг цахим мэдээллийг өөр этгээд түүний өмнөөс илгээсэн байж болно. Энэ тохиолдолд хэний өмнөөс илгээсэн тэр тал. Хэрэв уг цахим мэдээллийг хадгалахаас өмнө бэлтгэсэн бол тийнхүү бэлтгэсэн тал. Уг цахим мэдээлэлтэй холбогдуулан завсрын этгээдийн үүрэг гүйцэтгэж буй тал үүнд хамаарахгүй.
[НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим мэдээллийн (цахим харилцааны) тухай конвенц]

OTHER CHARGES, AMOUNT

Amount of specified individual charge or fee, other than weight and valuation charge for a consignment.
[UNTDED]

БУСАД ЗАРДЛЫН ДҮН

Тодорхой нэг зардал буюу хураамжийн дүн. Үүнд аль нэг ачааны жин буюу үнэлгээтэй холбогдсон зардал хамаарахгүй.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

OUTRIGHT EXPORTATION

Customs procedure applicable to goods which, being in free circulation, leave the Customs territory and are intended to remain permanently outside it.
Note:
Specific Annex C, Chapter 1 of the revised Kyoto Convention.

БҮРМӨСӨН ГАРГАХ

Чөлөөт эргэлтэд байгаад гаалийн нутаг дэвсгэрээс гарч, түүний гадна байнга үлдэх зорилготой барааны хамаарах гаалийн горим.
Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт С-гийн 1 дүгээр бүлэг.

OUTTURN REPORT

Written statement by a stevedoring company in which the condition of cargo discharged from a vessel is noted along with any discrepancies in the quantity compared with the vessel's manifest.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА БУУЛГАСАН ТУХАЙ ТАЙЛАН МЭДЭЭ

Ачаа буулгагч компанийн бичгээр гаргасан мэдэгдэл. Энэ мэдэгдэлд усан онгоцноос буулгасан ачааны нөхцөл байдлыг бичиж тэмдэглэсэн байна. Тухайн усан онгоцны манифесттай харьцуулахад тоо хэмжээний зөрөө гарсан бол түүнийг бас бичиж тэмдэглэсэн байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

OUTWARD PROCESSING

The Customs procedure under which goods which are in free circulation in a Customs territory may be temporarily exported for manufacturing, processing or repair abroad and then re -imported with total or partial exemption from import duties and taxes.

Note:
Specific Annex F, Chapter 2 of the revised Kyoto Convention.
[Art. 10.9.2(c) TFA]

ГАДААДАД БОЛОВСРУУЛАХ

Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа барааг гадаадад үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварт оруулахаар түр хугацаагаар гаргаж, дараа нь импортын гаалийн болон бусад татвараас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж буцаан оруулах гаалийн горим.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт F, 2 дугаар бүлэг.
[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 9.2(c)]

OVERLAND TRANSPORT

Transport or movement of goods on land, usually using road, rail or pipelines. [UNECE/ Glossary for Transport Statistics]

ХУУРАЙ ЗАМЫН ТЭЭВЭР

Барааг хуурай газраар тээвэрлэх буюу хөдөлгөх. Ерөнхийдөө автомашины зам, төмөр зам, эсхүл хоолой ашигладаг.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

P

PACKAGE

Boxes, containers or similar objects into which goods or groups of goods are put in order to be stored, transported, and/ or sold.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

САВ БООДОЛ (БАГЛАА БООДОЛ)

Барааг, эсхүл бүлэг барааг хадгалах, тээвэрлэх, мөн/эсхүл худалдан борлуулах зорилгоор хийх хайрцаг, чингэлэг, эсхүл тэдгээртэй адилтгах зүйл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PACKINGS

All articles and materials used, or to be used, in the state in which they are imported, to pack, protect, stow or separate goods, excluding packing materials such as straw, paper, glasswool, shavings, etc., when imported in bulk. Containers and pallets are also excluded.

Notes:
1. Temporary admission facilities for packings are dealt with in the Customs Convention on the temporary importation of packings, and in Annex B.3. to the Istanbul Convention.
2. The Convention on the valuation of goods for Customs purposes and the Agreement on Implementation of Article VII of the GATT 1994 (commonly referred to as the WTO Agreement on Customs Valuation) contains provisions dealing with the treatment of packings for valuation purposes.
3. General Rule 5 (b) for the Interpretation of the Harmonized System (International Convention on the Harmonized Commodity Description and Coding System) contains provisions on the tariff classification of packing materials and packing containers
4. In the case of specific duties and taxes, the weight of packings is included in the dutiable weight, gross weight or net weight, as the case may be.

БАГЛАА БООДОЛ

Барааг баглаж боох, хамгаалах, нийлүүлж, эсхүл салгаж савлах зорилгоор импортоор оруулсан байдлаар нь ашигласан, эсхүл ашиглах бүх төрлийн эд зүйл болон материал. Бөөнөөр нь оруулсан сүрэл, цаас, шилэн хөвөн, чигжээс зэрэг баглаа боодлын материал үүнд хамаарахгүй. Чингэлэг болон ачааны тавиур үүнд бас хамаарахгүй.

Жич:
1. Баглаа боодлыг түр хугацаагаар оруулах ажиллагааг хөнгөвчлөх талаар Баглаа боодлыг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенцид, мөн Стамбулын конвенцийн хавсралт B.3-т заасан байдаг.
2. Барааг гаалийн зорилгоор үнэлэх тухай конвенц болон 1994 оны ТХЕХ (ерөнхийдөө Гаалийн үнэлгээний тухай ДХБ-ын Хэлэлцээр гэдэг)-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт баглаа боодлыг үнэлгээний зорилгоор хэрхэн авч үзэх талаар заасан байдаг.
3. Уялдуулсан систем (Барааг тодорхойлох болон кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенц)-ийн Тайлбар дүрмийн 5 (b)-д баглаа боодлын материал болон боодлын савны тарифын ангиллын талаар заасан байдаг.
4. Биет хэмжигдэхүүнээр тогтоосон гаалийн болон бусад татварын хувьд баглаа боодлын жинг тухайн тохиолдлоос хамааруулан татвар тооцох жин, бохир жин, эсхүл цэвэр жингийн аль тохироход нь оруулан тооцдог.

PACKING INSTRUCTIONS

Document issued within an enterprise giving instructions on how goods are to be packed.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАГЛАА БООДЛЫН ЗААВАР

Барааг хэрхэн баглаж боох (савлах) тухай заавар бүхий, аль нэг аж ахуйн нэгж (үйлдвэрийн газар)-ын хүрээнд үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PACKING LIST

Document specifying the distribution of goods in individual packages
(UN/ECE/FAL)

БАГЛАА БООДЛЫН ЖАГСААЛТ

Сав боодол бүрт байгаа барааг тус бүрд нь жагсаасан баримт. (НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

PALLET

A device on the deck of which a quantity of goods can be assembled to form a unit load for the purpose of transporting it, or of handling or stacking it with the assistance of mechanical appliances. This device is made up of two decks separated by bearers, or of a single deck supported by feet; its overall height is reduced to the minimum compatible with handling by fork lift trucks or pallet trucks; it may or may not have a superstructure.

АЧААНЫ ТАВИУР

Барааг тээвэрлэх, эсхүл механик хэрэгслийн тусламжтайгаар өргөж буулгах, эсхүл овоолж хураах зорилгоор тодорхой тооны барааг багцалж, ачилтын нэг нэгж болгох зориулалттай тавцан бүхий төхөөрөмж. Энэ төхөөрөмж нь хөндөл модоор тусгаарлагдсан давхар тавцантай, эсхүл дан тавцантай, дороо хөлтэй хийгддэг; түүний ерөнхий өндөр нь по (ачаа өргөж, зөөх зориулалттай, урдаа сэрээтэй жижиг тэрэг)-гоор, эсхүл уг тавиурыг өргөж, тээвэрлэх тусгай зориулалтын тэргээр зөөвөрлөхөд тохиромжтой хэмжээнээс хэтрэхгүй байна; Ачааны тавиур нь хашлагатай, эсхүл хашлагагүй байж болно;

Note:
This item is defined in Annex B.3. to the Istanbul Convention.

Жич:
Энэ нэр томьёог Стамбулын Конвенцийн хавсралт B.3-т тодорхойлсон байдаг.

PARALLEL IMPORTS

When a product made legally (i.e. not pirated) abroad is imported without the permission of the intellectual property right-holder (e.g. the trademark or patent owner). Some countries allow this, others do not.

ЗЭРЭГЦЭЭ (ПАРАЛЛЕЛЬ) ИМПОРТ

Гадаадад хууль ёсны дагуу үйлдвэрлэсэн (өөрөөр хэлбэл, хууль бусаар буюу хулгайгаар (дуурианлган) үйлдвэрлээгүй) бүтээгдэхүүнийг оюуны өмчийн эрх эзэмшигч (жишээ нь, барааны тэмдэг эзэмшигч буюу патент эзэмшигч)-ийн зөвшөөрөлгүйгээр импортлох. Зарим улсад үүнийг зөвшөөрдөг бол зарим нь зөвшөөрдөггүй.

PARIS CONVENTION
Treaty, administered by the World Intellectual Property Organization (WIPO), for the protection of industrial intellectual property, i.e. patents, utility models, industrial designs, etc.

ПАРИСЫН КОНВЕНЦ
Аж үйлдвэрийн оюуны өмч, өөрөөр хэлбэл, патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, гэх мэтийг хамгаалах зорилгоор Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас хяналт тавин хэрэгжүүлж байгаа гэрээ.

PARTIAL RELIEF
Relief from payment of a part of the total amount of import duties and taxes which would otherwise be payable had the goods been cleared for home use on the date on which they were placed under the temporary admission procedure.
Note:
This term is defined in Annex E to the Istanbul Convention.

ТАТВАРААС ХЭСЭГЧЛЭН ЧӨЛӨӨЛӨХ
Түр хугацаагаар оруулах горимд байршуулсан өдөр дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар бүрдүүлэлт хийлгэсэн бол төлөх ёстой байсан импортын гаалийн болон бусад татварын зарим хэсгээс чөлөөлөх.
Жич:
Энэ нэр томьёог Стамбулын Конвенцийн хавсралт Е-д тодорхойлсон байдаг.

PART LOAD
A load that is carried as part of a larger load.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХЭСЭГ АЧАА
Арай том ачааны нэг хэсэг гэж тээвэрлэж буй ачаа.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PARTICULAR AVERAGE
Loss due to unintentional damage to the ship or cargo. Usually, the costs of a private accident are borne by the injured party or liable for causing losses.
[FIATA]

ХУВИЙН ЧАНАРТАЙ ОСОЛ (ХОХИРОЛ)
Усан онгоц буюу ачааны санаандгүй гэмтэл учруулсанаас үүдэлтэй хохирол. Хувийн чанартай ослын зардлыг үндсэндээ хохирогч тал өөрөө, эсхүл хохирол учруулсан хариуцагч этгээд төлдөг.
[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

PAYMENT INSTRUCTIONS
Text specifying the instructions for a payment.
[UNTDED]

ТӨЛБӨР ГҮЙЦЭТГЭХ ЗААВАР
Төлбөр гүйцэтгэх зааврын текст.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

PAYMENT ORDER
Document containing information needed to initiate the payment. It may cover the financial settlement for one or more commercial trade transactions.

A payment order is an instruction to the ordered bank to arrange for the payment of one specified amount to the beneficiary.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР
Төлбөр үйлдэхэд шаардагдах мэдээлэл агуулсан бичиг баримт. Энэ нь нэг буюу хэд хэдэн худалдааны хэлцлийн санхүүгийн төлбөр тооцоог хамарсан байж болно.
Төлбөрийн даалгавар нь тодорхой нэг мөнгөн дүнг төлбөр хүлээн авагч буюу нэхэмжлэгчид төлөх арга хэмжээ авахыг захиалгат банканд өгсөн заавар юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PENALTIES

Those imposed by a WTO Member's Customs administration for a breach of the WTO Member's Customs laws, regulations, or procedural requirements.
[Art. 6.3.1 TFA]

ШИЙТГЭЛ

ДХБ-ын гишүүн орны гаалийн хууль тогтоомж, дүрэм журам, горимын шаардлага зөрчсөн тохиолдолд ДХБ-ын гишүүн орны гаалийн байгууллагаас ногдуулдаг шийтгэл.
[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 6.3.1]

PERFORMING PARTY

A person other than the carrier that performs or undertakes to perform any of the carrier's obligations under a contract of carriage with respect to the receipt, loading, handling, stowage, carriage, care, unloading or delivery of the goods, to the extent that such person acts, either directly or indirectly, at the carrier's request or under the carrier's supervision or control. Performing party does not include any person that is retained, directly or indirectly, by a shipper, by a documentary shipper, by the controlling party or by the consignee instead of by the carrier.
[Rotterdam Rules]

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ

Тээвэрлэгчээс өөр, тээвэрлэгчийн хүсэлтээр, эсхүл тээвэрлэгчийн хараа, хяналтын дор холбогдох барааг хүлээж авах, ачих, зөөх (арчлан хамгаалах), усан онгоцны зооринд эмх цэгцтэй өрж ачих, тээвэрлэх, халамжлах, буулгах, эсхүл хүргэхтэй холбогдсон тээвэрлэгчийн аль нэг үүргийг тээврийн гэрээний дагуу шууд буюу шууд бус байдлаар тодорхой хэмжээнд гүйцэтгэж буй, эсхүл гүйцэтгэхээр үүрэг авсан этгээд. Гүйцэтгэгч талд тээвэрлэгчээс өөр ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн, гэрээт ачаа бэлтгэгч (ачигч компани)-ийн, хянагч талын, эсхүл ачаа хүлээн авагчийн шууд буюу шууд бус байдлаар хөлсөлсөн аливаа этгээд хамаарахгүй.
[Роттердамын дүрэм]

PERISHABLE FOODSTUFFS

Goods considered as perishable according to the Agreement on the International Carriage of Perishable Foodstuffs and on the Special Equipment to be used for such Carriage (ATP), 1970.
[UNECE/TRANS/ATP]

ТҮРГЭН МУУДДАГ ХҮНСНИЙ ЗҮЙЛ

Түргэн мууддаг хүнсний зүйлийг улс хооронд тээвэрлэх тухай болон тийм тээвэрт ашигладаг тусгай тоног төхөөрөмжийн тухай 1970 оны хэлэлцээрийн дагуу түргэн мууддаг гэж үзэх бараа.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/Тээвэр/ATP]

PERISHABLE GOODS

Goods that rapidly decay due to their natural characteristics, in particular in the absence of appropriate storage conditions.
The Analysis of Section I of the Trade Facilitation Agreement.

ТҮРГЭН МУУДДАГ БАРААА

Байгалийн төрх байдлаасаа, ялангуяа хадгалах нөхцөл байхгүйгээс түргэн (амархан) мууддаг бараа.
Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн I хэсгийн дүн шинжилгээ.

PERMITTED (PERMISSIBLE) SUBSIDIES

Subsidies not prohibited by the WTO Agreement on Subsidies and Countervailing Measures.
[WTO/SCM]

ЗӨВШӨӨРӨГДСӨН (ЗӨВШӨӨРЧ БОЛОХУЙЦ) ТАТААС

ДХБ-ын Татаас болон нөхөн төлөөсийн/саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрээр хориглоогүй татаас.
[ДХБ/Татаас болон нөхөн төлөөсийн/саармагжуулах арга хэмжээ]

PERSON

Both natural and legal persons, unless the context otherwise requires.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ЭТГЭЭД

Тухайн заалтад өөр утгаар хэрэглэгдээгүй бол хувь хүн болон хуулийн этгээдийн аль алин нь.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

PERSONAL EFFECTS

All articles (new or used) which a traveller may reasonably require for his or her personal use during the journey, taking into account all the circumstances of the journey, but excluding any goods imported or exported for commercial purposes.

Note:
Specific Annex J, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ХУВИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЭД ЗҮЙЛС

Зорчигчийн аяллын хугацаанд түүний хувийн хэрэглээнд шаардагдах (шинэ, эсхүл хуучин) бүх эд зүйлс. Үүнд тухайн аяллын нөхцөл байдлыг харгалзан үзэх бөгөөд арилжааны зорилгоор оруулсан, эсхүл гаргасан аливаа бараа хамаарахгүй.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J, 1 дүгээр бүлэг.

PHYTOSANITARY CERTIFICATE

Document issued by the competent body in the exporting country evidencing that plants, fruit, or vegetables are free from disease and fit for consumption and giving details on fumigation or other treatment to which they may have been subjected (UN/ECE/FAL)

УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ГЭРЧИЛГЭЭ

Ургамал, жимс, хүнсний ногоо нь өвчин эмгэггүй бөгөөд хэрэглэхэд тохиромжтой болохыг гэрчлэн, мөн утаж ариутгах буюу шаардлагатай бусад халдваргүйжүүлэх арга хэмжээ авсан талаар нарийвчилсан мэдээлэл агуулсан, экспортлогч улс дахь эрх бүхий байгууллагаас үйлдсэн бичиг баримт. (НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

PHYTOSANITARY INSPECTION

Inspection intended to prevent the spread and the introduction across national boundaries of pests of plants and plant products.
International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods, 1982, Chapter I

УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ (ШАЛГАЛТ)

Ургамал (хорт ургамал) болон ургамлын гаралтай бүтээгдэхүүний хортон шавж тархах, улсын хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналт (шалгалт).
Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он), 1 дүгээр бүлэг.

PICK LIST

A list, typically generated by a computer, of what items need to be picked to fulfil an order.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТҮҮВЭР ЖАГСААЛТ

Ерөнхийдөө компьютерын санамсаргүй сонголтоор гаргадаг, аливаа нэг захиалгыг биелүүлэхийн тулд ямар бараа түүвэрлэх тухай жагсаалт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PIGGY-BACK TRAFFIC

Combined road-rail transportation with the loading of motor vehicles on special railway platforms.
[FIATA]

КОНТРЕЙЛЕРЫН ТЭЭВЭР

Автомашиныг төмөр замын тусгай вагон (платформ) дээр ачсан байдаг авто зам-төмөр замын хосолсон тээвэр
[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

PILFERAGE

Partial loss of the contents of a package through theft.

ХУЛГАЙ (ЖИЖИГ ХУЛГАЙ)

Ямар нэгэн багцын агуулгыг хэсэгчлэн хулгайлах.

PIRACY

Unauthorized copying of materials protected by intellectual property rights (such as copyright, trademarks, patents, geographical indications, etc) for commercial purposes and unauthorized commercial dealing in copied materials.

ХУЛГАЙГААР (ДУУРАЙЛГАН) ХИЙХ

Оюуны өмчийн эрх (зохиогчийн эрх, барааны тэмдэг, патент, газарзүйн заалт гэх мэт)-ээр хамгаалагдсан материалыг арилжааны зорилгоор зөвшөөрөлгүй хуулбарлах (дуурианлган хийх), мөн хуулбарласан (дуурианал) материалыг зөвшөөрөлгүй худалдах.

PLACE OF BUSINESS

Any place where a party maintains a non-transitory establishment to pursue an economic activity other than the temporary provision of goods or services out of a specific location.
[UNCITRAL Electronic Communications Convention]

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАЗАР

Бараа, үйлчилгээг тодорхой нэг байршлаас түр хугацаагаар хангаж байгааг үл харгалзан аль нэг талын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй түр зуурын бус байгууллага байгаа газар.
[НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын Цахим мэдээллийн (цахим харилцааны) тухай конвенц]

PLACE OF DELIVERY

The place at which the cargo leaves the custody of the carrier under the terms and conditions of the transport contract.
[UNTDED]

АЧАА ХҮРГЭХ ГАЗАР

Ачаа холбогдох тээврийн гэрээнд заасан болзол, нөхцөлийн дагуу тээвэрлэгчийн мэдлээс гарч байгаа газар.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

PLACE OF ISSUE

The location where a document was issued and when appropriate, signed or otherwise authenticated.
[UNTDED]

БИЧИГ БАРИМТ ҮЙЛДСЭН ГАЗАР

Ямар нэг бичиг баримт үйлдсэн, шаардлагатай бол, түүнд гарын үсэг зурсан, эсхүл түүнийг баталгаажуулсан газар.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

PLACE OF LOADING

Seaport, airport, freight terminal, rail station or other place at which goods are loaded onto the means of transport being used for their carriage.
[UNTDED]

АЧАА АЧИХ ГАЗАР

Барааг түүнийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд ачих далайн боомт, нисэх онгоцны буудал, ачааны терминал, төмөр замын өртөө, эсхүл өөр бусад газар.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

PLACE OF TRANSHIPMENT

Name of a place where goods are to be or have been transferred from one means of transport to another during the course of one transport operation.
[UNTDED]

ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ГАЗАР

Барааг тээврийн нэг үйл ажиллагааны явцад нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шилжүүлэн ачих газар.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

PLACE/PORT OF DISCHARGE

Seaport, airport, freight terminal, rail station or other place at which goods are unloaded from the means of transport having been used for their carriage.
[UNTDED]

АЧАА БУУЛГАХ ГАЗАР/БООМТ

Барааг түүнийг тээвэрлэсэн тээврийн хэрэгслээс буулгах далайн боомт, нисэх онгоцны буудал, ачааны терминал, төмөр замын өртөө, эсхүл өөр бусад газар.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

PLACE/PORT OF LOADING/ LADING

The place in which the goods are loaded on a vehicle to be transported by it.
[UNECE/Glossary for Transport Statistics]

АЧАА АЧИХ ГАЗАР (АВТОМАШИН)

Барааг түүнийг тээвэрлэх автомашинд ачих газар.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

PLACE/PORT OF UNLOADING/ UNLADING

The place in which the goods are unloaded from a vehicle after being transported by it.
[UNECE/Glossary for Transport Statistics]

АЧАА БУУЛГАХ ГАЗАР/БООМТ (АВТОМАШИН)

Барааг түүнийг тээвэрлэсэн автомашинаас буулгах газар.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

PORT

Any location with permanent facilities at which vessels can load or discharge cargo moving in maritime traffic.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БООМТ

Далайн тээврээр тээвэрлэх ачааг усан онгоцонд ачих, эсхүл түүнээс буулгах, байнгын барилга байгууламж бүхий аливаа газар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PORT CHARGES DOCUMENTS

Documents specifying services rendered, storage and handling costs, demurrage and other charges due to the owner of goods described therein.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БООМТЫН ТӨЛБӨРИЙН БИЧИГ БАРИМТ

Түүнд заасан барааны эзэмшигч төлбөл зохих, үзүүлсэн үйлчилгээ, бараа хадгалсан болон арчлан хамгаалсан өртөг зардал, сул зогсолтын болон бусад хөлсийг заасан бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PORT COMMUNITY SYSTEM (PCS)

A Port Community System (PCS) usually defines itself as a neutral and open electronic platform enabling intelligent and secure exchange of information between public and private stakeholders in order to improve the competitive position of the sea and air ports' communities (sometimes referred to as Port User Groups). A PCS is usually associated with a single port (sea, air, inland or rail) or a multiple port environment within an economy.

It rganizat, manages and automates port and logistics processes through a single submission of data and connecting transport and logistics chains.
[UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms]

БООМТЫН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ СИСТЕМ

Боомтын мэдээлэл, харилцааны систем гэдгийг ихэвчлэн тухайн далайн боомт болон нисэх онгоцны буудлын нийгмийн бүлэг (заримдаа Боомт хэрэглэгчдийн баг гэдэг)-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, компанийн хооронд мэдээллийг ухаалаг, найдвартай аргаар солилцох боломж олгодог төвийг сахисан, нээлттэй цахим платформ гэж тодорхойлсон байдаг. Хэрэглэгчийн бүлгүүд).
Боомтын мэдээлэл, харилцааны систем нь ихэвчлэн аль нэг эдийн засгийн (улсын) хүрээнд нэг төрлийн боомтын орчинд (далайн, агаарын, гүний, эсхүл төмөр замын), эсхүл олон төрлийн боомтын орчинд холбогдсон байдаг. Энэ нь боомтын болон ложистикийн үйл ажиллагааг нэг шугамаар мэдээлэл дамжуулах замаар, мөн тээвэр, лижистикийн сүлжээг холбох замаар оновчтой болгож, удирдан зохион байгуулж, автоматжуулдаг.
[Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт]

PORT COMMUNITY SYSTEM OPERATOR

An rganization that is either public, private or public/private that operates and maintains a Port Community System and where the Port Community System represents the core of that rganization's business. It usually has a board, or some form of steering committee, consisting of representatives from different internal and external groups within the Port and Logistics community. It typically has "service level agreements" with PCS users to manage the electronic exchange of information between different parties on their behalf.
[IPCSA] [UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms]

БООМТЫН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ СИСТЕМИЙН ОПЕРАТОР

Боомтын мэдээлэл, харилцааны системийг ажиллуулдаг, мөн хөгжүүлдэг төрийн, хувийн, эсхүл төрийн/хувийн байгууллага. Түүний үйл ажиллагааны цөм нь Боомтын мэдээлэл, харилцааны систем болдог. Энэ байгууллага нь гол төлөв тухайн боомтын болон ложистикийн хамт олны хүрээнд доторх болон гаднах янз бүрийн бүлгийн төлөөллөөс бүрдсэн зөвлөл буюу зарим нэг хэлбэрийн удирдах хороотой байна. Боомтын мэдээлэл, харилцааны системийн оператор нь ерөнхийдөө Боомтын мэдээлэл, харилцааны систем хэрэглэгчдийн нэрийн өмнөөс янз бүрийн талуудтай мэдээллийг цахимаар солилцох ажлыг удирдан зохицуулах зорилгоор Боомтын мэдээлэл, харилцааны системийн хэрэглэгч нартай "үйлчилгээ үзүүлэх түвшний гэрээ" байгуулан ажилладаг.
[Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт]

PORT MARKS

An identifying set of letters numbers and/or geometric symbols followed by the name of the port of destination, which are placed on export shipments.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БООМТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Экспортын ачаан дээр ачаа хүлээн авах боомтын нэрийн өмнө тавьдаг хэд хэдэн үсэг, тоо болон/эсхүл геометрийн ялгах тэмдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PORT OF DISCHARGE (POD)

Port where vessel is off loaded and cargo discharges.

АЧАА БУУЛГАХ БООМТ

Усан онгоцыг суллаж, ачаа буулгах боомт
.

PORT OF ENTRY

A port at which foreign goods are admitted into the receiving country.

ОРОХ БООМТ

Гадаадын барааг хүлээн авах улсад оруулах боомт

PORT OF LOADING (POL)

Port where cargo is loaded aboard the vessel lashed and stowed.

АЧАА АЧИХ БООМТ

Усан онгоцонд ачаа ачиж, бэхлэн, дүүргэх боомт.

POST CLEARANCE AUDIT

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ

A systematic Customs control measure to ensure the accuracy and authenticity of declarations through the examination of the relevant books, records, business systems, and commercial data kept by persons/companies directly or indirectly involved in the international trade.

Олон улсын худалдаанд шууд, эсхүл шууд бусаар оролцож буй этгээд буюу компанийн холбогдох данс тооцоо, бүртгэл, бизнесийн (компьютерийн) систем, арилжааны мэдээ баримтыг шалгах замаар мэдүүлгийн үнэн, зөвийг тогтоох зорилготой гаалийн хяналтын системтэй (цэгцтэй) арга хэмжээ.

POSTAL ITEMS

Letter-post and parcels, as described in the Acts of the Universal Postal Union currently in force, when carried by or for postal services.

Note:
Specific Annex J, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ШУУДАН ИЛГЭЭМЖ

Дэлхийн шуудангийн холбооны одоо мөрдөж буй актуудад заасан, шуудангийн байгууллагын шугамаар, эсхүл түүний төлөө тээвэрлэж буй захидал болон илгээлт.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 2 дугаар бүлэг.

POSTAL PARCELS

Items called postal parcels within the meaning of the Acts of the
Universal Postal Union currently in force.

Note:
According to the Acts of the Universal Postal Union postal parcels are
required to be accompanied by a Customs declaration form CN22/CN23
Annex F.4. to the Kyoto Convention of 1974.

ШУУДАН ИЛГЭЭЛТ

Дэлхийн шуудангийн холбооны өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа актуудад “шуудан илгээлт” гэж нэрлэсэн зүйлс.

Жич:
Дэлхийн шуудангийн холбооны актуудад зааснаар шуудан илгээлтийг Гаалийн мэдүүлгийн маягт CN22/CN23 дагалдана.
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт F.4.

POSTAL SERVICE

A public or private body authorized by the government to provide the international services governed by the Acts of the Universal Postal Union currently in force.

Notes:
Specific Annex J, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ШУУДАНГИЙН БАЙГУУЛЛАГА

Дэлхийн шуудангийн холбооны одоо мөрдөж буй актуудаар зохицуулагдах олон улсын үйлчилгээг үзүүлэхээр засгийн газраас эрх авсан төрийн, эсхүл хувийн өмчийн байгууллага.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 2 дугаар бүлэг.

PRE-ARRIVAL CLEARANCE

Customs clearance before the arrival of the good.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

УРЬДЧИЛСАН БҮРДҮҮЛЭЛТ

Бараа ирэхээс өмнө хийгдэх гаалийн бүрдүүлэлт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PRE-ARRIVAL PROCESSING

Pre-arrival processing involves the (electronic) submission of the relevant goods or cargo declaration data to the relevant authorities prior to the arrival (for import) or prior to departure (for export) of goods. Authorities are then able to conduct risk assessment and to process the declaration with a view to prepare the release decision prior to the goods arriving at the port of entry/port of exit, thus enabling the release of the goods immediately upon arrival. This may include communicating the release decision to the persons concerned so that they can continue their supply chain and logistics planning.

Voluntary pre-arrival declaration and processing arrangements are the solution to expedite release. According to Standard 3.25 of the Revised Kyoto Convention (RKC), Customs shall allow the lodging and registering of goods declarations and supporting documents prior to arrival of goods.

At the same time, as stipulated by Standard 3.23 of the RKC, if Customs sets a time limit for lodging the goods declaration (even in a pre-arrival mode), the time allowed shall be sufficient to enable the declarant to complete the goods declaration and to obtain the supporting documents/information required. Art. 7.1.1 of the TFA: Each Member shall adopt or maintain procedures allowing for the submission of import documentation and other required information, including manifests, in order to begin processing prior to the arrival of goods with a view to expediting the release of goods upon arrival.

УРЬДЧИЛСАН БОЛОВРУУЛАЛТ/ БҮРДҮҮЛЭЛТ (БИЧИГ БАРИМТЫН БҮРДҮҮЛЭЛТИЙГ БАРАА ИРЭХЭЭС ӨМНӨ ХИЙЛГЭХ)

Урьдчилсан боловсруулалт/бүрдүүлэлт (бичиг баримтын бүрдүүлэлтийг бараа ирэхээс өмнө хийлгэх) гэж барааны буюу ачааны мэдүүлгийн мэдээллийг бараа ирэхээс өмнө (импортын хувьд), эсхүл бараа илгээхээс өмнө (экспортын хувьд) холбогдох эрх бүхий байгууллагад (цахимаар) хүргүүлэхийг хэлнэ. Ингэснээр эрх бүхий байгууллагууд эрсдэлийн тооцоо хийх, мөн орох буюу гаргах боомтод бараа ирэхээс өмнө олгох шийдвэрийг бэлэн болгох зорилгоор холбогдох мэдүүлгийг хянаж шалгах (боловсруулах) боломжтой болно. Ингэснээр бараа ирэх үед түүнийг шууд олгох боломжтой болно. Урьдчилсан бүрдүүлэлт гэдэгт уг олгох шийдвэрийг холбогдох этгээдүүдэд (урьдчилан) илгээх явдлыг хамруулж болно. Ингэснээр тэд бараа нийлүүлэх сүлжээ болон ложистикийн ажлын төлөвлөгөөгөө үргэлжлүүлэн боловсруулах боломжтой байх болно. Бараагаа ирэхээс нь өмнө сайн дураараа мэдүүлж, бичиг баримтын бүрдүүлэлт хийлгэх нь бараа олгох явдлыг түргэсгэх нэг шийдэл юм. Шинэчилэн найруулсан Киотогийн конвенцийн стандарт 3.25-ын дагуу гаалийн байгууллага бараа ирэхээс өмнө тухайн барааны мэдүүлэг болон хавсралт бичиг баримтыг нь гарган өгч, бүртгүүлэх явдлыг зөвшөөрөх ёстой байдаг. Үүний зэрэгцээ, шинэчилэн найруулсан Киотогийн конвенцийн стандарт 3.23-т заасны дагуу хэрэв гаалийн байгууллага барааны мэдүүлэг гаргаж өгөх (бараа ирэхээс өмнөх горимд ч гэсэн)-д хугацаа тогтоосон бол уг хугацаа нь мэдүүлэгч барааны мэдүүлэг бөглөх, түүнд хавсаргах шаардлагатай бичиг баримт/ мэдээллийг олж авахад хангалттай байвал зохино. Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 1.1: Гишүүн бүр бараа ирмэгц түүнийг олгох явцыг түргэсгэх үүднээс импортын бичиг баримт болон шаардлагатай бусад мэдээлэл, түүний дотор манифестыг бичиг баримтын бүрдүүлэлтийг бараа ирэхээс өмнө эхлүүлэх зорилгоор гаргаж өгөх боломжтой байх журам баталж, эсхүл тийм журамтай бол түүнийгээ үргэлжлүүлэн мөрдөнө.

PRE-CARRIAGE BY

Transportation of goods from the place where they are received to the place where they are loaded onto the main means of their transportation by the carrier.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААГ АЧУУЛАХ ГАЗАР ХҮРТЭЛ ТЭЭВЭРЛЭХ

Бараг хүлээж авсан газраас тээвэрлэгч түүнийг улс хооронд тээвэрлэх үндсэн тээврийн хэрэгсэлд ачуулах газар хүртэл тээвэрлэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PRECURSOR

A substance containing ephedrine or pseudoephedrine used in the manufacture of methamphetamine.

УГТВАР БОДИС

Метамфетамин үйлдвэрлэхэд ашигладаг эфедрин буюу псевдоэфедрин агуулсан бодис.

PREFERENTIAL TARIFFS

Tariffs lower than those that a country usually applies for the importation of a good, granted to one or more countries when they belong to a certain geographical area, a free trade area, a customs union or a group with specific characteristics, such as “developing countries” and “least developed countries.

ХӨНГӨЛӨЛТТЭЙ ТАРИФ

Ямар нэг бараа импортлоход ихэвчлэн мөрддөг тарифаас доогуур хувь хэмжээтэй, газарзүйн тодорхой нэг бүс, чөлөөт худалдааны бүс, гаалийн холбоонд хамаардаг нэг буюу хэд хэдэн улсад, эсхүл “хөгжиж буй орнууд” болон “буурай хөгжилтэй орнууд” гэх мэт онцлог шинжтай бүлэгт олгодог тариф.

PREFERENTIAL TRADE ARRANGEMENTS (PTAS)

This is the term used in the WTO for trade preferences, such as lower or zero tariffs, which a member may offer to a trade partner unilaterally. These include the Generalized System of Preferences schemes, under which developed countries grant preferential tariffs to imports from developing countries.

ХУДАЛДААНЫ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗОХИЦУУЛАЛТУУД

Энэ нь ДХБ-ын аль нэг гишүүн худалдааны аль нэг түншдээ дангаараа олгож болох арай бага буюу тэг хувьтай тариф зэрэг худалдааны хөнгөлөлтийн тухайд ДХБ-д ашигладаг нэр томьёо юм. Үүнд Хөнгөлөлтийн ерөнхий систем хамаарна. Энэ системийн дагуу хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудаас импортлох бараанд хөнгөлөлттэй тариф мөрддөг.

PREPAID FREIGHT

Note in the transport document indicating that freight is prepaid in the port of loading.

УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРТ ТЭЭВЭР

Тээврийн зардлыг ачих боомтод урьдчилан төлсөн болохыг зааж тээврийн баримтад хийсэн тэмдэглэгээ.

PRESHIPMENT INSPECTION (PSI)

The practice of employing specialized private companies to check shipment details of goods ordered overseas — i.e. price, quantity, quality, etc.

АЧИЛТЫН ӨМНӨХ ШАЛГАЛТ

Гадаадаас захиалсан барааны ачилтын тухай дэлгэрэнгүй мэдээлэл – өөрөөр хэлбэл, үнэ, тоо хэмжээ, чанар гэх мэтийг мэргэшсэн хувийн компаниудыг хөлслөн шалгуулдаг практик.

PRICE UNDERTAKING

Undertaking by an exporter to raise the export price of the product to avoid the possibility of an anti-dumping duty.

ҮНЭЭ НЭМЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Экспортлогч демпингийн эсрэг татвар ногдуулахаас зайлсхийх зорилгоор бүтээгдэхүүнийхээ экспортын үнийг нэмэх үүрэг амлалт авах.

PRIMA FACIE

Latin, “on first appearance”. A term frequently encountered in foreign trade. When a steamship company issues a Clean Bill of Lading, it acknowledges that the goods were received “in apparent good order and condition” and this is said by the courts to constitute prima facie evidence of the conditions of the containers; that is, if nothing to the contrary appears, it must be inferred that the cargo was in good condition when received by the carrier.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

PRIMA FACIE

Латин хэллэг: “анх харахад”. Энэ нэр томьёо нь гадаад худалдааны үйл ажиллагаанд байнга тохиолддог. Хэрэв (уурын) усан онгоцны компани “тээврийн цэвэр баримт” үйлдсэн бол тухайн барааг “эвдрэл гэмтэлгүй, бүрэн бүтэн” байдалтайгаар хүлээж авсан гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа хэрэг болно. Үүнийг шүүхээс тухайн чингэлгийн нөхцөл байдлыг prima facie гэрчлэх баримт гэж үздэг; өөрөөр хэлбэл, хэрэв үүнийг няцаах өөр баримт байхгүй бол тухайн ачааг тээвэрлэгч “эвдрэл гэмтэлгүй, бүрэн бүтэн” хүлээж авсан гэж ойлгоно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PRINCIPAL

Person, in relation to whom another person is acting as an agent.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ҮНДСЭН ЭТГЭЭД

Өөр нэг этгээдийг агентаар ажиллуулж буй этгээд.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PRIVATE KEY

In public-key cryptography, the private key is a key (string of characters) used for decryption and signing which is private to the users.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУВИЙН (ХААЛТТАЙ) ТҮЛХҮҮР

Нийтийн (нээлттэй) түлхүүрийн криптографын хүрээнд хувийн (хаалттай) түлхүүр гэдэг нь код тайлахад болон гарын үсэг зурахад ашигладаг, хэрэглэгч нарын хувьд хувийн чанартай түлхүүр (тэмдэгтүүдийн жагсаалт) юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PROCESSING OF GOODS FOR HOME USE

The Customs procedure under which imported goods may be manufactured, processed or worked, before clearance for home use and under Customs control, to such an extent that the amount of the import duties and taxes applicable to the products thus obtained is lower than that which would be applicable to the imported goods.

Note:
Specific Annex F, Chapter 4 of the revised Kyoto Convention.

БАРААГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАН ОРУУЛАХААР БОЛОВСРУУЛАХ

Импортын барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаас өмнө гаалийн хяналтын дор үйлдвэрлэл, боловсруулалт буюу дахин боловсруулалтад оруулж, тийнхүү гаргаж авсан бүтээгдэхүүнд хамаарах импортын гаалийн болон бусад татварын хэмжээг тухайн импортын бараанд хамаарах татварын хэмжээнээс багасгаж болох гаалийн горим.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт F-ийн 4 дүгээр бүлэг, Chapter 4.

PRODUCT

Any tangible output or service produced by human or mechanical effort or by a natural process for trade purposes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БҮТЭЭГДЭХҮҮН

Худалдааны зорилготой, хүний буюу механик хүчин чармайлтаар, эсхүл байгалийн процессын явцад бүтээгдсэн аливаа материаллаг үр дүн буюу үйлчилгээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PRODUCT INSTANCE

An individual trade product or batch of similar trade products produced by human or mechanical effort or by a natural process.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОДИТ ЗАГВАР

Хүний буюу механик хүчин чармайлтаар , эсхүл байгалийн процессын явцад бүтээгдсэн худалдааны нэг бүтээгдэхүүн буюу түүнтэй адилтгах худалдааны багц (бөөм) бүтээгдэхүүн.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PRODUCTION OF GOODS TO THE CUSTOMS

The act of presenting goods to the competent Customs authorities, at the place designated or accepted by them, for completion of the Customs formalities.

Note:
The production of goods to the Customs is itself one of the Customs formalities.

БАРААГ ГААЛИЙН БАЙГУУЛЛАГАД ГАРГАЖ ҮЗҮҮЛЭХ

Гаалийн ёс журмын ажиллагааг гүйцэлдүүлэх зорилгоор, барааг эрх бүхий гаалийн байгууллагад түүнээс тогтоосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн газарт гаргаж үзүүлэх үйлдэл.

Жич:
Барааг гаалийн байгууллагад гаргаж үзүүлэх нь өөрөө гаалийн ёс журмын нэг ажиллагаа болно.

PROFESSIONAL EQUIPMENT

Equipment necessary for the exercise of the calling, trade or profession of a person who enters a country to exercise his or her profession in that country.

Notes:
1. This equipment includes the equipment set out in the illustrative lists in:
(a) Annexes A, B and C to the Customs Convention on the temporary importation of professional equipment, Brusssels,1961;
(b) Annex B.2 to the Istanbul Convention, 1990.
2. In countries where the ATA system is applied, ATA carnets are as a rule accepted for the temporary admission of professional equipment.

МЭРГЭЖЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Тухайн улсад өөрийн мэргэжлийн дагуу ажил үүрэг гүйцэтгэхээр аль нэг улсад нэвтэрч байгаа этгээдийн өөрийн дур сонирхолтой ажлаа эрхлэх, гар урлалын ажил эрхлэх, эсхүл мэргэжлийнхээ ажлыг эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж.

Жич:
1. Энэ тоног төхөрөмжид дараах хавсралтуудад жишээ болгон жагсаасан тоног төхөрөмж хамаарна:
(a) 1961 онд Брюссель хотноо батлагдсан Мэргэжлийн тоног төхөөрөмжийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенцийн хавсралт А, В, С;
(b) 1990 оны Стамбулын конвенцийн хавсралт В.2.
2. АТА карнейн систем үйлчилдэг улсуудад мэргэжлийн тоног төхөөрөмжийг түр хугацаагаар оруулахад зарчмын хувьд АТА карнейг хүлээн зөвшөөрдөг.

PROFORMA INVOICE

Document serving as a preliminary invoice, containing - on the whole - the same information as the final invoice, but not actually claiming payment. (UN/ECE/FAL)

УРЬДЧИЛСАН НЭХЭМЖЛЭХ

Урьдчилсан нэхэмжлэх гэсэн бичиг баримт. Энэ нь - үндсэндээ - эцсийн нэхэмжлэхтэй ижил мэдээлэл агуулсан байдаг боловч төлбөрийг жинхэнээсээ нэхэмжлээгүй байдаг. (НҮБ/Европын эдийн засгийн комисс/ Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

PROHIBITIONS OF GOODS (PROHIBITED GOODS)

Goods whose importation or exportation is prohibited by law.

БАРААГ ХОРИГЛОХ (ХОРИГЛОСОН БАРАА)

(Хилээр) оруулахыг, эсхүл гаргахыг хууль тогтоомжоор хориглосон бараа.

PROHIBITED GOODS

Goods whose importation or exportation is prohibited

ХОРИГЛОСОН БАРАА

(Хилээр) оруулахыг, эсхүл гаргахыг хориглосон бараа.

PROOF OF DELIVERY

Delivery document - receipt signed by the consignee upon delivery.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРГЭЖ ӨГСӨН БАРИМТ (ТАСАЛБАР)

Бараа хүргэж өгсөн баримт– бараа хүргэсэн даруйд бараа хүлээн авагч гарын үсэг зурсан баримт (тасалбар).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PUBLICATION

Access to information about the legal framework and procedures in place is a critical element in establishing a transparent and predictable environment for international trade and for improving Customs compliance. Publication of relevant laws and regulations, as well as any changes to these, must be published in good time prior to entry into force. This information needs to be diffused by various means. Standard 9.1. of the Revised Kyoto Convention (RKC) requires Customs administrations to make readily available all relevant information of general application (such as Customs laws and regulations, forms, and tariffs). Ideally, this information should be on the internet.

(ХЭВЛЭН) НИЙТЛЭХ

Тухайн үед мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын талаарх мэдээлэлд нэвтрэх боломжтой байх нь олон улсын худалдааны орчин ил тод, урьдчилан тааварлах боломжтой байх явдлыг бүрдүүлэх, мөн гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг (хууль сахилтыг) дээшлүүлэх нэг чухал элемент юм. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, мөн түүнчлэн тэдгээрт оруулсан аливаа өөрчлөлтийг тэдгээр нь хүчин төгөлдөр болохоос тодорхой хугацааны өмнө (хэвлэн) нийтэлсэн байх ёстой. Ийм мэдээллийг янз бүрийн аргаар түгээх хэрэгтэй байдаг.

Шинэчлэн найруулсан Киотогийн Конвенцийн стандарт 9.1-д гаалийн байгууллагууд нийтлэг хэрэглээний холбогдох бүх мэдээлэл (гаалийн хууль, дүрэм журам, маягт болон тариф, гэх мэт) –ийг нийтэд ил байлгахыг шаарддаг. Хамгийн боловсронгуй нь гэвэл ийм мэдээлэл интернетэд байх ёстой.

PUBLICATION AND AVAILABILITY OF INFORMATION

Information to be published in a non-discriminatory and easily accessible manner in order to enable governments, traders, and other interested parties to become acquainted with them as defined in the TFA.

[Art.1.1 TFA]

МЭДЭЭЛЛИЙГ ХЭВЛЭН НИЙТЛЭХ БОЛОН ХҮРТЭЭЛТЭЙ БОЛГОХ

Засгийн газрууд, худалдаа эрхлэгч нар болон сонирхогч бусад талууд танилцсан байх боломжийг бүрдүүлэх зорилгоор үл ялгаварласан бөгөөд хялбар хүртээлтэй байх арга хэлбэрээр хэвлэн нийтэлсэн байх мэдээлэл

[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 1.1]

PUBLIC KEY

In public-key cryptography, the public key (string of characters) is used for encryption and verifying the authenticity of electronic signatures and it is known to the public.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НИЙТИЙН (НЭЭЛТТЭЙ) ТҮЛХҮҮР

Нийтийн (нээлттэй) түлхүүрийн криптографын хүрээнд нийтийн (нээлттэй) түлхүүр гэдэг нь код тайлахад болон цахим гарын үсгийн үнэн зөвийг шалгахад ашигладаг, нийтэд тараагдсан түлхүүр (тэмдэгтүүдийн жагсаалт) юм.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PUBLIC KEY INFRASTRUCTURE (PKI)

A specific system of digital certificates, certificate servers and Certification Authorities based on public key cryptography technologies.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НИЙТИЙН (НЭЭЛТТЭЙ) ТҮЛХҮҮРИЙН ДЭД БҮТЭЦ

Нийтийн (нээлттэй) түлхүүрийн криптографын технологид суурилсан, дижитал гэрчилгээ, магадлан итгэмжлэгдсэн сервер, гэрчилгээ олгогч байгууллагын тусгайлсан систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PUBLIC-PRIVATE PARTNERSHIPS

A public service or private business venture which is managed and funded through a partnership of the government and at least one private sector company.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

Загийн газар болон хувийн хэвшлийн дор хаяж нэг компанийн түншлэлээр дамжуулан удирдан зохион байгуулж, санхүүжүүлдэг төрийн үйлчилгээ, эсхүл хувийн бизнесийн хамтарсан үйлдвэр.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PURCHASE

In foreign trade: the acquisition of goods and services abroad for the purpose of import into the country and sale on its domestic market.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДАН АВАХ

Тухайн улсад оруулж, түүний дотоодын зах зээлд борлуулах зорилгоор гадаадаас бараа, үйлчилгээ худалдан авах.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PURCHASE ORDER

Document issued within an enterprise to initiate the purchase of articles or materials required for the production or manufacture of goods to be offered for sale or otherwise supplied to customers.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА

Худалдан борлуулах санал тавих, үгүй бол үйлчлүүлэгч нартаа нийлүүлэх зорилготой барааг боловсруулах буюу үйлдвэрлэхэд шаардагдах эд зүйл, материалыг худалдан авахын тулд аль нэг аж ахуйн нэгж (үйлдвэрийн газар)-ын хүрээнд үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

PURCHASE ORDER

Document issued within an enterprise to initiate the purchase of articles or materials required for the production or manufacture of goods to be offered for sale or otherwise supplied to customers.
(UN/ECE/FAL)

ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА

Худалдан борлуулах санал тавих, үгүй бол үйлчлүүлэгч нартаа нийлүүлэх зорилготой барааг боловсруулах буюу үйлдвэрлэхэд шаардагдах эд зүйл, материалыг худалдан авахын тулд аль нэг аж ахуйн нэгж (үйлдвэрийн газар)-ын хүрээнд үйлдсэн бичиг баримт. (НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

Q

QUALITY CONTROL

Any control other than those referred to above to ensure that the goods correspond to the minimum international or national definitions of quality specified by relevant laws and regulations.
International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods, 1982, Chapter I

ЧАНАРЫН ХЯНАЛТ

Бараа нь холбогдох хууль тогтоомж, журмаар тогтоосон чанарын олон улсын, эсхүл дотоодын наад захын үзүүлэлтийг хангуулах зорилгоор хийж буй, дээр дурдсанаас ялгагдах бусад аливаа хяналт.
Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он), 1 дүгээр бүлэг.

QUANTITATIVE QUOTA

Any pre-set quantity, authorized for importation or exportation of given goods, during a specified period, beyond which no additional quantity of these goods can be imported or exported.

ТОО ХЭМЖЭЭНИЙ КВОТ

Тодорхой барааг тогтоосон хугацаанд багтаан оруулах, эсхүл гаргахыг зөвшөөрч, урьдчилан тогтоосон аливаа тоо хэмжээ. Тухайн тоо хэмжээнээс хэтэрсэн барааг оруулж, эсхүл гаргаж болохгүй.

QUANTITATIVE RESTRICTIONS (QRS)

These are trade measures that impose a quantitative limit or cap on the importation or exportation of specific goods. It includes import or export bans or embargoes, quotas, non-automatic licensing requirements, and voluntary export restraints. Explicit limits, or quotas, on the physical amounts of particular commodities that can be imported or exported during a specified time period, usually measured by volume but sometimes by value. This is a measure of the operational regulation of foreign economic relations by the state, which acts as a non-tariff measure of external economic regulation (article XI of GATT 1994: general quantification of quantitative restrictions).
[WTO/GATT]

ТОО ХЭМЖЭЭНИЙ ХЯЗГААРЛАЛТ

Энэ нь тодорхой барааг оруулах, гаргахад тоон хязгаар буюу дээд хязгаар тогтоох худалдааны арга хэмжээ юм. Үүнд импорт, экспортын хориг буюу эмбарго, квот, шууд бус лиценз олгох шаардлага, экспортын сайн дурын хязгаарлалт хамаарна. Тодорхой хугацааны туршид оруулж, гаргаж болох тодорхой бараа бүтээгдэхүүний бодит хэмжээнд тавьсан тодорхой хязгаарлалт буюу квот. Үүнийг ихэвчлэн эзлэхүүнээр, гэхдээ заримдаа үнээр нь тооцдог. Энэ нь гадаад эдийн засгийн харилцааны тарифын бус арга хэмжээ маягаар хэрэгжих төрийн гадаад эдийн засгийн харилцааны шуурхай зохицуулалтын арга хэмжээ юм (1994 оны ТХЕХ-ийн XI зүйл: Тоон хязгаарлалтыг ерөнхийд нь халах).
[ДХБ/ТХЕХ]

QUOTATION

(see offer)
An offer to sell goods at a stated price and under specified conditions, with a view to concluding a contract.

ҮНИЙН САНАЛ

(“оферт буюу санал”-ыг үз)
Гэрээ байгуулах зорилгоор барааг заасан үнээр, заасан нөхцөлийн дагуу худалдах оферт буюу санал.

R

RADIO FREQUENCY IDENTIFICATION (RFID)

RFID refers to systems that use transponders that transmit data to an RFID receiver. RFID systems can be used to track items as large as ocean-going containers onboard a ship to being incorporated into a label on a product. RFID can carry more information than barcodes, allowing for such information as batch number, and date of manufacture.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

РАДИО ДАВТАМЖААР ИЛРҮҮЛЭГЧ (RFID)

Радио давтамжаар илрүүлэгч (радио давтамжит (цахилгаан соронзон) долгионоор тодорхойлогч, радио давтамжаар таних систем) (RFID) нь RFID-гийн хүлээн авагчид мэдээлэл дамжуулдаг радио хариулагч (ретранслятор, транспо́ндер) ашигладаг систем юм. RFID системийг усан онгоцонд ачсан далайн тээврийн чингэлэг шиг том эд зүйлийг түүнд хавсаргасан хаягийн тусламжтайгаар мөрөөр нь мөшгихөд ашиглаж болдог. RFID нь зураасан кодоос илүү бүрэн мэдээлэл тээх боломжтой. Уг мэдээлэлд барааны багц (бөөм)-ын дугаар, үйлдвэрлэсэн огноог оруулж болно.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RAIL CONSIGNMENT NOTE

(see CIM Consignment Note)

Generic term: transport document constituting a contract for the carriage of goods between the sender and the carrier (the railway).

Remark: for international rail traffic, this document must conform to the model prescribed by the international conventions concerning carriage of goods by rail, e.g. CIM Convention, SMGS Convention.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТӨМӨР ЗАМЫН АЧААНЫ ДАГАЛДАХ

(“CIM-ийн ачааны дагалдах”-ыг үз)

Нийтлэг ойлголт: бараа илгээгч этгээд болон тээвэрлэгч (төмөр замын) хоёрын хооронд тээвэрлэх гэрээ болох тээврийн бичиг баримт.

Тайлбар: олон улсын төмөр замын тээврийн хувьд энэ бичиг баримт нь барааг төмөр замаар тээвэрлэх тухай олон улсын конвенциуд (жишээ нь, Олон улсын төмөр замын тээврийн тухай Конвенц, Олон улсын төмөр замын ачааны харилцааны тухай Хэлэлцээр)-д заасан загвартай тохирч байх ёстой.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RAILWAY GAUGE

Broad, narrow, standard gauge.

[UNECE/Glossary for Transport Statistics]

ТӨМӨР ЗАМЫН ЦАРИГ

Өргөн, нарийн, стандарт цариг.

[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

READY FOR DISPATCH ADVICE

Document issued by a supplier informing a buyer that goods ordered are ready for dispatch. (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ИЛГЭЭХЭД БЭЛЭН БОЛСОН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Захиалсан бараа нь илгээхэд бэлэн болсон тухай худалдан авагчид мэдэгдэж байгаа, нийлүүлэгчээс үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

REASONABLE CHARGES

Charges required by Customs and other regulatory agencies from traders and their agents that are commensurate with administrative expenses entailed by transit or other procedures or with the cost of services rendered.
[GATT article V: Transit]

УХААЛАГ ХЭМЖЭЭНИЙ ХУРААМЖ

Гааль болон тохируулагч бусад агентлагын зүгээс худалдаа эрхлэгч нар болон тэдний агентуудаас шаарддаг төлбөр. Энэ нь дамжин өнгөрөх буюу өөр бусад горимын захиргааны зардалтай, эсхүл үзүүлсэн үйлчилгээний зардалтай тэнцүү байна.
[ТХЕХ-ийн V зүйл: Дамжин өнгөрөх]

RED CLAUSE LETTER OF CREDIT

A letter of credit that allows the exporter to receive a percentage of the face value of the letter of credit in advance of shipment. This enables the exporter to purchase inventory and pay other costs associated with producing and preparing the export order.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УЛААН ТАЙЛБАРТАЙ АККРЕДИТИВ

Экспортлогч нь ачаа ачуулахаас өмнө аккредитивийн нэрлэсэн үнийн тодорхой хувийг урьдчилан авах боломж олгодог аккредитив. Ингэснээр экспортлогч бараа материал худалдан авч, экспортын захиалгат барааг үйлдвэрлэх болон бэлдэхтэй холбогдсон бусад зардлыг төлөх боломжтой болдог.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

REEFER

Refrigerated container

РИИФЕР

Хөргөгчтэй чингэлэг

RE-EXPORTATION

Exportation from a Customs territory of goods previously imported into that territory.

БУЦААН ГАРГАХ

Өмнө нь аль нэг гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг уг гаалийн нутаг дэвсгэрээс гаргах.

REFUND

The repayment, in whole or in part, of duties and taxes paid on goods.

БУЦААН ОЛГОХ

Бараанд төлсөн гаалийн болон бусад татварыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаан олгох.

REGIONAL APPELLATION CERTIFICATE

A certificate drawn up in accordance with the rules laid down by an authority or approved body, certifying that the goods described therein qualify for a designation specific to the given region (e.g. Champagne, Port wine, Parmesan cheese).

Note:
Annex D.2. to the Kyoto Convention of 1974.

БҮС НУТГИЙН НЭРШЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Эрх бүхий төрийн байгууллагаас, эсхүл зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллагаас батлан гаргасан дүрмийн дагуу бүрдүүлсэн гэрчилгээ. Тэр нь түүнд заасан бараа тодорхой нэг бүс нутгийн нэршлийг ашиглахад тавигдсан нөхцөл шаардлагыг хангасан болохыг гэрчилнэ (тухайлбал, Шампанск, Портвейн, Пармеза́н бяслаг).

Жич:
1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.2.

RE-IMPORTATION

Importation into a Customs territory of goods previously exported from that territory

БУЦААН ОРУУЛАХ

Өмнө нь аль нэг гаалийн нутаг дэвсгэрээс гаргасан барааг уг гаалийн нутаг дэвсгэрт оруулах.

RE-IMPORTATION IN THE SAME STATE

The Customs procedure under which goods which were exported may be taken into home use free of import duties and taxes, provided they have not undergone any manufacturing, processing or repairs abroad and provided that any sums chargeable as a result of repayment or remission of or conditional relief from duties and taxes or of any subsidies or other amounts granted in connection with exportation must be paid. The goods that are eligible for re-importation in the same state can be goods that were in free circulation or were compensating products.

Note:
Specific Annex B, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАЛГҮЙГЭЭР БУЦААН ОРУУЛАХ

Экспортолсон барааг хилийн чанадад аливаа үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварт оруулаагүй байх тохиолдолд, мөн түүнийг экспортлохтой холбогдуулан гаалийн болон бусад татварыг буцаан өгсөн, хорогдуулан тооцсон, эсхүл болзолтойгоор тэдгээрээс чөлөөлсөн, татаас олгосон, эсхүл өөр бусад хэлбэрээр мөнгөн дэмжлэг үзүүлсэн учраас буцаан төлбөл зохих аливаа мөнгөн дүнг заавал төлөх нөхцөлд импортын гаалийн болон бусад татваргүйгээр дотоодын хэрэглээнд зориулан оруулж болох гаалийн горим. Өөрчлөлт оруулалгүйгээр буцаан оруулах горимд байршуулах бараа нь чөлөөт эргэлтэд байсан бараа, эсхүл орлох бүтээгдэхүүн байсан бараа байж болно.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт B-гийн 2 дугаар бүлэг.

REJECTED GOODS

Where goods presented for import and rejected by the competent authority of a country on account of their failure to meet prescribed sanitary or phytosanitary regulations or technical regulations.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРААГ ОРУУЛАХААС ТАТГАЛЗАХ

Импортоор оруулах барааг амьтан, ургамлын хорио цээрийн тогтсон журам зөрчсөн, эсхүл техникийн шаардлага хангаагүйн улмаас эрх бүхий байгууллага оруулахаас татгалзах тохиолдол.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RELEASE OF GOODS

The action by the Customs to permit goods undergoing clearance to be placed at the disposal of the persons concerned.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

БАРАА ОЛГОХ

Бүрдүүлэлт хийгдэж буй барааг холбогдох этгээдийн мэдэлд шилжүүлэхийг зөвшөөрөх зорилгоор гаалийн байгууллагаас хийж буй үйлдэл.
Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

RELEASE TIME

Release is a critical step in the clearance process as it involves the decision by government agencies (mostly coordinated by the Customs) in cross-border trade for the importer/exporter or his/her designated agent to remove goods from the designated Customs control area (usually the Customs office at the border, port or airport) and to continue delivery of the goods to its destination. Release should be separate from clearance, i.e. the assessment and payment of applicable duties and taxes should take place after the release of goods.
According to Standard 3.40 of the Revised Kyoto Convention, Customs shall release the goods as soon as they have been examined or the decision has made not to examine them.

БАРАА ОЛГОХ ХУГАЦАА

Барааг олгох нь бүрдүүлэлтийн хамгийн чухал үе шат бөгөөд үүнд хил дамнасан худалдааны талаар төрийн байгууллагууд (ерөнхийдөө гаалийн байгууллага уялдуулан зохицуулах үүрэгтэй оролцдог)-аас гаргадаг багтана. Импортлогч/экспортлогч, эсхүл түүний томилсон төлөөлөгч бараа бүтээгдэхүүнээ дээрх шийдвэрийн дагуу гаалийн хяналтын зориулалтын бүс (гол төлөв хил, боомт, нисэх онгоцны буудал дахь гаалийн газар)-ээс гаргаж, цаааш нь хүрэх газарт нь хүргэнэ. Барааг олгох ажиллагаа нь бүрдүүлэлтээс тусдаа байх ёстой, өөрөөр хэлбэл, холбогдох гаалийн болон бусад татвар тооцож, төлөх ажиллагаа бараа ологосны дараа явагдана.
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн стандарт 3.40-ийн дагуу гаалийн байгууллага барааг шалгаж дуусмагц шууд, эсхүл шалгах шаардлаггүй гэж шийдсэн бол нэн даруй эзэнд нь олгох ёстой.

RELIEF CONSIGNMENTS

- Goods, including vehicles and other means of transport, foodstuffs, medicaments, clothing, blankets, tents, prefabricated houses, water purifying and water storage items, or other goods of prime necessity, forwarded as aid to those affected by disaster; and
- All equipment, vehicles and other means of transport, specially trained animals, provisions, supplies, personal effects and other goods for disaster relief personnel in order to perform their duties and to support them in living and working in the territory of the disaster throughout the duration of their mission.

ТУСЛАМЖИЙН АЧАА

- Гамшигт өртсөн хүмүүст тусламж хэлбэрээр хүргүүлсэн автомашин болон бусад төрлийн тээврийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, эм, хувцас, хөнжил, майхан, угсармал сууц, ус цэвэршүүлэх болон ус хадгалах төхөөрөмж зэрэг бараа, эсхүл зайлшгүй хэрэгцээт бусад бараа; мөн
- Гамшгаас чөлөөлөх ажил үүрэг гүйцэтгэж яваа хүмүүс үүрэгт ажлаа гүйцэтгэх зориулалттай, мөн тэд уг ажил үүргээ гүйцэтгэх бүхий л хугацаанд гамшиг тохиолдсон нутаг дэвсгэрт амьдарч, ажиллахад нь тус дэм болох бүх төрлийн тоног төхөөрөмж, автомашин болон бусад төрлийн тээврийн хэрэгсэл, тусгайлан сургасан амьтад, хоол хүнс, хангалт, хувийн хэрэглээний зүйлс болон бусад бараа.

Note:
Specific Annex J, Chapter 5 of the revised Kyoto Convention.
- All goods, such as vehicles and other means of transport, blankets, tents, prefabricated houses or other goods of prime necessity, forwarded as aid to those affected by natural disaster and similar catastrophes (Annex B.9 of Istanbul Convention: Annex concerning goods imported for humanitarian purpose).

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн
5 дугаар бүлэг.
- Байгалийн гамшиг, эсхүл түүнтэй адилтгах сүйрэлд нэрвэгдсэн хүмүүст туслахаар илгээсэн бүх бараа, автотээврийн хэрэгсэл болон тээврийн бусад хэрэгсэл, хөнжил, майхан, угсардаг сууц, эсхүл тэргүүн ээлжинд шаардлагатай бараа зэрэг бүх бараа (Стамбулын конвенцийн Хавсралт B.9. – Хүмүүнлэгийн зорилгоор оруулах барааны тухай хавсралт)

RELIEF FROM IMPORT DUTIES AND TAXES

Clearance of goods for home use free of import duties and taxes, irrespective of their normal tariff classification or normal liability, provided that they are imported in specified circumstances and for specified purposes.

Note:
Relief from import duties and taxes is dealt with specifically in Annex B.2. to the Kyoto Convention of 1974 and in Specific Annex B, Chapter 3 of the revised Kyoto Convention.

ИМПОРТЫН ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ

Барааг тодорхой нөхцөлд, тусгай зорилгоор оруулах тохиолдолд тарифын хэвийн ангилал буюу хэвийн нөхцөлд ногдуулбал зохих татварыг үл харгалзан импортын гаалийн болон бусад татваргүйгээр дотоодын хэрэглээнд зориулан оруулах.

Жич:
Импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх талаар Киотогийн конвенцийн хавсралт B.2-т заасан байдаг.

REMISSION OF IMPORT DUTIES AND TAXES

The waiver of payment, in whole or in part, of import duties and taxes where payment has not been made.

Note:
Remission of import duties and taxes is dealt with in Annex F.6. to the Kyoto Convention of 1974. That Annex also covers the refund, in whole or in part, of import duties and taxes paid on goods declared for home use.

ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРЫГ ХОРОГДУУЛАН ТООЦОХ

Импортын гаалийн болон бусад татварын төлбөр хийгдээгүй тохиолдолд уг төлбөрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах.

Жич:
Импортын гаалийн болон бусад татварыг хорогдуулан тооцох талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт F.6-д заасан байдаг. Энэхүү хавсралтад бас дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар мэдүүлсэн барааND төлсөн импортын гаалийн болон бусад татварыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаан олгох тухай заасан байдаг. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийг үзэх.

REPAYMENT

The refund, in whole or I n part, of duties and taxes paid on goods and the remission, in whole or in part, of duties and taxes where payment has not been made.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ТАТВАР БУЦААН ӨГӨХ

Барааанд төлсөн гаалийн болон бусад татварыг бүхэлд нь, эсхүл хэсгийг нь эргүүлэн олгохыг, мөн гаалийн болон бусад татварын төлбөр хийгдээгүй тохиолдолд уг татварыг бүхэлд нь, эсхүл хэсгийг нь хорогдуулан тооцох.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

REQUEST FOR DELIVERY INSTRUCTIONS

Document issued by a supplier requesting instructions from the buyer regarding the details of the delivery of goods ordered.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХҮРГЭХ ЗААВАР АВАХ ХҮСЭЛТ

Бараа нийлүүлэгчээс үйлдсэн, захиалсан барааг хүргэх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий зааврыг худалдан авагчаас хүссэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

REQUEST FOR QUOTATION

A document that an organization submits to one or more potential suppliers eliciting quotations for a product or service. It reflects a standard business process of inviting suppliers to bid on specific products or services in a bidding process.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

ҮНИЙН САНАЛ АВАХ ХҮСЭЛТ

Аль нэг байгууллага нэг буюу хэд хэдэн боломжит нийлүүлэгчээс бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн санал авахаар үзүүлдэг бичиг баримт. Энэ нь тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгчдийг тендерт урих стандарт бизнесийн процесстой адил юм.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RESIDENT AGENT

A trading company located in the country of the principal and carrying out import operations at its expense.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

СУУРИН АГЕНТ

Үндсэн этгээдийн улсад байрладаг, түүний зардлаар импортын үйл ажиллагаа явуулдаг худалдааны компани.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RESTRICTED ARTICLES

Special goods, the carriage of which requires special authorization.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХЯЗГААРЛАСАН ЭД ЗҮЙЛ

Тээвэрлэхийн тулд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байдаг тусгай бараа.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RESTRICTION

Means of state protection of the interests of national producers and consumers, as well as ensuring national interests and fulfilment of international obligations.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХЯЗГААРЛАЛТ

Үндэсний үйлдвэрлэгч, хэрэглэгч нарын ашиг сонирхлыг төрөөс хамгаалах, мөн үндэсний эрх ашгийг хамгаалах болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх арга.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RESTRICTION OF GOODS

A legal requirement by law for the submission and approval of an application or other document (other than for Customs purposes) as a prior condition to importation or exportation.

БАРААГ ХЯЗГААРЛАХ

Импортын, эсхүл экспортын үйл ажиллагаа явуулах урьдчилсан нөхцөл болгож өргөдөл гаргах, эсхүл өөр бусад бичиг баримт (гаалийн зорилгоор бүрдүүлэх бичиг баримтаас бусад) бүрдүүлэх, тэдгээрийг баталгаажуулахаар хуульд заасан эрх зүйн шаардлага.

REVISED ARUSHA DECLARATION

The expression commonly used to refer to the Declaration of the Customs Co-operation Council concerning good governance and integrity in customs, adopted by the Customs Co-operation Council in Arusha in 1993 and revised in 2003.

ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН АРУШАГИЙН ТУНХАГЛАЛ

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 1993 онд баталж, 2003 онд шинэчлэн найруулсан Гаалийн байгууллага дахь сайн засаглал, ариун шударга ёсны тухай тунхаглалын түгээмэл нэр.

REVISED KYOTO CONVENTION

The expression commonly used to refer to the international Convention on the simplification and harmonization of Customs procedures (amended), adopted by the Customs Co-operation Council in Brussels in 1999.

ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН КИОТОГИЙН КОНВЕНЦ

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 1999 онд Брюссель хотноо баталсан Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц (шинэчлэн найруулсан)-ийн түгээмэл нэр.

RFID

(see radio frequency identification)

RFID

(“радио давтамжаар илрүүлэгч”-ийг үз)

RIGHT OF APPEAL

The right to ask a court or other official body to consider changing a decision with which an economic operator or their agent disagrees.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАВЖ ЗААЛДАХ ЭРХ

Аж ахуйн нэгж буюу түүний агентын хүлээн зөвшөөрөхгүй байгаа шийдвэрийг өөрчлөх асуудлыг авч үзэхийг шүүх буюу өөр бусад албан байгууллагаас хүсэх эрх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

RIGHT OF CONTROL OF THE GOODS

The right under the contract of carriage to give the carrier instructions in respect of the goods. [Rotterdam Rules]

БАРААНД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ

Холбогдох бараатай холбогдуулан тээвэрлэгчид заавар өгөх тухай тээврийн гэрээнд заасан эрх.
[Роттердамын дүрэм]

RISK

The chance of something happening that will have an impact on Customs objectives, including potential non-compliance with Customs laws and failure to facilitate trade.

The potential for non-compliance with Customs laws. (Chapter 6 of the General Annex to the Revised Kyoto Convention)

ЭРСДЭЛ

- Гаалийн хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх, худалдааг хөнгөвчлөхгүй байх зэрэг гаалийн зорилтод нөлөөлөх аливаа зүйл тохиолдох магадлал.
- Гаалийн хууль тогтоомж зөрчих магадлал. (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэг)

RISK ANALYSIS

The systematic use of available information to determine the likelihood and consequence of a risk.
The systematic use of available information to determine how often defined risks may occur and the magnitude of their likely consequences. (Chapter 6 of the General Annex to the Revised Kyoto Convention)

ЭРСДЭЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

- Эрсдэл тохиолдох магадлал ба үр дагаврыг тодорхойлох зорилгоор байгаа мэдээллээ системтэй (цэгцтэй) ашиглах.
- Тодорхой эрсдэл дахин давтагдах магадлал болон түүний үр дагаврыг тогтоох зорилгоор байгаа мэдээллийг системтэй (цэгцтэй) ашиглах ажиллагаа. (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэг)

RISK AREAS

Those Customs procedures and categories of international traffic which present a risk. (Chapter 6 of the General Annex to the Revised Kyoto Convention)

ЭРСДЭЛТ ОРЧИН (ЭРСДЭЛТ БҮЛЭГ)

Эрсдэл бүхий гаалийн үйл ажиллагааны (гаалийн горимын) болон олон улсын тээвэр, худалдааны төрлүүд. (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэг)

RISK ASSESSMENT

The systematic determination of risk management priorities by analysing and evaluating identified risks.

The systematic determination of risk management priorities by evaluating and comparing the level of risk against predetermined standards, target risk levels or other criteria. (Chapter 6 of the General Annex to the Revised Kyoto Convention)

ЭРСДЭЛИЙН ТООЦОО

- Илрүүлсэн (олж тогтоосон) эрсдэлд дүн шинжилгээ хийж, үнэлэх замаар эрсдэлийн менежментийн тэргүүлэх чиглэлийг системтэй (цэгцтэй) тодорхойлох.
- Эрсдэлийн түвшинг урьдчилан тогтоосон стандарт, эрсдэлийн онилсон түвшин, эсхүл өөр бусад шалгууртай харьцуулан дүгнэх замаар эрсдэлийн удирдлагын тэргүүлэх чиглэлийг системтэй (цэгцтэй) тогтоох ажиллагаа
(Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэг)

RISK EVALUATION

The systematic use of available information to determine the acceptability of an identified risk, and to prioritize the importance of those risks that are deemed to be unacceptable.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Илрүүлсэн (олж тогтоосон) эрсдэлийг хүлээн зөвшөөрч болмоор (тэр нь байж болох эрсдэл) эсэхийг тодорхойлох, мөн хүлээн зөвшөөрөхөөргүй (байж боломгүй) гэж үзсэн эрсдэлийн ач холбогдлыг эрэмбэлэх зорилгоор бэлэн байгаа мэдээллийг системтэй (цэгцтэй) ашиглах.

RISK IDENTIFICATION

The identification of events and activities that have the potential to impact on the achievement of Customs objectives. A risk is identified in terms of what can happen and how it can happen.

ЭРСДЭЛИЙГ ИЛРҮҮЛЭХ (ОЛЖ ТОГТООХ)

Гаалийн зорилтод нөлөөлж болзошгүй үйл явдал, үйл ажиллагааг илрүүлэх (олж тогтоох). Ямар нэг эрсдэлийг юу, хэрхэн тохиолдох гэж байгаа вэ гэдэг үүднээс илрүүлдэг (олж тогтоодог).

RISK INDICATORS

Specific criteria which, when combined, serve as a practical tool to select and target potentially high-risk consignments.

Specific criteria which, when taken together, serve as a practical tool to select and target movements for the potential for non-compliance with Customs law. (Chapter 6 of the General Annex to the Revised Kyoto Convention)

ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Тодорхой шалгууруудыг хослуулан хэрэглэх нь өндөр эрсдэлтэй ачаа барааг сонгох (шигших), онилох практик хэрэгсэл болж өгдөг.
- Хамтад нь авч үзвэл гаалийн хууль тогтоомж зөрчих магадлал бүхий хөдөлгөөнийг сонгож, онилох практик хэрэгслийн үүрэг гүйцэтгэх тодорхой шалгуур үзүүлэлтүүд. (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэг)

RISK MANAGEMENT

The process of measuring, or assessing risk and developing strategies to manage it. Strategies include transferring the risk to another party, avoiding the risk, reducing the negative effect of the risk, and accepting some or all of the consequences of a particular risk.
Traditional risk management focuses on risks stemming from physical or legal causes (e.g. natural disasters or fires, accidents, death, and lawsuits).

Coordinated activities by administrations to direct and control risk.

ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ (УДИРДЛАГА)

- Эрсдэлийг хэмжих буюу тооцох, мөн түүнийг хянан удирдах стратеги боловсруулах үйл явц. Стратеги гэдэгт эрсдэлийг өөр нэг талд үүрүүлэх (шилжүүлэх), эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийн сөрөг нөлөөг бууруулах, тодорхой нэг эрсдлийн үр дагаврыг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээж зөвшөөрөх явдал хамаарна. Эрсдэлийн уламжлалт менежмент нь бодитой буюу хууль эрх зүйн шалтгаан (жишээ нь, байгалийн гамшиг, гал түймэр, осол аваар, нас баралт, шүүн таслах ажиллагаа)-тай эрсдэлд анхаарлаа төвлөрүүлдэг.
- Эрсдэлийг байгууллагаас удирдан чиглүүлэх болон хянах зохицуулалттай үйл ажиллагаа.

The systematic application of management procedures and practices which provide Customs with the necessary information to address movements or consignments which present a risk. (Chapter 6 of the General Annex to the Revised Kyoto Convention)

- Эрсдэл бүхий хөдөлгөөн буюу ачааг онцлон авч үзэхэд шаардлагатай мэдээллээр гаалийн байгууллагыг хангаж буй удирдлагын (менежментийн) арга, туршлагыг системтэй (цэгцтэй) мөрдөх ажиллагаа. (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэг)

RISK PROFILE

A predetermined combination of risk indicators that is used to assist in the identification of high-risk activities, entities or transactions.

A predetermined combination of risk indicators, based on information which has been gathered, analysed and categorised. (Chapter 6 of the General Annex to the Revised Kyoto Convention)

ЭРСДЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ЭРСДЭЛИЙН ТҮҮХ, ЭРСДЭЛИЙН ПРОФАЙЛ)

- Өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, хэлцлийг илрүүлэх (олж тогтоох)-д туслах зорилгоор ашигладаг, урьдчилан тодорхойлсон эрсдэлийн үзүүлэлтүүдийн хослол.

- Цуглуулсан, дүн шинжилгээ хийсэн болон төрөлжүүлсэн мэдээлэлд үндэслэсэн эрсдэлийн үзүүлэлтийн урьдчилан тооцсон хувилбарууд (комбинац). (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 6 дугаар бүлэг)

RISK TREATMENT

A strategy designed to address an identified risk, which may include mitigating, avoiding, accepting or transferring the risk.

ЭРСДЭЛИЙГ ШИЙДЭХ (ТУЛЖ АЖИЛЛАХ)

Илрүүлсэн (олж тогтоосон) эрсдэлтэй тэмцэх стратеги. Үүнд эрсдэлийг бууруулах, эрсдэлээс зайлсхийх, эрдсэлийг хүлээн зөвшөөрөх, эсхүл бусдад үүрүүлэх (шилжүүлэх) явдал хамаарна.

RIVER WAYBILL

Transport document issued by the carrier to the shipper of goods carried by river which evidences receipt of the goods for carriage and binds the carrier to surrender the goods to the consignee at the port of destination.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УСАН ТЭЭВРИЙН БАРИМТ

Тээвэрлэгчээс ачаа бэлтгэгч (ачигч компани)-д зориулан үйлдсэн, голын усаар тээвэрлэж буй барааг тээвэрлэхээр хүлээж авсаныг, мөн тээвэрлэгч нь уг барааг хүлээн авах боомт дээр байгаа хүлээн авагчид хүлээлгэн өгөх үүрэг хүлээснийг нотлох тээврийн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

ROAD CONSIGNMENT NOTE

(see CMR consignment note)
Generic term: transport document which evidences a contract between a carrier and a sender for the carriage of goods by road.
Remark: for international road traffic, this document must contain at least the particulars prescribed by the Convention on the Contract for the International Carriage of Goods by Road.
[UNECE/CMR]

АВТО ЗАМЫН АЧААНЫ ДАГАЛДАХ

("CMR конвенцийн ачааны дагалдах хуудас"-ыг үз)
Нийтлэг ойлголт: барааг авто замаар тээвэрлэх тухай тээвэрлэгч болон бараа илгээгч этгээд хоёрын хооронд байгуулсан гэрээг илтгэх тээврийн бичиг баримт.
Тайлбар: олон улсын авто замын тээврийн хувьд энэ бичиг баримт нь дор хаяж Ачааг олон улсын хэмжээнд авто замаар тээвэрлэх гэрээний тухай НҮБ-ын Конвенц (Женев, 1956-5-19)-д заасан мэдээллийг агуулсан байх ёстой.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Ачааг олон улсын хэмжээнд авто замаар тээвэрлэх гэрээ]

ROAD HAULAGE; TRAILER TRUCK

Transport of goods by road vehicles, for example using road tractors hauling semi-trailers or trailers.
[UNECE/Glossary for Transport Statistics]

АЧААНЫ АВТОМАШИНЫ ТЭЭВЭР; ЧИРГҮҮЛТЭЙ АЧААНЫ АВТОМАШИН

Автомашинаар бараа тээвэрлэх, жишээлбэл, хагас чиргүүл буюу хэд хэдэн чиргүүлтэй трактор ашиглан бараа тээвэрлэх.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

ROLLING ROAD

Transport of complete road vehicles, using roll-on roll-off techniques, on trains comprising low floor wagons throughout.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ГУЛГАДАГ/ГҮЙДЭГ ЗАМ

Ачаатай автомашин тээвэрлэх. Намхан шалтай вагон дээр хэвтээ байдлаар ачиж, булгах арга техник ашиглана.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

ROLL-ON ROLL-OFF (RO-RO)

Loading and unloading of a road vehicle, a wagon or an ITU on or off a ship on its own wheels or wheels attached to it for that purpose. In the case of rolling road, only road vehicles are driven on and off a train.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ХЭВТЭЭ БАЙДЛААР АЧИЖ, БУУЛГАХ АРГА (РО-РО)

Автомашин, вагон, холимог тээврийн хэрэгслийг усан онгоцонд өөрийн дугуйгаар нь, эсхүл ийм зорилгоор түүнд тоноглосон дугуйгаар ачиж, буулгах. Гулгадаг/гүйдэг замын хувьд зөвхөн автомашиныг вагонд ачиж, буулгана.
[НҮБ- ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

ROME CONVENTION

Treaty, administered by the World Intellectual Property Organization (WIPO), United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO) and International Labour Organization (ILO), for the protection of the works of performers, broadcasting organizations and producers of phonograms.

РОМЫН КОНВЕНЦ

Уран бүтээлчдийн бүтээл, өргөн нэвтрүүлгийн байгууллага, фонограм үйлдвэрлэгчдийн бүтээлийг хамгаалах зорилгоор Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДОӨБ), НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас хамтран хэрэгжүүлж байгаа гэрээ.

ROYALTY

Royalty is an amount paid or credited as consideration for:
(a) The making, use, exercise or vending of an invention or the right to make, use, exercise or vend an invention;
(b) The use of, or the right to use:
(i) A design or trade mark;
(ii) Confidential information; or
(iii) Machinery, implements, apparatus or other equipment;
© The supply of scientific, technical, industrial, commercial or other knowledge or information.
May be included in the Customs Value.

РОЯЛТИ (ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ШИМТГЭЛ)

Роялти буюу оюуны өмчийн эрхийн шимтгэл гэдэг нь дараах болзолтойгоор төлсөн буюу шилжүүлсэн дүн болно:
(a) Шинэ бүтээл хийх, ашиглах, ажиллуулах, борлуулах, эсхүл шинэ бүтээл хийх, ашиглах, ажиллуулах, борлуулах эрх эзэмших;
(b) Дараах зүйлийг ашиглах, эсхүл ашиглах эрх эзэмших:
i) Загвар, худалдааны тэмдэг;
(ii) Нууц мэдээлэл; эсхүл
(iii) Машин, багаж хэрэгсэл, аппарат, эсхүл бусад тоног төхөөрөмж;
© Шинжлэх ухаан, техник, үйлдвэрлэл, арилжааны буюу өөр бусад мэдлэг, мэдээлэл нийлүүлэх. Эдгээрийг гаалийн үнэд оруулан тооцож болно.

RULES FOR INTERNATIONAL CARRIAGE OF DANGEROUS GOODS BY RAIL (RID)

Regulation which applies to the transportation of dangerous goods by rail and forms appendix C to the COTIF Convention.
[OTIF/RID]

АЮУЛТАЙ БАРААГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД АВТО ЗАМААР ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДҮРЭМ

Аюултай бараг төмөр замаар тээвэрлэх тухай журам бөгөөд энэ нь Олон улсын төмөр замын тээврийн тухай Конвенц (КОТИФ)-ийн С хавсралт болдог.
[Төмөр замын олон улсын тээврийн засгийн газар хоорондын байгууллага/Аюултай бараг олон улсын хэмжээнд авто замаар тээвэрлэх]

RULES FOR INTERNATIONAL CARRIAGE OF FREIGHT (CIM)

Apply to direct international rail contracts irrespective of the system of lines entered, so that goods cross the COTIF Member States' border under the aegis of a single contract and uniform liability regime.

БАРААГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ

Бараг улс хооронд төмөр замаар тээвэрлэх гэрээний хэрэгжилтийг төмөр замын шугамын ямар систем байхаас үл хамааран чиглүүлэхэд хэрэглэдэг.

CIM Rules form appendix B to COTIF and are used as basis for the CIM model contract established by the International Rail Transport Committee.
[OTIF/CIM]

Тэгэхээр бараа Олон улсын төмөр замын тээврийн тухай Конвенц (КОТИФ)-ын гишүүн орнуудын хилээр нэгдсэн нэг гэрээгээр, мөн хариуцлагын тухай нэг ижил дэглэмийн дагуу нэвтэрнэ. CIM-ийн нийтлэг дүрэм нь Олон улсын төмөр замын тээврийн тухай Конвенц (КОТИФ)-ийн B хавсралт болдог бөгөөд түүнийг Төмөр замын тээврийн олон улсын хорооноос баталсан CIM-ийн загвар (үлгэрчилсэн) гэрээний үндэс болгон ашигладаг.
[Төмөр замын олон улсын тээврийн засгийн газар хоорондын байгууллага/Аюултай барааг олон улсын хэмжээнд авто замаар тээвэрлэх]

RULES OF ORIGIN

Specific provisions, developed from principles established by national legislation or international agreements (“origin criteria”), applied by a country to determine the origin of goods.

Note: Rules of origin are dealt with in Annex D.1. to the Kyoto Convention of 1974 and in Specific Annex K, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРЭМ

Үндэсний хууль тогтоомжоор, эсхүл олон улсын хэлэлцээрээр тогтоосон зарчмыг үндэслэн боловсруулсан, аливаа нэг улсад барааны гарал үүслийн улсыг тодорхойлох зорилгоор мөрдөж буй тодорхой заалт (“гарал үүслийн шалгуур”).

Жич: Барааны гарал үүслийн дүрмийн талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.1-д, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт К-гийн 1 дүгээр бүлэгт заасан байдаг.

S

SAFE FRAMEWORK OF STANDARDS

The expression commonly used to refer to the WCO SAFE Framework of Standards to secure and facilitate global trade, adopted by the Customs Co-operation Council in 2005, as amended.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГЦ СТАНДАРТ

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлөөс 2005 онд батлагдсан ДГБ-ын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх тухай багц стандартын түгээмэл нэр (2007, 2012, 2018 онд тус тус шинэчлэгдсэн).

SAFEGUARD MEASURES

Action taken to protect a specific industry from an unexpected build-up of imports — generally governed by Article 19 of GATT. The Agriculture Agreement and Textiles and Clothing Agreement have different specific types of safeguards: "special safeguards" in agriculture, and "transitional safeguards" in textiles and clothing.

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Тодорхой нэг үйлдвэрлэлийг (салбарыг) импортын барааны хэт өсөлтөөс хамгаалах талаар авсан арга хэмжээ бөгөөд ерөнхийдөө ТХЕХ-ийн 19 дүгээр зүйлээр зохицуулагддаг. Хөдөө аж ахуйн хэлэлцээр болон Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай хэлэлцээрт өөр өөрийн гэсэн тусгай хамгаалалтын арга хэмжээ тусгагдсан байдаг: хөдөө аж ахуйн "тусгай хамгаалалт", сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны "шилжилтийн үеийн хамгаалалт".

SAFETIR

System of Electronic Control for TIR Carnets.

АЮУЛГҮЙ ТИР

ТИР карнейн цахим хяналтын систем.

SALES ORDER

Contractual document by means of which a buyer initiates a transaction with a seller involving the supply of goods or services as specified, according to conditions which are either set out in a formal quotation or otherwise known to the buyer.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА

Худалдан авагч худалдагчтай хэлцэл эхлүүлэх арга болгон үйлдсэн бичиг баримт. Энэ бичиг баримтад түүнд дурдсан бараа, үйлчилгээг албан ёсны үнийн саналд заасан, эсхүл худалдан авагчийн мэддэг өөр бусад нөхцөлийн дагуу нийлүүлэх санал тусгагдсан байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SAMPLES

Articles which are representative of a particular category of goods already produced or are examples of goods the production of which is contemplated; the term does not include identical articles brought in by the same individual, or sent to a single consignee, in such quantity that, taken as a whole, they no longer constitute samples under ordinary commercial usage.

ДЭЭЖ ЗАГВАР

Үйлдвэрлэгдсэн барааны тодорхой зүйл ангийг төлөөлсөн, эсхүл үйлдвэрлэхээр зэхэж/төлөвлөж байгаа барааны жишээ болох эд зүйлийг хэлнэ. Үүнд нэг этгээд олон дахин авч ирсэн, эсхүл ганц хүлээн авагчид олон дахин илгээсэн бөгөөд нийтэд нь авч үзвэл худалдааны ердийн заншил ёсоор загвар, дээж гэж үзэхээргүй тоо хэмжээтэй нэг нэр төрлийн эд зүйл хамааарахгүй;

Note:
Temporary admission facilities for samples are dealt with in Annex B.3.
to the Istanbul Convention.

Жич:
Загвар, дээжийг түр хугацаагаар оруулах таатай нөхцлийн талаар Стамбулын конвенцийн хавсралт B.3-т заасан байдаг.

SAMPLES OF NO COMMERCIAL VALUE

Articles which are regarded by the Customs to be of negligible value and which are to be used only for soliciting orders for goods of the kind they rep resent.

Note:
Such articles are normally allowed relief from import duties and taxes. In Annex B.2. to the Kyoto Convention of 1974, it is recommended that the following should be regarded as samples of no commercial value:

(a) raw materials and products of such dimensions that they are useless except for purposes of demonstration;

(b) articles of non-precious materials affixed to cards or put up as samples in the manner usual in the trade, provided that there is not more than one of each size or kind;

(c) raw materials and products, and articles of such materials or products, rendered useless, except for purposes of demonstration, by slashing, perforation, indelible marking or by any other effective method;

(d) products which cannot be put up as samples of no commercial value in accordance with paragraphs (a) to (c) above and which consist of:

(1) non-consumable goods of an individual value not exceeding US$5, and provided there is not more than one sample of each kind or quality;

(2) consumable goods of an individual value not exceeding US$5, even if they consist wholly or partly of samples of the same kind or quality, provided the quantity and the manner in which they are put up preclude their being used otherwise than as samples.

International Convention to facilitate the importation of commercial samples and advertising material (Geneva, 1952).

АРИЛЖААНЫ ӨРТӨГГҮЙ ЗАГВАР, ДЭЭЖ

Гаалийн байгууллагаас өчүүхэн бага үнэтэй/ өртөгтэй (арилжааны өртөггүй) гэж үзсэн, зөвхөн тэдгээрийн төлөөлсөн барааны захиалга авах зорилгоор ашиглах эд зүйл.

Жич:
Ийм эд зүйлийг ерөнхийдөө импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлдөг. 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт B.2-т зааснаар, дараах барааг арилжааны өртөггүй загвар, дээж хэмээн үзэхийг зөвлөсөн:

(a) үзэсгэлэнд тавихаас бусад тохиолдолд хэрэгцээгүй үлэмж бага хэмжээний түүхий эд болон бүтээгдэхүүн;

(b) карталсан, эсхүл худалдаанд түгээмэл хэрэглэдэг аргаар загвар, дээж маягтай болгон өртөг багатай материалаар хийсэн эд зүйл, тэдгээрийн нэр төрөл, размер бүр нь нэгээс илүүгүй байх тохиолдолд;

(c) зүсэх, цоолох, арилшгүй тэмдэг тавих, эсхүл боломжийн өөр бусад аргаар үзэсгэлэнд тавихаас бусад тохиолдолд хэрэглэх боломжгүй болгосон түүхий эд, бүтээгдэхүүн, тийм түүхий эд, бүтээгдэхүүнээр хийсэн эд зүйл;

(d) дээрх (a)-(c)-д заасны дагуу арилжааны өртөггүй загвар, дээж болгож болохгүй дараах бүтээгдэхүүн:

(1) нэр төрөл, размер бүр нь нэг ширхэгээс илүүгүй, нэг бүрийн үнэ нь 5 ам. доллараас хэтрэхгүй байх өдөр тутмын хэрэглээний бус бүтээгдэхүүн;

(2) бүхэлдээ, эсхүл зарим хэсэг нь нэг төрлийн буюу ижил чанарын загвар, дээжээс бүтсэн хэдий ч загвар, дээжээс өөр зориулалтаар ашиглах боломжгүй тоо хэмжээтэй, мөн тийм аргаар хийсэн, нэг бүрийн үнэ нь 5 ам. доллараас хэтрэхгүй хэрэглээний бүтээгдэхүүн.

Загварын бараа болон сурталчилгааны материал оруулах таатай нөхцлийн тухай олон улсын конвенц (Женев, 1952).

SANITARY AND PHYTOSANITARY MEASURES (SPS)

Any measure applied within the territory of a State to:

a) protect animal or plant life or health from risks arising from the entry, establishment or spread of pests, diseases, disease-carrying organisms or disease-causing organisms;

b) protect human or animal life or health from risks arising from additives, contaminants, toxins or disease-causing organisms in foods, beverages or feedstuffs;

c) protect human life or health from risks arising from diseases carried by animals, plants or products thereof, or from the entry, establishment or spread of pests; or

d) prevent or limit other damage from the entry, establishment or spread of pests.

[WTO/SPS]

АМЬТАН, УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН АРГА ХЭМЖЭЭ (SPS)

Аль нэг улсын нутаг дэвсгэрт дараах зорилгоор хэрэгжүүлдэг аливаа арга хэмжээ:

а) амьтан, ургамлын амь нас, эрүүл мэндийг хортон шавьж, өвчин, өвчин тээгч организм, эсхүл өвчин үүсгэгч организм нэвтэрч халдах, үржих, тархахаас үүдэлтэй эрсдлээс хамгаалах;

b) хүн, амьтны амь нас, эрүүл мэндийг хүнсний нэмэлт, бохирдуулагч, хорт бодис, эсхүл хүнсний бүтээгдэхүүн, ундаа, эсхүл хүнс тэжээлд байдаг өвчин үүсгэгч организмаас үүдэлтэй эрсдэлээс хамгаалах;

с) хүний амь нас, эрүүл мэндийг амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний тээж яваа өвчнөөс үүдэлтэй эрсдэлээс, эсхүл хортон шавьж нэвтэрч халдах, үржих, тархахаас үүдэлтэй эрсдлээс хамгаалах; эсхүл

d) хортон шавьж нэвтэрч халдах, үржих, тархахаас үүдэлтэй бусад хохирлоос сэргийлэх буюу хязгаарлах.

[ДХБ/Амьтан, ургамлын хорио цээрийн арга хэмжээ]

SANITARY CERTIFICATE

Document issued by the competent authority in the exporting country evidencing that alimentary and animal products, including dead animals, are fit for human consumption, and giving details, when relevant, of controls undertaken.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АМЬТНЫ ХОРИО ЦЭЭРИЙН ГЭРЧИЛГЭЭ

Экспортлогч улсад байгаа эрх бүхий байгууллагаас олгосон, хүнсний болон амьтны, түүний дотор үхсэн амьтны гаралтай бүтээгдэхүүн хүний хэрэглээнд тохирч буй эсэхийг тогтоосон, мөн зүйтэй гэж үзсэн тохиолдолд хяналт шалгалт хийсэн бол тийм хяналт шалгалтын дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан бичиг баримт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SCANNING

Capturing information (which may include images or radiation signatures) relating to goods and means of transport by utilising non-intrusive detection equipment.

СКАННИНГ

Бараа болон тээврийн хэрэгсэлтэй холбоотой мэдээлэл (үүнд дүрсний, эсхүл цацрагийн дохио хамаарч болно)-ийг барааг задлахгүйгээр шалгах төхөөрөмж (рентген төхөөрөмж) ашиглан олж авах арга.

SCREENING

The evaluation of information and intelligence relating to goods and means of transport in a risk assessment process (manual, automated or otherwise).

СКРИНИНГ

Бараа болон тээврийн хэрэгсэлтэй холбоотой боловсруулаагүй болон боловсруулсан мэдээллийг эрсдэлийн тооцоо хийх процесс (гар буюу механик, автомат, эсхүл өөр бусад)-ын үед үнэлж дүгнэх ажиллагаа.

SEA SHIPPING

Any movement of cargo using merchant ships undertaken wholly or partly at sea.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ДАЛАЙН ТЭЭВЭР

Ачааг худалдааны усан онгоц ашиглан бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн далайгаар тээвэрлэх аливаа хөдөлгөөн.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

SEA WAYBILL

Non-negotiable document which evidences a contract for the carriage of goods by sea and the taking over of the goods by the carrier, and by which the carrier undertakes to deliver the goods to the consignee named in the document.
Remark: Synonymous with “straight” or “non-negotiable Bill of Lading” used in certain countries, e.g. Canada and the United States of America.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАЛАЙН ТЭЭВРИЙН БАРИМТ

Барааг далайгаар тээвэрлэх гэрээ болоод төлбөрийн бус (эргэлтийн бус) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас бус хэрэгсэл) болох бичиг баримт. Энэ бичиг баримтын дагуу тээвэрлэгч барааг өөрийн мэдэлд авч, түүнд нэр заасан бараа хүлээн авагчид хүргэж өгөх үүрэг хүлээдэг.
Тайлбар: Зарим улсад, жишээлбэл, Канад, АНУ-д ашигладаг “энгийн” (нэр заасан) буюу төлбөрийн бус (эргэлтийн бус) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас бус хэрэгсэл) болох тээврийн баримттай адил утгатай.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SEAL

A piece of metal or other material used to join together two ends of a fastening in a secure manner.
Note:
Council Recommendation concerning Customs sealing systems in connection with the international transport of goods, 1968.

ЛАЦ, ЛОМБО

Бэхэлгээ утасны хоёр үзүүрийг бат бэх байдлаар холбоход хэрэглэх метал буюу бусад төрлийн материалаар хийсэн зүйл.
Жич:
Барааны олон улсын тээвэрт хэрэглэх гаалийн битүүмжлэлийн системийн тухай 1968 оны ГХАЗ-ийн зөвлөмж.

SEAMLESS PROCESS

A process which does not contain procedural, “manual”, or other interventions that would hamper the possibility of developing an automated version of this process.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

САДГҮЙ (ТАСРАЛТГҮЙ) ПРОЦЕСС

Уг процессын автомат хувилбарыг боловсруулахад саад бэрхшээл учруулах горим журам, “гар ажиллагаа”, эсхүл өөр бусад хөндлөнгийн оролцоо байдаггүй процесс.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SECURITY

That which ensures to the satisfaction of the Customs that an obligation to the Customs will be fulfilled. Security is described as “general” when it ensures that the obligations arising from several operations will be fulfilled.

Note:
Security usually takes the form of a deposit or of a legal obligation (a bond). A surety to the bond is usually required.

БАТАЛГАА

Гаалийн байгууллагын өмнө хүлээсэн үүрэг биелэгдэх нөхцөлийг гаалийн байгууллагын шаардлагад нийцүүлэн хангасан зүйл. Хэд хэдэн үйл ажиллагаанаас үүсэх үүргийн биелэлтийг хангасан баталгааг “ерөнхий” баталгаа гэнэ.

Жич:
Баталгааг ихэвчлэн барьцааны хэлбэрээр, эсхүл эрх зүйн дагуу үүрэг хүлээх (үүргийн) хэлбэрээр гаргадаг. Үүргийн биелэлтийг хангуулахын тулд голчлон батлан даалт гаргахыг шаарддаг.

SELECTIVITY

The systematic application of processes and procedures to identify activities, entities or transactions for specific Customs scrutiny.

СОНГОЛТ/ШИГШИЛТ ХИЙХ

Гаалийн байгууллагаас (тодорхой чиглэлтэй) нарийвчилсан (гүнзгийрүүлсэн) шалгалт хийх шаардлагатай үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, хэлцлийг олж тогтоох зорилгоор процесс (технологи ажиллагаа) болон процедур (горим журам)-ыг системтэй (цэгцтэй) мөрдөх.

SELLER

The party stipulated as the supplier of goods or services. The primary role of the Supplier as specified in the Sales Order Contract is the Seller and other possible roles include the Original Consignor/Shipper, Transport Services Buyer, Exporter, and Invoice Issuer.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДАГЧ

Бараа, үйлчилгээ нийлүүлэгч гэж заасан тал. Бараа худалдах, худалдан авах захиалгын гэрээний гол тоглогч нь худалдагч бөгөөд бусад тоглогч нь анхны илгээгч/анхны ачаа бэлтгэгч (ачигч компани), тээврийн үйлчилгээ худалдан авагч, экспортлогч, үнийн нэхэмжлэх үйлдэгч байж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SENDER

Party consigning goods as stipulated in the transport contract by the party ordering transport.
[UNTDED]

БАРАА ИЛГЭЭГЧ ЭТГЭЭД

Бараа тээвэрлэх захиалга өгсөн талаас тээврийн гэрээнд заасан барааг илгээж буй тал.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

SENDER’S INSTRUCTIONS

Instructions and declarations provided by the sender to the carrier concerning Customs, insurance, and other formalities.
[UNTDED]

БАРАА ИЛГЭЭГЧ ЭТГЭЭДИЙН ЗААВАР

Гаалийн, даатгалын, өөр бусад ёс журмын ажиллагаатай холбогдуулан бараа илгээгч этгээдээс тээвэрлэгчид өгсөн заавар болон мэдүүлэг.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

SENSITIVE PRODUCTS

Products that are vulnerable or particularly susceptible to competition from imports. Such products usually get longer terms for tariff reduction or elimination in trade agreements.

ЭМЗЭГ БҮТЭЭГДЭХҮҮН

- Зах зээлийн өрсөлдөөнд эмзэг буюу илүү өртөмтгий импортын бүтээгдэхүүн. Худалдааны хэлэлцээрүүдэд тийм бүтээгдэхүүний тарифыг бууруулах, эсхүл тэглэхэд ерөнхийдөө илүү урт хугацаа заасан байдаг.

Agricultural products imported through tariff quotas and with smaller tariff cuts to provide some access to the market. Flexibility available for the agriculture of all the countries.

- Зах зээлд нэвтрэх зарим боломж олгох зорилгоор тарифын квот тогтоож, бас тарифыг нь бага зэрэг бууруулан оруулдаг хөдөө аж ахуйн импортын бүтээгдэхүүн. Ийм уян хатан байдал бүх орны хөдөө аж ахуйн салбарт хамаатай.

SEPARATION OF RELEASE FROM FINAL DETERMINATION OF CUSTOMS DUTIES, TAXES, FEES AND CHARGES

(separating release from clearance procedures) Procedures allowing the release of goods prior to the final determination of Customs duties, taxes, fees, and charges, if such a determination is not done prior to, or upon arrival of the goods, or as rapidly as possible after arrival and provided that all other regulatory requirements have been met.
[Art. 7.3.1 TFA]

БАРАА ОЛГОХ АЖИЛЛАГААГ ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРЫГ, МӨН ТӨЛБӨР, ХУРААМЖИЙГ ЭЦЭСЛЭН ТОДОРХОЙЛОХ АЖИЛЛАГААНААС ЯЛГАН САЛГАХ

(бараа олгох ажиллагааг бүрдүүлэлтийн үйл ажиллагаанаас ялган салгах)
Гаалийн татвар, бусад татвар, хураамж, төлбөрийг бараа ирэхээс өмнө, эсхүл бараа ирэх үед, эсхүл бараа ирсэнээс хойш аль болон хурдан хугацаанд тодорхойлж чадахгүй бол тэдгээрийг эцэслэн тодорхойлохоос өмнө, гэхдээ бусад бүх журмын шаардлага хангагдсан тохиолдолд бараа олгох горим журам.
[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7.3.1]

SERVICE LEVEL AGREEMENTS

A contract between the service provider and the customer which formally defines the service and the related details.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТҮВШНИЙ ГЭРЭЭ

Үйлчилгээ үзүүлэгч болон харилцагч хоёрын хооронд байгуулсан гэрээ. Энэ гэрээнд холбогдох үйлчилгээ, түүнтэй холбогдсон дэлгэрэнгүй мэдээллийг албан ёсоор тодорхойлсон байдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIP'S GENERAL DECLARATION

Declaration (IMO FAL Form 1) conforming to the provisions of the
Annex to the Convention on Facilitation of Maritime Traffic, London,
1965. The general declaration is the basic document on arrival and departure providing information concerning the ship itself and summary information relating to the cargo, crew, passengers and voyage.

УСАН ОНГОЦНЫ ЕРӨНХИЙ МЭДҮҮЛЭГ

1965 онд Лондон хотноо батлагдсан Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенцийн хавсралтын заалтад нийцсэн мэдүүлэг (Олон улсын далайн тээврийн байгууллагын Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц (IMCO FAL)-ийн загвар маягт 1). Уг ерөнхий мэдүүлэг нь усан онгоц ирсэн, явсан тухай үндсэн бичиг баримт бөгөөд түүнд тухайн усан онгоцны талаарх мэдээлэл, мөн ачаа бараа, багийн гишүүд, зорчигчид, аяллын маршруттай холбогдсон товч мэдээлэл агуулагдана.

SHIP'S MANIFEST

An instrument in writing containing a list of the shipments comprising the cargo of the vessel, signed by the captain.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

УСАН ОНГОЦНЫ МАНИФЕСТ

Усан онгоцны ачаанаас бүрдсэн ачааны жагсаалт агуулсан, тухайн усан онгоцны ахмадын гарын үсэг бүхий, бичгээр үйлдсэн баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIPMENT

An identifiable collection of one or more Trade Items (available to be) transported together from the Seller (Original Consignor/ Shipper), to the Buyer (Final/ Ultimate Consignee).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧИЛТ

Худалдагч (Анхны илгээгч/Ачигч)-аас Худалдан авагч (Эцсийн/Сүүлчийн Хүлээн авагч) хүртэл хамтад нь тээвэрлэх (тээвэрлэхэд бэлэн байгаа) нэг буюу хэд хэдэн худалдааны барааны ялгаран танигдах цуглуулга.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIPPER

A party that tenders goods for transportation, as opposed to a carrier, who transports shipments.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)

Ачаа тээвэрлэдэг тээвэрлэгчээс өөр, барааг тээвэрлүүлэх санал тавигч тал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIPPER'S DECLARATION (OF DANGEROUS GOODS)

Document prepared by a consignor or shipper to certify that the dangerous goods being transported have been packaged, labeled, and declared in accordance with the standard international shipping regulations.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)-ИЙН МЭДҮҮЛЭГ (АЮУЛТАЙ БАРААНЫ ТУХАЙ)

Тээвэрлэж буй аюултай барааг олон улсын тээврийн стандарт журмын дагуу савласан, шошго тавьсан, мэдүүлсэн болохыг гэрчилж, ачаа илгээгчээс, эсхүл ачаа бэлтгэгч (ачигч компани)-ээс бэлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIPPER'S INTERMODAL WEIGHT CERTIFICATE (FIATA-SIC)

Document issued by a shipper to a freight forwarder for certification of the gross weight to comply with weight restriction regulations in certain countries (eg. In the USA the Intermodal Safe Container Act, 1992).
[FIATA]

АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)-ИЙН ОЛОН ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН (ХОЛИМОГ ТЭЭВРИЙН) ЖИНГИЙН ГЭРЧИЛГЭЭ

Ачаа бэлтгэгч (ачигч компани)-ээс тээвэр зуучид олгосон, зарим улсад байдаг жингийн хязгаарлалтын тухай журам (жишээлбэл, АНУ-д 1992 оны Олон төрлийн тээврийн (холимог тээврийн) зориулалттай аюулгүй чингэлгийн тухай хууль)-д нийцсэн болохыг гэрчилсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)
[Тээвэр зуучдын нийгэмлэгүүдийн олон улсын холбоо]

SHIPPING INSTRUCTIONS; SHIPPER'S LETTER OF INSTRUCTION (SLI); CONSIGNMENT INSTRUCTIONS

Document advising details of cargo and exporter's requirements for its physical movement. Instructions from either the seller/shipper or the buyer/consignee to a freight forwarder, carrier or their agent, or other provider of a service, enabling the movement of goods and associated activities. The following functions can be covered: movement and handling of goods (shipping, forwarding and stowage), Customs formalities, distribution of documents, allocation of documents (freight and charges for the connected operations), special instructions (insurance, dangerous goods, goods release, additional documents required).
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)-ИЙН ЗААВАР; АЧАА БЭЛТГЭГЧ (АЧИГЧ КОМПАНИ)-ИЙН ЗААВАРЧИЛГАА БҮХИЙ ЗАХИДАЛ; АЧААНЫ ЗААВАР

Ачааны талаар, мөн түүний биет хөдөлгөөнтэй холбогдуулан тавих экспортлогчийн шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан бичиг баримт. Худалдагч/ачаа бэлтгэгч (ачигч компани)-ээс, эсхүл худалдан авагч/бараа хүлээн авагчаас аль нэг тээвэр зууч, тээвэрлэгч, эсхүл тэдгээрийн агент, эсхүл үйлчилгээ үзүүлэгч бусад этгээдэд барааг хөдөлгөх болон түүнтэй холбогдсон үйл ажиллагааг явуулах талаар өгсөн заавар. Энэ зааварт дараах зүйлийг тусгасан байж болно: барааг хөдөлгөх, арчлан хамгаалах (ачуулах, явуулах, эмх цэгцтэй өрж ачих), гаалийн ёс журмын ажиллагаа, бичиг баримт түгээх, бичиг баримт хуваарилах (тээврийн зардал болон түүнтэй холбогдсон үйл ажиллагааны төлбөр), тусгай зааварчилгаа (даатгал, аюултай бараа, бараа олгох, шаардлагатай нэмэлт бичиг баримт).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIPPING MARKS

An identifying word, number, or symbol placed on freight to designate the consignee, destination, weight, and related information.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧИЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Тухайн ачилт, чиглэл, жин болон холбогдох мэдээллийг тэмдэглэх зорилгоор ачаан дээр тавьсан ялган таних үг, тоо, эсхүл ялгах тэмдэг.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIPPING NOTE (S/N)

Document provided by the shipper or his agent to the carrier, multimodal transport operator, terminal or other receiving authority, giving information about export consignments offered for transport, and providing for the necessary receipts and declarations of liability.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧИЛТЫН ХУУДАС

Ачаа бэлтгэгч (ачигч компани) буюу түүний түүний агентаас тээвэрлэгч, холимог тээврийн оператор, терминал, өөр бусад хүлээн авагч байгууллагаад өгсөн бичиг баримт. Энэ бичиг баримтад тээвэрлэхийг санал болгосон экспортын ачааны талаарх мэдээллийг тусгасан, шаардлагатай баримт тасалбарууд, хариуцлагын тухай мэдүүлгүүдийг дурдсан байна. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHIPPING ORDER

Document accompanying the shipment during the transfer to the ship. It is written instructions of the owner of the goods to the person representing his interests, about the delivery of the cargo to the recipient. It is issued in several copies and contains: the name of the vessel, the date of compilation, the port of departure and destination, the marking, the name of the cargo, the type of package, weight, volume, consignor identification and consignee identification. A shipping order is not a document of title on the shipped goods.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧИЛТЫН ЗАХИАЛГА

Ачааг усан онгоц руу шилжүүлэх үед түүнийг дагалдах бичиг баримт. Энэ нь тухайн барааг эзэмшигчээс түүний эрх ашгийг төлөөлөх этгээдэд бичсэн заавар бөгөөд тухайн ачааг бараа хүлээн авагчид хүргэж өгөх тухай юм. Түүнийг хэд хэдэн хувь үйлдсэн байх бөгөөд түүнд дараах зүйлийг бичсэн байна: усан онгоцны нэр, түүнийг үйлдсэн огноо, явах болон очих боомт, тэмдэглэгээ, ачааны нэр, сав боодлын төрөл, жин, эзлэхүүн, илгээгчийн тодорхойлолт ба хүлээн авагчийн тодорхойлолт. Ачилтын захиалга нь ачуулсан барааг эзэмших (өмчлөх) эрхийн бичиг биш юм.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SHORT SHIPPED

Cargo manifested but not loaded.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧАГДААГҮЙ АЧАА

Манифест бичигдсэн, гэхдээ ачигдаагүй ачаа.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SIGHT DRAFT

A draft payable upon presentation to the drawee.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ҮЗҮҮЛЭГЧИЙН ВЕКСЕЛЬ (ЧЕК, ТРАТТА)

Төлбөр хариуцагчид үзүүлсэн тохиолдолд мөнгө нь төлөгдөх ёстой вексель (чек, тратта).

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

“SINGAPORE ISSUES”

Four issues introduced to the WTO agenda at the December 1996 WTO Ministerial Conference in Singapore: trade and investment, trade and competition policy, transparency in government procurement, and trade facilitation. Only trade facilitation remained on the “core agenda” (issues of negotiation, on which a possible WTO agreement is in view) after July 2004.

[WTO/Singapore issues]

“СИНГАПУРЫН АСУУДЛУУД”

1996 оны 12 дугаар сард Сингапур улсад болсон ДХБ-ын Сайд нарын Бага хурлын үеэр тавигдсан 4 асуудал: худалдаа ба хөрөнгө оруулалт, худалдаа ба өрсөлдөөний бодлого, засгийн газрын худалдан авалтын ил тод байдал, худалдааг хөнгөвчлөх асуудал. 2004 оны 7 дугаар сараас хойш зөвхөн худалдааг хөнгөвчлөх асуудал “гол хэлэлцэх асуудал” болж үлдсэн. Олон жил хэлэлцээ хийсний үр дүнд 2013 онд ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр байгуулагдсан.

[ДХБ/Сингапурын асуудлууд]

SINGLE ADMINISTRATIVE DOCUMENT (SAD)

A document used within the European Union for export, import and transit procedures. Has unified about 200 different Customs and statistical forms used earlier in the countries of the European Union. It is based on the UNECE Layout Key for trade and transport documents. The SAD is increasingly used in countries outside the European Union; e.g. EurAsEC countries decided to apply it from 1 January 2007. Using one single document reduces the administrative burden and increases the standardization and harmonization of trade data collection.

[European Union/SAD]

ЗАХИРГААНЫ НЭГДСЭН БИЧИГ БАРИМТ

Экспорт, импорт, дамжин өнгөрөх горимын зориулалтаар Европын холбооны хүрээнд хэрэглэдэг бичиг баримт. Өмнө нь Европын холбооны улсуудад хэрэглэж байсан янз бүрийн гаалийн болон статистикийн 200 орчим маягтыг нэгтгэсэн. Энэ нь НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын худалдаа, тээврийн бичиг баримтын үлгэрчилсэн загварыг үндэс болгосон. Захиргааны нэгдсэн бичиг баримтыг Европын холбоноос гадна олон улс оронд хэрэглэж байна; жишээлбэл, Евразийн эдийн засгийн холбооны орнууд түүнийг 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөхөөр шийдсэн байдаг. Нэгдсэн нэг бичиг баримт хэрэглэснээр захиргааны дарамт багасч, худалдааны мэдээлэл цуглуулах явдлыг стандартчилах, уялдуулах ажил сайжирна.

[Европын холбоо/Захиргааны нэгдсэн бичиг баримт]

SINGLE ENVIRONMENT

An approach that brings together Information and Computer Technology systems (ICT) that work collaboratively to aggregate data related to a transaction with the view to submitting information to satisfy a regulatory requirement. Usually, the systems will establish a certain level of trust and data protection between themselves in order to seamlessly share the information. This can be completely transparent to the trader. This collaboration between IT systems is, of course, only the technical side of a much larger trade facilitation process of harmonizing and streamlining procedures, business processes and data elements (as described in Recommendation n°34). [UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms] [UN/CEFACT/Rec. 34]

НЭГ ЦОНХНЫ ОРЧИН

Дүрэм журмын шаардлага хангах зорилгоор мэдээлэл дамжуулахын тулд ямар нэг хэлцэлтэй холбогдсон мэдээллийг хамтран нийлүүлж нэгтгэх мэдээллийн технологийн (компьютерийн технологийн) системүүдийг холбох арга. Мэдээллийг саадгүй (тасралтгүй) хуваалцах зорилгоор эдгээр систем нь ерөнхийдөө тодорхой түвшинд итгэл даах, мэдээлэл хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ нь худалдаа эрхлэгч нарт бүх талаараа ил тод байх боломжтой. Мэдээллийн технологийн системүүд ийнхүү нэгдэж ажиллах нь горим журмууд, бизнес процессууд болон мэдээллийн элементүүдийг уялдуулж, цэгцтэй болгох замаар худалдааг хөнгөвчлөх том ажлын зөвхөн техникийн талын асуудал юм (Зөвлөмж №34-д зааснаар).
[Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт] [НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв / Зөвлөмж №34]

SINGLE SUBMISSION PORTAL (SSP)

Allows traders to submit all of the information related to a specific activity in a single electronic platform. This platform then redistributes the information to all participants within that portal. A Single Submission Portal differs from a Single Window in that it may or may not handle regulatory procedures and it may or may not be the only portal within a market.
[UN/CEFACT Technical Note on Terminology for Single Window and other electronic platforms] [UN/CEFACT/Rec. 37]

МЭДЭЭЛЛИЙГ НЭГ ДОРООС ИЛГЭЭХ ПОРТАЛ

Энэ портал нь тодорхой нэг үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийг цахим нэг платформоор дамжуулан илгээх боломжийг худалдаа эрхлэгч нарт олгодог. Энэ платформ нь уг мэдээллийг цааш нь энэ платформд нэгдсэн бүх оролцогч нарт дахин түгээнэ. Мэдээллийг нэг дор илгээх портал нь Нэг цонхноос дараах шинжээр ялгагдана: энэ портал нь хэм хэмжээ тогтоосон горим журмуудын хэрэгжилтийг хангах албагүй, мөн зах зээлд байх ёстой ганц портал биш.
[Нэг цонх болон бусад цахим платформын нэр томьёоны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Техникийн баримт]

SINGLE WINDOW (SW)

A facility that allows parties involved in trade and transport to lodge standardized information and documents with a single-entry point to fulfill all import, export, and transit-related regulatory requirements. If information is electronic, then individual data elements should only be submitted once.

Note:
UN/CEFACT Recommendation No. 33.

НЭГ ЦОНХ

Худалдаа, тээврийн үйл ажиллагаанд оролцогч талууд импорт, экспортын, мөн дамжин өнгөрөхтэй холбоотой дүрэм журмын шаардлагыг хангах үүднээс стандарт хангасан мэдээлэл, бичиг баримт нэг цэгт гаргаж өгөх боломжтой байгууламж. Хэрэв мэдээлэл цахим хэлбэртэй бол өгөгдлийн бие даасан элементүүдийг зөвхөн нэг удаа оруулна.

Жич:
НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн зөвлөмж No.33.

SINGLE WINDOW INTEROPERABILITY

The ability of two or more Single Window systems or their components to exchange and use information across borders without additional effort on the part of the user.
[UN/CEFACT/Rec. 36]

НЭГ ЦОНХНЫ СИСТЕМИЙН ХАРИЛЦАН ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ БАЙДАЛ

Нэг цонхны хоёр буюу хэд хэдэн систем, эсхүл тэдгээрийн бүрдэл хэсгүүд хэрэглэгч нарт нэмэлт дарамт учруулалгүйгээр мэдээллийг хил дамнуулан солилцох, ашиглах боломжтой байх.
[UN/CEHҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Зөвлөмж №36]

SMART CONTRACT

A computer program that encodes business logic and executes by itself when certain pre-defined conditions are met. This self-execution is not launched, or at least not directly by human intervention.
[UN/CEFACT White Paper on Technical Applications of Blockchain to UN/CEFACT deliverables]

СМАРТ-КОНТРАКТ (УХААЛАГ ХЭЛЦЭЛ)

Бизнесийн логикийг кодлон шифрлэж, урьдчилан тодорхойлсон зарим нөхцөл хангагдсан тохиолдолд өөрөө ажиллах компьютерийн програм.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн бүтээгдэхүүнд блокчэйн ашиглах техник арга ажиллагааны тухай НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн цагаан хуудас]

SMGS

(See Agreement on International Goods Traffic)

СМГС

(“Олон улсын төмөр замын ачааны харилцааны тухай хэлэлцээр”-ийг үз)

SMGS CONSIGNMENT NOTE

A uniform transport document used for rail transport between the SMGS member countries, as well as in communication between the SMGS member countries and other countries.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СМГС-ИЙН АЧААНЫ ДАГАЛДАХ (ХУУДАС)

СМГС-ийн гишүүн орнуудын хооронд, мөн түүнчлэн СМГС-ийн гишүүн орнууд болон бусад орнуудын хооронд явагдах төмөр замын тээвэрт ашигладаг тээврийн нэгдсэн нэг бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SMUGGLING

Customs offence consisting in the movement of goods across a Customs frontier in any clandestine manner, thereby evading Customs control.

Notes:
1. This term may also cover certain violations of Customs legislation relating to the possession and movement of goods within the Customs territory.
2. In certain countries:
- The concept of clandestine movement of goods across frontiers is not a mandatory feature of smuggling.
- An offence is not defined as smuggling unless it is intentional.

Nairobi Convention.

БАРААГ ХУУЛЬ БУСААР ХИЛ НЭВТРҮҮЛЭХ (КОНТРАБАНД)

Барааг аливаа хууль бусаар гаалийн хил нэвтрүүлж, гаалийн хяналтаас зайлсхийх гаалийн зөрчил.

Жич:
1. Энэхүү нэр томьёонд мөн гаалийн нутаг дэвсгэрт байгаа барааг эзэмших, хөдөлгөхтэй холбогдсон, гаалийн хууль тогтоомж зөрчсөн зарим үйлдэл хамаарна.
2. Зарим улсад:
- Барааг нууцаар хил давуулах тухай ойлголт нь контрабандын хэргийг тодорхойлоход заавал харгалзан үзэх онцлог шинж (гол үзүүлэлт) болдоггүй.
- Аливаа зөрчил олон улсын шинжтэй биш бол контрабанд гэж үздэггүй.

Найробийн конвенц

SPECIAL AND DIFFERENTIAL TREATMENT FOR DEVELOPING COUNTRY MEMBERS AND LEAST-DEVELOPED COUNTRY MEMBERS OBLIGATIONS (SDT)

Assistance and support for capacity building should be provided to help developing and least-developed country Members implement the provisions of Trade Facilitation Agreement, in accordance with their nature and scope.
[Art. 13.2 TFA]

ХӨГЖИЖ БУЙ ГИШҮҮН ОРНУУД БОЛОН БУУРАЙ ХӨГЖИЛТЭЙ ГИШҮҮН ОРНУУДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ БОЛОН ЯЛГАВАРТАЙ НӨХЦӨЛТЭЙ ХОЛБОГДСОН ҮҮРГҮҮД

Чадавхыг бэхжүүлэх зорилготой тусламж, дэмжлэгийг хөгжиж буй гишүүн орнууд болон буурай хөгжилтэй гишүүн орнууд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэхэд тус дэм болох зорилгоор тэдгээрийн мөн чанар, үйлчлэх хүрээний дагуу үзүүлнэ.
[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 13.2]

SPECIAL PRODUCTS (SP)

In Doha Round agriculture: products for which developing countries are to be given extra flexibility in market access for food and livelihood security and rural development.

ТОДОРХОЙ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Дохагийн раундын хөдөө аж ахуйн барааны хэлэлцээ: хүнсний болон амьжиргааны баталгаа, мөн хөдөөгийн хөгжлийн зорилгоор зах зээлд нэвтрэхэд хөгжиж буй орнуудад илүү уян хатан нөхцөл олговол зохих бүтээгдэхүүн.

SPECIAL REQUIREMENTS RELATED TO BORDER MEASURES

The legal provision contained in the TRIPS Agreement (section 4). It allows the right holder's intellectual property, which has reasonable grounds to suspect that may be the import of goods with counterfeit trademark or produced in violation of copyright, to submit to the competent administrative or judicial authority for suspension by the Customs authorities of the release of such goods for free circulation.
[WTO/TRIPS]

ХИЛИЙН АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБОГДСОН ТУСГАЙ ШААРДЛАГУУД

Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр (4 дэх хэсэг)-т байгаа эрх зүйн заалт. Энэ нь оюуны өмчийн эрх эзэмшигчийн оюуны өмч хуурамч барааны тэмдэгтэй, эсхүл зохиогчийн эрх зөрчиж үйлдвэрлэсэн импортын бараа байж болзошгүй гэсэн сэжиг бүхий үндэслэлээр тийм барааг чөлөөт эргэлтэд оруулахыг гаалийн байгууллагаар саатуулах зорилгоор эрх бүхий захиргааны буюу шүүхийн байгууллагад хандах боломж олгож байгаа.
[ДХБ/ Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр]

SPECIFIC DUTIES AND TAXES

Duties and taxes which are calculated on a basis other than value.

Note
The basis for calculation may be, for example: gross or net weight, the number of items, the volume, the length, the alcoholic strength by volume.

БИЕТ ХЭМЖИГДЭХҮҮНЭЭР ТОГТООСОН ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР

Үнийн дүнгээс бусад зүйлийг үндэслэн тооцдог гаалийн болон бусад татвар.

Жич:
Татвар тооцох суурь нь тухайлбал дараах зүйлс байж болно: цэвэр, бохир жин, барааны тоо, хэмжээ, эзлэхүүн, урт, спирт агууламжийн хэмжээ.

SPECIFIC TARIFF

Import tax expressed in an amount of money per unit imported. Specific tariffs are trade barriers designed to reduce imports into countries.

http://www.businessdictionary.com/definition/specific-tariff.html

БИЕТ ХЭМЖИГДЭХҮҮНЭЭР ТОГТООСОН ТАРИФ

Импортын барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон импортын тариф. Биет хэмжигдэхүүнээр тогтоосон тариф нь улс орнуудын импортыг буруулах зориулалттай худалдааны саад тотгор юм.
http://www.businessdictionary.com/definition/specific-tariff.html

STANDARD

Norm, sample, reference, accepted as initial for comparing with other objects.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СТАНДАРТ

Бусад обьекттой харьцуулах зорилгоор анхных гэж хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, загвар, эх хэмжүүр (эталон).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STANDARD BILL OF LADING

A transport document of the standard form accepted in international practice for the carriage of goods that certifies its loading, carriage and right to receive.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН СТАНДАРТ БАРИМТ

Бараа тээвэрлэх зорилгоор олон улсын практикт хүлээн зөвшөөрөгдсөн стандарт хэлбэр бүхий, бараа ачих, тээвэрлэх, мөн түүнчлэн бараа хүлээн авах эрхийг гэрчлэх тээврийн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STANDARD CONTAINER

Designated size - twenty linear feet = 610 cm.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СТАНДАРТ ЧИНГЭЛЭГ

Тогтсон хэмжээс: уртаашаа 20 фуут = 610 см.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STANDARD INTERNATIONAL TRADE CLASSIFICATION (SITC)

A standard numerical code system developed by the United Nations to classify commodities used in international trade.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ СТАНДАРТ АНГИЛАЛ

Олон улсын худалдаанд ашиглаж буй барааг ангилах зорилгоор Нэгдсэн Үндэстний байгууллагаас боловсруулсан тоон код бүхий стандарт систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STANDARDIZATION

A universally agreed set of guidelines seeking to facilitate international trade by harmonizing individual countries' trade-relevant regulations. Standardized input parts permit the creation of effective cross-country supply chain.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СТАНДАРТЧИЛАЛ

Улс орнуудын худалдаатай холбогдсон дүрэм журмыг уялдуулах замаар олон улсын худалдааг хөнгөвчлөх зорилготой дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн багц заавар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STATISTICAL DOCUMENT (EXPORT)

Document in which an exporter provides information about exported goods required by the body responsible for the collection of international trade statistics.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СТАТИСТИКИЙН БИЧИГ БАРИМТ (ЭКСПОРТ)

Олон улсын худалдааны статистик цуглуулах үүрэг бүхий байгууллагаас шаардсан, экспортлогчийн гаргаж өгсөн экспортын барааны мэдээлэл бүхий бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STATISTICAL DOCUMENT (IMPORT)

Document in which an importer provides information about imported goods required by the body responsible for the collection of international trade statistics.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СТАТИСТИКИЙН БИЧИГ БАРИМТ (ИМПОРТ)

Олон улсын худалдааны статистик цуглуулах үүрэг бүхий байгууллагаас шаардсан, импортлогчийн гаргаж өгсөн импортын барааны мэдээлэл бүхий бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STEVEDORE

Name of specialized organizations and firms engaged in loading and unloading vessels; a representative of a stevedoring organization or firm exercising direct control over the loading and unloading of vessels.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СТИВИДОР

Усан онгоцонд ачаа ачих, буулгах ажил эрхэлдэг мэргэжлийн байгууллага, компанийн нэр; усан онгоцонд ачаа ачих, буулгах ажилд шууд хяналт тавьдаг стивидор байгууллага, компанийн төлөөлөгч.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STOCK NOTE (TIMBER QUOTATION)

A detailed specification for sawnwood offered for sale on the foreign market. Stocknote indicates: the number of the sink, the port of shipment, the breed, the size, the grade, the date of shipment and the total amount of sawn timber separately for the varieties. The document also indicates the type of delivery of the goods - in packages or in bulk.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

СТОКНОТ (МОДНЫ ҮНИЙН САНАЛ)

Гадаадын зах зээлд борлуулахаар санал болгосон зүсмэл модны дэлгэрэнгүй (техникийн) тодорхойлолт. Стокнотод дараах зүйлийг заасан байна: стокнотын дугаар, ачсан боомт, үүлдэр (төрөл), хэмжээ, зэрэглэл, ачсан огноо, зүсмэл модны нийт тоо хэмжээ төрөл тус бүрээр. Уг бичиг баримтад бас тухайн барааг хүргэх хэлбэрийг заасан байна: савласан, эсхүл задгай.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STORES

- Stores for consumption; and
- Stores to be taken away.

Note:
Special Annex J, Chapter 4, to the Revised Kyoto Convention.

ОЛОН УЛСЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРАА

- Хэрэглэх зориулалттай бараа; мөн
- Авч явах зориулалттай бараа.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 4 дүгээр бүлэг.

STORES DECLARATION

Documents providing the particulars concerning stores carried on board the means of transport, to be presented as required by the Customs.

ОЛОН УЛСЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРААНЫ МЭДҮҮЛЭГ

Тухайн тээврийн хэрэгсэлд авч яваа олон улсын тээврийн үйлчилгээний бараанд холбогдох мэдээллийг агуулсан, гаалийн байгууллагад гаргаж өгөх шаардлагатай бичиг баримт.

Note:
The Annex to the Convention on Facilitation of International Maritime Traffic, London, 1965, provides for a Ship's stores declaration (Model Form IMO FAL Form 3). Usually only the following stores need to be listed in detail in the Shi p's stores declaration: narcotics for medical use, tobacco products, beer, spirits, wines. Some countries require some or all of the information to be incorporated in the Ship's cargo declaration.
The Annex to the IMO Convention contains provisions limiting the conditions under which the presentation of Stores declaration can be required, whilst Annex 9 to the Convention on International Civil Aviation, Chicago, 1944, provides for the abolition of such requirement in respect of stores remaining on board an aircraft. Annex A.4. to the Kyoto Convention of 1974 takes into account the provisions of the above instruments.

Жич:
1965 онд Лондон хотноо батлагдсан Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенцийн хавсралтад Усан онгоцны Олон улсын тээврийн үйлчилгээний барааны мэдүүлэг (Олон улсын далайн тээврийн байгууллагын Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц (IMCO FAL)-ийн загвар маягт 3)-ийн талаар заасан байдаг. Тухайн усан онгоцны олон улсын тээврийн үйлчилгээний барааны мэдүүлэгт зөвхөн дараах төрлийн олон улсын тээврийн үйлчилгээний барааг дэлгэрэнгүй байдлаар жагсаан бичих ёстой: эмчилгээний зориулалттай мансууруулах бодис, тамхины төрлийн бүтээгдэхүүн, пиво, спирт, вино. Зарим улс Усан онгоцны мэдүүлэгт зарим төрлийн, эсхүл бүх мэдээлэл оруулахыг шаарддаг.
Олон улсын далайн тээврийн байгууллагын конвенцийн хавсралтад Олон улсын тээврийн үйлчилгээний барааны мэдүүлэг гаргаж өгөхөд тавих нөхцөл, шаардлагыг хязгаарласан заалт байдаг. Тэгвэл 1944 онд Чикаго хотноо батлагдсан Олон улсын иргэний агаарын тээврийн тухай конвенцийн хавсралт 9-д нисэх онгоцонд үлдсэн олон улсын тээврийн үйлчилгээний барааны хувьд дээрх нөхцөл, шаардлагыг үгүй болгох талаар заасан. Киотогийн конвенцийн хавсралт А.4-т дээрх заалтуудыг анхаарч авч үзсэн байдаг.

STORES FOR CONSUMPTION

- Goods intended for consumption by the passengers and the crew on board vessels, aircraft or trains, whether or not sold and
- goods necessary for the operation and maintenance of vessels, aircraft or trains including fuel and lubricants but excluding spare parts and equipment

which are either on board upon arrival or are taken on board during the stay in the Customs territory of vessels, aircraft or trains used, or intended to be used, in international traffic for the transport of persons for remuneration or for the industrial or commercial transport of goods, whether or not for remuneration.

ХЭРЭГЛЭХ ЗОРИУЛАЛТТАЙ БАРАА

Хүмүүсийг төлбөртэй тээвэрлэх, эсхүл үйлдвэрлэлийн буюу худалдааны зориулалттай барааг төлбөртэй, эсхүл төлбөргүй тээвэрлэх зориулалтаар олон улсын тээвэрт ашиглаж буй, эсхүл ашиглахаар төлөвлөж буй усан онгоц, нисэх онгоц, эсхүл галт тэрэг хилийн чанадаас ирэх үед дотор нь байсан, эсхүл тэдгээр нь гаалийн нутаг дэвсгэрт зогсож байх үед дотор нь оруулсан бөгөөд
- хөлөг онгоц, агаарын хөлөг, эсхүл галт тэргэнд суусан зорчигчид болон багийн гишүүд төлбөртэй, эсхүл төлбөргүй хэрэглэх зориулалттай бараа; мөн

Note:
Specific Annex J, Chapter 4 of the revised Kyoto Convention.

- хөлөг онгоц, агаарын хөлөг, эсхүл галт тэргийг ажиллуулах болон тэдгээрт үйлчилгээ хийхэд шаардлагатай, сэлбэг болон тоног төхөөрөмжөөс бусад бараа, түүний дотор шатахуун болон тосолгооны материал.
Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 4 дүгээр бүлэг.

STORES REQUISITION

Document issued within an enterprise ordering the taking out of stock of goods ordered by a customer.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ОЛОН УЛСЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРААНЫ ЗАРЛАГЫН ПАДААН (ЦОХДОС, НАРИАД)

Харилцагчийн захиалсан барааг агуулахаас гаргах тухай, аль нэг аж ахуйн нэгж (үйлдвэрийн газар)-ын хүрээнд үйлдсэн бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STORES TO BE TAKEN AWAY

Goods for sale to the passengers and the crew of vessels and aircraft with a view to being landed, which are either on board upon arrival or are taken on board during the stay in the Customs territory of vessels and aircraft used, or intended to be used, in international traffic for the transport of persons for remuneration or for the industrial or commercial transport of goods, whether or not for remuneration.

Note:
Specific Annex J, Chapter 4 of the revised Kyoto Convention.

АВЧ ЯВАХ ЗОРИУЛАЛТТАЙ БАРАА

Хүмүүсийг төлбөртэй тээвэрлэх, эсхүл үйлдвэрлэлийн буюу худалдааны зориулалттай барааг төлбөртэй, эсхүл төлбөргүй тээвэрлэх зориулалтаар олон улсын тээвэрт ашиглаж буй, эсхүл ашиглахаар төлөвлөж буй усан онгоц, нисэх онгоц, эсхүл галт тэрэг хилийн чанадаас ирэх үед дотор нь байсан, эсхүл тэдгээр нь гаалийн нутаг дэвсгэрт зогсож байх үед дотор нь оруулсан бөгөөд газардах дөхсөн хөлөг онгоц болон агаарын хөлгийн зорчигчид болон багийн гишүүдэд худалдан борлуулах зориулалттай бараа.
Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 4 дүгээр бүлэг.

STOWAGE

Stowage of cargo in the hold of the vessel with rational use of the place and with the intention to avoid cargo loss; cost of stowage.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧААГ УСАН ОНГОЦНЫ ЗООРИНД ЭМХ ЦЭГЦТЭЙ ӨРЖ АЧИХ

Зай завсрыг зөв зохистой ашшиглах, ачаа үрэгдэж сүйдэхээс зайлсхийх зорилгоор ачааг усан онгоцны зооринд эмх цэгцтэй өрж ачих; ачааг усан онгоцны зооринд эмх цэгцтэй өрж ачсан хөлс
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

STREAMLINE

To simplify, to modernize processes or procedures.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЦЭГЦТЭЙ БОЛГОХ

Процесс (технологи ажиллагаа) болон процедур (горим журам)-ыг хялбарчлах, шинэчлэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SUBSIDY

An economic benefit granted by a government, directly or indirectly, to producers of certain goods or services to strengthen their competitive position. Some economic support measures (export subsidies and local content subsidies) are prohibited because they distort trade, while others must include a commitment to reduce them. A subsidy may cause injury even though it is permitted.

ТАТААС

Тодорхой бараа, үйлчилгээ үйлдвэрлэгч нарт тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор төрөөс шууд, эсхүл шууд бус байдлаар олгосон эдийн засгийн хөнгөлөлт. Эдийн засгийн дэмжлэг (татаас) үзүүлэх зарим арга хэмжээ (экспортын татаас, орон нутгийн шинжтэй татаас) нь худалдаанд саад тотгор учруулдаг тул хориглодог. Бусад тийм арга хэмжээний хувьд тэдгээрийг бууруулах амлалт өгөх ёстой байдаг. Татаас нь зөвшөөрөгдсөн ч гэсэн хор хохирол учруулж болзошгүй байдаг.

SUBSTANTIAL TRANSFORMATION CRITERION

The criterion according to which origin is determined by regarding as the country of origin the country in which the last substantial manufacturing or processing, deemed sufficient to give the commodity its essential character, has been carried out.

Note:

Annex D.1. to the Kyoto Convention of 1974 and Specific Annex K, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ҮЛЭМЖ ХЭМЖЭЭНИЙ БОЛОВСРУУЛАЛТ ХИЙГДСЭН БАЙХ ШАЛГУУР

Тухайн барааны үндсэн шинж байдлыг бүрдүүлэхэд хангалттай гэж үзсэн үйлдвэрлэлийн, эсхүл боловсруулалтын эцсийн шатны нэн чухал ажиллагаа явагдсан улсыг гарал үүслийн улс гэж үзэн гарал үүслийг тодорхойлох учиртай шалгуур.

Жич:

1974 оны Киотогийн конвенцийн хавсралт D.1., шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт К-гийн 1 дүгээр бүлэг.

SUPPLIER

Person or organization that provides something needed such as a product or service.

НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг хэрэгцээтэй зүйлс нийлүүлдэг этгээд, эсхүл байгууллага.

SUPPLY CHAIN

Logistic chain; International Supply Chain is a system of relationships, measures and people, which consists, in particular, of producers, exporters, brokers, transport operators, intermediaries, port operators, airports, terminals, warehouse operators, distributors, etc.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА НИЙЛҮҮЛЭХ СҮЛЖЭЭ

Ложистикийн сүлжээ; Бараа нийлүүлэх олон улсын сүлжээ гэж харилцаа, арга хэмжээ, хүмүүс, ялангуяа, үйлдвэрлэгч, экспортлогч, зуучлагч, тээврийн оператор, завсрын этгээд, боомтын оператор, нисэх онгоцны буудал, терминал, агуулахын оператор, түгээгч, г.м.-ийн систем.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SUPPLY CHAIN MANAGEMENT

SCM plans and manages the supply chain, i.e. the entire production and distribution process of a good from its raw materials to the final sale to the customer. The supply chain usually includes third parties like suppliers, wholesalers or intermediaries, which are frequently located in different countries. Thus, efficient inter-country SCM crucially depends on simplified and standardized border-crossing procedures. Optimizing the supply chain can attain substantial cost reductions, can boost the competitiveness of firms and can increase their consumer-friendliness by producing goods, which are tailored to the customers' needs.

БАРАА НИЙЛҮҮЛЭХ СҮЛЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

Бараа нийлүүлэх сүлжээний менежмент нь бараа нийлүүлэх сүлжээг, өөрөөр хэлбэл, ямар нэг барааг түүхий эдээс нь эхлээд эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж, хэрэглэгчид түгээх процессыг бүхэлд нь төлөвлөж, удирдан зохицуулдаг. Бараа нийлүүлэх сүлжээнд ихэвчлэн янз бүрийн улс оронд байрладаг ханган нийлүүлэгч, бөөний худалдаачин, эсхүл завсрын этгээд зэрэг гуравдагч этгээд бас хамаарна. Тиймээс, бараа нийлүүлэх сүлжээний менежментийг улс хооронд эрчимтэй явуулах нь хялбаршуулсан бөгөөд стандартчилагдсан хил нэвтрэх горимоос ихээхэн хамаардаг. Бараа нийлүүлэх сүлжээг оновчтой болгосноор өртөг зардал их хэмжээгээр буурч, компаниудын өрсөлдөх чадвар нэмэгдэж, мөн үйлчлүүлэгч нарын хэрэгцээ шаардлагыг хангасан захиалгат бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар хэрэглэгчдэд ээлтэй чанарыг нэмэгдүүлэх болно.

SURETY BOND

A bond insuring against loss or damage or for the completion of obligations; the obligation of the professional insurer in the field of financial guarantees to make payment that is required to be made in the event of default or the unlawful act of the principal; written guarantee that the principal will fulfil the obligation specified in the contract.

(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАТЛАН ДААГЧИЙН БАТАЛГАА

Хохирол, гэмтлээс, мөн үүргээ үл биелүүлэхээс сэргийлсэн баталгаа; үндсэн этгээд үүргээ үл гүйцэтгэсэн, эсхүл хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд төлбөл зохих төлбөрийг гүйцэтгэх санхүүгийн баталгааны салбар дахь мэргэжлийн даатгагчийн үүрэг; үндсэн этгээд гэрээнд заасан үүргээ гүйцэтгэнэ гэж бичгээр гаргасан баталгаа.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

SURETY

A natural or legal person (generally a bank or insurance company) who accepts responsibility in due legal form for the financial consequences of non-fulfilment of another's obligations to the Customs.

БАТЛАН ДААГЧ

Өөр этгээдээс гаалийн байгууллагын өмнө хүлээсэн үүргийн биелэлтээс үүдэн гарах санхүүгийн үр дагаврыг хариуцах тухайгаа хууль тогтоомжид заасан хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн аливаа хувь хүн, эсхүл хуулийн этгээд (ихэвчлэн банк буюу даатгалын компани).

T

TALLY SHEET

List of cargo, incoming and outgoing, checked by tally clerk on dock.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БҮРТГЭЛИЙН ХУУДАС

Усан онгоцны зогсоол дээрх бараа тоологчоос шалгасан, ирж байгаа болон явж байгаа ачааны жагсаалт
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TALLYMAN

A person/body controlling the loading/unloading of goods and checking the correspondence of the loaded/unloaded quantity of goods with the quantity marked in the accompanying documents.
(Trade Facilitation Terms: An English – Russian – Chinese Glossary, UNECE, 2019)

БАРАА ТООЛОГЧ

Ачиж, буулгаж байгаа ачааг тоолдог, мөн ачсан, буулгасан ачааны тоо дагалдах бичиг баримт дээр байгаа тоотой тохирч байгаа эсэхийг шалгадаг хүн.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TANK WAGON

Wagon designed for the bulk transport of liquids or gases.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ЦИСТЕРНТЭЙ ВАГОН

Шингэн болон хийн бүтээгдэхүүн задгайгаар тээвэрлэх зориулалттай вагон.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

TARE WEIGHT

Weight (mass) of a piece of logistics transport equipment including permanent equipment but excluding goods and loose accessories. This is the weight of the container and/or packaging materials only.
[UN/CEFACT/CCL]

САВНЫ ЖИН

Ложистикийн тээврийн тоног төхөөрөмжийн нэг ширхэгийн жин (масс). Үүнд түүний байнгын бүрдэл хэсгүүд хамаарах боловч бараа болон нэмэлт тоноглолууд хамаарахгүй. Энэ нь чингэлэг болон/эсхүл зөвхөн сав (баглаа) боодлын материалын жин болно.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан]

TARGET ZONE ARRANGEMENT

A monetary system under which countries pledge to maintain their exchange rates within a specific margin around agreed upon, fixed central exchange rates.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН СИСТЕМ

Улс орнууд өөрсдийн валютын ханшаа харилцан тохиролцож тогтоосон валютын төв ханштай ойролцоо тодорхой хэмжээнд тогтоон барих үүрэг амлалт авдаг валютын зохицуулалтын систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TARIFF

Tax or duty levied on goods transported from one customs territory to another (often, from one country to another). Tariffs are applied to imports of goods and may also be applied to exports. The tariff is designed to provide a level of protection to domestic producers and generate revenue for the government. The price of the goods being traded always increases when tariffs are imposed on products. The list of goods and their duties are established in the customs tariff.

ТАРИФ

Гаалийн нэг нутаг дэвсгэрээс нөгөөд (ихэвчлэн, нэг улсаас нөгөөд) тээвэрлэж байгаа барааND ногдуулдаг гаалийн буюу бусад татвар. Тарифыг импортын барааND мөрддөг бөгөөд экспортын барааND ч бас мөрдөж болно. Тариф нь дотоодын үйлдвэрлэгчдийг тодорхой түвшинд хамгаалах, мөн улсын төсвийн орлого бүрдүүлэх зорилготой юм. Бараа бүтээгдэхүүнд тариф ногдуулахад худалдаалагдаж буй барааны үнэ үргэлж нэмэгддэг. Бараа болон тэдгээрт ногдуулах гаалийн татварыг гаалийн тарифт жагсаасан байдаг.

TARIFF APPLIED

Duties that are actually charged on imports. These can be below the bound rates.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ТАРИФ

Импортын барааND бодитоор ногдуулж буй гаалийн татвар. Энэ нь (ДХБ-ын гишүүн орнуудын Үүрэг амлалтын жагсаалтад заасан) заавал мөрдөх хувь хэмжээнээс доогуур байж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TARIFF BARRIERS

A system of Customs tariffs impeding the importation or exportation of certain goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТАРИФЫН СААД ТОТГОР (ТАРИФЫН ХЯЗГААРЛАЛТ)

Зарим барааны импорт, экспортыг хязгаарласан (хүндрүүлсэн) гаалийн тарифын систем.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TARIFF BINDING

Commitment not to increase a rate of duty beyond an agreed level. Once a rate of duty is bound, it may not be raised without compensating the affected parties.

ТАРИФЫН ҮҮРЭГ АМЛАЛТ

Гаалийн татварын хувь хэмжээг тохиролцсон түвшнээс хэтрүүлэхгүй байлгах үүрэг амлалт. Гаалийн татварын дээд хувь хэмжээ ямар байхыг нэгэнт амласан бол хохирогч талд нөхөн төлбөр олгохгүйгээр түүнийг өсгөж болохгүй.

TARIFF CEILING

Any pre-set value or quantity, authorized for importation or exportation of given goods, during a specified period, with a reduction of the normal Customs duties, and beyond which the granting of the said tariff reduction may be suspended until the end of the period in question.

ТААЗ ТАРИФ (ТАРИФЫН ДЭЭД ХЯЗГААР)

Өгөгдсөн барааны гаалийн татварыг тодорхой хугацаанд хэвийн хэмжээнээс нь бууруулан оруулах, эсхүл гаргахыг зөвшөөрч, урьдчилан тогтоосон аливаа үнэ буюу тоо хэмжээ. Тийнхүү бууруулсан тарифыг уг үнэ буюу тоо хэмжээ хэтэрсэн тохиолдолд дээрх хугацаа дуустал түр зогсоож болно.

TARIFF CLASSIFICATION OF GOODS

Determination of the tariff subheading in a tariff nomenclature under which particular goods should be classified.

БАРААНЫ ТАРИФЫН АНГИЛАЛ

Тодорхой бараг ангилах тарифын жагсаалт дахь тарифын мөрийг тодорхойлох.

TARIFF CODE

Numerical code used to classify goods, to facilitate their identification in international trade. Commonly referred to as Customs tariff.

ТАРИФЫН КОД

Бараг олон улсын худалдаанд ялган таних явдлыг хялбарчлах зорилгоор түүнийг ангилахад ашигладаг тоон код. Ерөнхийдөө гаалийн тариф гэж нэрлэдэг.

TARIFF DESCRIPTION

Description of an article or product in accordance with the terminology used in the tariff nomenclature.

ТАРИФЫН БИЧИГЛЭЛ (ТАРИФЫН ТОДОРХОЙЛОЛТ)

Аливаа эд зүйл буюу бүтээгдэхүүнийг тарифын жагсаалтад хэрэглэдэг нэр томьёоны дагуу тодорхойлох.

TARIFF ESCALATION

Higher import duties on semi-processed products than on raw materials, and higher still on finished products. This practice protects domestic processing industries and discourages the development of processing activity in the countries where raw materials originate.

ТАРИФЫН ЭСКАЛАЦ

Хагас боловсруулсан бүтээгдэхүүнд түүхий эдээс арай өндөр импортын гаалийн татвар ногдуулах, түүнчлэн эцсийн бүтээгдэхүүнд бас л өндөр татвар ногдуулах. Энэхүү практик нь дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг хамгаалахын зэрэгцээ түүхий эд гаргадаг улс оронд боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх сонирхлыг бууруулдаг.

TARIFF HEADING (OR SUBHEADING)

The textual designation in a tariff nomenclature of a single commodity or a single group of related commodities.

ТАРИФЫН ЗҮЙЛ (ЭСХҮЛ МӨР)

Нэг бараг, эсхүл хамаарал бүхий нэг бүлэг бараг тарифын жагсаалтад бичгээр илэрхийлэх.

Notes:
1. For ease of reference, each tariff heading (or subheading) is identified by a code number which is used, inter alia, for the purposes of Customs declarations. For those countries or Customs or Economic Unions using a tariff based on the Nomenclature of the Harmonized Commodity Description and Coding System (generally referred to as the Harmonized System Nomenclature), this code number may be the heading or subheading number in the Nomenclature of the Harmonized Commodity Description and Coding System.
2. In certain countries the term “Tariff item” is used instead of “Tariff heading ”.

Жич:
1. Амар хялбар байх явдлыг хангах, тухайлбал, гаалийн мэдүүлгийн зорилгоор тарифын зүйл (эсхүл мөр) бүрийг код бүхий дугаараар ялган тэмдэглэсэн байдаг. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (ерөнхийдөө Уялдуулсан системийн жагсаалт гэдэг)-д үндэслэсэн тариф хэрэглэдэг улс орон, гаалийн буюу эдийн засгийн холбоодын хувьд энэ кодын дугаар нь Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн жагсаалт дахь зүйлийн, эсхүл мөрийн дугаар байна.
2. Зарим улсад “Тарифын зүйл” гэсэн нэр томьёоны оронд “Тарифын зүйл анги/ байршил” гэсэн нэр томьёог хэрэглэдэг.

TARIFF LINE

A product as defined in lists of tariff rates. Products can be sub-divided, the level of detail reflected in the number of digits in the Harmonized System (HS) code use to identify the product.
WTO Glossary

ТАРИФЫН МӨР

Тарифын хувь хэмжээний жагсаалтад дурдсан аливаа бүтээгдэхүүн. Бүтээгдэхүүнийг Уялдуулсан системийн код болон үндэсний задаргааны дагуу хэд хэдэн оронгоор задлан ангилсан байж болно.
ДХБ-ын глоссари

TARIFF MEASURE (TARIFF BARRIER)

Trade barrier that consists of imposing taxes on imports (tariffs). A government or country applies a tariff or a tariff barrier to protect the domestic production of imported products, restrict exports, or increase fiscal revenues.

ТАРИФЫН АРГА ХЭМЖЭЭ (ТАРИФЫН СААД ТОТГОР)

Импортын барааны татвар ногдуулах явдлаас (тарифаас) бүрдэх худалдааны саад тотгор. Аливаа нэг засгийн газар буюу улс орон импортын бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, экспортыг хязгаарлах, эсхүл төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тариф мөрддөг буюу тарифын саад тотгор бий болгодог.

TARIFF NOMENCLATURE

Any classification and coding system introduced by national administrations or Customs or Economic Unions to designate commodities or groups of related commodities for Customs tariff purposes.

ТАРИФЫН ЖАГСААЛТ

Үндэсний (дотоодын) байгууллагууд, гаалийн буюу эдийн засгийн холбоод барааг, эсхүл хамаарал бүхий бүлэг барааг гаалийн тарифын зорилгоор зүйлчлэн ангилах үүднээс нэвтрүүлсэн ангиллын болон кодлох аливаа систем.

Notes:
1. At present, a majority of countries base their tariff nomenclatures on the Nomenclature of the Harmonized Commodity Description and Coding System (generally referred to as the Harmonized System Nomenclature), which comprises General Rules for its interpretation, Section and Chapter Notes and a list of headings arranged in systematic order.
2. Some countries and Customs or Economic Unions combine in one system the requirements for Customs tariff and for external trade statistics.

Жич:
1. Одоогийн байдлаар, ихэнх улсын тарифын жагсаалт Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (ерөнхийдөө Уялдуулсан системийн жагсаалт гэдэг)-д үндэслэсэн байгаа. Уялдуулсан системийн жагсаалт нь Ерөнхий тайлбар дүрэм, Хэсэг, бүлгийн тайлбар бичиг, мөн системчлэн байршуулсан зүйлийн жагсаалтаас бүрддэг.
2. Зарим улсууд, гаалийн буюу эдийн засгийн холбоод гаалийн тариф болон гадаад худалдааны статистикт тавих шаардлагыг нэгтгэн нэг системд оруулсан байдаг.

TARIFF PEAKS

Relatively high tariffs, usually on “sensitive” products, amidst generally low tariff levels. For industrialized countries, tariffs of 15% and above are generally recognized as “tariff peaks”.

ТАРИФЫН ПИК (ТАРИФЫН ОРГИЛ, ОРГИЛ ТАРИФ)

Бусад бүтээгдэхүүний тарифын түвшин ерөнхийдөө доогуур байхад харьцангуй өндөр тарифыг ихэвчлэн “эмзэг” бүтээгдэхүүнд ногдуулдаг. Аж үйлдвэржсэн орнуудын хувьд 15% ба түүнээс дээш тарифыг ерөнхийдөө “тарифын пик” гэж хүлээн зөвшөөрдөг.

TARIFF PREFERENCE

Tariff preferences are a reduction in the duties applied to imports from a specific country or region.

ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТ БУЮУ ТАРИФЫН ПРЕФЕРЕНЦ

Тарифын хөнгөлөлт буюу тарифын преференц гэдэг нь тодорхой нэг улс, бүс нутгаас импортлох бараанд ногдуулдаг гаалийн татварыг бууруулах явдал юм.

TARIFF QUOTA

Any pre-set value or quantity, authorized for importation or exportation of given goods, during a specified period, with a reduction of the Customs duties, and beyond which any additional quantity of these goods can be imported or exported by paying normal Customs duties.

ТАРИФЫН КВОТ

Өгөгдсөн барааны гаалийн татварыг тодорхой хугацаанд бууруулан оруулах, эсхүл гаргахыг зөвшөөрч, урьдчилан тогтоосон аливаа үнэ буюу тоо хэмжээ. Тийнхүү тогтоосон тоо хэмжээнээс хэтэрсэн бараанд ердийн журмаар гаалийн татвар төлж оруулж, гаргаж болно.

TARIFF REDUCTION

Elimination or reduction of import or export tariffs.

ТАРИФЫГ БУУРУУЛАХ

Импортын, эсхүл экспортын тарифыг тэглэх буюу бууруулах.

TARIFF SUB-HEADING

Digits that follow the four main digits; used to identify sub-classifications of products.

ТАРИФЫН МӨР

Дөрвөн оронтой код (зүйл)-ийн дараах цифрүүд; бүтээгдэхүүний дэд ангиллыг тодорхойлоход ашигладаг.

TAX DECLARATION (VALUE-ADDED TAX)

Document in which an importer states the pertinent information required by the competent body for assessment of value-added tax.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТАТВАРЫН МЭДҮҮЛЭГ (НЭМЭГДСЭН ӨРТГИЙН ТАТВАР)

Импортлогч нэмэгдсэн өртгийн татвар тооцох зорилгоор эрх бүхий байгууллагаас шаардсан мэдээллийг тусгасан бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TBT AGREEMENT

(see Agreement on Technical Barriers to Trade) [WTO/TBT]

ХУДАЛДААН ДАХЬ ТЕХНИКИЙН САААД ТОТГОРЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

(“Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр”-ийг үз.)
[ДХБ/Худалдаан дахь техникийн саад тотгор]

TECHNICAL BARRIERS TO TRADE (TBT)

Technical barriers to trade refer to technical regulations, minimum standards and certification systems for health, safety and environmental protection and to enhance the availability of information about products, which may result in the erection of technical barriers to trade (TBTs). Some of the non-tariff barriers to trade are the widely divergent measures that countries use to regulate markets, protect their consumers, or preserve their natural resources (among other objectives), but they also can be used (or perceived by foreign countries) to discriminate against imports in order to protect domestic industries.
[WTO/TBT]

ХУДАЛДААН ДАХЬ ТЕХНИКИЙН САААД ТОТГОР

Худалдаан дахь техникийн саад тотгор гэдэг нь эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилготой, мөн бүтээгдэхүүний мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх зорилготой, худалдаанд техникийн саад тотгор үүсгэж болзошгүй техникийн дүрэм журам, наад захын стандарт, гэрчилгээний системийг хэлнэ. Худалдаан дахь тарифын бус саад тотгор нь маш олон янз байдаг бөгөөд тэдгээрийг улс орнууд зах зээлийг зохицуулах, хэрэглэгчдийг хамгаалах, байгалийн нөөц баялгаа хадгалан хамгаалах зорилгоор (өөр бусад олон зорилт байдаг) ашигладаг боловч тэдгээрийг бас дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах үүднээс импортыг хавчин хязгаарлах зорилгоор (эсхүл гадаадын улс орнууд тийнхүү ойлгодог) ашиглаж болдог.
[ДХБ/Худалдаан дахь техникийн саад тотгор]

TECHNICAL RULES; TECHNICAL REGULATION

A document containing binding requirements approved by the competent state authority.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЕХНИКИЙН ДҮРЭМ; ТЕХНИКИЙН ЖУРАМ

Төрийн эрх бүхий байгууллагаас баталсан, заавал дагаж мөрдөх шаардлагуудыг агуулсан бичиг баримт.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TEMPORARY ADMISSION

The Customs procedure under which certain goods can be brought into a Customs territory conditionally relieved totally or partially from payment of import duties and taxes; such goods must be imported for a specific purpose and must be intended for re -exportation within a specified period and without having undergone any change except normal depreciation due to the use made of them.

Note:

Specific Annex G, Chapter 1 of the revised Kyoto Convention.

Under the TFA, each WTO Member shall allow, as provided for in its laws and regulations, goods to be brought into its Customs territory conditionally relieved, totally or partially, from payment of import duties and taxes if such goods are brought into its Customs territory for a specific purpose, are intended for re-exportation within a specific period, and have not undergone any change except normal depreciation and wastage due to the use made of them.

[Art. 10.9.1 TFA]

ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ

Тодорхой барааг импортын гаалийн болон бусад татвараас болзолтойгоор бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөх нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт оруулах гаалийн горим; Ийм барааг тусгай зорилгоор, мөн тогтоосон хугацааны дараа буцаан гаргах болзолтойгоор оруулах буюу чингэхдээ ашиглалтаас үүдэлтэй хэвийн элэгдэл хорогдлоос өөр ямар нэгэн өөрчлөлт ороогүй байвал зохино.

Жич:

Шинэчлэн боловсруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт G-гийн 1 дүгээр бүлэг.

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн дагуу ДХБ-ын Гишүүн бүр хэрэв барааг тэдгээрийн гаалийн нутаг дэвсгэрт тусгай зориулалтаар оруулж, тодорхой хугацааны дараа буцаан гаргах гэж байгаа бөгөөд тэдгээрийг ашигласнаар хэвийн элэгдэл, хорогдлоос өөр ямар нэгэн өөрчлөлт орохооргүй бол уг барааг импортын гаалийн болон бусад татвараас болзолтойгоор бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж өөрсдийн гаалийн нутаг дэвсгэрт оруулахыг өөрсдийн хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу зөвшөөрнө.

[Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 10.9.1]

TEMPORARY ADMISSION PAPERS

The international Customs document accepted as a Customs declaration which makes it possible to identify goods (including means of transport) and which incorporates an internationally valid guarantee to cover import duties and taxes.

ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ БИЧИГ БАРИМТ

Гаалийн мэдүүлэг гэж хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын гаалийн бичиг баримт. Энэ нь бараа (тээврийн хэрэгсэл хамаарна)-г ялган таних боломжийг бүрдүүлж, импортын гаалийн болон бусад татвар төлөх олон улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчлэх баталгаа юм.

TEMPORARY STORAGE OF GOODS

Storing of goods under Customs control in premises and enclosed or unenclosed spaces specified by the Customs (temporary stores) pending lodgement of the Goods declaration.

БАРААГ ТҮР ХАДГАЛАХ

Гаалийн хяналтанд байгаа барааг гаалийн байгууллагаас (түр агуулахаас) тогтоосон байранд болон битүү буюу задгай талбайд Барааны мэдүүлэг гаргаж өгөх хүртэл хугацаагаар хадгалах.

Note:
Temporary storage is dealt with in Annex A.2. to the Kyoto Convention of 1974 and in Specific Annex A, Chapter 2 of the revised Kyoto Convention.

Жич:
Барааг түр хадгалах талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт А.2 болон шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт А-гийн 2 дугаар бүлэгт заасан байдаг.

THE CARRIAGE OF GOODS COASTWISE PROCEDURE

The Customs procedure under which:
(a) goods in free circulation, and
(b) imported goods that have not been declared under the condition that they must be transported in a vessel other than the importing vessel in which they arrived in the Customs territory
are loaded on board a vessel at a place in the Customs territory and are transported to another place in the same Customs territory where they are then unloaded.

БАРААГ ЭРГИЙН ДАГУУ ТЭЭВЭРЛЭХ ГОРИМ

(a) чөлөөт эргэлтэд байгаа барааг; мөн
(b) гаалийн нутаг дэвсгэрт оруулж ирсэн хөлөг онгоцноос өөр хөлөг онгоцоор тээвэрлэх шаардлагатай болсон гэсэн үндэслэлээр мэдүүлээгүй импортын барааг тухайн гаалийн нутаг дэвсгэр дэх аль нэг газраас ямар нэгэн хөлөг онгоцонд ачиж, мөн тухайн гаалийн нутаг дэвсгэрийн өөр нэг газар аваачиж, тэнд нь буулгах гаалийн горим.

Note:
Specific Annex E, Chapter 3 of the revised Kyoto Convention.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е-гийн 3 дугаар бүлэг.

THE UNIVERSAL POSTAL UNION

The inter-governmental organization founded in 1874 by the Treaty of Bern as the “General Postal Union” which, in 1878, was renamed the “Universal Postal Union (UPU)” and which since 1948 has been a specialized agency of the United Nations.

ДЭЛХИЙН ШУУДАНГИЙН ХОЛБОО

Бернийн хэлэлцээрээр 1874 онд “Шуудангийн ерөнхий холбоо” нэртэйгээр байгуулагдаж, 1878 оноос “Дэлхийн шуудангийн холбоо” гэдэг нэртэй болж, 1948 оноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага болсон Засгийн газар хоорондын байгууллага.

Note:
Specific Annex J, Chapter 2 of the revised Kyoto Convention.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 2 дугаар бүлэг.

THIRD PARTY

Any person who deals directly with the Customs, for and on behalf of another person, relating to the importation, exportation, movement or storage of goods.

ГУРАВДАГЧ ТАЛ

Бараа оруулах, гаргах, хөдөлгөх, эсхүл хадгалахтай холбогдуулан өөр нэг этгээдийн төлөө, мөн түүний нэрийн өмнөөс гаалийн байгууллагатай шууд харьцдаг аливаа этгээд.

Note:
General Annex, Chapter 2 of the revised Kyoto Convention.

Жич:
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Ерөнхий хавсралтын 2 дугаар бүлэг.

THIRD PARTY LOGISTICS (3PL)

Outsourcing all or part of a firm's logistics, usually transport or warehousing, to an external specialized service provider. The firm thus seeks to benefit from the scale effects and the expertise of the 3PL-provider in order to obtain a costminimizing tailor-made logistics service.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ГУРАВДАГЧ ТАЛЫН ЛОЖИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Ямар нэгэн компанийн ложистикийн үйл ажиллагааг, гол төлөв тээврийн, эсхүл агуулахын үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн мэргэжлийн үйлчилгээний гадны компаниар хийлгэх.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

THROUGH BILL OF LADING (T.B.L.)

Bill of Lading which evidences a contract of carriage from one place to another in separate stages of which at least one stage is a sea transit, and by which the issuing carrier accepts responsibility for the carriage as set forth in the Through Bill of Lading.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

НЭВТ ТЭЭВРИЙН БАРИМТ

Ачааг нэг гзараас нөгөөд салангид шатлалаар тээвэрлэх гэрээ болох тээврийн баримт. Үүний ядаж нэг шатлал нь далайн тээвэр байх бөгөөд энэ бичиг баримтаар түүнийг үйлдсэн тээвэрлэгч уг нэвт тээврийн баримтад заасан тээврийг гүйцэтгэх үүрэг хүлээсэн байдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TIME RELEASE STUDY (TRS)

A strategic, internationally recognized tool to measure the actual time required for the release and/or clearance of goods, from the time of arrival until the physical release of cargo, with a view to finding bottlenecks in the trade flow process and taking the corresponding necessary measures to improve the effectiveness and efficiency of border procedures.

Note:
The TRS Guide Version 3 (2018).

БАРААГ ОЛГОХ ХУГАЦААГ ХЭМЖИХ СУДАЛГАА (БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАГ ХУГАЦААНЫ СУДАЛГАА)

Худалдааны урсгалд саад тотгор учруулдаг зүйлсийг олж илрүүлэх, хилийн (хяналтын) горим журмын үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх зохистой арга хэмжээг авах үүднээс ачаа бараг ирэх үеэс эхэнд нь биетээр олгох үе хүртэл буюу бараа олгох болон/эсхүл бүрдүүлэлт хийхэд шаардагдах бодит цаг хугацааг хэмжих стратегийн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл.

Жич:
Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх хөтчийн хувилбар 3 (2018).

TIR CARNET

International Customs document (International Transit by Road) issued by a guaranteeing association approved by Customs authorities, under the cover of which transiting goods are transported, in most cases under a Customs seal, in road vehicles and/or containers in compliance with the requirements of the TIR Convention on the International Transport of Goods under cover of TIR Carnets (TIR Convention).

TIR КАРНЕЙ

Гаалийн байгууллагаас зөвшөөрсөн баталгаа гаргагч холбооноос гаргасан (авто замаар олон улсын хэмжээнд дамжин өнгөрөх) олон улсын гаалийн бичиг баримт. Ийм бичиг баримт бүхий дамжин өнгөрөх барааг ихэнх тохиолдолд гаалийн битүүмжлэлтэй, ТИР карней ашиглан барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай Конвенцийн шаардлагад нийцсэн авто тээврийн хэрэгсэл болон чингэлгээр тээвэрлэдэг.

TIR CONVENTION

Convention on the International Transport of Goods under Cover of TIR Carnets.

TIR КОНВЕНЦ

ТИР карней ашиглан барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц.

TRACK GAUGE

Distance between a pair of rails measured between the inside edges of the rail heads.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ЗАМЫН ЦАРИГ

Төмөр замын хос дугуй хоорондын зай.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

TRACTOR

Motor vehicles designed to haul other road vehicles which are not power-driven. Should be differentiated from Agricultural tractors which are designed exclusively or primarily for agricultural purposes.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ЗҮТГҮҮР (ЧИРДЭГ) ТРАКТОР

Бусад моторгүй автотээврийн хэрэгслийг чирэх зориулалттай моторт хэрэгсэл. Энэ нь зөвхөн, эсхүл ихэнхдээ хөдөө аж ахуйн зорилгоор ашигладаг тракторaас өөр юм.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

TRADE AGREEMENT

A type of international agreements regulating trade and economic relations between countries.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Улс орны хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааг зохицуулдаг олон улсын хэлэлцээрийн нэг төрөл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRADE CONTROLS

Government trade policy measures, usually aimed at cutting and expanding exports for the elimination of balance of payments deficits.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААНЫ ХЯНАЛТ

Гол төлөв төлбөрийн тэнцвэрийн алдагдлыг арилгах зорилгоор экспортыг танах, эсхүл өргөтгөх зорилгоор төрөөс явуулж буй худалдааны бодлогын арга хэмжээ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRADE DISTORTION

Used to describe a tax or action that changes the normal characteristics of trade: Some experts believe that trade-distorting agricultural subsidies are partly responsible for increases in global food prices.

ХУДАЛДААНЫ ХАЗАЙЛТ (ГАЖИЛТ)

Энэ хэллэгийг худалдааны ердийн байдлыг өөрчилдөг татвар буюу арга хэмжээг илэрхийлэх зорилгоор ашигладаг: Зарим мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар худалдааны хазайлт (гажилт) үүсгэдэг хөдөө аж ахуйн татаас зарим талаараа хүнсний дэлхийн зах зээлийн үнэ өсөхөд хүргэдэг.

TRADE FACILITATION

Removal or reduction of obstacles to the movement of goods across borders (e.g., simplification of customs procedures).

The simplification and harmonization of international trade procedures, including activities, practices, and formalities involved in collecting, presenting, communicating, and processing data required for the movement of goods in international trade.

Note:

This concept refers to the WTO definition of trade facilitation.

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ

- Хилээр нэвтрүүлэх барааны хөдөлгөөнд учрах саад тотгорыг арилгах буюу багасгах (жишээ нь, гаалийн горимыг хялбарчлах).
- Олон улсын худалдааны горим журмыг хялбарчлах, уялдуулах. Үүнд олон улсын худалдаан дахь барааны хөдөлгөөнд шаардагдах мэдээллийг цуглуулах, гаргаж өгөх, дамжуулах болон боловсруулахад хамаарах үйл ажиллагаа, практик, ёс журмын ажиллагаа багтана.

Жич: Энэ нь ДХБ-ын тодорхойлолт болно.

TRADE FACILITATION AGREEMENT (TFA)

The TFA, which entered into force in February of 2017, is a new set of trade rules to which all WTO Members signed up. These rules cover a variety of trade bureaucracy processes and practices, such as publishing information online and having clear procedures to appeal an unfavourable customs decision. It contains a mixture of obligations to do (the Member SHALL), and obligations to try (the Member SHALL ENDEAVOUR).

When the TFA entered into force, all Developed Country WTO Members were automatically bound by all of its provisions. However, Developing Country were allowed to designate which rules they would be bound by immediately, which they would need time to implement and which they would need technical assistance to meet.

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ХЭЛЭЛЦЭЭР

2017 оны 2 дугаар сард хүчин төгөлдөр болсон Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр нь ДХБ-ын бүх гишүүн орнууд гарын үсэг зурсан худалдааны шинэ цогц дүрэм юм. Эдгээр дүрэмд мэдээллийг онлайнаар нийтлэх, гаалийн байгууллагын тааламжтай бус шийдвэрийг давж заалдах тодорхой журамтай байх зэрэг худалдааны хүнд суртлын янз бүрийн процесс болон практик ажиллагаа багтсан байгаа. Энэ хэлэлцээрт хийх ёстой үүргүүд (Гишүүн орнууд ... ТЭГНЭ) болон хичээх ёстой үүргүүд (Гишүүн орнууд ... ТЭГЭХИЙГ ЭРМЭЛЗЭНЭ) холилдон тусгагдсан байгаа.

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор ДХБ-ын хөгжингүй бүх гишүүн орон түүний бүх заалтыг автоматаар дагаж мөрдөх үүрэгтэй. Харин хөгжиж буй орнууд аль дүрмийг нь шууд дагаж мөрдөх, алиныг нь тодорхой хугацаа авч дагаж мөрдөх, мөн алиныг нь мөрдөхөд техникийн туслалцаа авах вэ гэдгээ тогтон шийдэх эрхтэй юм.

TRADE FACILITATION INDICATORS

Owing to the multidimensionality of trade facilitation, a combination of effects need to be considered as relevant for measuring the level and existence of trade facilitation. Trade facilitation may manifest in various effects, such as fewer delays at border crossings, better targeting of risk shipments, higher productivity of staff, or on-line filing of documents. Trade facilitation indicators therefore describe and interpret different aspects of trade facilitation. The most commonly used indicators tend to focus on the following aspects:

- required time for key procedures or processes, such as release of goods at border stations;
- costs, usually reflected as transport or freight costs;
- number of documents, such as the documents required for clearing goods;
- availability and quality of transport infrastructure and services;
- prevalence of rule of law or level of corruption.

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Худалдааг хөнгөвчлөх нь олон хэмжүүртэй ухагдахуун учир худалдааг ямар хэмжээнд хөнгөвчилж байгаа, тэр нь
үнэхээр бодитой эсэхийг хэмжихийн тулд янз бүрийн зүйлийн нөлөөг авч үзэх ёстой. Худалдаа хөнгөвчлөгдөж буй эсэхийг, тухайлбал, хилээр нэвтрэхэд саатдаг явдал багассан, эрсдэлтэй ачааг зөв онилж чаддаг болсон, ажилчдын бүтээмж дээшилсэн, эсхүл бичиг баримтыг онлайнаар илгээдэг болсон гэх мэт олон зүйлийн үр дүнгээс харж болно. Ийм учраас худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг хэмжих үзүүлэлтүүд нь худалдааг хөнгөвчлөх үйл явцыг олон талаас нь харж, тайлбарласан байх ёстой.

Хамгийн түгээмэл үзүүлэлтэд дараах зүйлс орно:

- үндсэн горим журам буюу процесст зарцуулж буй цаг хугацаа, тухайлбал, барааг хилийн өртөөн дээр олгоход зарцуулж буй цаг хугацаа;
- гол төлөв тээврийн буюу ачаа зөөж тээвэрлэх өртөг зардлаар илэрдэг зардлууд;
- бичиг баримтын тоо, жишээлбэл, бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримтын тоо;
- тээврийн дэд бүтэц, үйлчилгээний хүрэлцээ болон чанар;
- хуульд захирагдаж буй байдал (хууль дүрмээ барьж ажиллаж буй байдал), авлигын түвшин.

TRADE FLOW

Purchase and sale of goods and services between countries or regions (exports and imports). Used to measure the balance of trade.

ХУДАЛДААНЫ УРСГАЛ

Улс орон, эсхүл бүс нутгийн хооронд бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон худалдах (экспорт ба импорт). Худалдааны тэнцлийг хэмжихэд ашигладаг.

TRADE IN SERVICES

This refers to the supply of a service by a service supplier to a service consumer, through any of the four modes of supply of a service, across national borders:

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДАА

Энэ нь үйлчилгээ эрхэлдэг байгууллагаас үйлчилгээгээ улсын хил давуулан үйлчилгээ хэрэглэгчдэд хүргэхдээ үйлчилгээ хүргэх дараах дөрвөн хэлбэрийн нэгээр дамжуулахыг хэлнэ:

Mode 1: Cross-border Trade in Service (Supply of Services) Definition: services supplied from the territory of one WTO Member into the territory of any other Member Example: A user in country A receives services from abroad through its telecommunications or postal infrastructure.	Хэлбэр 1: Хил дамнасан үйлчилгээний худалдаа (Үйлчилгээний нийлүүлэлт): Тодорхойлолт: ДХБ-ын нэг гишүүн улсын нутаг дэвсгэрээс нөгөө нэг гишүүн улсын нутаг дэвсгэрт нийлүүлж буй үйлчилгээ. Жишээ: “А” улс дахь хэрэглэгч А цахилгаан холбооны хэрэгсэл буюу шуудангийн үйлчилгээ ашиглан гадаадаас үйлчилгээ авах, тухайлбал, зөвлөгөө авах, зах зээлийн судалгаа авах, телевизээр эмчилгээний зөвлөгөө авах, зайн сургалтад хамрагдах, уран барилгын схем зураг авах;
Mode 2: Consumption abroad Definition: services supplied in the territory of one WTO Member to the service consumer of any other Member Example: Nationals of country A have moved abroad as tourists, students, or patients to consume the respective services.	Хэлбэр 2: Хилийн чанад дахь үйлчилгээ: Тодорхойлолт: ДХБ-ын нэг гишүүн улсын нутаг дэвсгэрт нөгөө нэг гишүүн улсын хэрэглэгч нарт нийлүүлж буй үйлчилгээ. Жишээ: “А” улсын иргэд аялахаар, суралцахаар, эсхүл эмчлүүлэхээр гадаад явах;
Mode 3: Commercial presence Definition: services supplied by a service supplier of one WTO Member, through commercial presence, in the territory of any other Member Example: The service is provided within country A by a locally-established affiliate, subsidiary, or representative office of a foreign-owned and — controlled company (bank, hotel group, construction company, etc.).	Хэлбэр 3: Арилжааны төлөөлөл: Тодорхойлолт: ДХБ-ын нэг гишүүн улсын үйлчилгээ үзүүлэгч нөгөө гишүүн улсын нутаг дэвсгэрт арилжааны төлөөллөөрөө дамжуулан нийлүүлж буй үйлчилгээ. Жишээ: Гадаадад байгаа этгээдийн эзэмшил (өмчлөл)-д буюу хяналтанд байгаа гадаад дахь компани (банк, зочид буудлын сүлжээ, барилгын компани, г.м.)-ийн “А” улсад байгуулсан салбар байгууллага буюу төлөөлөгчийн газраас “А” улсад нийлүүлж буй үйлчилгээ;
Mode 4: Presence of natural persons Definition: services supplied by a service supplier of one WTO Member, through the presence of natural persons of a Member in the territory of any other Member Example: A foreign national provides a service within country A as an independent supplier (e.g.,consultant, health worker) or employee of a service supplier (e.g. consultancy firm, hospital, construction company).	Хэлбэр 4: Хувь хүний оролцоо: Тодорхойлолт: ДХБ-ын нэг гишүүн улсын үйлчилгээ үзүүлэгч нөгөө гишүүн улсын нутаг дэвсгэрт хувь хүний оролцоотойгоор нийлүүлж буй үйлчилгээ. Жишээ: Гадаадын иргэн “А” улсад бие даасан байдлаар (жишээлбэл, зөвлөх, эрүүл мэндийн ажилтан байдлаар), эсхүл үйлчилгээ үзүүлэгч (жишээлбэл, зөвлөгөө өгдөг пүүс, эмнэлэг, барилгын компани)-ийн ажилтан байдлаар үйлчилгээ үзүүлэх.
WTO “The Services Sectoral Classification List”: 1. Business Services, Legal, accounting & auditing, computer & related, R&D, advertising, management consulting, etc.	ДХБ-ын “Үйлчилгээний салбарын ангиллын жагсаалт”: 1. Бизнесийн зөвлөх үйлчилгээ, эрх зүй, нягтлан бодох, аудит, компьютер, судалгаа-хөгжил, зар сурталчилгаа, менежментийн зөвлөх үйлчилгээ, г.м.;

2. Communication services;
3. Construction and rel. Engineering Services;
4. Distribution Services;
5. Educational Services;
6. Environmental Services Sewage, refuse disposal, sanitation, etc.;
7. Financial Services Insurance, reinsurance and auxiliary services, banking, payments, trading, asset management, advisory and other auxiliary financial services;
8. Health Related and Social Services);
9. Travel service;
10. Recreational, Cultural and Sporting Services;
11. Transport Services;
12. Other Services not included elsewhere.

2. Харилцаа холбооны үйлчилгээ;
3. Барилга, түүнтэй холбоотой инженерийн үйлчилгээ;
4. Түгээлтийн үйлчилгээ;
5. Боловсролын үйлчилгээ;
6. Байгаль орчны үйлчилгээ, ус суваг, цэвэршүүлэх, сантехникийн үйлчилгээ, г.м.;
7. Санхүүгийн үйлчилгээ, даатгал, банк, төлбөр, худалдаа арилжаа, хөрөнгийн менежмент, бусад туслах үйлчилгээ;
8. Эрүүл мэнд, амралт, сувилал, нийгмийн хангамжийн үйлчилгээ;
9. Аялал жуулчлал;
10. Зугаалга, биеийн тамир, спорт, соёлын үйлчилгээ;
11. Тээврийн үйлчилгээ;
12. Өмнөх 11 салбарт ороогүй бусад үйлчилгээ.

TRADE ITEM

An item that is the subject of trade. It is a term used primarily by people in supply chain management and logistic engineering.
A collection of information specific to an item being used or reported on for supply chain trade purposes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААНЫ БАРАА

- Худалдаалж буй эд зүйл. Энэ нэр томьёог хүмүүс үндсэндээ бараа нийлүүлэх сүлжээний менежмент болон ложистикийн инженерингэд ашигладаг.
- Бараа нийлүүлэх сүлжээнд худалдааны зорилгоор ашигладаг, эсхүл тайлагнадаг, аливаа нэг барааанд хамааралтай мэдээллийн иж бүрдэл (товарная позиция).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRADE LIBERALIZATION

This refers to the process of reducing or eliminating tariff and non-tariff barriers, including technical barriers to trade and quantitative restrictions, in order
to encourage international trade in goods and services (export and import of goods or services), with the ultimate objective of achieving free trade at a regional or global level.

ХУДАЛДААНЫ ЛИБЕРАЛЧЛАЛ (ХУДАЛДААГ ЧӨЛӨӨТЭЙ БОЛГОХ)

Энэ нь худалдааг бүс нутгийн буюу дэлхийн түвшинд чөлөөтэй болгох эцсийн зорилттойгоор барааны болон үйлчилгээний олон улсын худалдаа (бараа, үйлчилгээний импорт, экспорт)-г хөхүүлэн дэмжих зорилгоор тарифын болон тарифын бус саад тотгор, түүний дотор худалдааны техникийн саад тотгор, тоо хэмжээний квотыг багасгах буюу арилгах үйл явц юм.

TRADER

(1) an agent undertaking export and/or import operation; (2) a person trading financial instruments and/or commodities at stock/ commodity exchange.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДАА ЭРХЛЭГЧ

(1) Экспортын болон/эсхүл импортын үйл ажиллагаа эрхэлдэг агент; (2) үнэт цаасны/ барааны зах зээл дээр санхүүгийн хэрэгсэл болон/эсхүл бараа худалдаалдаг (арилждаг) этгээд.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRADE MEASURES

These are laws, rules, or regulations adopted by governments that may either promote trade liberalization or impose limitations on the pace of trade liberalization.

ХУДАЛДААНЫ АРГА ХЭМЖЭЭ

Энэ нь худалдааны либералчлалыг дэмжих, эсхүл худалдааны либералчлалын хурдыг сааруулах нөлөөтэй, төрөөс баталсан хууль, дүрэм, журам юм.

TRADE PROCEDURES (INTERNATIONAL TRADE PROCEDURES)

Activities, practices and formalities involved in collecting, presenting, communicating and processing data required for the movement of goods in international trade (WTO). This definition relates to a wide range of activities such as import and export procedures (e.g. Customs or licensing procedures); transport formalities; payments, insurance, and other financial requirements. Work in the area has been carried out by organizations such as UNCTAD, UNECE or the WCO for several decades.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААНЫ ГОРИМ ЖУРАМ

Олон улсын худалдаанд барааны хөдөлгөөнд шаардлагатай мэдээллийг цуглуулах, гаргаж өгөх, хүргүүлэх (дамжуулах), боловсруулахад хамаарах үйл ажиллагаа, практик, ёс журмын ажиллагаа (ДХБ). Энэ тодорхойлолт нь импорт, экспортын горим журам (жишээлбэл, гаалийн, эсхүл лицензийн горим журам) зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаанд хамаарна: тээврийн ёс журмын ажиллагаа; төлбөр, даатгал, санхүүгийн бусад шаардлага. Энэ чиглэлийн ажлыг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (ЮНКТАД), НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, ДГБ зэрэг байгууллагууд хэдэн арван жилийн турш хийж байна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRADE RELATED ASPECTS OF INTELLECTUAL PROPERTY RIGHTS (TRIPS)

One of the multilateral trade agreements within the World Trade Organization, which has little connection with trade facilitation matters.
(WTO/TRIPS)

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХУДАЛДААТАЙ ХОЛБОГДСОН АСУУДЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР (ТРИПС)

Худалдааг хөнгөвчлөх асуудалтай төдийлөн их хамааралгүй, ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрүүдийн нэг.
(ДХБ/ТРИПС)

TRADE REMEDIES

The term “Trade remedies” is usually applied to measures that governments can implement in three specific cases of perceived abuses in international trade in goods. These measures are provided for in three separate agreements of the World Trade Organisation, namely the Agreements on Implementation of Article VI of the General Agreement on Tariffs and Trade 1994 (commonly known as the Anti-dumping Agreement); the Agreement on Subsidies and Countervailing Measures; and the Agreement on Safeguards.

ХУДАЛДААНЫ АРГА ХЭРЭГСЭЛ

“Худалдааны арга хэрэгсэл” гэдэг нэр томьёог гол төлөв олон улсын барааны худалдаанд гардаг зүй бус үйлдийн тодорхой гурван тохиолдолд төрөөс авч хэрэгжүүлдэг арга хэмжээнд хамааруулан хэрэглэдэг. Эдгээр арга хэмжээг Дэлхийн худалдааны байгууллагын дараах гурван хэлэлцээрт тус тусад нь заасан байдаг: 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (түгээмэл нэр нь Демпингийн эсрэг хэлэлцээр); Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээр; Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээр

TRADE TREATIES

A type of international treaties regulating international trade and economic relations.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХУДАЛДААНЫ ГЭРЭЭ

Олон улсын худалдаа болон эдийн засгийн харилцааг зохицуулж буй олон улсын гэрээний нэг төрөл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRAFFIC

Freight, transportation, turnover of goods, freight flow.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭР (ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨН)

Далайн тээвэр, тээвэрлэлт, бараа эргэлт, ачааны урсгал.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRAILER

Goods road vehicle designed to be hauled by a road motor vehicle.
[UNECE/Glossary for Transport Statistics]

ЧИРГҮҮЛ

Автомашинаар чирэх зориулалттай автозамын ачаа тээвэрийн хэрэгсэл.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээвэрийн статистикийн глоссари]

TRANSACTION

A group of supply chain trade items, trade agreement, trade delivery and trade settlement details.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХЭЛЦЭЛ

Бараа нийлүүлэх сүлжээн дэх худалдааны барааны бүлэг, худалдааны хэлэлцээр, худалдааны бараа хүргэх болон худалдааны төлбөр тооцоог барагдуулах дэлгэрэнгүй мэдээлэл
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSACTION COSTS

Any costs paid on top of the agreed price in an economic exchange. Transaction costs include the costs of searching for an appropriate exchange opportunity, negotiating a contract and enforcing it. They also contain supplementary payments like tariffs or ad hoc taxes and the opportunity costs of time wasted in dealing with bureaucracy.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ

Эдийн засгийн солилцооны тохиролцсон үнэ дээр нэмэгдэх аливаа зардал. Хэлцлийн зардалд тохирох түншээ эрж хайх, гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх зардлууд багтана. Эдгээр зардалд бас тариф, эсхүл тусгай зориулалтын татвар зэрэг нэмэлт төлбөрүүд, мөн хүнд сурталтай тулж үрэгдсэн цаг хугацаанд зориулагдсан зардал хамаарна.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSACTION VALUE

This is the prime method for determining the Customs value as defined in the WTO Valuation Agreement. It is based on the price actually paid or payable for the goods when sold for export to the country of importation (Article 1 of the WTO Valuation Agreement), adjusted in accordance with the provisions of Article 8 of the WTO Valuation Agreement.

ХЭЛЦЛИЙН ҮНЭ

Энэ бол ДХБ-ын Үнэлгээний хэлэлцээрт заасны дагуу гаалийн үнийг тодорхойлох үндсэн арга юм. Энэ нь тухайн барааг импортлогч орон руу экспортоор худалдахад бодитоор төлсөн буюу төлбөл зохих үнийг үндэслэн (ДХБ-ийн Үнэлгээний гэрээний 1 дүгээр зүйл), ДХБ-ын Үнэлгээний хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасны дагуу залруулга хийсэн үиэ юм.

TRANS-EUROPEAN TRANSPORT NETWORK (TEN)

ЕВРОПЫН (ЕВРОПЫГ ДАМНАСАН) ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ

TRANSFER OF A NEGOTIABLE ELECTRONIC TRANSPORT RECORD

The transfer of exclusive control over the record. (see Negotiable electronic transport record) (Rotterdam Rules)

ТӨЛБӨРИЙН (ЭРГЭЛТИЙН) ХЭРЭГСЭЛ (ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮНЭТ ЦААС) БОЛОХ ТЭЭВРИЙН ЦАХИМ БҮРТГЭЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

Уг бүртгэлд хяналт тавих онцгой эрхийг шилжүүлэх. (“Төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болох тээврийн цахим бүртгэл”-ийг үз)
[Роттердамын дүрэм]

TRANSFERABLE LETTER OF CREDIT

A letter of credit that allows all or a portion of the proceeds to be transferred from the original beneficiary to one or more additional beneficiaries.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ШИЛЖИХ (ШИЛЖИХ НӨХЦӨЛТЭЙ) АККРЕДИТИВ

Бүх орлогыг, эсхүл түүний хэсгийг төлбөр хүлээн авагч буюу нэхэмжлэгч анхны этгээдээс өөр нэг буюу хэд хэдэн төлбөр хүлээн авагч буюу нэхэмжлэгчид шилжүүлж болох аккредитив.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSFER PRICING

A neutral concept that refers to the determination of transfer prices for transactions between related parties.

ШИЛЖИХ ҮНИЙН БОДЛОГО

Харилцан хамаарал бүхий талуудын хооронд хийгдсэн хэлцлийн шилжих үнийг тодорхойлоход хамаарах төвийг сахисан үзэл баримтлал.

TRANSPARENCY

Degree to which trade policies and practices, and the process by which they are established, are open and predictable. The concepts of transparency and predictability are always associated with each other. Customs clients are entitled to expect a high degree of certainty and predictability in their dealings with Customs. Customs laws, regulations, procedures and administrative guidelines should be made public, be easily accessible and applied in a uniform and consistent manner.

ИЛ ТОД БАЙДАЛ

Худалдааны бодлого, үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх үйл явц хэр зэрэг нээлттэй, урьдчилан таамаглах боломжтойг харуулах түвшин. Ил тод байдал болон урьдчилан таамаглах боломж нь үргэлж харилцан уялдаа холбоотой байдаг. Гаалиар үйлчлүүлэгчид гаальтай харьцахдаа түүний үйл ажиллагааг илүү тодорхой, ойлгомжтой, урьдчилан таамаглах боломжтой байгаасай гэж хүсэх эрхтэй. Гаалийн хууль тогтоомж, дүрэм журам, горим заавар, захиргааны шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ёстой бөгөөд тэдгээр нь нэвтрэхэд хялбар, мөн тэдгээрийг нэг мөр, тууштай мөрддөг байх ёстой.

TRANSHIPMENT

Customs procedure under which goods are transferred under Customs control from the importing means of transport to the exporting means of transport within the area of one Customs office which is the office of both importation and exportation.

Note:

Transhipment is dealt with in Annex E.2. to the Kyoto Convention of 1974 and in Specific Annex E, Chapter 2 of the revised Kyoto Convention.

ШИЛЖҮҮЛЭН АЧИХ

Оруулах болон гаргах үйл ажиллагааны аль алиныг нь гүйцэтгэж байгаа гаалийн нэг байгууллагын харьяалах газар нутагт бараг хилээр орох тээврийн хэрэгслээс хилээр гарах тээврийн хэрэгсэлд гаалийн хяналтын дор шилжүүлэн ачих гаалийн горим.

Жич:

Шилжүүлэн ачих горимын талаар 1974 оны Киотогийн конвенцийн хавсралт Е.2-т, мөн шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт Е-гийн 2 дугаар бүлэгт заасан байдаг.

TRANSHIPMENT PORT

A port where cargo is transferred from one carrier to another or from one vessel of a carrier to another vessel of the same carrier without the cargo leaving the port.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БООМТ

Ачааг нэг тээвэрлэгчээс нөгөө рүү, эсхүл нэг тээвэрлэгчийн тээврийн хэрэгслээс тухайн тээвэрлэгчийн өөр нэг тээврийн хэрэгсэл рүү тухайн ачааг уг боомтоос гаргалгүйгээр шилжүүлэн ачих боомт.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSIT

(see also transit trade) The business connected with the passage of goods through a country to their destination. Customs: A procedure according to which cargo or passengers pass from one Customs office to another under Customs control, whereby the cargo can pass in inward transit, i.e. from an import office to an inland Customs office; in outward transit, i.e. from an inland Customs office to an export office; in through transit, i.e. from an import office to an export office; in interior transit, i.e. from one inland Customs office to another. Inward transit, outward transit and through transit are referred to as international Customs transit if they are done in a single transit operation crossing several frontiers. A prerequisite for this is a bilateral agreement.

(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ (ГОРИМ)

("Дамжуулан өнгөрүүлэх худалдаа" гэдгийг үз) Барааг аль нэг улсаар дамжуулан хүлээн авах газар нь хүргэхтэй холбогдсон бизнес. Гааль: Ачааг, эсхүл зорчигчийг гаалийн нэг байгууллагаас нөгөөд гаалийн хяналтын дор явуулах горим. Үүнд ачааг дараах чиглэлээр дамжуулан өнгөрүүлж болно: оруулах чиглэлээр дамжуулан өнгөрүүлэх, өөрөөр хэлбэл, хилээр оруулсан гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллага хүртэл; гаргах чиглэлээр дамжуулан өнгөрүүлэх, өөрөөр хэлбэл, гүний гаалийн байгууллагаас хилээр гаргах гаалийн байгууллага хүртэл; шууд дамжуулан өнгөрүүлэх, өөрөөр хэлбэл, хилээр оруулах гаалийн байгууллагаас хилээр гаргах гаалийн байгууллага хүртэл; дотоодод дамжуулан өнгөрүүлэх, өөрөөр хэлбэл, гүний гаалийн нэг газраас гүний гаалийн нөгөө газар хүртэл. Оруулах чиглэлээр дамжуулан өнгөрүүлэх, гаргах чиглэлээр дамжуулан өнгөрүүлэх, шууд дамжуулан өнгөрүүлэх горимыг хэрэв тэдгээр нь хэд хэдэн хил дамнасан дамжуулан өнгөрүүлэх нэг ажиллагаагаар явагдсан бол олон улсын дамжуулан өнгөрүүлэх гаалийн горим гэнэ. Үүний урьдчилсан шаардлага нь хоёр талын хэлэлцээр болно.

(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSIT BOND-NOTE

National Customs document providing authority for goods to be conveyed in Customs transit without prior payment of import duties and taxes, generally containing all the particulars necessary for the assessment, where appropriate, of import duties and taxes, and an undertaking, covered by security, to produce the goods at the Customs office of destination with Customs seals intact.

ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ БАТАЛГААТ ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ

Барааг гаалийн дамжуулан өнгөрүүлэх горимоор импортын гаалийн болон бусад татварыг урьдчилан төлөлгүйгээр тээвэрлэх, хэрэв шаардлагатай бол импортын гаалийн болон бусад татвар ногдуулахад шаардагдах бүх мэдээллийг ерөнхийд нь агуулсан бөгөөд тухайн барааг гаалийн лац, ломбыг нь хөндөлгүйгээр хүлээн авагч гаалийн газарт хүргэх баталгаат үүрэг амлалт бүхий үндэсний гаалийн бичиг баримт.

TRANSIT DUTIES

Duties levied on the transit transportation of foreign goods through the territory of a country. (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ГААЛИЙН ТАТВАР

Гадаадын барааг аль нэг улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхэд ногдуулдаг гаалийн татвар.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSIT TRADE

A cross-border trade transaction, where the transported goods cross one or several countries before arriving at the country of destination. Transit trade could considerably raise freight and transaction costs and thus discourage cross-border trade. Major obstacles could be different standards and regulations, lacking transport infrastructure or ICT usage, and border crossing fares and delays. Article V of the GATT endorses the freedom of transit, non-discriminatory treatment of transit trade, and an abolition of delays and excessive border levies, in order to encourage transit trade.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХ ХУДАЛДАА

Тээвэрлэж буй бараа хүлээн авах улсад ирэхийн өмнө нэг буюу хэд хэдэн улсаар дайран өнгөрдөг хил дамнасан худалдааны хэлцэл. Дамжуулан өнгөрүүлэх худалдаа нь тээврийн болон хэлцлийн зардлыг ихээхэн хэмжээгээр өсгөдөг учир хил дамнасан худалдаа хийх сонирхлыг бууруулдаг. Гол хүндрэлүүд нь янз бүрийн стандарт, дүрэм журам, тээврийн дэд бүтцийн, эсхүл мэдээлэл холбооны технологийн хоцрогдол, хил нэвтрэх төлбөр хураамж, саатал. ТХЕХ-ийн V зүйлд дамжуулан өнгөрүүлэх худалдааг дэмжих үүднээс дамжуулан өнгөрүүлэх эрх чөлөө, дамжуулан өнгөрүүлэх худалдааг үл ялгаварлах, саатал болон хилийн хэт өндөр төлбөр хураамжийг арилгах тухай заасан байдаг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT (RAILWAY TRANSPORT)

The movement of freight and passenger trains by railway, even in those cases when a part of the transport is carried out by waterways.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭР (ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР)

Төмөр замаар явах ачааны болон суудлын вагоны хөдөлгөөн. Энэ тээврийн зарим хэсэгт усан зам ашигласан байж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT (ROAD TRANSPORT)

The movement of laden or unladen motor-vehicles by road, even if for a part of the journey the motor-vehicle, trailer or semitrailer is using waterways or rail.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВЭР (АВТО ЗАМЫН ТЭЭВЭР)

Автозамаар явах ачаатай, эсхүл ачаагүй моторт автомашины хөдөлгөөн. Энэ аяллын зарим хэсэгт тухайн моторт автомашин, чиргүүл, хагас чиргүүл усан зам, эсхүл төмөр зам ашигласан байж болно.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT DOCUMENT
A document issued under a contract of carriage by the carrier that: (a) Evidences the carrier's or a performing party's receipt of goods under a contract of carriage; and (b) Evidences or contains a contract of carriage.
[Rotterdam Rules]

ТЭЭВРИЙН БИЧИГ БАРИМТ
Тээврийн гэрээний дагуу тээвэрлэгчийн үйлдсэн, дараах зүйлийг гэрчилж буй бичиг баримт: (a) тээвэрлэгч буюу гүйцэтгэгч тал тээврийн гэрээний дагуу бараа хүлээн авсан болохыг; мөн (b) тээврийн гэрээ болохыг, эсхүл тээврийн гэрээ агууож байгааг.
[Роттердамын дүрэм]

TRANSPORT EQUIPMENT
A piece of equipment used to hold, protect or secure cargo for logistics purpose.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
Ложистикийн зорилгоор ачаа хадгалах, хамгаалах, аюулгүй байлгахад ашигладаг тоног төхөөрөмж.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT INFORMATION
A set of information that is used for commercial purposes.
[UNTDED]

ТЭЭВРИЙН МЭДЭЭЛЭЛ
Арилжааны зорилгоор ашигладаг багц мэдээлэл.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

TRANSPORT MEANS
The devices used to convey goods or other objects from place to place during logistics cargo movements.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН (ТЭЭВЭРЛЭХ) ХЭРЭГСЭЛ
Ачааг хөдөлгөх ложистикийн үйл ажиллагааны явцад бараа буюу өөр бусад обьектыг нэг газраас нөгөөд хүргэхэд ашигладаг хэрэгсэл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT MOVEMENT
The conveyance (physical carriage) of goods or other objects used for transport purposes.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨН
Тээврийн зорилгоор ашиглаж буй бараа буюу өөр бусад обьектын тээвэрлэлт (биет тээвэр).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT PACKAGE

(see also logistics package)
A self-contained wrapping or container within which goods can be contained for transport purposes, such as a box or a barrel which can be filled, partially filled or empty.
[UN/CEFACT/CCL]

ТЭЭВРИЙН ЗОРИЛУЛАЛТТАЙ САВ БООДОЛ
(бас "ложистикийн зорилулалттай сав боодол"-ыг үз)
Хайрцаг, торх гэх мэт тээврийн зорилулалтаар бараа хийх сав боодол буюу чингэлэг. Эдгээр нь дүүрэн, эсхүл дүүрэн бус ачаатай, эсхүл хоосон байж болно.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үндсэн бүрдэл хэсгийн сан]

TRANSPORT SERVICES BUYER

The buyer of transport services as stipulated in a transport service contract.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАГЧ

Тээврийн үйлчилгээний гэрээнд заасан тээврийн үйлчилгээ худалдан авагч.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT SERVICE ORDER

(see consignment)

ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХИАЛГА

("Консигнаци" гэдгийг үз.)

TRANSPORT SERVICES PROVIDER

The provider i.e. seller of transport services as stipulated in a transport service contract.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ КОМПАНИ

Тээврийн үйлчилгээний гэрээнд заасан тээврийн үйлчилгээг үзүүлэгч, өөрөөр хэлбэл, худалдагч.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

TRANSPORT-UNIT

Any means of transporting goods suitable for use in a Customs transit operation or under Customs seal.

Notes:
1. The term transport -unit means: (a) containers having an internal volume of one -cubic metre or more, including demountable bodies;
(b) road vehicles, including trailers and semi -trailers;
(c) railway coaches or wagons;
(d) lighters, barges and other vessels; and
(e) aircraft.
2. Approval of transport -units for transport of goods under Customs seal is dealt with in various international instruments, for example, the Kyoto Convention of 1974 (Annex E.1.), the Customs Convention on Containers, 1972, and the Customs Convention on the international transport of goods under cover of TIR carnets (TIR Convention), 1975.

Specific Annex E, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Дамжуулан өнгөрүүлэх гаалийн (горимын) ажиллагаанд хэрэглэх, эсхүл гаалийн битүүмжлэл тавин хэрэглэхэд тохиромжтой, бараа тээвэрлэх зориулалттай аливаа хэрэгсэл.

Жич:
1. Бараа тээвэрлэх зориулалтын хэрэгсэлд дараах зүйл багтана:
(a) нэг куб метр буюу түүнээс дээш дотоод эзэлхүүнтэй чингэлэг, түүний дотор задалж, угсардаг биетүүд;
(b) хуурай замын тээврийн хэрэгсэл, түүний дотор чиргүүл, хагас чиргүүл;
(c) төмөр замын зорчигч тээврийн буюу ачаа тээврийн вагон;
(d) завь, сал болон бусад хөлөг онгоц; мөн
(e) нисэх онгоц.
2. Бараа тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгслийг гаалийн битүүмжлэлтэй бараа тээвэрлэх зорилгоор хүлээн зөвшөөрөх талаар олон улсын янз бүрийн баримт бичигт, тухайлбал, 1974 оны Киотогийн конвенц (Хавсралт E.1.), 1972 оны Чингэлгийн тухай конвенц, мөн ТИР карней ашиглан олон улсын хэмжээнд бараа тээвэрлэх тухай 1975 оны гаалийн конвенцид заасан байдаг.
Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт E-гийн 1 дүгээр бүлэг.

TRAVELLER

(1) Any person who temporarily enters the territory of a country in which he or she does not normally reside ("non -resident") or who leaves that territory; and

(2) any person who leaves the territory of a country in which he or she normally resides ("departing resident") or who returns to that territory ("returning resident").

Note:

Specific Annex J, Chapter 1 of the revised Kyoto Convention.

ЗОРЧИГЧ

(1) Ерөнхийдөө байнга оршин суудаггүй аль нэг улсын нутаг дэвсгэрт түр хугацаагаар орж байгаа ("байнгын бус оршин суугч"), эсхүл тийм нутаг дэвсгэрээс гарч байгаа аливаа этгээд; мөн

(2) Ерөнхийдөө байнга оршин суудаг аль нэг улсын нутаг дэвсгэрээс гарч байгаа ("явж буй байнгын оршин суугч"), эсхүл тийм нутаг дэвсгэрт эргэн ирж байгаа (буцаж ирж байгаа оршин суугч) аливаа этгээд.

Жич:

Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцийн Тусгай хавсралт J-гийн 1 дүгээр бүлэг.

TRIPS (TRADE RELATED INTELLECTUAL PROPERTY RIGHTS)

Under the Uruguay Round accord of December 1993, GATT member countries agreed to a comprehensive set of international rules and stronger measures at international borders to stop trade in goods that infringe on intellectual property rights. Under the TRIPS agreement, nations are obliged to rewrite national laws to make them conform to internationally agreed norms for the protection of patents, trademarks, copyrights, industrial designs, trade secrets, integrated circuits (semiconductor chip mask works), and geographical indications. It also broadens the areas of protection to include technological areas—such as pharmaceutical products, computer software, and inventions and works arising from new technologies—that are not currently protected in many countries.

ТРИПС (ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХУДАЛДААТАЙ ХОЛБОГДСОН АСУУДЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР)

ТХЕХ-ийн гишүүн орнууд олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны үеэр оюуны өмчийн эрхийг зөрчиж буй бараа бүтээгдэхүүний худалдааг зогсоохын тулд олон улсын хэмжээний цогц дүрэм журмыг гаргаж, улс орнуудын хил дээр илүү хатуу арга хэмжээ авахаар 1993 оны 12 дугаар сард тохиролцов. TRIPS-ийн хэлэлцээрийн дагуу улс орнууд патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, бүтээгдэхүүний загвар, худалдааны нууц, нэгдсэн хэлхээ (интеграл микросхем), газарзүйн заалтыг хамгаалах олон улсын стандартад нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоо шинэчлэн боловсруулах үүрэг хүлээжээ. Энэ нь одоогоор олон оронд хамгаалагдаагүй байгаа эмийн бүтээгдэхүүн, компьютерийн програм хангамж, шинэ технологиос үүдэлтэй шинэ бүтээл гэх мэт технологийн чиглэлүүдийг багтаан хамрах хүрээгээ өргөжүүлж байна.

TWENTY-FOOT EQUIVALENT UNIT (TEU)

A statistical unit based on an ISO container of 20-foot length (6.10 m) to provide a standardised measure of containers of various capacities and for describing the capacity of container ships or terminals. One 20 Foot ISO container equals 1 TEU.

[UNECE/Glossary for Transport Statistics]

ХОРИН ФУУТТАЙ ТЭНЦЭХ НЭГЖ (TEU)

Янз бүрийн даацтай чингэлэг хэмжих, эсхүл чингэлэг тээврийн усан онгоц буюу чингэлгийн терминалын хүчин чадлыг хэмжих стандарт хэмжигдэхүүн болох Олон улсын стандартчиллын байгууллагын 20 фуутын (6.10 м) урттай чингэлэгт үндэслэсэн статистикийн хэмжих нэгж. Олон улсын стандартчиллын байгууллагын 20 фуутын (6.10 м) урттай нэг чингэлэг нь нэг TEU болно.

[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/ Тээврийн статистикийн глоссари]

U

ULTRA LARGE CONTAINER SHIP (ULCS)

Generic name for container ships with a nominal container capacity of 10,000 TEU and over. TEU – twenty-foot equivalent unit.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ХЭТ ТОМ (АВАРГА) УСАН ОНГОЦ

10,000 болон түүнээс дээш TEU-гийн ердийн чингэлгийн хүчин чадалтай чингэлэг тээврийн усан онгоцны ерөнхий нэр. Нэг TEU гэдэг нь хорин фууттай тэнцэх нэгж (20 фуут (6.10 м)-ын урттай нэг чингэлэг гэсэн үг).
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

UN/EDIFACT

(see EDIFACT)
The only global standard for electronic data interchange (EDI), UN/EDIFACT is a user application protocol for use within user application systems for data exchange. UN/CEFACT develops standards for UN/EDIFACT covering data elements, codes, segments and syntax rules for EDI, using complete standard message types for business data interchange. These standards, together with other UN/CEFACT recommendations, represent the business knowledge necessary to exchange data in whatever format through the Internet, VANS or other means. Electronic business uses these building blocks to ensure that the right information is available at the right time.
[UN/EDIFACT]

ЗАХИРГААНЫ, ХУДАЛДААНЫ БОЛОН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНД МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМААР ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ НҮБ-ЫН ДҮРЭМ

(“Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох дүрэм”-ийг үз)
Мэдээллийг цахимаар харилцан солилцох зориулалттай дэлхийн хэмжээний цорын ганц стандарт болох захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэм (UN/EDIFACT) нь мэдээлэл солилцох зориулалттай хэрэглэгчийн хэрэглээний системийн хүрээнд ашиглах зориулалттай хэрэглэгчийн хэрэглээний протокол юм. НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв нь Мэдээллийг цахимаар харилцан солилцох (EDI)-ын зориулалттай мэдээллийн элементүүд, кодууд, сегментүүд, синтаксийн дүрмүүдийг оролцуулан, бизнесийн мэдээллийг харилцан солилцох стандарт мессежийн бүх хэлбэрийг ашиглан UN/EDIFACT-д зориулсан стандартууд боловсруулдаг. Эдгээр стандарт нь UN/EDIFACT-ын бусад зөвлөмжүүдийн хамт Интернэт, VANS, эсхүл өөр бусад арга хэрэгслээр дамжуулан, ямар ч форматаар хамаагүй мэдээлэл дамжуулахад шаардлагатай бизнесийн мэдлэг болдог. Цахим бизнес нь зөв мэдээллийг зөв цагт нь хүргэх эдгээр үндсэн элементүүдийг ашигладаг.
[Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэм]

UNFAIR TRADE

Measures that companies or governments adopt to give artificial advantages to their exports and thus improve their conditions in the international market. The principal unfair trade practices are dumping and export and production subsidies.

ШУДАРГА БУС ХУДАЛДАА

Өөрсдийн экспортод зохиомлоор давуу байдал олгож, ингэснээр олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зорилгоор компаниуд, эсхүл засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ. Шударга бус худалдааны үндсэн хэлбэр нь демпинг, экспортын болон үйлдвэрлэлийн татаас юм.

UNACCOMPANIED BAGGAGE

Baggage that is transported as cargo and may or may not be carried on the same aircraft with the person to whom it belongs.
(ICAO Convention on International Civil Aviation, Annex 9)

БИЕЭС ТУСДАА ИЛГЭЭСЭН АЧАА ТЭЭШ

Ачаа байдлаар, гэхдээ эзэнтэйгээ хамт нэг онгоцоор, эсхүл тусдаа тээвэрлэж буй ачаа тээш.
(Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (Олон улсын иргэний нислэгийн байгууллага)-ын Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн хавсралт 9)

UNCLAIMED BAGGAGE

Baggage that arrives at an airport and is not picked up or claimed by a passenger.
(ICAO Convention on International Civil Aviation, Annex 9)

ЭЗЭНГҮЙ АЧАА ТЭЭШ

Нисэх онгоцны буудал дээр ирсэн боловч зорчигч хүлээж аваагүй үлдсэн ачаа тээш.
(Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (Олон улсын иргэний нислэгийн байгууллага)-ын Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн хавсралт 9)

UNION CUSTOMS CODE (UCC)

The Union Customs Code (UCC) of the European Union is seen as a key tool for trade facilitation and for the modernization of EU Customs. It provides a comprehensive framework for Customs rules and procedures in the EU Customs territory.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ХОЛБООНЫ ГААЛИЙН ХУУЛЬ (КОДЕКС)

Европын холбооны Холбооны гаалийн хууль (кодекс)-ийг худалдааг хөнгөвчлөх болон Европын холбооны Гаалийн байгууллагыг шинэчлэх нэг түлхүүр хэрэгсэл гэж үздэг. Энэ нь Европын холбооны гаалийн нутаг дэвсгэрт үйлчилдэг гаалийн дүрэм, горим журмын цогц үндсийг бүрдүүлдэг.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

UNIT LOAD DEVICE (ULD); PALLET OR CONTAINER FOR FREIGHT

Device for strengthening, manning, stacking of a package.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧИЛТ НЭГ НЭГЖ БҮРДҮҮЛЭХ ХЭРЭГСЭЛ; ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ АЧААНЫ ТАВИУР БУЮУ ЧИНГЭЛЭГ

Нэг сав боодлыг багцалж бэхлэх, нэг бүрдэл болгох, нуруулдах хэрэгсэл.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

UNIQUE CONSIGNMENT REFERENCE (UCR)

The Unique Consignment Reference (UCR) is a reference number for Customs use and may be required to be reported to Customs at any point during a Customs procedure.

АЧААНЫ ҮЛ ДАВТАГДАХ ДУГААР

Ачааны үл давтагдах дугаар нь гаалийн зориулалтаар ашигладаг дугаар бөгөөд түүнийг гаалийн горимын аль ч үед гаалийн байгууллагад мэдэгдэхийг шаардаж болно.

UNITED NATIONS CODE FOR TRADE AND TRANSPORT LOCATIONS (UN/LOCODE)

UN code system to represent names of certain locations of interest in international trade and transport. It is used for purposes of trade to designate locations whenever there is a need for a coded representation for the names of ports, airports, inland clearance depots, inland freight terminals and other transport related locations, such as places of receipt and delivery, which are used for goods movements associated with trade (for example locations where Customs clearance of goods can take place), or otherwise proposed by Governments. [UN/LOCODE] [UN/CEFACT/Rec.16]

ХУДАЛДАА, ТЭЭВРИЙН БАЙРШЛЫГ ТОДОРХОЙЛОХ НҮБ-ЫН КОД

Олон улсын худалдаа болон тээвэрт зарим холбогдолтой газрын нэрийг илэрхийлэх НҮБ-ын кодын систем. Үүнийг худалдааны зорилгоор дараах газруудын нэрсийг кодоор илэрхийлэх шаардлагатай тохиолдолд тэдгээрийг заах зорилгоор ашигладаг: усан онгоцны боомт, нисэх онгоцны буудал, гүний бүрдүүлэлтийн депо, гүний ачааны терминалын нэрс, мөн бараа хүлээн авах болон хүргэх газар зэрэг тээвэрлэлттэй холбоотой, барааны худалдаатай холбогдсон хөдөлгөөнд ашигладаг (жишээлбэл, бараанд гаалийн бүрдүүлэлт хийх газар), эсхүл төр засгаас санал болгосон бусад газрын нэрс.
[НҮБ-ЫН БАЙРШЛЫН КОД] [НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв /Зөвлөмж №16]

UNITED NATIONS COMMODITY TRADE STATISTICS DATABASE (COMTRADE) [UN/COMTRADE]

НҮБ-ЫН БАРААНЫ ХУДАЛДААНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН БААЗ [НҮБ/Барааны худалдаа]

UNITED NATIONS LAYOUT KEY FOR TRADE DOCUMENTS (UNLK)

The United Nations Layout Key is intended particularly to serve as a basis for designing aligned series of forms employing a master document in a reprographic one run method of document preparation. It can also be used to design screen layouts for the visual display of electronic documents.
[UN/CEFACT/Rec. 1]

НҮБ-ЫН ХУДАЛДААНЫ БИЧИГ БАРИМТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

НҮБ-ын худалдааны бичиг баримтын үлгэрчилсэн загвар нь ялангуяа мастер бичиг баримт ашиглан бичиг баримт бэлдэх репрографикийн нэг удаа гүйлгэх аргаар нэг мөр маягт үйлдэх үндсийг бүрдүүлэх зориулалттай юм. Үүнийг бас цахим бичиг баримтыг дэлгэцээр харуулах зорилгоор дэлгэцийн үлгэрчилсэн загвар бүтээхэд ашиглаж болно.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв /Зөвлөмж №1]

UNITED NATIONS TRADE DATA ELEMENTS DIRECTORY (UNTDED)

Directory of standard data elements intended to facilitate an open interchange of data in international trade. These standard data elements can be used with any method for data interchange on paper documents as well as with other means of data processing and communication: they can be selected for transmission one by one, or used within a particular system of interchange rules, e.g. United Nations rules for Electronic Data Interchange for Administration, Commerce and Transport. An EDI message may be referred to as a UN/EDIFACT standardised message only if it complies with the rules and directories of the United Nations Trade Data Interchange Directory (UNTDID), and if it has been approved by the United Nations Economic Commission for Europe.
(UN/EDIFACT) [UN/CEFACT/UNTDED]

НҮБ-ЫН ХУДАЛДААНЫ МЭДЭЭЛЛИЙН ЭЛЕМЕНТҮҮДИЙН ЛАВЛАХ

Олон улсын худалдаанд мэдээллийг нээлттэй хэлбэрээр харилцан солилцох явдлыг хөнгөвчлөх зорилготой стандарт мэдээллийн элементүүдийн лавлах. Эдгээр стандарт мэдээллийн элементийг цаасан бичиг баримтаар мэдээлэл солилцох аливаа аргын хамт, мөн мэдээлэл боловсруулах болон дамжуулах өөр бусад аргын хамт ашиглаж болно: тэдгээр элементийг нэг нэгээр нь сонгон мэдээлэл дамжуулахаар ашиглаж болно, эсхүл мэдээлэл харилцан солилцох дүрэм бүхий тодорхой нэг системийн хүрээнд, өөрөөр хэлбэл, Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрмийн хүрээнд ашиглаж болно.
Мэдээллийг цахимаар харилцан солилцох (EDI) ямар нэг мессеж нь хэрэв НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлахын дүрэм болон лавлахуудтай тохирч байвал, мөн түүнийг НҮБ-ын Европын эдийн засгийн комиссоос зөвшөөрсөн бол Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэм гэж үзэж болно.
(Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрэм)
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

UN/CEFACT MODELLING METHODOLOGY (UMM)

The UMM provides a procedure for specifying (modelling) collaborative business processes (business collaborations) involving information exchange in a technology-neutral, implementation-independent manner. The UMM provides the conceptual framework to communicate common concepts.

НҮБ-ЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ БОЛОН ЦАХИМ БИЗНЕСИЙН ТӨВИЙН ЗАГВАРЧЛАХ АРГАЧЛАЛ

НҮБ-ын худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн загварчлах аргачлал (UMM) нь бизнесийн хамтын процессыг загварчлах нэг горим юм. Үүнд технологиос хамааралгүй, тусад нь хэрэгжүүлж болох мэдээлэл солилцоо хамаарна. UMM нь нийтлэг ойлголтыг дамжуулах алсыг харсан систем юм.

Historically business partner communication methodologies (such as EDI) have focused on modelling the business documents being exchanged while the UMM instead focuses on modelling the business actions and objects that create and consume business information.
[UN/CEFACT/UMM]

Түүхэзс нь сонирхуулбал, бизнесийн түншийн харилцааны аргачлал (EDI зэрэг) нь солилцож буй бизнесийн бичиг баримтуудыг загварчлахад анхаардаг бол UMM нь бизнесийн мэдээлэл бий болгож ашигладаг бизнесийн үйл ажиллагаа болон обьектуудыг загварчлахад анхаардаг. [НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв / НҮБ-ын худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн загварчлах аргачлал]

UN/CEFACT REFERENCE DATA MODEL

An exchange-syntax neutral semantic model based on the principles laid down in UN Key Layouts, UN Trade Data Element Directory and UN/EDIFACT subset of the UN/CEFACT Core Component Library (CCL) as well as UN/CEFACT principles of harmonization, standardization and simplification.
[UN/CEFACT/RDM]

НҮБ-ЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ БОЛОН ЦАХИМ БИЗНЕСИЙН ТӨВИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДАТА МОДЕЛЬ (ҮЛГЭРЧИЛСЭН ӨГӨГДЛИЙН ЗАГВАР)

НҮБ-ын Үлгэрчилсэн загвар болон НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлахад дурдсан зарчмууд, НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн Үндсэн бүрдэл хэсгийн сангийн Захиргааны, худалдааны болон тээврийн байгууллага хооронд мэдээллийг цахимаар харилцан солилцох НҮБ-ын дүрмийн дэд функц, мөн НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвийн уялдуулах, стандартчилах, хялбарчлах зарчмуудыг үндэс болгон сентакс солилцох төвийг сахисан семантик модель юм.
[НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв/Үлгэрчилсэн дата модель (Үлгэрчилсэн өгөгдлийн загвар)]

UNITIZATION

The packing of single or multiple consignments into ULDs or pallets.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЧИЛТЫН НЭГЖ БОЛГОН НЭГТГЭХ

Нэг буюу хэд хэдэн ачааг ачилтын нэг нэгж хэрэгсэл буюу ачааны тавиурт савлах
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

UNIVERSAL BUSINESS LANGUAGE (UBL)

The product of an international effort to define a royalty-free library of standard electronic XML business documents such as purchase orders and invoices. It was developed jointly by OASIS (Organization for the Advancement of Structured Information Standards) and the UN/CEFACT.

БИЗНЕСИЙН УНИВЕРСАЛ ХЭЛ

Бараа худалдан авах захиалга болон үнийн нэхэмжлэх зэрэг роялти төлдөггүй бизнесийн XML цахим стандарт бичиг баримтын санг тодорхойлох зорилгоор олон улсын хүчин чармайлтаар бий болсон бүтээгдэхүүн. Үүнийг Бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй) мэдээллийн стандартыг боловсронгуй болгох байгууллага болон НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төвөөс хамтран боловсруулсан.

It was designed to plug directly into existing business, legal, auditing, and records management practices, eliminating the re-keying of data in existing fax-and paper-based supply chains and providing an entry point into electronic commerce for small and medium-sized businesses.
[UN/CEFACT and OASIS - UBL]

Үүнийг бизнес, эрх зүй, аудитын хяналт, бүртгэлийн менежментийн практикт шууд нэвтрүүлэх зорилгоор бүтээсэн. Энэ нь одоогийн факс болон цаасан бичиг баримтад суурилсан бараа нийлүүлэх сүлжээний мэдээлэл давтан оруулдаг системийг халж, жижиг болон дунд үйлдвэрүүдийг цахим худалдаанд оруулах үүдийг нээн өгч байгаа юм. [НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх болон цахим бизнесийн төв болон Бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй) мэдээллийн стандартыг боловсронгуй болгох байгууллага - Бизнесийн универсал хэл]

UNIVERSAL (MULTIPURPOSE) TRANSPORT DOCUMENT

A transport document confirming the existence of a contract of carriage by any mode or several modes of transport through the territory of one or more countries in accordance with any applicable international convention or national law and in accordance with the conditions of carriage under which any carrier or transport operator carries out or provides for the carriage, mentioned in this document.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН УНИВЕРСАЛ (ОЛОН ТӨРЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ) БИЧИГ БАРИМТ

Олон улсын холбогдох аливаа нэг конвенц, эсхүл үндэсний хууль тогтоомжийн дагуу нэг буюу хэд хэдэн улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээврийн аль нэг төрлөөр, эсхүл хэд хэдэн төрлөөр бараа тээвэрлэх тээврийн гэрээ болох тээврийн бичиг баримт. Энэ бичиг баримтад заасан тээврийг түүнд заасан тээврийн нөхцөлийн дагуу аливаа тээвэрлэгч, эсхүл тээврийн оператор гүйцэтгэх буюу гүйцэтгэх нөхцөлийг хангана.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

UNNECESSARY DELAYS

[GATT article V: Transit]

ШААРДЛАГАГҮЙ ҮНДЭСЛЭЛЭЭР СААТУУЛАХ

[ТХЕХ-ийн V зүйл: Дамжин өнгөрөх]

URGENT CONSIGNMENTS

Goods which require rapid clearance as a matter of priority due to:
- their nature;
- their meeting a fully justified urgent need.

Note:
Urgent consignments should be granted priority and rapid clearance.

ЯАРАЛТАЙ АЧАА

Дараах хүчин зүйлийн улмаас тэргүүн ээлжинд шуурхай бүрдүүлэлт хийх шаардлагатай бараа:
- түүний мөн чанар;
- түүний яаралтай хэрэгцээ шаардлага бүрэн үндэслэлтэй байх.

Жич:
Яаралтай ачааг нэн тэргүүнд авч үзэн, шуурхай бүрдүүлэлт хийнэ.

UTILITY BLOCK

What is a Utility Block?

A specific part of the Customs business process, explained in simple yet comprehensive terms that everyone can understand. It describes strategic aims for policy makers, business processes for managers, legal issues for lawyers, functional approaches for operational officers, and technical specifications for IT staff.

How is a Utility Block put together?

It is constructed and reviewed by experts using a standard development template. It focuses on the needs of a specific part of the Customs business process, including relevant data elements. For example, Authorized Economic Operator (AEO), commercial fraud, transit, etc.

Why break down Customs business processes into individual Utility Blocks?

This allows Customs authorities to be selective about what business process and associated information they choose to share with their partner(s), and to more quickly facilitate those networking arrangements.

Do the same Utility Blocks have to be used in the same way with all partners?

The choice of Blocks falls within the purview of the parties to the agreements. To benefit from GNC, each block has to be implemented in the same way by all partners. However, there is flexibility within in each block, such as the list of data elements to be exchanged.

УТИЛИТИ БЛОК (ХЭРЭГЛЭЭНИЙ БЛОК)

Утилити блок гэж юу вэ?

Хүн бүрт ойлгогдохоор энгийн боловч агуулгыг бүрэн илэрхийлсэн үгээр тайлбарлавалл утилити блок гэдэг нь гаалийн байгууллагын бизнес процессын тодорхой нэг хэсэг юм. Энэ нь бодлого боловсруулагч нарт стратегийн зорилтуудыг, менежерүүдэд бизнес процессуудыг, хуульч нарт эрх зүйн асуудлуудыг, нэгжийн ажилтнуудад ажлын арга барилуудыг, мэдээллийн технологийн ажилтнуудад техникийн тодорхойлолтуудыг тайлбарлаж өгдөг.

Утилити блокийг хэрхэн бүтээх вэ?

Үүнийг мэргэжилтнүүд боловсруулалтын стандарт загвар ашиглан бүтээж, хянан үздэг. Энэ нь гаалийн байгууллагын бизнес процессын тодорхой нэг хэсгийн хэрэгцээ шаардлагад анхаарлаа төвлөрүүлдэг. Үүнд холбогдох мэдээллийн элементүүд хамаарна. Жишээлбэл, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж, худалдааны луйвар, дамжуулан өнгөрүүлэх горим, г.м.

Гаалийн байгууллагын бизнес процессуудыг яагаад нэг нэг утилити блок болгон задалдаг вэ?

Ингэснээр гаалийн байгууллагууд ямар бизнесс процесс болон холбогдох мэдээллийг сонгож өөрийн түнш (түншүүд)-тэйгээ хуваалцах вэ гэдгээ шийдэж, тэдгээрийн сүлжээний зохицуулалтыг илүү хялбар болгох боломжтой болдог.

Нэг ижил утилити блокуудыг бүх түгшүүдтэй нэг ижил арга замаар ашиглах ёстой юу?

Ямар блок сонгох нь хэлэлцээрийн талуудын эрх мэдлийн асуудал. “Дэлхий даяар сүлжээнд холбогдсон гааль” хөтөлбөрөөс ашиг хүртэхийн тулд бүх түнш (улс) блок тус бүрийг нэг ижил арга замаар хэрэгжүүлэх ёстой. Гэвч блок тус бүрт уян хатан байдал байдаг. Тухайлбал, солилцох мэдээллийн элементүүдийн жагсаалт гаргах.

What is the principle attraction of a standard Utility Block?
Once tested and lodged with the WCO Secretariat, it can be accessed and re-used by any WCO Member with little further work required.

Аль нэг стандарт утилити блокийн юу нь хамгийн сонирхолтой байх вэ?
Нэгэнт туршаад, ДГБ-ын Нарийн бичгийн даргын газарт хүргэсэн бол түүнийг ДГБ-ын аль нэг гишүүн үнэлж дүгнээд, шаардлагатай гэсэн жижиг засвар хийгээд дахин ашигладаг.

Can all the Utility Blocks be implemented in one go?
Yes, but do not assume your partner(s) can also cope with making a quantum leap to full data exchange across all parts of the Customs business at one go. Also, it will take time to build up the WCO library of blocks.

[Globally Networked Customs Concep]

Бүх утилити блокийг нэгэн зэрэг хэрэгжүүлж болох уу?
Болно. Гэвч таны түнш (түншүүд) гаалийн бүх асуудлаар шууд бүрэн дүүрэн мэдээлэл солилцох гэнэтийн үсрэлт хийхэд бэлэн байгаа гэж та бодож болохгүй. Бас ДГБ-ын утилити блокын сан бий болгоход цаг хугацаа хэрэгтэй байгаа.

[“Дэлхий даяар сүлжээнд холбогдсон гааль” төслийн концепц]

V

VALUATION

The appraisal of the worth of imported goods by customs officials for the purpose of determining the amount of duty payable in the importing country. The GATT Customs Valuation Code obligates governments that sign it to use the "transaction value" of imported goods—or the price actually paid or payable for them—as the principal basis for valuing the goods for customs purposes.

ҮНЭЛГЭЭ

Гаалийн ажилтнууд импортлогч оронд төлбөл зохих гаалийн татварын хэмжээг тогтоох зорилгоор импортын барааг үнэлэх ажиллагаа. ТХЕХ-ийн гаалийн үнэлгээний конвенц (кодекс)-иор түүнд гарын үсэг зурсан засгийн газруудад дараах зүйлийг үүрэг болгосон байдаг: импортын барааны "хэлцлийн үнэ" буюу тухайн бараанд бодитоор төлсөн буюу төлбөл зохих үнийг гаалийн зорилгоор барааг үнэлэх үндэс суурь болгон ашиглах.

VALUE DECLARATION

Document in which a declarant (importer) states the invoice or other price (e.g. selling price, price of identical goods), and specifies costs for freight, insurance and packing, etc., terms of delivery and payment, any relationship with the trading partner etc., for the purpose of determining the Customs value of goods imported. (UN/ECE/FAL)

ҮНИЙН МЭДҮҮЛЭГ

Мэдүүлэгч (импортлогч) импортын барааны гаалийн үнийг тодорхойлох зорилгоор нэхэмжлэхийн буюу бусад үнэ (жишээ нь, зарсан үнэ, ижил төрлийн барааны үнэ)-ийг, тээврийн зардал, даатгалын хураамж, баглаа боодлын зардал зэргийг, бараа нийлүүлэх нөхцөл ба төлбөрийн нөхцөлийг, худалдааны түнштэйгээ ямар хамааралтай болох зэргийг мэдүүлж байгаа бичиг баримт. (НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

VALUE INSURED

Total sum covered by an insurance.
[UNTDED]

ДААТГУУЛСАН ҮНЭ

Даатгуулсан нийт үнийн дүн.
[НҮБ-ын Худалдааны мэдээллийн элементүүдийн лавлах]

VEHICLE

A road or railroad cargo vehicle.
[Rotterdam Rules]

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Автозамын, эсхүл төмөр замын ачааны тээврийн хэрэгсэл
[Роттердамын дүрэм]

VESSEL

A floating structure with one or more surface displacement hulls used in sea and inland transport, can either be self-propelled or designed to be hauled by another vessel.
[UNECE/Glossary for Transport Statistics]

УСАН ОНГОЦ

Нэг буюу хэд хэдэн их биетэй, далай болон дотоодын усанд ашигладаг, өөрөө явдаг, эсхүл чирүүлдэг хөвдөн бүтэц.
[НҮБ-ын Европын эдийн засгийн комисс/Тээврийн статистикийн глоссари]

VETERINARY CERTIFICATE

Document issued by the competent authority in the exporting country evidencing that live animals or birds are not infested or infected with disease, and giving details regarding their provenance, and of vaccinations and other treatment to which they have been subjected. (UN/ECE/FAL)

МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ

Амьд амьтад буюу шувууд халдвар тээгээгүй, эсхүл халдвар аваагүйг нотолж, тэдгээрийн гарал үүслийг дэлгэрэнгүй тайлбарлаж, тэднийг хамруулах ёстой вакцинжуулалт болон бусад эмчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл тусгасан, экспортлогч улс орны эрх бүхий байгууллагаас гаргасан бичиг баримт. (НҮБ/Европын эдийн засгийн комисс/Олон улсын далайн тээврийг хөнгөвчлөх тухай конвенц)

VETERINARY INSPECTION

Sanitary inspection applied to animals and animal products with a view to protecting the life and health of persons and animals, as well as that carried out on objects or goods which could serve as a carrier for animal diseases.
International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods, 1982 Chapter I.

МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ (ШАЛГАЛТ)

Хүн, амьтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор амьтан болон амьтны гаралтай бүтээгдэхүүнд хийх эрүүл ахуйн хяналт шалгалт, мөн амьтны гаралтай өвчин тээгч эд зүйл буюу бараанд хийх хяналт шалгалт.
Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он), 1 дүгээр бүлэг.

VOLUME CONTRACT

A contract of carriage that provides for the carriage of a specified quantity of goods in a series of shipments during an agreed period of time. The specification of the quantity may include a minimum, a maximum or a certain range.
[Rotterdam Rules]

ТОДОРХОЙ ТОО ХЭМЖЭЭНИЙ БАРАА ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

Тодорхой тоо хэмжээний барааг хэд хэдэн ачилтаар тохиролцсон хугацааны турш тээвэрлэх тухай тээврийн гэрээ. Тоо хэмжээний тодорхойлолт нь хамгийн доод хэмжээ, хамгийн дээд хэмжээ, эсхүл тодорхой диапазон байж болно.
[Роттердамын дүрэм]

W

WAREHOUSE DEPOSITOR

Person who delivered the goods to the warehouse.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АГУУЛАХЫН БАРАА ХҮРГЭГЧ

Агуулахад бараа хүргэж өгсөн этгээд.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

WAREHOUSE RECEIPT

A receipt of commodities deposited in a warehouse, identifying the commodities deposited. It is non-negotiable if permitting delivery only to a specified person or firm, but it is negotiable if made out to the order
of a person or firm or to a bearer. Warehouse receipts are common documents in international banking.

АГУУЛАХЫН БАРИМТ (ТАСАЛБАР)

Агуулахад хадгалуулсан барааг ялган таних бичиг баримт (тасалбар). Энэ нь хэрэв зөвхөн тодорхой нэг хувь хүн буюу пүүст хүргэх бол төлбөрийн бус (эргэлтийн бус) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас биш), хэрэв хувь хүний, эсхүл пүүсийн, эсхүл эзэмшигчийн зааврын дагуу үйлдсэн бол төлбөрийн (эргэлтийн) хэрэгсэл (төлбөр тооцооны үнэт цаас) болдог. Агуулахын баримт нь олон улсын банкны үйлчилгээнд түгээмэл ашиглагддаг бичиг баримт юм.

WAREHOUSE WARRANT

A special warehouse certificate, which acts as a document of the title to the goods on stock. A document guaranteeing the existence and availability of a given quantity and quality of a commodity in storage and commonly used as the instrument of transfer of ownership in both cash and futures transactions.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АГУУЛАХЫН ГЭРЧИЛГЭЭ

Агуулахад байгаа барааг эзэмших (өмчлөх) эрхийн бичиг болох агуулахын тусгай гэрчилгээ. Агуулахад тодорхой тоо, чанарын бараа бэлэн байгаа болохыг баталгаажуулсан, мөн ерөнхийдөө бэлэн мөнгө болон үнэт цаасны үндсэн дээр өмчлөх эрх шилжүүлэх хэрэгсэл болох бичиг баримт. (Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

WAYBILL

A generic name for a document accompanying goods.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

ТЭЭВРИЙН БАРИМТ

Бараа дагалдах бичиг баримтын ерөнхий нэр.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

WARRANTY GOODS

Warranty goods are those that are supplied free of charge to replace defective goods.

БАТАЛГААТ ХУГАЦААНЫ БАРАА

Баталгаат хугацааны бараа гэдэг нь гэмтэлтэй барааг солих зорилгоор үнэ төлбөргүй нийлүүлж буй бараа юм.

WCO DATA MODEL

A compilation of clearly structured, harmonized, standardized and reusable sets of data definitions and electronic messages to meet operational and legal requirements of cross-border regulatory agencies, including Customs, which are responsible for border management.

ДГБ-ЫН ДАТА МОДЕЛЬ (МЭДЭЭЛЛИЙН ЗАГВАР)

Хилийн менежментийн асуудал хариуцсан (хил дамнасан) тохируулагч агентлагууд, түүний дотор гаалийн байгууллагын үйл ажиллагааны болон хууль эрх зүйн шаардлагыг хангахуйц тодорхой байдлаар бүтэцлэгдсэн (шаталсан бүтэцтэй), уялдсан, стандартчилагдсан, түүнчлэн дахин ашиглах боломжтой багц өгөдлийн тодорхойлолт болон цахим мессежийн эмхэтгэл.

WORKFLOW

Full or partial automation of business processes, where documents (messages) are sent from one participant to another in order to fulfil certain activities defined in a list of procedural rules.
(Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)

АЖЛЫН (БИЧИГ БАРИМТЫН) УРСГАЛ

Бизнес процессын бүрэн, эсхүл хэсэгчилсэн автоматжуулалт. Энд бичиг баримтууд (мессежүүд)-ийг дотоод журамд заасан зарим ажиллагааг гүйцэтгэх зорилгоор нэг оролцогчоос нөгөөд илгээнэ.
(Худалдааг хөнгөвчлөх нэр томьёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)

WORLD CUSTOMS ORGANIZATION (WCO)

Previously known as the Customs Co-operation Council (CCC). It is the independent, intergovernmental agency, based in Brussels, responsible for simplifying and rationalizing customs procedures.

ДЭЛХИЙН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА (ДГБ)

Өмнө нь Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл гэдэг байсан. Энэ нь Брюссель хотод төвтэй, хараат бус, засгийн газар хоорондын байгууллага бөгөөд гаалийн горимыг хялбарчлах, оновчтой болгох үүрэгтэй ажилладаг.

WORLD INTELLECTUAL PROPERTY ORGANIZATION (WIPO)

Agency of the United Nations system that promotes the development and use of the international intellectual property system (patents, copyright, trademarks, designs (drawings and models), etc.) as a means of stimulating innovation and creativity. The WIPO is a forum that permits Member States to prepare and harmonize standards and practices designed to protect intellectual property rights; it also administers the systems for the international registration of marks, industrial designs and geographical indications, and an international system for the submission of patent applications.

ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГА (ДОӨБ)

Олон улсын оюуны өмчийн тогтолцоо (патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг, загвар (зураг төсөл болон загвар) гэх мэт)-г инноваци, бүтээлч байдлыг дэмжих хэрэгсэл болгон хөгжүүлж, ашиглахыг дэмждэг НҮБ-ын системийн байгууллага. ДОӨБ нь оюуны өмчийн эрхийг хамгаалахад чиглэсэн стандарт, практик ажиллагааг боловсруулж, уялдуулах боломжийг гишүүн орнуудаа бүрдүүлж өгдөг форум юм; энэ нь түүнчлэн барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, газарзүйн заалтыг бүртгэх олон улсын систем болон патентын өргөдөл гаргаж өгөх олон улсын системийг хянан удирддаг.

WTO APPELLATE BODY

A standing body of seven persons that hears appeals from reports issued by panels in disputes brought by WTO Members. The Appellate Body can uphold, modify or reverse the legal findings and conclusions of a panel. Appellate Body Reports, once adopted by the Dispute Settlement Body (DSB), must be accepted by the parties to the dispute.
[WTO/DSB]

ДХБ-ЫН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ БАЙГУУЛЛАГА

ДХБ-ын гишүүдээс тэдний маргааныг тасалсан хөндлөнгийн шүүхийн тайланг давж заалдсан хэргийг шүүн таслах 7 хүний бүрэлдэхүүнтэй байнгын ажиллагаатай байгууллага. Давж заалдах шатны байгууллага нь хөндлөнгийн шүүхийн гаргасан эрх зүйн шинжтэй дүгнэлт, шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох эрхтэй байна. Давж заалдах шатны байгууллагын тайланг Маргаан шийдвэрлэх байгууллагаас нэгэнт баталсан бол маргаанд оролцогч талууд түүнийг хүлээн зөвшөөрнө.
[ДХБ/Маргаан шийдвэрлэх байгууллага]

WTO VALUATION AGREEMENT

The expression commonly used to refer to the Agreement on Implementation of Article VII of the General Agreement on Tariffs and Trade 1994, which sets out the methodology and requirements for determining the Customs value for imported goods subject to ad valorem duties.

ДХБ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛЭЛЦЭЭР

1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн түгээмэл нэр. Энэ хэлэлцээрт гаалийн адвалорем татвартай импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлал болон шаардлагууд тусгагдсан байдаг.

Z

ZEROING

An investigating authority usually calculates the dumping margin by getting the average of the differences between the export prices and the home market prices of the product in question. When it chooses to disregard or put a value of zero on instances when the export price is higher than the home market price, the practice is called “zeroing”. Critics claim this practice artificially inflates dumping margins.

ТЭГЛЭХ

Демпингийн үнийг мөрдөн шалгах байгууллага нь гол төлөв тодорхой нэг барааны экспортын үнэ болон дотоод зах зээлийн үнийн зөрүүний дунджийг олж тогтоох замаар демпингийн хэмжээ (маржин)-г тооцдог. Экспортын үнэ нь дотоодын зах зээлийн үнээс өндөр байх тохиолдолд демпинг байхгүй буюу тэг утгатай гэж үздэг практикийг “тэглэх” гэж нэрлэдэг. Шүүмжлэгчид энэхүү практик нь демпингийн хэмжээг зохиомлоор өсгөдөг гэж үздэг.

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар
Сүхбаатар дүүрэг, Их тойруу 81/1, Улаанбаатар-14193
icd@customs.gov.mn
Утас: +976-11-350064

Монголын Худалдааг Дэмжих Төсөл

Гадаад Харилцааны Яам, Энх тайвны өргөн чөлөө-7А, Улаанбаатар 14210
МҮХАҮ Танхимын байр, өрөө 401 Махатма Гандигийн гудамж, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар 17011
Утас: +976-7000-8160, 7000-8162